



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 4 (105)

Улаанбаатар хот
2025 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: Б.Заяа

Хэвлэсэн газар: "Тоонот принт" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
байр, 11 дүгээр хороо, 7 дугаар хороолол
/14182/, Алтайн гудамж 841, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.nli.gov.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Н.Жамьянхүү Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

Эрхлэгч:

М.Түвшинжаргал Хууль зүйн доктор, дэд профессор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Гишүүд:

С.Нарангэрэл “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн эмерит профессор

Ц.Сарантуяа Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

Б.Амарсанаа Хууль зүйн доктор, профессор,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал

Г.Банзрагч Хууль зүйн доктор, Улсын дээд шүүхийн шүүгч

Б.Бат-Орших Хууль зүйн доктор, дэд профессор, УЕП-ын туслах прокурор, Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал

С.Болормаа Хууль зүйн доктор, дэд профессор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төвийн эрхлэгч

Б.Буянхишиг Хууль зүйн доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн, дэд профессор

С.Гантулга Хууль зүйн доктор, ДХИС-ийн Дэд бөгөөд Эрдэм шинжилгээ, инновацын газрын захирал, дэд профессор

Д.Зүмбэрэлхам Хууль зүйн доктор, профессор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн

Г.Нарантуяа Хууль зүйн доктор, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн

Д.Сүнжид Хууль зүйн доктор, дэд профессор, Хүний эрхийн үндэсний комиссын дарга

Г.Туяа Хууль зүйн доктор, дэд профессор, Их Засаг ОУИС-ийн Сургалт, үйл ажиллагаа эрхэлсэн проректор

Д.Эрдэнэчимэг Хууль зүйн доктор, дэд профессор, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн Академийн захирал

Ж.Эрхэсхулан Хууль зүйн доктор, дэд профессор, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Гармаев Юрий Петрович Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, ОХУ-ын Буриадын Улсын их сургуулийн профессор

Накамура Масаки Хууль зүйн доктор, Япон Улсын Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор

Ким Габ Сок Хууль зүйн доктор, БНСУ-ын Жүнбү их сургуулийн Цагдаагийн сургуулийн профессор

Пак Жеон Вон Хууль зүйн доктор, БНСУ-ын Кукмины их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор

Том Гинсбург Хууль зүйн доктор, АНУ-ын Чикагогийн их сургуулийн профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

М.Энхжин Сэтгэл судлалын магистр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

EDITORIAL BOARD

EDITOR-IN-CHIEF

JAMIYANKHUU Narmandakh

Director of The National Legal Institute of Mongolia

MANAGING EDITOR

TUVSHINJARGAL Moyor

Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Academic Secretary, The National Legal Institute of Mongolia

MEMBERS

NARANGEREL Sodovsuren

Order of Chinggis Khaan, Member of the Academy of Sciences, Science, Doctor of law (Sc.D.), Emeritus Professor, National University of Mongolia

SARANTUYA Tserenbaltav

Science Doctor of Law (Sc.D.), Professor, School of Law, National University of Mongolia

AMARSANAA Batbold

Doctor of Law (Ph.D.), Professor, Director of the School of Law, National University of Mongolia

BANZRAGCH Gochoo

Doctor of Jurisprudence (Dr.jur.), Justice, The Supreme Court of Mongolia

BAT-ORSHIKH Battumur

Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Associate Prosecutor General, Director of Training and Research Institute under the Prosecutor General's Office

BOLORMAA Soloon

Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Head of Legal Clinic Center, School of Law, National University of Mongolia

BUYANKHISHIG Bat-Erdene

Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Private Law Department, School of Law, National University of Mongolia

GANTULGA Sengee

Doctor of Law (Ph.D.) Associate Professor, Vice president and Director of Research and Innovation Department of University of Internal Affairs

ZUMBERELLKHAM Dorjdamba

Doctor of Law (Ph.D.), Professor, Member of The Judicial General Council of Mongolia

NARANTUYA Ganbat

Doctor of Law (Ph.D.), Commissioner, The National Human Rights Commission of Mongolia

SUNJID Dugar

Doctor of Jurisprudence (Dr.jur.), Associate Professor, Chief Commissioner, The National Human Rights Commission of Mongolia

TUYA Gal

Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Vice-rector in charge of training and activities, Ikh Zasag University

ERDENECHIMEG Dashpuntsag

*Doctor of Law (Ph.D.), Associate Professor,
Director, Judicial Academy of Mongolia*

ERKHESKHULAN Jambaajultem

*Doctor of Law (Ph.D.), Head of the Public Law
Department, School of Law, National University
of Mongolia*

GARMAEV Yury

*Doctor of Law (Ph.D.), Professor, Buryat State
University, Russian Federation*

MASAKI NAKAMURA

*Doctor of Law (Ph.D.), Professor, Nagoya
University of Economics, Japan*

GIM, GAB-SEOK

*Doctor of Law (Ph.D.), Professor, Department of
Police, Joongbu University Republic of Korea*

PARK JEON WONG

*Doctor of Law (Ph.D.), Professor, Department of
Police, Joongbu University Republic of Korea*

TOM GINSBURG

*Doctor of Law (Ph.D.), Professor, The University
of Chicago, USA*

STAFF:

ENKHJIN Munbish

*Master of Arts in Psychology (M.A.), Researcher,
The National Legal Institute of Mongolia*

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes
Mongolian Journal of Law five times
per year.

Address: NATIONAL LEGAL INSTITUTE
Altain street 841, 11th khoroo, 7 khoroolol,
Sukhbaatar district, Ulaanbaatar 14182, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт Академич С.Нарангэрэлийн Монголын ард түмэндээ айлтгасан үг 10

“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн эмерит профессор С.Нарангэрэл

Байгууллагын нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлага, хэрэгцээ (Байгууллагын нууцын тухай ойлголт) 14

МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хууль зүйн доктор Б.Тэмүүлэн

Гэмт хэрэг ба хиймэл оюун 24

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн магистр О.Дарханболд

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан Д.Ариунзаяа, М.Үүрийнтуяа

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Эмийн хууль бус эргэлтгүй тэмцэх эрх зүйн зохицуулалт 41

ДХИС-ийн Гэмт явдал судлалын докторант, цагдаагийн дэд хурандаа П.Өлзийтогтох

Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүйн хүрээнд тулгамдаж буй асуудал / Цагдаагийн байгууллагын жишээн дээр/ 58

Хууль зүйн магистр Б.Баатарцогт

Төрийн өмчит компани болон төрийн өмчит үйлдвэрийн газрын эрх зүйн зохицуулалт ба эрсдэлд суурилсан дотоод хяналтын системийг бий болгох хэрэгцээ, шаардлага 71

МУИС-ийн ХЗС-ийн магистрант Л.Энхсайхан

Монгол Улсад гэр бүлийн харилцаа дуусгавар болсны дараах хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, практикт тулгамдсан асуудал 86

Идэр их сургуулийн ХЗС-ийн магистрант Б.Бадамханд

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

Класс акцион болон хамтын маргааны шүүхийн зардлын гуравдагч этгээдийн санхүүжилт (Харьцуулсан судалгаа: АНУ, Австрали, Итали, Франц) 93

Өмгөөллийн Голомт Консалтинг ХХН-ийн партнер, гүйцэтгэх захирал, өмгөөлөгч З.Буяндаваа

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эрүүгийн эрх зүйн зарим асуудал 108

МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.Намуун-Эрдэнэ

Нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчим, тулгамдсан асуудал 122

Э.Энхзул МУИС-ийн ХЗС-ийн магистрант

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Мэдээ 146

CONTENT

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

- The need to change the legal regulation of business secrets of organization (The concept of business secrets)** 14

Temuulen.B Doctor of Law (Ph.D.), Associate Professor, Private Law Department, School of Law, NUM

- Crime and Artificial Intelligence** 24

Darkhanbold.O Master of Law (LL.M.), Lecturer, School of Law, NUM

Ariunzaya.D Bachelor's student, School of Law, NUM

Uriintuya.M Bachelor's student, School of Law, NUM

IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

- Legal regulation for combating the illegal circulation of medicines** 41

Ulziitogtokh.P (Ph.D. Candidate), Criminology, UIA, Police Lieutenant Colonel

- Issues Arising Within the Ethical Framework of Public Servants' Professional Relations (Using the Police Organization as an Example)** 58

Baatartsogt.B (LL.M.) Master of Law

- Legal regulation and requirements for the implementation of risk-based internal control systems in state-owned companies and state-owned enterprises** 71

Enkhsaikhan.L (Master's student), School of Law, NUM, Researcher, Administrative Law sector, Judicial Academy under the Supreme Court of Mongolia

- Protecting children's rights after family relationship termination: Legal and practical challenges in Mongolia** 86

Badamkhand.B (Master's student), School of Law, Ider University

LEGAL RESEARCH OVERVIEW

- Third-party funding of litigation costs in class actions and collective disputes (A Comparative Study of the United States, Australia, Italy, and France)** 93

Buyandavaa.Z Founding Partner and Director of Golomt Legal Consulting LLP

- Issues of the Criminal code regarding the Statute of Limitations for Criminal offense** 108

Namuun-Erdene.B (Master's student), School of Law, NUM

- The principle of proof and exoneration in cases of Insufficient evidence: Challenges and issues** 122

Enkhzul.E (Master's student), School of Law, NUM

NOTES

- News* 146

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм уншигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

2003 оноос хойш Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс тасралтгүй эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2025 оны 4 дүгээр улирлын 105 дахь цувралаар эрхэм уншигч та бүхэнтэйгээ золгож буйдаа таатай байна.

Уншигч та бүхэндээ хүргэх ээлжит дугаараар “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Академич Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор, Хууль зүйн үндэсний

хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн дарга бөгөөд “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хуульч, өмгөөлөгч, төр, нийгмийн зүтгэлтэн Содовсүрэнгийн Нарангэрэл Монголын ард түмэндээ айлтгасан эрхэм үгсээр эхлүүлж байгааг онцолж байна. Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Монгол Ард Улс тунхагласны 101 дэх жилийн ойн өдөр Хууль зүйн шинжлэх ухааны салбараас анх удаа Монгол Улсын төрийн дээд шагнал-тэргүүн зэргийн одон “Чингис хаан” одонгоор шагнагдсан түүхэн үйл явдал болсныг уншигч та нартаа хуваалцаж байна.

Сэтгүүлийн энэхүү дугаарт нийтийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүй, арилжааны эрх зүй зэрэг хууль зүйн салбарын шимтэн уншихуйц сонирхолтой өгүүллүүд багтлаа.

Ялангуяа, сэтгүүлийн 105 дахь дугаарт онцлох судалгааны бүтээлээс дурдвал МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн доктор, дэд профессор Б.Тэмүүлэнгийн Байгууллагын нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлага, хэрэгцээ (байгууллагын нууцын тухай ойлголт) сэдвийг хөндөн судалсан судалгааны ажлыг ийнхүү нийтийн хүртээл болгож байна.

Мөн энэ дугаараар хууль зүйн салбарын нэн чухал гэж хэлж болох хиймэл оюун ухаанд холбогдох эрх зүйн судалгаа болон бусад салбар эрх зүйн асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэж судалсан шинэлэг судалгааны өгүүллүүдтэй танилцах боломжтой.

Мөн уншигчдадаа зориулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг олон улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүл болгох зорилго тавин ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Сэтгүүлийн үйл ажиллагааг ямагт дэмжин ажилладаг хууль зүйн салбарын эрдэмтэн багш, хуульч, судлаач, шүүгч, прокурор та бүхэнд гүн талархал илэрхийлэхийн зэрэгцээ цаашдын эрдмийн их үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөе.

Эцэст нь тус дугаарт нийтлэгдсэн бүтээлүүд нь уншигч Та бүхний хууль зүйн салбарын онол, практикийн мэдлэгийг улам арвижуулна гэдэгт итгэж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ,

 Н. ЖАМБЯНХҮҮ

“ЧИНГИС ХААН” ТЭРГҮҮН ЗЭРГИЙН ОДОНТ АКАДЕМИЧ С.НАРАНГЭРЭЛИЙН МОНГОЛЫН АРД ТҮМЭНДЭЭ АЙЛТГАСАН ҮГ



С.Нарангэрэл

*“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт,
Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
МУИС-ийн эмерит профессор*

Монгол Улсын төрийн дээд шагнал - тэргүүн зэргийн одон “Чингис хаан” одонт Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор буй болгож, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх, эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлж, нийгмийн дэвшлийг хангах, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг гүнзгий судалж, хойч үедээ өвлүүлэх, тэдгээрийг дэлхийн бусад оронд сурталчлан таниулах үйлст жинтэй хувь нэмэр оруулж, төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавьяа байгуулсан Монгол Улсын иргэн болон улс түмний эв нэгдэл, хөгжил цэцэглэлт, хүн төрөлхтний амар амгалан байдлыг бэхжүүлэх болон Монгол Улс гадаад орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэлхий дахинд Монгол Улсын нэр хүндийг өргөн сурталчлах, тус улсын эдийн засаг, нийгэм, оюун санааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гадаад орны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, иргэнийг шагнаж байхаар заажээ.

“Чингис хаан” одон нь дугуй хэлбэрийн төвтэй, саарал өнгийн паалан дээр Чингис хааны дүрийг цагаан алтаар товойлгож, түүний гадуурх тойргийн хөх өнгийн паалан дээр баруун хэсэгт “Мөнх тэнгэрийн хүчинд”, зүүн хэсэгт “Чингис хаан Тэмүүжин” гэж худам монгол бичгээр товойлгон алтаар бичигдсэн байдаг. Түүний гадуур алтадсан эвэр угалзан дугуй хүрээг товойлгон хийж, гадуураа дөрвөн зүг, найман зовхисыг бэлгэдсэн цацрагуудтай ажээ. Эв нэгдэл, бат бэхийг бэлгэддэг багцалж боосон таван сумны дүрстэй алтсан урт цацрагтай, багцалсан боолт нь цагаан алтан суурь бүхий үнэт эрдэнийн очир алмаз шилтгээтэй. Цацраг тус бүрийн баруун, зүүн талд түүнтэй ижил урттай, үзүүртээ алтан бөмбөлөгтэй, ховил бүхий цагаан алтан цацрагтай. Эдгээр цацрагуудын хооронд үзүүртээ үнэт эрдэнийн бадмаараг шилтгээ бүхий богиновтор өргөн алтан цацрагтай, түүний хоёр талд ховил бүхий цагаан алтан богино холбоостой. Бүх хос цацрагуудын хооронд цагаан алтан богино холбоос хийсэн.

“Чингис хаан” одонгийн дээд хэсэгт одон зүүлт хоёрыг холбосон зориулалттай холбоосны хэсэгтэй, холбоос нь Чингис хааны Гэрэгэ дэвсгэртэй цагаан туг юм. Тугийг цагаан алтаар, Гэрэгэ-г алтаар хийжээ.

Одонгийн зүүлт нь алтадсан эвэр угалзан гинжин чимэглэлээр холбогдсон цагаан туг болон бадам цэцгээр хүрээлүүлсэн хөх өнгийн пааландсан суурь бүхий алтан соёмбоос бүрджээ. Цагаан тугууд нь эвэр угалзан хүрээтэй. Туг, бадам цэцгийг цагаан алтаар, соёмбыг алтаар хийжээ. Одон, зүүлтийн хэсэгт нийт есөн цагаан тугийг дүрсэлжээ. Одон, холбоос, зүүлтийн их биеийг мөнгөөр хийж, цацрагаар холбосон байдаг.

Монгол бахархлын өдөр буюу 2025 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн морин цагт Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Төрийн хүндэтгэлийн өргөөнд академич С.Нарангэрэлд Төрийн дээд шагнал “Чингис хаан” тэргүүн одонг ёслол төгөлдөр гардуулав.

“Чингис хаан” одон гардуулах ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хэлсэн үгэндээ - Их эзэн Чингис хааны мэндэлсний 863 жилийн ой, Монгол бахархлын өдрийг тохиолдуулан, ардчилсан Үндсэн хуулийг хэрэгжүүлэх эх үндэс болсон хууль тогтоомжийг шинэчлэн батлах, Монгол Улсад хууль зүйн боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, үндэсний эрх зүйн тогтолцоо, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр хийгээд Эзэн Чингис хааны дэлхий дахинд шударга ёс, энхийг тогтоосон их үйл хэрэг, гарамгай гавьяаг сурвалжлан судлахад олон жилийн нөр их хөдөлмөр зүтгэлээ зориулж, эх оронч үзлийг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх олон арван бүтээл туурвин, шинжлэх ухааны болон сургалт, судалгааны эргэлтэд оруулсан гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлэн Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын Их Сургуулийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн Их Сургуулийн хүндэт доктор, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, Академич Содовсүрэнгийн Нарангэрэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 170 дугаар зарлигаар Монгол Улсын төрийн дээд шагнал “Чингис хаан” тэргүүн зэргийн одонг хүртээж байгааг онцлон тэмдэглэжээ.

Академич С.Нарангэрэл хүндэтгэл талархлын үгэндээ “Төрөлх эх орон - Монгол Улсынхаа төрийн дээд шагнал – Их эзэн Чингис хааны тэргүүн зэргийн одонг эгэл жирийн агаад удамт угшилтай иргэн, багш сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн-судлаач, хуульч надад хүртээж байгаад Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Танд, монголын ард түмэндээ чин сэтгэлийн гүн талархлаа илэрхийлье.

Монгол Улсын маань газар зүй, байгаль орчин, цаг уур, гэр орон, амин зуулгад тохирсон тогтвортой хөгжил цэцэглэлт, хүн ардын маань сэтгэл тэнүүн амьдралын үндэс язгуур нь Их эзэн Чингис хааны маань өвлүүлж өгсөн үнэт сургаалын эрдэнэсийн сан, эрхэмбээрийн цаглашгүй их өвд оршин байгааг ухаарч ойлгоод, миний бие иргэн бүрийнхээ ой санамжид Монгол бахархлыг сэргээх болон соён гэгээрүүлэх үйлсэд нэн хэрэгтэй сургамжийг олж тогтоохын төлөө эрэлхийлэн хайх, судлан шинжлэх ажлыг олон жилийн туршид цөхрөлтгүй хийсний үр дүнд гаргаж авсан сургамж, дүгнэлтийн заримаас нь Монгол бахархлын энэ сайхан өдөр Та бүхэндээ хураангуйлж айлтгая.

Монгол бахархал бол олон зууны туршид огт хуучраагүй аж төрөх ёс, амьдралаа авч явах монгол айл өрхийн арга билиг, гал голомтоо залгуулан үр хүүхдээ эгэл жирийн амьдралд жинхэнэ монгол хүн болгон төлөвшүүлэх сурган хүмүүжүүлэх өнө эртний үнэт уламжлал, элгэмсүү эх монгол хэлэнд маань оршиж байсан байна.

Монгол бахархал бас өвөг дээдсийнхээ гайхамшигт ухаанаас цаг ямагт суралцаж, түүнд суурилан амьдралаа тодорхойлж, цаашдын ажил үйлсийнхээ зүг чиг, эрч хүчийг олж авахад оршиж байжээ.

Монгол бахархал харийн улс гүрний аж төрөх ёсыг мөнхөд өөрийн болгодоггүй, нэг мэдэхэд буцаад л буурин дээрээ эргээд буучихдаг монгол хүмүүний язгуур мөн чанар, генд нь хадгалагдаж иржээ. Ямар ч хүн өөрийнхөө гэр оронд өвлөж, нүдний цөцгий мэт нандигнаж ирсэн уламжлалаа хадгалахыг эрмэлздэгийн адил үзэсгэлэн төгөлдөр, өргөн уудам эх орныхоо хөрс шороон дээр таван хошуу мал сүргийн аж ахуй бүхий бэлчээр

дагасан соёл иргэншлийн аж төрөх ёс мөнхөд оршин байхыг, нэгэн цагт хүн төрөлхтний дотор асаж байсан, жинхэнэ аз жаргалант амьдралын гал цог бадарч, эцэг Тэнгэрээс заяасан эрч хүч цогцолсон амьдралын уламжлалт хэв маягаа үргэлж хадгалж явцгаахыг Их эзэн Чингис хаан монголчууд бидэндээ хичээнгүйлэн захисан байна.

Их эзэн Чингис хааны маань нандигнаж байсан гурван үеийнхний амин хэлхээ холбоог хэрэв үл тоомсорлож салгавал монголчууд бид өөдлөхгүй гэдгээ ухаарах цаг үетэй учран золгожээ.

Их эзэн Чингис хааны маань буй болгосон Монгол бахархал нь өвөг дээдсийнх нь генээр дамжиж өвлөгдсөн дараах билиг оюунаас ундарч гарсныг судалгааны зарим үр дүн баттай харууллаа. Их эзэн Чингис хаан маань Монгол зарим хүмүүний бүдүүлэг, цэвдэг сэтгэлийг нь эелдэг, найрсаг зочломтгой; шударга бусы нь голч шударга; залхуу хойрго, унхиагүйг нь ажилсаг хөдөлмөрч; ханашгүй шунахайрлыг нь эс шунахуй; эрээ цээргүйг нь ичиж эмээдэг; дур зоргын цадиггүй авирыг нь үүргээ гүнээ ухамсарладаг болгож байжээ. Мөн хүний мөсгүйг нь жудагтай; харгис хэрцгийг нь нинжин; худал хуурмагийг нь үнэн; хэн нэгнийхээ найдвар хөсөрдүүлэхий нь итгэл даадаг; нэр хүндээ унагахы нь нэр төрөө дээдэлдэг; амин хувиа хичээхийг нь нийтэч, хамтач болгож байсан. Түүнчлэн хэн нэгнийхээ үзүүлсэн тусыг хариулж чадахгүй юмаа гэхэд эргээд төвөг учруулдаггүй; сэтгэлийн тэнхээ, хатуужил муутайг нь тэсвэр тэвчээртэй; хагарал, талцал, дайсагнацлыг нь эв эе; үзэн ядалт, өс хонзон, хорон муу санаархал нь өгөөмөр атгаг бус; эргэж буцдаг шарвалтыг нь урвашгүй чанар болгон хувиргаж чадаж байжээ. Ингэсний үр дүнд XIII зуунд цул нэгдмэл хүчирхэг монгол үндэстэн бүрэлдэж, тэдний сэтгэлийн эерэг сайхан энергид харийнхан өөрийн эрхгүй татагдан, ёс суртахууныг хэвшүүлэхийг хуулийн амин сүнс болгосны үр дүнд дэлхий дахинд 140 жилийн туршид шударга ёс, энхийг тогтоох ариун үйлсийг бидний гайхамшигт өвөг дээдэс оройлон манлайлж, энэ хорвоогийн хүн ард эвтэй найрсаг эн зэрэгцэн эрх тэгш сэтгэл тэнүүн аж төрөх нөхцөлийг бүрдүүлж өгч байжээ. Их эзэн Чингис хаан болон эрхэмбээрийг шууд залгамжлагчид дэлхийн ямар ч улс үндэстний аж төрөх ёс, өөрийн удирдлага, заншил, хэл, соёл, уламжлал, шашин шүтлэгт дур мэдэн халдаж, ялгаварлан гадуурхалгүй, монголын гэсэн зүйлийг тэдэнд тулган хүлээлгэлгүйгээр дэлхий дахиныг хоёр жарны туршид элбэн засан тохинуулж, их амар амгалан (Pax Mongolica)-г авчирч байжээ. Чингис хааны үеэс мэндэлсэн их эвийн энэ үзэл санаанд дэлхий дахиныг цаашид амар жимэр амьдруулах удвис оршиж байж болох юм.

Их эзэн Чингис хааны маань “Хаан миний бие их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, идэх хоол, өмсөх хувцсаа адуучин үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг үр хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эв эеийг сахиулан, энэрэл хишгээ түгээж явна” хэмээсэн айлдвар нь төр засгийн эрхийг барилцаж яваа хүмүүст хандсан нэг ёсны гэрээс, өнөөдөр бас хатуу анхааруулга болж байна.

Монголчууд бид бүгдээрээ төрөлх монгол эх орноо чин сэтгэлээсээ хайрладаг билээ. Тийм учраас Их эзэн Чингис хааныхаа “Эцгийн нэрийг үр хүүхэд нь л амьдруулж, Эцгийн үйлсийг үр хүүхэд нь л залгамжилмуй” хэмээсэн айлдварыг нь үеийн үед монгол хүн бүр сүсэглэн дагаж явах нь энэ хорвоод та бид төрөлх эх орондоо монголоороо үлдэх цорын ганц боломж ч байж болзошгүй юм.

Монголынхоо ард түмэндээ мэхийн, гүн хүндэтгэл, талархлаа дахин илэрхийлэхийн ялдамд Монгол Улсын Төрийн тэргүүн Танд, Их эзэн Чингис хааныхаа тухай бүтээлээсээ англи, орос, герман, солонгос, казах зэрэг хэлнээ хөрвүүлэгдэж, гадаадын зарим улсын хэвлэлийн газар нийтийн хүртээл болгосноос нь Танд өргөн барья.

Их эзэн Богд Чингис хааныхаа гал голомтыг сахин суугаа эрхэмбээрийн үр сад – Монгол Улсын эрхэм хүндэт иргэд ээ, Их хааныхаа “Миний сургаалыг мянган онд хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлатугай” хэмээсэн

айлдварыг нь чанд сахин биелүүлж, буян хишгээ арвижуулж явахын билигтэй ерөөлийг Та бүхэндээ өргөн дэвшүүлье” гэсэн юм.

Энэ дашрамд дурдахад академич С.Нарангэрэл багш зөвхөн Их эзэн Чингис хааны талаарх түүхэн эх сурвалж, хөлгөн судар, эрдэмтэн мэргэдийн бүтээлийг олон жилийн турш судлан шинжилсний үр дүнд “Чингис хааны сүр хүч” /2013 он/, “Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир” /2014 он/, “Ёс суртахууны монгол цагаан толгой” /2015 он/, “Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд” /2016 он/, “Бурхан Халдун – монголчуудын өлгий нутаг” /2019 он/ зэрэг олон чухал бүтээл туурвиж, нийтийн хүртээл болгожээ. Түүнчлэн Бурхан Халдуныг хамгаалах зорилгоор Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Хурцаа (Д.Гэрэл)-тай хамтран /95 сая төгрөгийн өртөг бүхий/ “Дээдийн дээд хүндлэл” цогцолборыг улсаас нэг ч төгрөг гаргуулахгүйгээр 2019 онд бүтээн байгуулжээ. Мөн академич С.Нарангэрэл хотын захад орших номын гэр өргөөндөө 200 гаруй м газарт, “Бурхан Халдун – монголчуудын гал голомт” хэмээх иж бүрдэл цогцолборыг 150 сая гаруй төгрөг хувиасаа зарцуулан бүтээжээ.

“Чингис хаан” тэргүүн зэргийн одонгоор шагнагдсан хүнийг Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баяр, Үндсэн Хуулийн өдөр, Цагаан сарын баяр, “Чингис хаан” одон гардуулах зэрэг төрийн ёслолын арга хэмжээнд урин оролцуулах ёстой ажээ.

БАЙГУУЛЛАГЫН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ (БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ)



Б.Тэмүүлэн

МУИС-ийн ХЗС-ийн

Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, Хууль зүйн доктор

ТОВЧЛОЛ:

Байгууллагын нууцын тухай хууль 1995 оноос өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хуулийн зохицуулалт дээр үндэслэн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд өөрийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс олон тооны мэдээ, мэдээлэл, бичиг баримт, эдийн бус үнэт зүйлийг нууцад авч, олон нийтэд мэдээлэх, тарах эрсдэлээс урьдчилан сэргийлж байна.

Гэвч, ийнхүү байгууллагын нууцад авсан мэдээллүүдийг олон нийтэд дэлгэх, хүртээлтэй болгох, олон нийтийн мэдээллээр хангах ашиг сонирхлыг хангахгүй байна хэмээх шүүмжлэл багагүй өрнөж байна.

Дээрх шүүмжлэл үндэслэлтэй эсэх, аж ахуйн нэгж, байгууллагууд үнэхээр нууцад хамаарах мэдээллийг нууцалж буй эсэх тухай асуултад хариулт олох зорилгоор ийнхүү байгууллагын нууцын тухай асуудлыг энэ өгүүлэлээр хөндөхийг зорьсон. Өгүүллийн хүрээнд тэргүүн ээлжид байгууллагын нууцад хамаарах зүйлийн талаарх тодорхойлолтыг тодруулахыг хичээсэн болно. Үүнийг хуулийн хэм хэмжээг тайлбарлах, бусад адил төстэй зохицуулалттай зорилго, зохицуулалтын аргаар харьцуулах, Үндсэн хуулийн үндсэн эрхийн нөлөөллийн тухай онол, эрх зүйн харьцуулалт зэрэг аргачлалыг хэрэглэн үндэслэн, хариулт өгөхийг оролдсон болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Байгууллагын нууц, мэдээлэл

I. ОРШИЛ

Байгууллын нууцын харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлага бий эсэх тухай асуудалд хариулахын тулд тэргүүн ээлжид байгууллагын нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, эдийн бус үнэт зүйлийн тухай ойлголтын асуудлыг шинжлэх асуудал байх нь маргаангүй.

Өгүүллийн хүрээнд Байгууллагын нууцын тухай хуульд байгууллагын нууцын тухай ойлголтыг оновчтой тодорхойлсон эсэх, тодорхойлолтыг агуулга, зориулалт, хамрах хүрээний асуудлыг өөрчлөн дэлгэрүүлэх шаардлагатай эсэх тухай асуудлыг хөндсөн болно.

Байгууллагын нууцын харилцааны эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлага, хэрэгцээ бий эсэхэд хариулт өгөхийн тулд дан ганц ойлголтын асуудлыг судлах нь хангалтгүй болох нь тодорхой.

Энэхүү өгүүллийн хүрээнд зохицуулалтын тулгамдсан асуудлыг нэгбүрчлэн хөндөх боломжгүй тул дараа дараагийн өгүүллийн хүрээнд бусад асуудлыг судлан, цуврал өгүүллүүд гарахыг онцлог тэмдэглэхийг хүсэж байна.

II. БАЙГУУЛЛАГЫН НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

2.1.Хуулийн тодорхойлолт

Байгууллагын нууцын тухай ойлголтыг 1995 оноос өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т дараах байдлаар тодорхойлсон:

“Байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлсийг хэлнэ”.

Энэхүү тодорхойлолтын дагуу байгууллагын нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлсэд ямар мэдээлэл хамаарах асуудал нь агуулгын хувьд тодорхойгүй, ойлгомжгүй байна. Тус хуулийн заалтыг хуулийн хэм хэмжээг тайлбарлах үгийн утгын дагуу тайлбар хийх аргачлалын дагуу тайлбарлавал,¹ байгууллагын нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, бичиг баримт нь ямар чиг үүрэг гүйцэтгэх буюу ямар зорилгод нийцсэн байх талаар хариулт өгч байна. Үүнийг тодруулбал, байгууллагын нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, бичиг баримт нь хүний эрх, нэр төр, алдар хүндийг, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүргийг гүйцэтгэх нь.²

Харин, тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т 2011 онд оруулсан өөрчлөлтөөр хүний эрх, нэр хүнд, нэр төр, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ямар мэдээ, баримт бичиг, биет зүйлсийг оруулж болох талаар жишээ дурдан, тоочсон байна:

“Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал, хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно”.

Байгууллагын нууцад хамаарч болох мэдээ, мэдээлэл, биет зүйлсийн ойлголтын талаар асуудлыг тодруулах үүднээс юуны өмнө Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т агуулагдаж буй тодорхойлолтыг бусад хуулиуд дахь адил төстэй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийх шаардлагатай байна. Үүнийг өгүүллийн дараах хэсэгт толилууля.

III. БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ БА ИРГЭНИЙ ХУУЛИЙН 21 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 21.2 ДАХ ЗААЛТЫН ХООРОНДЫН ХАМААРАЛ

Өгүүллийн эхний хэсэгт дурдсанчлан, байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь хүний эрх, хүний нэр хүнд, нэр төр, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэх ёстой. Харин, хүний нэр төр, нэр хүнд, түүнчлэн хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг Байгууллагын нууцын тухай хуулиас гадна Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн зохицуулалтаар хамгаалж буйг анхааран, харгалзан үзэх шаардлагатай байна.

¹ Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2010, 202 дахь тал., В.Ruethers, 2014, Rechtstheorie, S.466.

² Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2010, 203 дахь тал, В.Ruethers, 2014, Rechtstheorie, S.445.

Тухайлбал, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “ Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил төрлийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл эсхүл өөр хэлбэр хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.” –гэж хуульчилсан. Улмаар, тус заалтын зохицуулалтын агуулгыг хэм хэжээг тайлбарлах үгийн утгын дагуу тайлбарлах аргачлалыг авч хэрэглэвэл, хувь хүний талаар түүний хувийн нууцад хамаарахгүй, бодит үнэнд нийцсэн мэдээлэл олон нийтэд тараасан бол нэр төр, нэр хүндийг гутаасан хууль бус үйлдэл гэж үзэхгүй байна.

Гэтэл, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн зохицуулалтаар Иргэний хуулийн 21 дүгээр зохицуулалтын эсрэг байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс бодит үнэнд нийцсэн хувь хүний мэдээллийг тараахыг хориглож байна.

Үүнтэй холбоотой, дараах асуудал үүснэ: хувь хүний нэр төр, нэр хүнд нь байгууллагын нууцтай холбоотой ашиг сонирхолтой яаж уялдаж байгаа билээ? Байгууллага гэдэг нь хувь хүнээс салангид, хөрөнгийн эсхүл үйл ажиллагааны нэгдэл бөгөөд өөрийн хөрөнгөтэй, үүгээрээ хариуцлага хүлээж байдаг аж ахуйн нэгжийг эсхүл төрийн бус байгууллагын ойлгож байдаг. Байгууллагатай холбогдуулан, тухайн хувь хүн тус байгууллагад ажилладаг этгээд байж болох юм. Гэтэл, дурдсанчлан, байгууллага гэдэг нь хувь хүнээс тусдаа хуулийн этгээд тул хувь хүний нэр төр, нэр хүндийн асуудлыг байгууллагын нууцтай холбож үзэх нь үндэслэлгүй бөгөөд боломжгүй үзэл баримтлал болох нь маргаангүй. Хэрэв байгууллагын нууцын холбогдох зохицуулалтыг авч хэрэглэвэл, тус байгууллагын ажилтан, албан тушаалтан хууль зөрчсөн үйлдэл хийсэн, асуудалд холбогдсон байвал байгууллагын нууц хэмээн нууцлах боломж нь гарч ирж байна. Гэтэл энэ нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн зохицуулалттай зөрчилдөж буй нь тодорхой.

Энэ тохиолдолд Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-ын зохицуулалт эсхүл Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн зохицуулалтын аль нь хэрэглэгдэх ёстой бөгөөд үндэслэлтэй болох тухай асуудал үүсэх нь тодорхой. Үүнд өгүүллийн дараах хэсэгт хариулт өгөхийг оролдсон болно.

IV. ТУСГАЙ БОЛОН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРИЛЦАА

Хувийн эрх зүйн салбарт ерөнхий болон тусгай зохицуулалт хоорондоо зөрчилдөж эсхүл өрсөлдөж байвал тусгай зохицуулалтыг авч хэрэглэх зарчим үйлчилдэг (lex specialis).³ Энэхүү зарчмын дагуу Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн зохицуулалтыг авч хэрэглэхээс илүү Байгууллагын нууцын тухай 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг давуу байдлаар авч хэрэглэх нь зүйтэй мэт санагдана. Гэвч үүнийг дараах үндэслэлээр үгүйсгэх боломжтой:

- Иргэний хууль хувийн эрх зүйн салбарын ерөнхий анги гэж тооцогддог.⁴ Улмаар, хувийн эрх зүйн бусад хуулиуд, баримт бичгүүд Иргэний хуулийн зохицуулалтад нийцсэн байх шаардлагатай байдаг. Байгууллагын нууцын тухай хууль нийтийн эрх зүйн эх сурвалж бус, харин хувийн эрх зүйн харилцааг зохицуулж буй эх сурвалж гэдэгтэй маргах үндэслэл алга байна. Энэхүү харилцаанд төрийн байгууллага, албан тушаалтанд оролцож буй бус, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бусдад тараах үндэслэлгүй мэдээллийг өөрөө нууцад авч, хамгаалсны үндсэн дээр өөрийн бизнес, үйл ажиллагаатай холбоотой ашиг сонирхлоо хамгаалахад чиглэгдсэн харилцаа юм. Үүнийг тодруулбал, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага шаардлагатай мэдээллийг өөрийн ашиг сонирхлоо хамгаалах үүднээс нууцлах хувийн эрх зүйн субъектив эрхийг тус хуулиар байгууллагад

³ E. Vranes, 2005, Lex Superior, Lex Specialis, Lex Posterior-Zur Rechtsnatur der “Konfliktsloesungsregeln”, S.7., Max-Planck-Institut fuer auslaendisches oeffentliches Recht

⁴ Brox/Walker, 2009, Allgemeiner Teil des BGB, S.2.

- олгож байна.⁵ Улмаар, байгууллагын нууцын тухай зохицуулалт Иргэний хуулийн холбогдох зохицуулалт, ойлголттой нийцэж байх ёстой;
- Хувийн эрх зүйд адил төстэй харилцааг адил байдлаар зохицуулах зарчим үйлчилдэг. Үүнийг Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1., 4.2 дах хэсэгт зохицуулсан.⁶ Улмаар, Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дах хэсэгт хүний нэр төр, нэр хүндийг бодит үнэнд нийцээгүй мэдээллийг тараах аргаар зөрчих тухай асуудлыг зохицуулсан байхад Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т хүний талаар бодит үнэнд нийцсэн мэдээллийг нууцад авч болох талаар зохицуулах нь эрх зүйн үндэслэлгүй бөгөөд иргэний хуулийн 4 дүгээр зүйлд зохицуулсан зарчимд харш байна. Өөрөөр хэлбэл, эсрэг тэсрэг үзэл баримтлал, концепцийг тус хуулиудаар зохицуулсан байх бөгөөд энэ нь адил төстэй харилцааг адил төстэй байдлаар зохицуулна гэх зарчмыг зөрчиж байна.

Үр дүнд нь, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т ямар үндэслэл, шалтгаанаар ийнхүү “байгууллагын нууц гэх мэдээлэл нь” хүний эрх, нэр төр, нэр хүндийг ... хамгаалах зорилгоор ... “ хэмээн тодорхойлсон талаар асуудал тавигдана. Үүнийг өгүүллийн дараах хэсэгт авч үзсэн болно.

4.1 Үндсэн хууль ба Байгууллагын нууцын тухай хууль – харилцан хамаарал

Дээрх асуултад хариулах үүднээс Үндсэн хууль дах заалтыг холбогдох дурдах нь зүйтэй. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 -д дараах үндсэн эрхийг тунхагласан байдаг:

“..... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална ...”.

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дах хэсгийн зохицуулалттай үгийн утга, зорилгын дагуу харьцуулбал, Үндсэн хуулийн заалтын “ ... хүний эрх, нэр төр, байгууллагын ... нууц ... “ гэх хэсгийг шууд хуулбарлан хуулийн заалтад тусгасан нь илэрхий байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль дах хувь хүн, байгууллагын нууцтай хамаарах тунхаглалыг Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т шууд хуулбарлан дахин хуульчилсан. Энэ нь Үндсэн хууль дахь үндсэн эрхийн тунхаглал нь Иргэний эрх зүйд буюу хувийн эрх зүйд үзүүлэх шууд бус нөлөөллийн зарчмыг зөрчсөн тул Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 -т тусгагдсан зохицуулалттай үзэл баримтлал, концепцийн хувьд зөрчилдөх үндэслэл болжээ.

Үндсэн хуульд тунхаглагдсан үндсэн эрх, эрх чөлөө нь хувийн эрх зүйд, хувийн эрх зүйн ерөнхий анги болж буй иргэний эрх зүйд хэрхэн нөлөөлөх талаар Германы хуульч, судлаач Канарис “Үндсэн хууль дахь үндсэн эрх, эрх чөлөөний гуравдагч шинжийн нөлөөлөл” хэмээх номлолыг хөгжүүлж ирсэн бөгөөд⁷ өнөө үед эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын судлаачид энэхүү номлолыг хүлээн зөвшөөрсөн байдаг байна.

Канарис Үндсэн хуульд тунхаглагдсан үндсэн эрх, эрх чөлөөг иргэний эрх зүйд шууд авч хэрэглэх, шаардах эрхийн үндэслэл болгож буй үйлдлийг шүүмжлэхдээ Үндсэн хуулийн үндсэн эрх, эрх чөлөөний гүйцэтгэж буй чиг үүргийг суурь болгосон бөгөөд үүнээс бий болох эрх зүйн үр дагавар дээр суурилсан байна.⁸

Үндсэн эрх, эрх чөлөө нь юуны өмнө эрхэд халдахыг хориглосон хорио болон үндсэн эрхээ хамгаалах хамгаалалтын эрхүүд юм. Эдгээрийн практик ач холбогдол нь юуны өмнө формаль хууль, дүрэм журам, захиргааны акт, шийдвэрээр илэрдэг. Тодруулбал, үндсэн эрх, эрх чөлөөг холбогдох хууль, дүрэм журам, захиргааны акт зэргээр Үндсэн хуульд нийцүүлэн хамгаалсан эсхүл хязгаарласан байх шаардлагатай. Үндсэн эрх, эрх чөлөө

⁵ Brox/Walker, 2009, Allgemeiner Teil des BGB, S.302, Б.Тэмүүлэн, Д.Энхзүл, Б.Буянхишиг, 2012, Иргэний эрх зүй ерөнхий анги, 305 дахь тал.

⁶

⁷ Duchrig in M/D/H/S, Art. 1 Rn. 131 ff, Canaris, JuS 1989, 161, 162

⁸ Мөн тэнд

нь төрд харьяалагдан чиглэгдсэн байдаг болохоос хувийн эрх зүйн, иргэний эрх зүйн харилцаанд оролцож буй субъектийн эсрэг шууд чиглэдэггүй байна.⁹ Гэхдээ энэ нь Үндсэн хуулийн эрх, эрх чөлөө нь хувийн эрх зүйн харилцаанд оролцож буй субъектийн хувьд ямар ч үйлчлэл үзүүлэхгүй гэсэн үг биш юм.

Үндсэн эрх, эрх чөлөөг хувийн эрх зүйд шууд авч хэрэглэх нь үндсэн эрхийн эрх зүйн мөн чанарт харш юм, учир нь, эдгээр нь иргэдийн зүгээс төрийн эсрэг чиглэгдэж буй хамгаалалтын эрхүүд бөгөөд үүнтэй шууд уялдан өөрийн агуулга ба хязгаарлалттай байдаг. Улмаар, үндсэн эрх, эрх чөлөөг хувийн эрх зүйд, тэгш этгээдүүдийн хоорондын харилцаанд шууд авч хэрэглэх боломжгүй.¹⁰

Үндсэн хууль дахь үндсэн эрх, эрх чөлөөний хувийн эрх зүйд үйлчлэх шууд нөлөөллийг үгүйсгэснээр эдгээр эрх, эрх чөлөө нь хувийн эрх зүйд огт үйлчлэхгүй, нөлөөлөхгүй гэсэн үг биш. Үндсэн хуульд үндсэн эрх, эрх чөлөөг тунхаглаж өгснөөр төр, тодруулбал, хууль тогтоогч, иргэн болон хуулийн этгээдэд тэдгээрийн эрхийг хамгаалах үүрэг хүлээж буй үйлдэл гарцаагүй мөн.¹¹

Харин үүнтэй холбоотой, хууль тогтоогч зохицуулалтын ямар аргаар, арга хэрэгслээр дамжуулан субъектүүдийн эрхийг хамгаалах үүргээ хэрэгжүүлэх талаарх асуудал зүй ёсоор тавигдана. Үүнийг хууль тогтоогч хувийн эрх зүйн эх сурвалжуудаар дамжуулан, тодруулбал, хувийн эрх зүйн салбарт холбогдох хуулиудад зохих зохицуулалт хийж өгснөөр хэрэгжүүлэх боломжтой.¹²

Үүнийг тодруулбал, Байгууллагын нууц, хувь хүний нэр төр, нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн холбогдох зохицуулалтыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 хэсэгт нийцүүлэн Иргэний хууль, Байгууллагын нууцын тухай хууль хувийн эрх зүйн зохицуулалтын аргачлалыг хэрэглэх арга замаар хийж өгөх ёстой. Гэтэл, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т байгууллагын нууцын тухай ойлголтыг тодорхойлохдоо Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дах хэсгийн үндсэн эрхийг шууд хуулбарлан тусгасан нь арга зүйн хувьд алдаа болсон байна.

V. БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн зохицуулалтыг тус хуульд тусгасан нь арга зүйн алдаа мөн тул байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т тусгагдсан зохицуулалтыг шинжлэн дүгнэх шаардлагатай. Үүний тулд эрх зүйн харьцуулалтын аргачлалыг авч хэрэглэн, ОХУ, ХБНГУ болон 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн зохицуулалтыг харьцуулан авч үзсэний үндсэн дээр дүгнэлт хийхийг оролдъё.

Эрх зүйн харьцуулалт хийхэд 2 түвшнээр хийх боломжтой байдаг:

- Макротүвшинд – үүнд өөр өөр эрх зүйн тогтолцоог хооронд нь харьцуулах
- Микротүвшинд- үүнд эрх зүйн институтийг хооронд нь харьцуулах.¹³

Өгүүллийн хүрээнд байгууллагын нууцын тухай ойлголтыг авч үзэж буй бул нэг эрх зүйн бүлд хамаарч буй, тодруулбал, Эх газрын эрх зүйн тогтолцоотой ОХУ, ХБНГУ-ын холбогдох зохицуулалттай Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т тусгагдсан нууцын тухай ойлголтын тодорхойлолтыг харьцуулъя.

5.1.Оросын холбооны улсын холбогдох зохицуулалт

ОХУ-ын холбогдох хууль тогтоомжоор, тодруулбал, “Бизнесийн нууцын тухай хууль” -ийн 98 дугаар зүйлд байгууллагын нууц гэх ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байна:

⁹ Stolz,1964, Gutachten zum 45. Deutschen Juristentag, S.49

¹⁰ Ehlers, Der Geldersatz fuer immaterielle Schaden bei deliktischer Verletzung des allgemeinen Persoenlichkeitsrechts, S.24.

¹¹ Canaris, Grundrechte und Privatrecht, S.38,

¹² Looschelders, 2004, Allgemeiner Teil des BGB, S. 111

¹³ Bach, 2020, Einfuehrung in die Rechtsvergleichung, S.4.

Байгууллагын нууц гэдэг нь байгууллагын эрх бүхий цөөн тооны хүн мэддэг, байгууллагаас гадагш тараах, мэдэгдэхээс онцгой хамгаалалтын дэглэмээр хамгаалагдсан, тухайн байгууллагад зах зээл дахь давуу талыг олохыг буюу хадгалахад, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд, зардлаа багасгахад нөлөөлөх чиг үүрэг гүйцэтгэдэг мэдээллийг ойлгодог байна. Энэхүү байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь 3-дагч этгээдэд мэдэгддэггүй бөгөөд байгууллагаар хамгаалагдаж буй тул үнэ цэнэ нь илэрхийлэгдэж байдаг буюу үнэ цэнтэй байдаг байна.

Дээрх тодорхойлолтын дагуу, байгууллагын нууцад дараах мэдээллийг хамруулж болдог байна:

- Үйлдвэрлэлийн мэдээлэл – өвөрмөц технологи, жор, үйлдвэрлэлийн аргачлал зэрэг
- Техникийн мэдээлэл- бүтээлч үйл ажиллагааны үр дүн, жишээ нь, патент, техникийн нууц, программын кодын тухай мэдээлэл;
- Эдийн засгийн болон зохион байгуулалтын мэдээлэл – үүнд худалдан авалтын тухай мэдээлэл, хөрөнгө оруулалтын хуваарилалтын, маркетингийн стратегийн, шинэ бүтээгдэхүүн болон түүнийг зах зээлд гаргах төлөвлөгөө, ажил хэргийн түншүүдийн талаарх мэдээлэл багтдаг байна;
- Олон нийтэд зориулагдаагүй, байгууллагын ашиг орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бусад мэдээллүүд.¹⁴

Харин байгууллагын нууцад хамаарахгүй мэдээлэлд үүсгэн байгуулалттай холбоотой мэдээлэл, бичиг баримт, татвар төлөлт, ажилтнуудын цалин хөлс, ажилтны тоо зэрэг мэдээллүүд. Түүнчлэн, нуун далдалж, нууцалж болохгүй мэдээллүүд үүнд багтана, жишээ нь, хууль тогтоомж зөрчсөн тухай, тендерийн нөхцөл зэрэг...

5.2.Байгууллагын нууцын талаарх ХБНГУ-ын зохицуулалт

ХБНГУ-ын холбогдох хуулиар¹⁵ байгууллагын нууцад хамаарах мэдээллийг дараах байдлаар тодорхойлсон байна:

Байгууллагын нууц гэдэг нь тодорхой нэг байгууллагын олон нийтэд нээлттэй бус, эдийн засгийн үнэ цэнэ бүхий, тухайн мэдээллийг нууцад хадгалснаар байгууллагын ашиг сонирхлыг хамгаалж буй мэдээллийг хэлнэ.

Дээрх тодорхойлолтын агуулгад нийцэж буй байгууллагын нууц мэдээллийг үндсэндээ дараах төрөлд ангилж авч үздэг байна:

- Бизнесийн нууц мэдээлэл – Жишээ нь, үйлчлүүлэгч, түншүүдийн талаарх мэдээлэл, бүтээгдэхүүний үнийг тооцон гаргах тооцооллын аргачлал, худалдан авалтын үнэ, зах зээлийн үнэлгээ болон бизнес хийх стратеги, маркетингийн концепци болон бизнес төлөвлөгөө...
- Үйлдвэрлэлийн нууц – үүнд техникийн болон худалдаа арилжааны мэдлэг, мэдээлэл, ололт зэрэг багтдаг байна, тухайлбал, нээлт, патент, шинэ шийдэл, бүтээл, алгоритм, техникийн тооцоо, зураг, төсөл, үйлдвэрлэлийн технологи, жор гм.

Германы хуульчдын санал нэгтгэйгээр тодорхойлж байгаагаар, аливаа мэдээллийг байгууллагын нууцад хамааруулахын тулд дараах урьдчилсан нөхцөл хангагдсан байх шаардлагатай:

- Байгууллагын нууцад хамаарах мэдээлэл олон нийтэд нээлттэй, хүртээлтэй биш, зөвхөн тодорхой цөөн тооны хүнд хадгалагдаж байх;
- Мэдээлэл нь нууц учир эдийн засгийн үнэ цэнтэй, үнэлгээтэй байх;
- Мэдээллийг байгууллагын нууцад авахтай холбоотой тодорхой арга хэмжээ авагдсан эсхүл алхмууд хийгдсэн байх¹⁶.

¹⁴ Илякова И.Е., 2024, Коммерческая тайна, С.45., Федоров.П.И., 2022, Коммерческая тайна в современном бизнесе, С.32.

¹⁵ Gesetz zum Schutz von von Geschäftsgeheimnissen von 2019

¹⁶ Reinfeld/Leister, 2022, Geschäftsgeheimnisschutz, S. 40.

Дээрх нөхцөлүүд хангагдаж байх тохиолдолд тухайн мэдээлэл нь байгууллагын нууцад хамаарах нь байна.

VI. БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.2 -Т ТОДОРХОЙЛСОН БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т өгүүллийн хүрээнд дурдсанчлан, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн талаарх хангагдсан байх ёстой урьдчилсан нөхцөл, шалгуурыг тогтоохыг зорьсон, жишээ дурдсан аргачлалыг хэрэглэн тодорхойлохыг зорьсон. Хуулийн тодорхойлолтоос байгууллагын нууцад хамаарч болох мэдээллийг ямар шалгуур буюу урьдчилсан нөхцөл хангасан байх талаар дараах дүгнэлтийг хийх боломжтой:

- Байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь тухайн байгууллагын зах зээл дэх эзэлж буй байр суурь, шударга өрсөлдөөнд олж авсан өөрийн давуу тал зэргийг хамгаалахад чиглэгдсэн буюу эсрэгээр мэдээлэл алдагдсан тохиолдолд эдгээр байдлаа алдах эрсдэлийг бий болгох мэдээлэл байна;
- Цөөн тооны мэдээлэл эзэмшигчид хадгалагдаж байдаг;
- Байгууллагаа шийдвэр гаргаж нууцдаа авсан байх.

Дээрх нөхцөлийг хангаж буй мэдээллийг байгууллагын нууцад хамаарах мэдээлэл гэж үзэх нь. Харин ямар мэдээлэл үүнд хамаарч болох талаар жишээ дурдан тоочсон байх бөгөөд үүнд технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг хамруулж болохоор байна.

6.1.ОХУ, ХБНГУ болон Монголын холбогдох хууль тогтоомж дахь байгууллагын нууцын тухай тодорхойлолтын харьцуулалт

ОХУ, ХБНГУ болон Монголын Улсын холбогдох хуулиар байгууллагын нууцад хамаарах мэдээллийн тухай ойлголтыг тодорхойлохдоо нууцад хамаарах мэдээллийг түүний ач холбогдол, гүйцэтгэх чиг үүрэг талаас нь тодорхойлж гаргаж ирсэн байх бөгөөд энэ нь хэдийгээр өөр үг, нэр томьёо хэрэглэсэн боловч, агуулагдаж буй санаа, үзэл баримтлал, зорилгын хувьд адил төстэй байна гэж дүгнэх үндэслэлтэй. Тодруулбал, ОХУ болон Монголын хуулиудад байгууллагын нууцад хамрагдах мэдээллийг “зах зээл дэх давуу байдлаа хамгаалах”, “ирээдүйд ашиг” олох, зардлаа багасгах, нэмэгдэл зардал гаргахгүй байхад нөлөөлөх мэдээлэл гэх утгаар томьёолсон нь байгууллагын өнөөг хүртэл хийж ирсэн бизнесийн үйл ажиллагааны үр дүнд олж чадсан зах зээл дахь байр суурь, эдийн засгийн чадавч, бизнесийн мэдлэг, мэдээлэл, маркетинг менежментийн мэдлэг, туршлага гэх мэт үнэ цэнтэй ололтуудаа өөрийн бизнесийг цаашид амжилттай үргэлжлүүлэхэд өөрсдөө ашиглах, хамгаалж хадгалж үлдэхэд ач холбогдол бүхий байх гэсэн шалгуурыг өр үг, нэр томьёогоор илэрхийлж буй боловч агуулга нь адил байх нь маргаангүй байна.

Харин энэхүү адил агуулга бүхий шалгуурыг ХБНГУ-ын холбогдох хуулиар мөн л адил агуулга бүхий боловч өөр нэр томьёоны тусламжтай илэрхийлэн тодорхойлсон байна, тухайлбал, “Эдийн засгийн үнэ цэнтэй” байх гэх шалгуураар. Байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай мэдээлэл нь эдийн засгийн үнэ цэнтэй байна гэдэг нь бизнесийн үнэ цэнэ, үнэлгээтэй, цаашлаад бизнесийн үйл ажиллагаатай шууд уялдаа холбоотой байх нь тодорхой. Харин бизнесийн үйл ажиллагаа нь өөрөө ашиг олох, орлогоо нэмэгдүүлэх, үүний тул зах зээлээ тэлэх зэрэг бодлого, үүнд хамааралтай шийдлүүд гаргах нь маргаангүй билээ.

Дараах нийтлэг шалгуур нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь цөөн тооны хүнд мэдэгдэж байх буюу цөөн тооны хүн мэдээллийн эзэмшигч, хадгалагч байх гэх шалгуур болж байна.

Гуравдах шалгуур нь байгууллага өөрийн шийдвэрээр хамгаалалтдаа авсан байх эсхүл нууцад хамааруулсан байх гэх шалгуур 3 улсын хуульд адил байдлаар тусгагдсан байна.

VII. ДҮГНЭЛТ

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т хуульчилсан байгууллагын нууцад хамаарах мэдээллийн тухай тодорхойлолт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д тунхагласан “...Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална...”. гэх заалтыг хуулбарласан байх тул Үндсэн хууль дах үндсэн эрхийн хувийн эрх зүйд үзүүлэх шууд бус нөлөөллийн үзэл баримтлалыг зөрчиж буй тул тус хуулиас хасаж өөрчлөлт оруулах нь үндэслэлтэй байна. Хүний нэр төр, нэр хүндийн эрх зүйн хамгаалалтыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтаар олгосон байдаг.

Байгууллагын нууцад хамаарах мэдээллийн тодорхойлолтыг дараах байдлаар өөрчлөн найруулж, холбогдох заалтад нэмэлт өөрчлөлт оруулах нь оновчтой байна, үүнд:

“Байгууллагын зах зээл дэх байр суурийг хамгаалах, хадгалахад чиглэгдсэн, ашиг орлого нэмэгдүүлэх, зарлага багасгах чиг үүрэг гүйцэтгэдэг, эдийн засгийн үнэ цэнтэй, цөөн тооны хүмүүс мэдэхэд зориулагдсан техникийн, бизнесийн, зохион байгуулалт, технологийн эдийн болон эдийн бус мэдээллийг байгууллагын нууцад хамаарах мэдээлэл байна”.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх эх сурвалж:****А. Ном, сурах бичиг**

1. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2010 он.
2. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүй ерөнхий анги, 2012 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:**А. Герман хэл дээр**

1. Bach Ivo: Einfuehrung in die Rechtsvergleichung, 2020.
2. Brox/Walker: Allgemeiner Teil des BGB, 2009.
3. Ehlers, Wolfram: Der Geldersatz fuer immaterielle Schaeden bei deliktischer Verletzung des allgemeinen Persoenlichkeitsrechts, Berlin, 1977.
4. Canaris, Claus-Wilhelm: Grundrechte und Privatrecht, 1984, AcP 184.
5. Canaris, Claus-Wilhelm: Grundrechte und Privatrecht, Berlin 1999.
6. Looschelders, Dirk: Schuldrecht, Allgemeiner Teil, 2.Auflage, 2004.
7. Stoll, Heinrich: Empfiehlt sich eine Neuregelung der Verpflichtung zum Geldersatz fuer immaterielle Schaden? Gutachten zum 45. Deutschen Juristentag in Karlsruhe. Die Wirkung von Grundrechteund Grundfreiheiten zwischen Privaten, Detlev W.Belling.
8. Reinfeld/Leister: Geschaeftsgeheimnisschutz, 2022.
9. E. Vranes, Lex Superior, Lex Spezialis, Lex Posterior-Zur Rechtsnatur der: "Konfliktsloesungsregeln", Max-Planck-Institut fuer auslaendisches oeffentliches Recht, 2005.

Б. Орос хэл дээр

1. Илякова И.Е. Коммерческая тайна, 2024.
2. Федоров.П.И. Коммерческая тайна в современном бизнесе, 2022.

THE NEED TO CHANGE THE LEGAL REGULATION OF BUSINESS SECRETS OF ORGANIZATION (THE CONCEPT OF BUSINESS SECRETS)

Temuulen.B

*Doctor of Law (Ph.D.), Associate Professor;
Private Law Department, School of Law, NUM*

ABSTRACT:

The Corporate Secrets Act has been in force since 1995. Based on the regulation of the law, enterprises and non-governmental organizations keep a large number of news, information, documents, and non-material values confidential in order to protect their interests and prevent the risk of public information and dissemination.

However, there is considerable criticism that this approach to disclosing confidential information to the public, making it accessible, and providing public information does not protect the interests of the public.

This article aims to address the issue of corporate secrecy in order to find answers to the questions of whether the above criticism is justified and whether businesses and organizations are truly keeping confidential information confidential.

The article first attempts to clarify the definition of what constitutes corporate secrecy. This is attempted by interpreting legal norms, comparing them with other similar regulations in terms of purpose and regulatory methods, and using methods such as the theory of the impact of fundamental rights in the Constitution and legal comparison.

KEYWORDS:

Confidential corporate information, Information

ГЭМТ ХЭРЭГ БА ХИЙМЭЛ ОЮУН



О.Дарханболд
МУИС-ийн ХЗС-ийн багш,
хууль зүйн магистр



Д.Ариунзаяа
МУИС-ийн ХЗС-ийн 5-р
түвшний оюутан



М.Үүрийнтүяа
МУИС-ийн ХЗС-ийн 5-р
түвшний оюутан

ТОВЧЛОЛ:

Europol (European Union Agency for Law Enforcement Cooperation)-ийн 2024 оны тайланд дурдсанаар хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргийн гаралт огцом өсөж байна. Тодруулбал, 2023 онд бүртгэгдсэн фишинг болон цахим залилангийн халдлагын 70 хувь нь хиймэл оюуны тусламжтайгаар үйлдэгдсэн. Мөн онд deepfake технологид суурилсан залилангийн хэрэг Европын хэмжээнд 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна¹. Монгол улс Кибер аюулгүй байдлын тухай хуулийг 2021 онд баталж, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Кибер гэмт хэрэгтэй тэмцэх албыг байгуулсан боловч хиймэл оюуныг гэмт хэрэг үйлдэхэд ашиглахтай тэмцэх талаар эрх зүйн зохицуулалт дутмаг, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг авч буй хариу арга хэмжээ хангалтгүй байна. Энэхүү өгүүлэлээр хиймэл оюуныг гэмт хэрэг үйлдэхэд ашиглахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхтэй холбоотой олон улсын авч буй хариу арга хэмжээг судалсан болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хиймэл оюун, эрсдэлийн үнэлгээ, гэмт хэргийн зардал, гэмт хэргийн гаралт, кибер аюулгүй байдал

I. ОРШИЛ

XXI зууны технологийн хөгжил нь үйлдвэрлэл, эдийн засаг, нийгмийн харилцаанд төдийгүй хүний мөн чанарт ч гүнзгий нөлөө үзүүлж, шинэ эрин үеийг эхлүүлж байна. Дэлхийн эдийн засгийн форум (WEF)-ыг үүсгэн байгуулагч, профессор Клаус Шваб энэхүү өөрчлөлтийг “Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал” хэмээн нэрлэж, физик, дижитал, биологийн ертөнцүүдийг нэгтгэж буйгаараа онцлог гэж тодорхойлжээ². Технологийн өндөр хөгжлийг даган хүний амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн зэрэгцээ гэмт хэргийн ертөнц ч хувьсан өөрчлөгджээ. Хиймэл оюуны хурдацтай хөгжил нь хүний амьдралд шинэ боломжуудыг нээж буй хэдий ч хүмүүс энэ ололтыг зүй бусаар ашиглаж, энэ нь гэмт хэрэг үйлдэх арга замыг хялбарчлах, илрүүлэхэд төвөгтэй болгож, шинэ төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан болж байна.

¹ Europol, Internet Organised Crime Threat Assessment (IOCTA) 2024, <https://www.europol.europa.eu/cms/sites/default/files/documents/Internet%20Organised%20Crime%20Threat%20Assessment%20IOCTA%202024.pdf>, (last visited Apr.23, 2025)

² Klaus Schwab, “The Fourth Industrial Revolution: What It Means and How to Respond”, World Economic Forum, (2016), <https://www.weforum.org/stories/2016/01/the-fourth-industrial-revolution-what-it-means-and-how-to-respond/>, (last visited Apr.23, 2025).

Монголд сүүлийн жилүүдэд хиймэл оюуныг шүүх, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах боломж, эрсдэлүүдийг судалсан судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүд олон гарсан. Харин хиймэл оюун гэмт хэрэгт хэрхэн нөлөөлж байгаа, одоогийн хууль тогтоомжоор энэ харилцааг зохицуулах боломжтой эсэх талаар судалсан судалгаа хомс байна.

Хиймэл оюуны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хиймэл оюунд суурилсан гэмт хэргийн гаралт өсөж байна³. Иймд нэг талаас хиймэл оюуны хэрэглээг оновчтой зохицуулж, хяналт-хариуцлагын механизмыг бүрдүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас хиймэл оюунд суурилсан гэмт хэргийн онцлогийг танин мэдэж, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг хариу арга хэмжээ авах нь Монголд төдийгүй олон улсад тулгамдаж буй асуудал болоод байна. Монгол Улсад хиймэл оюун болон түүнтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, журам одоогоор байхгүй. Энэхүү өгүүллийн зорилго нь хиймэл оюуны хэрэглээ гэмт хэрэгт үзүүлж буй нөлөөлөл болон үүнтэй холбоотой олон улсын авч буй хариу арга хэмжээ, холбогдох хууль тогтоомжийг судалж, Монгол улсад хэрхэн нэвтрүүлэх боломжтой талаар санал дэвшүүлэхэд оршино.

Энэ өгүүлэлд эдийн засаг, криминологи, сэтгэл судлалын онолуудыг ашиглан дүн шинжилгээ хийсэн. Мөн хууль зүйн аналитик судалгаа, кейс анализ болон харьцуулсан судалгааны аргуудыг ашигласан.

II. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.1. Хиймэл оюун гэмт хэргийн зардлыг хэмнэх нь

Английн сэтгэл судлаач, криминологич Дерек Б. Корниш болон АНУ-ын криминологич Рональд В. Кларк нар нь криминологийн салбарт Ухамсарт сонголтын онол (Rational Choice Theory)-ыг боловсруулсан. Тэдний санаа нь хүн гэмт хэрэг үйлдэхдээ зорилго, эрсдэл, өгөөжийг тооцоолж, шийдвэр гаргадаг гэсэн ойлголтод тулгуурладаг⁴. Тодруулбал, ухамсарт сонголтын онолын үүднээс хүмүүс оновчтой сонголт хийхийн тулд арга хэрэгсэл, зорилго, зардал, ашигтай байдлыг үнэлж, эрсдэл (Risk), ашиг (Reward), үйлдлийг хэрэгжүүлэхэд шаардагдах бие, сэтгэл зүйн хүч, хугацаа, төвөгтэй байдал (Self-defeat) зэргийг тооцоолж байж шийдвэр гаргадаг. Иймд гэмт хэрэг нь зөвхөн хувь хүний зан байдал бус, нөхцөл байдал, боломжоос ихээхэн хамаардаг байна⁵.

Америкийн эдийн засагч Гэри С. Беккер 1968 онд “Гэмт хэрэг ба ял шийтгэл: Эдийн засгийн хандлага” бүтээлдээ гэмт хэрэг үйлдэх шалтгааныг эдийн засгийн уламжлалт арга зүйн үүднээс тайлбарласан⁶. Беккерийн үзэж буйгаар хүмүүс гэмт хэрэг үйлдэх эсэхээ зардал-ашигийн шинжилгээний (cost-benefit analysis) үндсэн дээр ухамсартайгаар шийддэг. Гэмт хэрэг үйлдсэнээр олох ашиг (benefit) нь баригдах, ял авах эрсдэлтэй холбоотой зардлаас (expected cost) их байвал хүн гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр. Хэрэв гэмт хэргийг илрүүлэх магадлал өндөр, ялын бодлого нь хатуу байвал ашиггүй болох тул хүмүүс гэмт хэрэг үйлдэхээс зайлсхийдэг.

Гүйлгээний зардал⁷ (transaction cost) гэх ойлголтыг Английн эдийн засагч Роналд Х. Коуз 1937 онд “Фирмийн мөн чанар”⁸ гэх өгүүлэлдээ анх танилцуулж, Америкийн эдийн засагч Оливер Э. Уильямсон, Дуглас С. Норт нар дэлгэрүүлэн хөгжүүлсэн. Уильямсон гүйлгээний зардлыг гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх, зөрчил үүсэхэд шийдвэрлэхтэй

³ Europol, Internet Organised Crime Threat Assessment (IOCTA) 2024

⁴ Derek B. Cornish and Ronald V. Clarke, The Reasoning Criminal: Rational Choice Perspectives on Offending (Transaction Publishers, 2014), 45.

⁵ Ibid.

⁶ Becker, Gary S, “Crime and Punishment: An Economic Approach”, National Bureau of Economic Research, (1968), nber.org.

⁷ “Transaction cost” гэх ойлголтыг эдийн засгийн утгаар “гүйлгээний зардал” гэж орчуулах нь нэгэнт тогтсон тул ийнхүү орчуулав.


⁸ Coase, Ronald H, “The Nature of the Firm”, (1937), econsome.org.

холбоотой үйл ажиллагааны тодорхой зардлууд гэж тодорхойлсон⁹ бол Норт итгэлцэл, мэдээллийн хүртээмж, хууль зүйн тогтолцоо зэрэг институцийн хүрээнд бий болдог ил болон далд зардлын нийлбэр гэж тодорхойлсон¹⁰. Гүйлгээний зардлын онол нь эдийн засгийн онол боловч Америкийн эдийн засагч Брус Л. Бенсон тэргүүтэй судлаачид түүний логикийг эрүүгийн эрх зүйд хэрэглэсэн¹¹.

Бенсон гэмт хэрэг үйлдэхийг зах зээлийн харилцааны нэгэн адил зардал-ашигын үнэлгээнд суурилсан шийдвэр гэж үздэг. Тэрээр хууль бус зах зээл дэх оролцогчдын зан үйлийг судалсан бүтээлдээ гүйлгээний зардал (transaction cost)-ын үзэл баримтлалыг хэрэглэн, гэмт хэрэг үйлдэх үе шат хүний ухамсарт хэрхэн бүрэлддэгийг дараах байдлаар тайлбарласан байдаг:

Мэдээлэл цуглуулах зардал: Гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай нөхцөл, боломж, аюулгүй байршил, зорилтот этгээдийн талаарх мэдээллийг олоход гарах цаг хугацаа, техник, программ, холболтын зардал;

- **Харилцагчтай холбогдох зардал:** Гэмт хэргийг хамтран үйлдэх этгээдийг олох, итгэлцэл бий болгох, зуучлагч ашиглах зардал;
- **Эрсдэл даах зардал (risk premium):** Баригдах, шийтгэгдэх, илчлэгдэх магадлалыг туулах сэтгэлзүйн дарамт болон түүнийг “үнэлэх” нийгэм-сэтгэл зүйн зардал;
- **Хяналт, итгэлцлийг хангах зардал:** Гэмт хэргийг хамтран үйлдэх тохиолдолд харилцан итгэлцэл бий болгох, урвахгүй байх нөхцөл бүрдүүлэх, хяналт тавих хэрэгцээтэй холбоотой зардал¹².



Эдгээр зардал болон гэмт хэргийн гаралт нь хоорондоо урвуу хамааралтай бөгөөд зардал бага байх тусам тухайн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал ихэсдэг. Иймд төрийн зүгээс гэмт хэрэг үйлдэхэд гарах зардлыг өсгөх буюу тухайн гэмт хэргийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлэх, шаардлагатай бол ялын бодлогыг чангатгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь үр дүнтэй арга хэмжээ болдог байна.

График 1. Гэмт хэргийн зардал ба гэмт хэргийн гаралтын холбоо хамаарал.

Хиймэл оюун хүний амьдралд маш олон давуу талыг бий болгож байгаатай бид маргахгүй. Гэсэн хэдий ч хүн төрөлхтөн үүнийг зөвхөн хөгжил дэвшил, сайн сайхны төлөө бус гэмт үйлдэлдээ ч ашиглах болжээ. (Энэ талаар III хэсэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.) Гэмт хэрэгтэн хиймэл оюуныг ашиглан өөрийн үйлдлийг хөнгөвчилж, цаг хугацаа, хүчин чармайлт, эрсдэл зэрэг бүхий л зардлаа “хэмнэх” боломжтой байгаа нь гэмт хэрэг үйлдэх сэдлийг нэмэгдүүлж байна.

⁹ Williamson, Oliver E., “The Economic Institutions of Capitalism”, (1987), jstor.org.

¹⁰ North, Douglass C. “Institutions, Institutional Change and Economic Performance”, (1990), cambridge.org.

¹¹ Benson, Bruce L. “Privatization and Community in Criminal Justice”, The Urban Lawyer, Vol. 32, No. 1 (Winter 2000), 167-169, jstor.org.

¹² Ibid.

2.2.Хиймэл оюун гэмт хэргийн сэдэл болон хүний зан үйлд нөлөөлөх нь

Хүний ухамсартай үйл ажиллагааны нэг хэлбэр болох гэмт хэрэг нь гэмт этгээдийн гэмт сэдэлд үндэслэгдэн үйлдэгдэж, эцсийн үр дүн болох хор уршгийг учруулахад түүний зорилго чиглэгдэж байдаг.¹³ Гэмт хэргийн субъектив талын нэмэгдэл шинж болох сэдлийг монголын эрүүгийн эрх зүй судлаачид янз бүрээр тодорхойлж ирсэн. Тухайлбал, “Гэмт хэргийн сэдэл бол хүний ухамсрын түлхэц”¹⁴, “Гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдэхдээ удирдлага болгосон дотоод өдүүлбэрийн ашиг сонирхол, эрэлт хэрэгцээ”¹⁵, “Гэмт этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөж, түлхэж байгаа, хүний тодорхой ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагаар нөхцөлдсөн сэтгэхүйн дотоод хүчин зүйл”¹⁶, “Нийгмийн эсрэг хэрэгцээ сонирхлоор нөхцөлдөн үүсэж, гэмт хэрэг үйлдэх шийдмэг бодол санааг төрүүлдэг, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй хийхийг өдөөн түлхэгч, чиглүүлэн идэвхжүүлэгч, хөтлөн дагуулагч сэтгэл зүйн дотоод өдүүлбэр”¹⁷ гэжээ.

Сэтгэл судлалын үүднээс сэдлийг хүний зан үйлийг тодорхой зорилго, чиглэл рүү хөтөлдөг ухамсарт эсвэл ухамсаргүй түвшинд үйлчилдэг өдөөгч хүчин зүйл гэж тодорхойлдог¹⁸. Харин эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн сэдэлд зөвхөн ухамсарт сэдлийг хамааруулдаг¹⁹ бөгөөд тэр нь гэмт этгээдийн ашиг сонирхол болон хэрэгцээ шаардлагаар нөхцөлдөн хүний зан үйлд нөлөөлдөг. Хүний зан төлөвт сэдэл нь үйл ажиллагааны агуулга, чиглэлийг тодорхойлох, хүсэл зоригийг өдөөгч чиг үүргийг хэрэгжүүлдэг, хувь хүнийг идэвхжүүлдэг субъектив хүчин зүйл юм.

Зан үйлийн онол (Behavioral Theory)-ийн төлөөлөгч Америкийн сэтгэл судлаач Б.Ф.Скиннерийн Оперант нөхцөлт үйлдэл (Operant conditioning)-ийн үүднээс авч үзвэл хүний зан үйлийн төлөвшил нь S-R-C буюу өдөөгч (Stimulus), хариу үйлдэл (Response), үр дагавар (Consequence) гэсэн 3 бүрэлдэхүүнтэй²⁰.

- S (Stimulus/Өдөөгч): Орчны тодорхой нөхцөл, нөхцөл байдал.
- R (Response/Хариу үйлдэл): Өдөөгчид үзүүлсэн хүний хариу үйлдэл буюу зан үйлийн илэрхийлэл.
- C (Consequence/Үр дагавар): Тухайн зан үйлийн дараах үр дагавар нь дэмждэг (reinforcement) эсвэл шийтгэл (punishment)-ийн шинжтэй байж болно. Үр дагавар нь тухайн зан үйл цаашид давтагдах эсэхийг тодорхойлох гол хүчин зүйл болдог.

Энэ онолын гол санаа нь хүний аливаа зан үйл орчны өдөөгчид хариу үйлдэл үзүүлэх байдлаар илэрч, түүний үр дагавар нь тухайн зан үйлийн ирээдүйд давтагдах эсэхийг тодорхойлдог гэж үздэг.

¹³ Галбатын Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (УБ:2011), 224 дэх тал.

¹⁴ Галдангийн Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс: Ерөнхий анги, (УБ:1973), 252 дахь тал.

¹⁵ Содовсүрэнгийн Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги, (УБ:1999), 182 дахь тал.

¹⁶ Галбатын Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (УБ:2011), 229 дэх тал.

¹⁷ Суурийн Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, (УБ:2009), 521 дэх тал.

¹⁸ “Motivation.” APA Dictionary of Psychology. American Psychological Association. Accessed October 29, 2025. <https://dictionary.apa.org/motivation>

¹⁹ Галбатын Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (УБ:2011), 226 дахь тал.

²⁰ C.R.Jeffery, “Criminal Behavior and Learning Theory,” Journal of Criminal Law & Criminology 56, no. 3 (Sep.1965): 294-295.

	Response up	Response down	
Stimulus presented	S Positive reinforcement	S Positive punishment	Б.Ф.Скиннерийн онолын тулгуур элемент нь дэмжлэг болон шийтгэл юм. Ерөнхийдөө 4 төрлийн үр дагавар үүснэ. + Эерэг дэмжлэг (таатай зүйл нэмэгдэх)-Хариу үйлдэл буюу зан үйл давтагдах магадлал өснө.
Stimulus eliminated	S Negative reinforcement	S Negative punishment	- Сөрөг дэмжлэг (таагүй зүйл арилах)-Хариу үйлдэл буюу зан үйл давтагдах магадлал өснө. + Эерэг шийтгэл (таагүй зүйл нэмэгдэх)- Хариу үйлдэл буюу зан үйл

давтагдах магадлал буурна.

- Сөрөг шийтгэл (таатай зүйл хасагдах)- Хариу үйлдэл буюу зан үйл давтагдах магадлал буурна.

Жишээлбэл,

- S= “гэмт хэрэгтэн хиймэл оюун ашиглан мэдээлэл цуглуулах болон харилцагчтай холбогдох зардлаа хэмнэх боломжтой”. Энэ нь эерэг дэмжлэг бөгөөд үүний хариу үйлдэл нь тухайн зан үйл ирээдүйд давтагдах магадлал өснө.
- S= “хиймэл оюуныг гэмт хэрэгт ашиглах нь баригдах магадлал багатай”. Энэ нь сөрөг дэмжлэг буюу хариу үйлдэл нь тухайн зан үйл давтагдах магадлал мөн л өснө.
- S= “хиймэл оюун ашиглан үйлдсэн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгалаа”. Энэ нь эерэг шийтгэл буюу хариу үйлдэл нь тухайн зан үйл давтагдах магадлал буурна.
- S= “мөрдөн шалгах ажиллагаанд хиймэл оюун ашиглан ямар ч хүндрэлтэй гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлдэг боллоо”. Энэ нь сөрөг шийтгэл буюу хариу үйлдэл нь тухайн зан үйл давтагдах магадлал мөн л буурна.

Хиймэл оюуны хэрэглээ гэмт хэргийг хялбарчлах боломжтой байгаа нь ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагын адилаар гэмт хэргийн сэдлийг өдөөгч хүчин зүйл болж байна. Улмаар энэ хариу үйлдэл нь хүний зан үйлд нь нөлөөлөн давтагдах магадлалыг ихэсгэж байна. Нөгөө талаар төрөөс гэмт хэргийн зардлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах (ялын бодлогыг чангатгах, мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах гэх мэт) нь гэмт хэрэг үйлдэх сэдлийг бууруулах хүчин зүйл болж байна.

III. ГЭМТ ХЭРЭГ БА ХИЙМЭЛ ОЮУН

Хиймэл оюун бол хүн төрөлхтний түүхэн дэх гайхамшигт ололт мөн. Түүний хурдацтай хөгжил нь асар их боломжуудыг бий болгохын зэрэгцээ түүнтэй дүйцэхүйц хэмжээний сорилт, эрсдэлийг дагуулдаг. Үүнтэй холбоотойгоор AI Crime as a Service (CaaS) буюу “Хиймэл оюунд суурилсан гэмт хэргийн үйлчилгээ” хэмээх шинэ төрлийн хууль бус үйлчилгээ хүртэл бий болоод байна. Энэ нь кибер гэмт хэрэгтнүүд хиймэл оюунд суурилсан халдлагын хэрэгслүүд болох фишинг багц²¹, ботнет²² болон DDoS²³ гэх мэт

²¹ Phishing kit- Хуурамч вэбсайт, өгөгдөл хураагч скрипт, тохиргооны файл зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэх, хэрэглэгчийн мэдээллийг хуурч авах зорилготой бэлэн хэрэгслийн цуглуулга.

²² Ботнет гэдэг нь олон төхөөрөмжийг алсаас удирдан, нэгэн зэрэг халдлага хийх, мэдээлэл хулгайлахад ашигладаг цахим гэмт хэргийн хэрэгсэл юм.

²³ Distributed Denial of Service- Олон тооны компьютерууд нэгэн зэрэг зорилтот сервер, сүлжээ эсвэл вэбсайтад хүсэлт илгээнээр системийг хэт ачаалуулж, энгийн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх боломжгүй болгодог.

үйлчилгээг дарк вэбээр²⁴ дамжуулан бусдад санал болгож, тусгай мэдлэггүй этгээд ч гэмт хэргийг өндөр түвшинд үйлдэх боломж олгодог²⁵.

Олон улсад гэмт хэрэг үйлдэхэд түгээмэл ашиглаж буй технологиудаас заримыг нь товч танилцуулбал:

А. Deepfake- Дуу, дүрс, бичлэгийг хуурамчаар үүсгэх технологи

Deepfake гэдэг нь “deep learning” (гүнзгий суралцах) болон “fake” (хуурамч) гэсэн хоёр үгний нийлбэр бөгөөд хиймэл оюуны тусламжтайгаар хүний дүр төрх, дуу хоолойг хуурамчаар үүсгэх технологи юм. Deepfake нь нейрон сүлжээ буюу machine learning²⁶ ашиглаж, хүний дүр төрх, нүүрний хөдөлгөөн, дуу хоолойг маш нарийн судалж, бодит мэт хуурамч бичлэгийг үүсгэдэг. Ихэвчлэн GANs (Generative Adversarial Networks²⁷) гэх аргыг ашигладаг байна²⁸.

2019 онд Их Британид байрлах Герман компанийн салбарын захирал нь deepfake технологи ашиглан дуурайж ярьсан гар утасны дуудлагад итгэж 243.0 мянган еврог шилжүүлсэн байна²⁹. Тодруулбал, deepfake технологи ашиглан тус компанийн Европ дахь толгой компанийн гүйцэтгэх захирлын дуу хоолойг дуурайж, утсаар ярьснаар мөнгийг данс руу шилжүүлэн авчээ. Шилжүүлсэн мөнгө богино хугацаанд эхлээд Унгар, улмаар Мексик рүү дамжин гүйлгээгээр шилжсэн нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл учруулсан бөгөөд одоогоор уг гэмт хэргийг хэн үйлдсэн нь тогтоогдоогүй байна. Энэ тохиолдол нь deepfake технологи гэмт хэрэгт ашиглагдах бодит эрсдэлийг олон улсад анхлан харуулсан бөгөөд гэмт хэрэгтнүүд хиймэл оюунаар үүсгэсэн зураг, бичлэг төдийгүй дуу хоолойг ашиглан залилан хийх арга замаа хөнгөвчилж байна.

В. GPT- Урьдчилан бэлтгэгдсэн үүсгэгч, хувиргагч технологи

OpenAI компанийн 2018 онд анх бүтээж, танилцуулсан GPT (Generative Pre-trained Transformer) хэмээх чатбот нь хүний хэлний хэв шинж, утга зүйг өндөр түвшинд ойлгож, урьдчилан сургасан мэдээлэлд үндэслэн бичих чадвартай LLM (Large Language Model) бөгөөд хэрэглэгчийн асуултад хүнтэй төстэй байдлаар хариулж, төрөл бүрийн бичвэрийг үүсгэх чадвартай³⁰.

FraudGPT бол кибер гэмт хэрэгтнүүдийн зохион бүтээсэн, ChatGPT-ийн ёс зүйн болон аюулгүй байдлын хязгаарлалтыг давсан хувилбар юм. 2023 оны 7-р сард Netenrich-ийн аюулгүй байдлын судалгааны баг Telegram-аар дамжуулан худалдаалагдаж байхад нь анх олж илрүүлсэн. FraudGPT нь сард 200\$, жилд 1700\$ төлбөртэйгөөр фишинг имэйл бичих, вирус, хортой программ бүтээх, сул хамгаалалттай вэбсайтуудад нэвтэрч нууц үг, алдагдсан мэдээллийг олоход туслах, хакерийн зааварчилгаа өгөх гэх мэтээр гэмт хэрэг үйлдэхэд “туслах”-ын үүрэг гүйцэтгэдэг³¹.

Дээрхтэй төстэй бас нэгэн хувилбар болох WormGPT нь GPT-J хэлний загварт суурилсан, анх 2021 онд боловсруулагдсан. WormGPT нь ямар ч хэл, тэмдэгт, эможи, тусгай тэмдэгт зэргийг чөлөөтэй ашиглах боломжтой, өмнөх ярианы түүхийг санаж,

²⁴ Dark Web бол энгийн хайлтын системээр олддоггүй, тусгай программ хангамж ашиглаж хандах шаардлагатай хаалттай сүлжээ юм.

²⁵ Understanding Cybercrime-as-a-Service (CaaS), <https://register.bank/insights/cybercrime-as-a-service-overview/>, (last visited Apr.18, 2025).

²⁶ Компьютерийн туршлагаас суралцаж, өөрөө шийдвэр гаргаж сурах чадвартай болгох технологи юм. Тус технологийг ашиглан таны зан төлөвөөс суралцаж, танд тохирсон шийдвэр гаргаж, үзэх дуртай кино контент, видео бичлэгийг дахин дахин таны төхөөрөмжид гаргаж ирж буй үзэгдэл.

²⁷ Мөн тэнд, “GAN нь өрсөлдөөнт сургалтын зорилгоор бүтээгдсэн ухаалаг бүтэцтэй, буюу генератор (G) болон дискриминатор (D) хэмээх хоёр бүрэлдэхүүнтэй. Энэхүү аргыг ашиглан хүний нүүр, байгаль, хотын дүр зураг зэргийг хиймэлээр бий болгодог.”

²⁸ Liu, Yihao, Jinhe Huang, Yanjie Li, Dong Wang, and Bin Xiao, “Generative AI Model Privacy: A Survey”, *Artificial Intelligence Review* 58 (2025): 33, *springer.com*.

²⁹ Incident 200: Fraudsters Used AI to Mimic Voice of a UK-Based Firm’s CEO’s Boss, Last modified Mar.1, 2019, <https://incidentdatabase.ai/cite/200/>, (last visited Apr.16, 2025).

³⁰ Introducing GPTs, (Nov.6, 2023), <https://openai.com/index/introducing-gpts/>, (last visited Apr.17, 2025).

³¹ FraudGPT: The Villain Avatar of ChatGPT, Last modified Aug.3, 2023. <https://netenrich.com/blog/fraudgpt-the-villain-avatar-of-chatgpt> (last visited Apr.17, 2025).

хэрэглэгчтэй илүү уялдаатай харилцах боломжтой, текст болон кодыг тодорхой хэлбэрт оруулах боломжтой байдаг. Энэ загвар нь BEC (Business Email Compromise) буюу бизнес и-мэйл залилан зэрэг өндөр нөлөө бүхий халдлагыг боловсронгуй болгоход зориулагдсан³².

Гэмт этгээдүүд хууль бус үйлдэлд зориулагдсан хиймэл оюунаас гэмт хэрэг үйлдэх боломжит хамгийн сайн арга техникийг асууж, төлөвлөж, хэрэгжүүлэх замаар зардлаа хөнгөвчилж байгаа нь гэмт хэргийн гаралт нэмэгдэх шалтгаан болж байна.

IV. АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт ба тулгамдсан асуудал

Монгол Улс нь 2021 оны 12 дугаар сарын 17-нд “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг баталсан. Энэ хуулиар кибер аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлсон. Мөн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах боломж бүрдсэн³³. Тус хуулийн 4.1.1. “кибер аюулгүй байдал” гэж кибер орчинд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байхыг; 4.1.2. “кибер орон зай” гэж интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар гэж тодорхойлжээ³⁴. Мөн хуулийн зорилт нь кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэжээ. Үүнээс үзэхэд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээ нь мэдээлэл, мэдээллийн сангийн аюулгүй байдал, түүнтэй холбогдсон интернэт орчин, дэд бүтэц зэргээр хязгаарлагдаж байна.

2024 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр “Гадаад улсын гэмт бүлэглэлээс цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй залилах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Кибер аюулгүй байдлын зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн Ерөнхий газар, Монгол Банк” зэрэг байгууллагууд олон нийтэд сэрэмжлүүлэх, энэ гэмт хэргийн хохирлын талаар мэдээлэл хийсэн. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа С.Тайваны мэдээлснээр “Telegram залилангийн хамгийн өндөр дүнтэй хохирол нь 195.8 сая төгрөг бөгөөд гэмт этгээд зориудаар бэлтгэсэн найман данс руу 39 удаагийн үйлдлээр” шилжүүлсэн байна³⁵. Тус хэрэг нь цахим хэрэгсэл ашиглан их хэмжээний мөнгийг олон удаагийн үйлдлээр, зориудаар бэлтгэсэн данс руу шилжүүлж авсан үйлдлээрээ олон улсад deepfake зэрэг хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргүүдийн арга барилтай төстэй байна.

Монгол Улсад хиймэл оюуныг ашиглаж үйлчилгээ үзүүлдэг байгууллага, ААН-үүд байдаг. Гэвч хиймэл оюун болон түүнийг даган гарсан систем, технологи, олон төрлийн виртуал үйлчилгээнүүд зэргийг зохицуулсан хэм хэмжээ одоогоор байхгүй. Мөн хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэрэг бүртгэгдсэн эсэх талаар тодорхой статистик мэдээлэл байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг огт гардаггүй гэсэн үг биш, харин тодорхой хэм хэмжээгээр зохицуулаагүй учраас бүртгэх, илрүүлэх боломжгүй байгааг илтгэж байна.

³² Polra Victor Falade, “Decoding the Threat Landscape: ChatGPT, FraudGPT, and WormGPT in Social Engineering Attacks,” *International Journal of Scientific Research in Computer Science, Engineering and Information Technology* 9, no. 5 (Sep–Oct 2023): 188, [ijsrcseit.com](https://www.ijsrcseit.com).

³³ Монгол Улсын Их Хурал, “Инфографик: Кибер аюулгүй байдлын тухай хуулийн танилцуулга”, 2022, parliament.mn, (сүүлд хандсан 2025.04.17).

³⁴ Кибер аюулгүй байдлын тухай хууль, (2022), 4.1.1, 4.1.2, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он №8.

³⁵ Гадаад улсын гэмт бүлэглэлээс цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй залилах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Кибер аюулгүй байдлын зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Монгол банк зэрэг холбогдох байгууллагуудаас 2024 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн хэвлэлийн бара хурал, Cyber Crime Mongolia. Facebook. Accessed April 25, 2025. <https://www.facebook.com/cybercrimemongolia>.

Техник технологи асар хурдтай хөгжиж, хиймэл оюунд суурилсан олон үйлдэлт системүүд бий болж, хэрэглээнд нэвтэрч байгаа өнөө үед энэ харилцааг зөвхөн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалсан хэм хэмжээгээр зохицуулах нь хангалтгүй байна.

Гэмт этгээд хиймэл оюуны тусламжтайгаар өөрийн үйлдлийг хялбарчилж, гэмт хэрэг үйлдэхэд гарах зардлыг бууруулан, зорилгодоо хүрэх боломжийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн хиймэл оюуны тусламжтай үйлдэгдсэн гэмт хэрэг ул мөр багатай, орон зайнаас үл хамаарч үйлдэгдэх боломжтой зэрэг онцлогоос шалтгаалан илрүүлэхэд хүндрэлтэй хэвээр байна. Энэ нь зөвхөн үндэсний төдийгүй олон улсын эрүүгийн эрх зүйн томоохон сорилт, тулгамдсан асуудал мөн.

V. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

5.1.Европын холбооноос гаргасан Хиймэл оюуны тухай хуульд дүн шинжилгээ хийх нь

2021 оны 10-р сард Европын Парламент болон Европын Холбооноос эрүүгийн хууль болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хиймэл оюуны хэрэглэхтэй холбоотой тогтоол гаргасан³⁶. Тогтоолын зорилго нь хиймэл оюуныг гэмт хэрэгт ашиглахаас сэргийлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дижитал технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглахтай холбоотойгоор хүний үндсэн эрх, ёс зүйн зарчмуудыг хамгаалах, хиймэл оюунд суурилсан технологид хяналт тавих, олон нийтийг хамарсан аюултай технологийг хаах, хязгаарлах зэрэг тодорхой зохицуулалтыг хэрэглэх ёстой талаар дурджээ³⁷. Хиймэл оюун ашиглах боломжтой хэн бүхэн бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал болон үндсэн эрхүүдэд бодит хохирол учруулж, гэмт хэрэг үйлдэх өндөр эрсдэлтэй учир хиймэл оюуны хэрэглээнд эрсдэлийн үнэлгээ хийж, ямар нэгэн технологийн системийг хэрэглэхийн өмнө шинжлэх, тодорхой нарийн хэмжээ хязгаарыг тогтоох, аюулгүй үйл ажиллагааг хангах тухай хууль тогтоомжууд шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн.

Үүний дагуу Европын Холбоо “Хиймэл оюуны тухай хууль” (AI Act)-г 2024 оны 5-р сарын 21-нд баталсан бөгөөд дэлхийд анх удаа хиймэл оюуныг эрсдэлд суурилсан байдлаар зохицуулж буй цогц хууль болсон байна. Энэхүү хууль нь хиймэл оюуны системүүдийг эрсдэлийн түвшнээр ангилж, зохих үүрэг, хариуцлагыг тогтоосон³⁸. Хүний үндсэн эрхэд нөлөөлж буй байдлаар нь эрсдэлийг үнэлэх бөгөөд, нөлөөллийн үнэлгээний зорилго нь хиймэл оюуны системийг ашиглагч ААН, байгууллагууд системийг хэрэгжүүлснээр учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, эдгээр эрсдэл бодитой тохиолдсон бол авах арга хэмжээг урьдчилан бэлдэх гэжээ³⁹. Европын холбоо нь хиймэл оюуны системийг 1.Хэрэглэхийг бүрэн хориглосон эрсдэл (Unacceptable Risk), 2.Өндөр эрсдэл (High Risk), 3.Хязгаарлагдмал эрсдэл (Limited Risk), 4.Бага түвшний эрсдэл (Minimal Risk) гэж хуваан авч үзжээ.

Хиймэл оюуны тухай хууль (AI Act)-ийн 5 дугаар зүйлд “Хэрэглэхийг бүрэн хориглосон эрсдэлийг” зохицуулсан⁴⁰. Үүнд:

1. Хүнийг ухамсаргүйгээр удирдах, эсвэл зориуд төөрөгдүүлэх аргаар түүний зан үйлийг гажуудуулж, мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах чадварыг сулруулдаг хиймэл оюуны системийг;

³⁶ European Parliament, Resolution on Artificial Intelligence in Criminal Law and Its Use by the Police and Judicial Authorities in Criminal Matters (2020/2016(INI)), *Official Journal of the European Union*, C 132, (Mar.24, 2022).

³⁷ Ibid., Q(1–6).

³⁸ European Parliament and Council of the European Union, Regulation (EU) 2024/1689 of the European Parliament and of the Council of 13 March 2024 Laying Down Harmonised Rules on Artificial Intelligence (Artificial Intelligence Act) and Amending Certain Union Legislative Acts, *Official Journal of the European Union*, L 1689, (May 21, 2024).

³⁹ Ibid.

⁴⁰ European Union, Artificial Intelligence Act (Regulation (EU) 2024/1689), Chapter II, art. 5.

2. Хүний нас, хөгжлийн бэрхшээл, эсвэл нийгмийн болон эдийн засгийн онцгой нөхцөл байдлыг ашиглан, тэдгээрийн зан үйлийг гажуудуулах замаар хиймэл оюуны системийг зах зээлд гаргах, хэрэглэх нь тухайн эсвэл өөр хүнд бодит хохирол учруулж болзошгүй бол;
3. Гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг зөвхөн хувийн шинж чанар, зан үйлд үндэслэн дүгнэх хиймэл оюуны системийг хэрэглэх, тухайн систем нь зөвхөн хүний хувийн мэдээлэл дээр тулгуурласан бол;
4. Интернэт, камерын бичлэгүүдээс нүүр царайг системчилсэн байдлаар хураан аван, нүүр таних мэдээллийн санг үүсгэх, өргөжүүлэх зорилготой хиймэл оюуны систем ашиглах бол;

Эдгээр үйлчилгээг зах зээлд нийлүүлэх, ашиглахыг тусгай нөхцөлгүйгээр шууд хоригложээ.

Хуулийн 6 дугаар зүйл болон хавсралт 1,2,3 -т өндөр эрсдэлтэй (high risk) хиймэл оюуны хэрэглээг заасан. Тодруулбал, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хиймэл оюуны системийг зах зээлд нийлүүлэх тохиолдолд дараах хоёр нөхцөлийг зэрэг хангасан бол өндөр эрсдэлтэй гэж үзнэ. Үүнд:

1. Хиймэл оюуны систем нь тухайн бүтээгдэхүүний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байх тохиолдолд⁴¹,
2. эсвэл өөрөө бие даасан бүтээгдэхүүн байх тохиолдолд⁴² Хавсралт I-д заасан хууль тогтоомжийн дагуу зах зээлийн нийлүүлэлтэд оруулах зорилгоор хөндлөнгийн үнэлгээнд хамрагдсан байх шаардлагыг тавьдаг⁴³.

Хавсралт III-т зааснаар хүний талаарх профайл⁴⁴ (profiling) явуулах, боловсруулахыг үргэлж өндөр эрсдэлтэйд тооцох ба хиймэл оюуны системийг өндөр эрсдэлтэй биш гэж үзсэн нийлүүлэгчийн хувьд тухайн системийг зах зээлд нийлүүлэх буюу ашиглалтад оруулахаас өмнө үнэлгээний үр дүнг баримтжуулж нотлох үүрэгтэй байхаар заасан⁴⁵.

Цаашлаад, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хиймэл оюуны систем нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, эсвэл үндсэн эрхэд бодит эрсдэл учруулахгүй, хэрэглэгчийн шийдвэр гаргалтад мэдэгдэхүйц нөлөөлөхгүй бол өндөр эрсдэлтэйд тооцохгүй⁴⁶.

Эдгээр системийг шууд хориглохгүй ч өндөр шаардлага, үүрэг хариуцлагын дор нөлөөллийн үнэлгээ хийж, бүртгүүлснээр хэрэглэх боломжтой.

Хуулийн 50-р зүйлд тодорхой төрлийн хиймэл оюуны системийн ил тод байдал болон хэрэглэгчийг мэдээллээр хангах үүргийг тодорхойлжээ. Хиймэл оюуны системтэй харилцах үед хэрэглэгч тухайн систем нь хиймэл оюун гэдгийг мэдэх боломжтой байх, хиймэл оюунаар үүсгэсэн, өөрчилсөн контентод ил тод тэмдэглэгээ хийх шаардлагатай⁴⁷. Эдгээр шаардлага нь бага эрсдэлтэй буюу хэрэглэгчийн үйл ажиллагааг зөвхөн дэмжих, туслах зориулалттай системүүдэд хатуу үйлчлэхгүй бөгөөд ерөнхий байдлаар хамаарна⁴⁸.

⁴¹ Бүтээгдэхүүний ажиллах аюулгүй байдлыг шууд хангадаг, хяналт тавьдаг AI-г хэлнэ. Жишээ нь: Иргэний нисэхийн аюулгүй байдлын тухай журам (Civil Aviation Safety Regulation (EU) 2018/1139) -д заасан “Онгоцны нислэгийн үед хөдөлгүүрийн эвдрэл эсвэл системийн доголдлыг урьдчилан таамаглах AI систем”. Энэ нь осол гарахаас урьдчилан сэргийлж, нислэгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

⁴² Хиймэл оюуны систем өөрөө бие даасан бүтээгдэхүүн болохыг хэлнэ.

⁴³ Жишээ нь: Хавсралт I-д заасан Иргэний нисэхийн аюулгүй байдлын тухай журам (Civil Aviation Safety Regulation (EU) 2018/1139) -д “Хүний удирдлагагүйгээр нислэгийн чиглэл, өндрийн хяналт, саад илрүүлэлт, газардах зэрэг үйлдлийг хийх автономн дрон /Autonomous AI Dron/-ыг зах зээлд нийлүүлэхээс өмнө гуравдагч этгээдээр нислэгийн аюулгүй байдлын үнэлгээ хийлгэх шаардлагыг тавьдаг байна.

⁴⁴ Профайл (profiling) нь зөвхөн хувийн мэдээлэлд тулгуурладаг бус, тухайн мэдээллээр хүний зан төлөв, чадвар, сонирхол, байдал гэх мэт шинжийг дүгнэх, ангилах, урьдчилан таамаглах автомат үйл явцыг хэлдэг.

⁴⁵ Ibid., Chapter III, art. 6.3 Annex III.

⁴⁶ Ibid., Chapter III, art. 6. Annex II.

⁴⁷ European Union, Artificial Intelligence Act (Regulation (EU) 2024/1689), art. 50.

⁴⁸ Ibid.

Хуулийн 6 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор өндөр эрсдэлтэй болон бусад хиймэл оюуны систем, технологийг ашиглах боломжтой⁴⁹. Ингэхдээ “Цагдаагийн байгууллагад зориулсан тусгай зохицуулалт”-ыг мөрдөх ба хиймэл оюуныг ашиглах нь хэргийн оролцогчдын эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хэрэглэж буй системийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах процесс нь ил тод байх, зорилгодоо нийцсэн, хэмжээ хэтрээгүй байх, зарим тохиолдолд шүүхийн зөвшөөрөлтэйгөөр ашиглах зэрэг шаардлага тавьдаг⁵⁰.

Европын холбооноос баталсан тус хууль нь хиймэл оюуны олон төрлийн системийг эрсдэлээр нь ангилж, тохирох хяналтыг тавьснаар хэрэглэгчдийн үндсэн эрхийг хамгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна. Мөн цагдаагийн байгууллага гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан үндэслэл, зарчмын хүрээнд хиймэл оюуны давуу талыг хариу арга хэмжээ болгон ашиглахаар зохицуулсан нь инноваци болон хяналтын тогтолцоог тэнцвэржүүлж буй хэлбэр мөн гэж үзэж байна.

5.2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хиймэл оюунтай холбоотой эрх зүйн зохицуулалт

а.Хууль тогтоомжууд (урьдчилан сэргийлэх)

БНХАУ нь хиймэл оюуны хөгжлөөрөө тэргүүлэгч орнуудын тоонд зүй ёсоор багтах ба хиймэл оюуныг гэмт хэрэгт ашиглахтай тэмцэх хүрээнд Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай⁵¹, Өгөгдлийн аюулгүй байдлын тухай⁵², Кибер аюулгүй байдлын тухай⁵³ хуулиуд үйлчилж байна. Мөн БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын яам (САС)-аас хиймэл оюуны хэрэглээг зохицуулах зорилгоор дараах журмуудыг гаргасан.

1. “БНХАУ-ын Интернэт мэдээллийн үйлчилгээний алгоритмын санал болголтын зохицуулалтын журам”⁵⁴

TikTok, Taobao, WeChat зэрэг хүмүүсийн өдөр тутамдаа ашигладаг платформууд дээр бараа, үйлчилгээ, контент зэргийг сурталчлахдаа алгоритмд суурилсан “санал болгох систем” (recommendation system)-ийг өргөнөөр ашиглах болжээ. Энэ журам нь онлайн платформын хэрэглэгчдэд контент, мэдээ, видео, бараа, үйлчилгээг автоматаар санал болгох алгоритмын системүүдийг ил тод, шударга, аюулгүй ажиллуулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилготой.

Энэхүү журам үйлчилснээр WeChat, Soul, TikTok зэрэг платформууд дээр алгоритмын тохиргоог өөрчлөх, хаах функцүүд нэмэгдсэн⁵⁵. Энэ нь алгоритмын үйл ажиллагааны механизмын талаарх ойлголтыг нээлттэй, ил тод болгож, хэрэглэгчийн сонголт хийх эрх болон хувийн орон зайг хамгаалахад чухал ач холбогдолтой байна.

2. “БНХАУ-ын Интернэт мэдээллийн deep synthesis үйлчилгээний зохицуулалтын журам”⁵⁶

Хиймэл оюунд суурилсан дүрс, дуу, текст үүсгэх deep synthesis технологи эрчимтэй хөгжихийн хэрээр олон нийтэд хүрч буй контентын найдвартай байдалд ноцтой сорилт

⁴⁹ European Union, Artificial Intelligence Act (Regulation (EU) 2024/1689), art. 6; Annex III: 128

⁵⁰ European Union, Artificial Intelligence Act (Regulation (EU) 2024/1689), art. 82, Annex III.

⁵¹ 《中华人民共和国个人信息保护法》，2021年8月20日，https://www.gov.cn/xinwen/2021-08/20/content_5632486.htm（访问于2025年4月17日）。

⁵² 《中华人民共和国数据安全法》，2021年8月20日，https://www.gov.cn/xinwen/2021-06/11/content_5616919.htm（访问于2025年4月17日）。

⁵³ 《中华人民共和国网络安全法》，2021年8月20日，https://www.gov.cn/xinwen/2016-11/07/content_5129723.htm（访问于2025年4月17日）。

⁵⁴ 《互联网信息服务算法推荐管理规定》，2021年12月31日https://www.gov.cn/zhengce/zhengceku/2022-01/04/content_5666429.htm（访问于2025年4月17日）。

⁵⁵ “抖音、微信、Soul等都上线了这个功能：一键关闭算法推荐，将选择权交给用户”，China Daily. <https://tech.chinadaily.com.cn/a/202204/20/WS625fc5e9a3101c3ee7ad16c5.html>, (last visited Apr.18, 2025).

⁵⁶ 《互联网信息服务深度合成管理规定》，2022年11月25日，https://www.gov.cn/zhengce/zhengceku/2022-12/12/content_5731431.htm（访问于2025年4月17日）。

тулгарч байна. Энэ технологийг ашиглан зөвшөөрөлгүйгээр хүний дүр төрхийг ашиглах, гүтгэх, олон нийтийг төөрөгдүүлэх явдал ихээр гарч байгаа бөгөөд гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тохиолдол ч байна. Энэ журмын зорилго нь интернэт орчин дахь мэдээллийн үнэн бодит байдал, олон нийтийн итгэлийг хамгаалах, хүний хувийн мэдээлэл болон нийгмийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

Журмын 23 дугаар зүйлд тодорхойлсноор “Deep synthesis” гэдэг нь гүнзгий суралцах (deep learning), виртуал бодит байдал (virtual reality) зэргийг ашиглан үүсгэгч дарааллын алгоритм (generative sequencing algorithms)-аар текст, дүрс, аудио, видео, виртуал орчин зэрэг мэдээллийг үүсгэх технологийг хэлнэ. Үүнд дараах технологиуд мөн багтана:

1. Текст үүсгэх, засварлах технологи- (chatgpt, deepseek гэх мэт)
2. Дуу хоолой үүсгэх, засварлах технологи- (text-to-speech, voice conversion гэх мэт)
3. Дуу хоолойн бус аудио үүсгэх, засварлах технологи- (music generation, scene sound editing гэх мэт)
4. Дууны болон дуу, дүрсний дахь биометр шинж чанарыг үүсгэх, засварлах технологи- (нүүр үүсгэх, нүүр солих, хувийн шинжийг өөрчлөх, нүүр, биеийн хөдөлгөөнийг удирдах гэх мэт)
5. Дууны болон дуу, дүрсний биометр бус шинж чанарыг үүсгэх, засварлах технологи- (зураг үүсгэх, сайжруулах, нөхөн сэргээх гэх мэт)
6. Дижитал дүр, виртуал үзэгдэл үүсгэх, засварлах технологи- (3D дахин бүтээлт /3D reconstruction/, дижитал симуляци /digital simulation/ гэх мэт)⁵⁷

Контентын тэмдэглэгээ ба ил тод байдал- Deep synthesis-ээр үүсгэсэн контент нь “Хиймэл оюунаар бүтээгдсэн”, “synthesized content” гэх мэт ил тод тэмдэглэгээтэй байна. (16, 17) Эдгээр тэмдэглэгээг зориуд устгасан, нуусан бол хариуцлага хүлээх үндэслэл болно. (18)

Хувь хүний мэдээлэл ба зөвшөөрөл- Өгөгдөл нь хүний хувийн мэдээлэл агуулсан тохиолдолд Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль болон холбогдох журмуудыг дагаж мөрдөнө. Deep synthesis үйлчилгээ нь хүний царай, дуу хоолой гэх мэт биометр мэдээллийг ашиглах бол тухайн хүнд урьдчилан мэдэгдэж, тусгайлан зөвшөөрөл авах ёстой. (14)

Хяналт-шинжилгээ ба аюулгүй байдлын систем- Deep synthesis үйлчилгээ үзүүлэгч нь хууль бус Deepfake контентыг илрүүлэх автомат системтэй байх, сэжигтэй мэдээллийг устгах, засварлах, мэдээлэх дотоод журамтай байх, хэрэглэгч ба олон нийт гомдол, санал гаргах боломжтой ил тод сувгийг ажиллуулах шаардлагыг хангасан байна. (10, 12)

Зөрчил ба хариуцлага- Журмыг зөрчсөн тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид дараах байдлаар хариуцлага оногдуулна. Үүнд:

- Хуулийн дагуу торгууль ногдуулах, хууль бус контент хураах, үйлчилгээ явуулах эрхийг хязгаарлах,
- Кибер аюулгүй байдлын тухай, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай зэрэг хуулиар хариуцлага хүлээлгэх,
- Гэмт хэргийн шинжтэй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. (22)

3. “БНХАУ-ын Бүтээлч хиймэл оюун (Generative AI) үйлчилгээний зохицуулалтын түр журам”⁵⁸

Сүүлийн жилүүдэд хүний оролцоогүйгээр текст, дүрс, дуу, код болон видео контент үүсгэх чадвартай бүтээлч хиймэл оюун хурдацтай хөгжиж байна. Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлийн Үндэсний Хороо (ICPPCC)-ны мэдээлснээр 2021-2024 оны хооронд

⁵⁷ 《互联网信息服务深度合成管理规定》，第23条。

⁵⁸ 《生成式人工智能服务管理暂行办法》，2023年7月10日，https://www.cac.gov.cn/2023-07/13/c_1690898327029107.htm（访问于2025年4月17日）。

хиймэл оюунтай холбоотой нийт 1659 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний ихэнх нь бүтээлч хиймэл оюунтай холбоотой байжээ⁵⁹. Энэхүү түр журам нь Хятадын дотоодын зах зээлд энэ төрлийн хиймэл оюун ашиглаж үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг тогтоож, улсын аюулгүй байдал болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэн, хуулийн этгээд болон бусад байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн.

Ил тод байдал- Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан байна. (10) Үйлчилгээ үзүүлэгч нь зураг, видео зэрэг үүсгэсэн контентдоо тэмдэглэгээ хийх ёстой. Энэ нь хэрэглэгчид хиймэл оюунаар бүтээгдсэн гэдгийг нь ойлгуулах зорилготой. (12)

Үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам- Төрийн эрх мэдлийг үгүйсгэх, үндэсний эв нэгдлийг бусниулах, улс орны аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдалд халдах зэрэг хууль, тогтоомж зөрчсөн контент үүсгэж болохгүй. (4) Үйлчилгээ үзүүлэгч нь хууль зөрчсөн контент илрүүлсэн тохиолдолд тараахыг зогсоох, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авах мөн зохих төрийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. (14)

Зөрчил ба хариуцлага- Үйлчилгээ үзүүлэгч энэхүү журамд заасан зохицуулалтыг зөрчсөн бол:

- Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Өгөгдлийн аюулгүй байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн дэвшлийн тухай хууль гэх мэт хуульд заасан торгууль, шийтгэл оногдуулна.
- Хуулиар тусгайлан зохицуулаагүй бол сануулах, нээлттэй шүүмжлэх, тогтоосон хугацаанд зөрчлийг арилгахыг шаардах бөгөөд хэрэв энэ шаардлагыг биелүүлэхээс татгалзсан буюу зөрчил нь ноцтой бол үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авна.
- Зөрчил нь нийгмийн хэв журам зөрчсөн бол захиргааны шийтгэл,
- Гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (21)

Энэ нь бүтээлч хиймэл оюуныг зохистой, хариуцлагатайгаар ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн анхны иж бүрэн эрх зүйн баримт бичиг юм. Түр журам гэсний учир нь БНХАУ-ын Төрийн зөвлөл⁶⁰ 2023 оны Засгийн газрын хууль тогтоох ажлын төлөвлөгөөндөө Хиймэл оюуны тухай хуулийн төслийг багтаасан ба одоогоор хуулийн төсөл судалгааны шатандаа явж байна⁶¹.

в.Хиймэл оюуны эсрэг хиймэл оюун

БНХАУ нь хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хиймэл оюунд суурилсан тусгай системүүдийг төр, хувийн хэвшил хамтран хөгжүүлж байна. Эдгээрээс заримыг нь товч танилцуулбал:

- Baidu AI Content Forensics System- Хиймэл оюунд суурилсан агуулга хянах, шинжлэх систем юм. Энэхүү систем нь зураг, текст, аудио, видео зэрэг олон төрлийн мультимедиа агуулгыг автоматаар шалгаж, хууль бус, зохисгүй контентыг илрүүлэх, устгах зорилготой⁶².
- Alibaba Cloud Deepfake Detection- Хуурамч дуу, дүрс бичлэгийг (deepfake) илрүүлэх, таних зориулалттай шийдэл. Энэхүү технологийг аюулгүй байдал, цахим залилан, хуурамч мэдээлэлтэй тэмцэх зорилгоор хөгжүүлсэн⁶³.
- iFlytek Voiceprint Forensics- Дууны хээ (voiceprint) таних технологид суурилсан технологийн шийдэл. Хятадын засгийн газар iFlytek-ийн технологийг ашиглан

⁵⁹ 吕红兵，在沪全国政协委员吕红兵：加快制定有关生成式人工智能的行政法规，人民政协报，2025年4月7日，https://www.icppcc.cn/newsDetail_1151797（访问于2025年4月22日）。

⁶⁰ Төв Засгийн газар

⁶¹ 红兵，在沪全国政协委员吕红兵。

⁶² 百度，“ESG，” 百度 ESG，<https://esg.baidu.com>，（访问于2025年4月23日）

⁶³ ID Verification: FACE_DEEPFAKE, Alibaba Cloud Help Center, <https://www.alibabacloud.com/help/doc-detail/2881222.html>, (last visited Apr.23, 2025).

иргэдийн дууны хээг цуглуулж, үндэсний биометрийн өгөгдлийн сан байгуулах гэж байгаа талаар мэдээлсэн. Энэ нь иргэдийн эрхийг зөрчиж болохыг Хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллага (Human Rights Watch)-аас анхааруулсан байна⁶⁴.

Хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргийн ул мөрийг илрүүлэхэд хүндрэлтэй бөгөөд илүү сайн технологийг хөгжүүлж ашиглахаас өөр арга зам байхгүй. Гэвч энэ төрлийн технологийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглахдаа хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх шаардлагатай байна.

VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

Өмнө нь гэмт хэрэг үйлдэхийн тулд цаг хугацаа зарцуулж судалгаа хийх хэрэгтэй байсан бол FraudGPT, WormGPT гэх мэт хиймэл оюунд суурилсан чатботууд ашигласнаар “хуурамч имэйл бич” гэх мэтээр нэг л команд өгөхөд хангалттай болжээ. Гэмт бүлэглэлүүд хиймэл оюун ашиглан олон хүнтэй зэрэг харилцах, хуурамч имэйл илгээх, deepfake технологиор итгэл төрүүлэх зэргээр харилцаа холбоог автоматжуулж, илүү хурдтай, үр ашигтай ажиллах боломжтой болж байна. Нөгөөтгээгүүр хиймэл оюунаар бүтээгдсэн хуурамч дүр, бичлэг, кодлон нууцалсан мэдээлэл, дамжуулагч серверийн сүлжээ зэрэг нь гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг хүндрүүлж, хууль сахиулах байгууллагаас их хэмжээний хүний нөөц, цаг хугацаа, өндөр өртөгтэй техник, технологи шаардах болсон. Энэ мэтээр гэмт хэрэг үйлдэхэд гарах зардал буурч, эсрэгээрээ илрүүлэхтэй холбогдох зардал өсөж байгаа нь гэмт хэрэг үйлдэх сэдэл бий болоход нөлөөлж, гэмт хэргийн тоо өсөхөд хүргэж байна.

Харьцуулсан судалгаанаас дүгнэхэд олон улсад хиймэл оюуныг гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тохиолдолд “гэмт хэрэг үйлдэхэд ашиглах хэрэгсэл” гэж үзэж байна. Сүүлийн жилүүдэд, ялангуяа 2023 оноос хойш хиймэл оюуны тусламжтайгаар үйлдсэн гэмт хэргийн тоо эрчимтэй нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улсад хиймэл оюуныг тусгай хуулиар зохицуулах хандлагатай байна. Мөн холбогдох хууль, журам боловсруулахдаа системийн эрсдэлийг үнэлж, түүний хөгжилд саад учруулахгүй байх, хиймэл оюуны зохистой хэрэглээг хязгаарлалгүйгээр үр нөлөөтэй зохицуулахыг анхааруулж байна.

Дээр дурдсанчлан хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэрэг газар нутаг, орон зайнаас үл хамааран хаана ч гарах боломжтой. Монгол улс энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах тухай нэгдсэн бодлого, эрх зүйн зохицуулалтгүй тул харьцуулсан судалгаанд үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

а.Хиймэл оюуныг гэмт хэрэгт ашиглахтай тэмцэх хүрээнд:

1. Монгол улсад хиймэл оюунтай холбогдсон харилцааг тусгай эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах. Ингэхдээ эрсдэлийн үнэлгээг Европын холбоо болон БНХАУ-ын жишгээр 1. хэрэглэхийг бүрэн хориглосон эрсдэл, 2. өндөр эрсдэл, 3. хязгаарлагдмал эрсдэл, 4. доод эрсдэл гэх мэтчилэн шатлалтайгаар нарийвчлан ангилах;
2. Европын холбооны Хиймэл оюуны тухай хуулиар хиймэл оюун бүтээгч, хөгжүүлэгч аж ахуй нэгжүүд хэрэглэгчид учрах эрсдэлийг үнэлэх, эрсдэл гарвал хэрхэн арга хэмжээ авах хяналт төлөвлөгөөг боловсруулсан байдалд үндэслэн эрсдэлийг Европын холбооны ажлын хэсэг үнэлэх тухай заасан. Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий Кибер аюулгүй байдлын зөвлөл дээр дурдсан хиймэл оюуны системийг үнэлэх ажлыг хийж гүйцэтгэх

⁶⁴ China: Voice Biometric Collection Threatens Privacy, *Human Rights Watch*, <https://www.hrw.org/news/2017/10/22/china-voice-biometric-collection-threatens-privacy>, (last visited Apr.23, 2025).

3. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж, хиймэл оюуны үйлчилгээ бүрд хяналт, хариуцлагыг ялгамжтайгаар зохицуулах.

б. Хиймэл оюун ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх хүрээнд:

1. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт хиймэл оюун ашиглан үйлдсэн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх чиг үүрэг бүхий институцийг бий болгож, мэргэшүүлэх
2. Олон улсын жишгээр хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд тусгай систем хөгжүүлж, ашиглаж байгаа тул Монгол улсад мөн энэ төрлийн системийг хөгжүүлэх, ашиглах;
3. Хиймэл оюун ашиглаж үйлдсэн гэмт хэргийг эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл болгож Эрүүгийн хуульд тусгах. Ингэхдээ бодит хохирол учирсан, хохирлын хэмжээ их байхаар хязгаарлаж, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарах.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх эх сурвалж****А. Эрх зүйн эх сурвалж**

1. Монгол Улсын Их Хурал. Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021 он.

Б. Ном, сурах бичиг

1. Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, 2011 он.
2. Г.Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс: Ерөнхий анги, 1973 он.
3. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги, 1999 он.
4. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, 2009 он.

Гадаад хэл дээрх эх сурвалж**А. Англи хэл дээр**

1. Becker, Gary S. "Crime and Punishment: An Economic Approach." National Bureau of Economic Research, 1968. nber.org.
2. Benson, Bruce L. "Privatization and Community in Criminal Justice." The Urban Lawyer 32, no. 1 (Winter 2000): 167–169. jstor.org.
3. C.R.Jeffery, "Criminal Behavior and Learning Theory," Journal of Criminal Law & Criminology 56, no. 3 (Sep.1965): 294-295. scholarcommons.law.northwestern.edu/jclc
4. Coase, Ronald H. "The Nature of the Firm." 1937. econdse.org.
5. Cornish, Derek B., and Ronald V. Clarke. The Reasoning Criminal: Rational Choice Perspectives on Offending. Transaction Publishers, 2014.
6. European Parliament and Council of the European Union. Regulation (EU) 2024/1689 of the European Parliament and of the Council of 13 March 2024 Laying Down Harmonised Rules on Artificial Intelligence (Artificial Intelligence Act) and Amending Certain Union Legislative Acts.
7. European Parliament. Resolution on Artificial Intelligence in Criminal Law and Its Use by the Police and Judicial Authorities in Criminal Matters (2020/2016(INI)).
8. Falade, Polra Victor. "Decoding the Threat Landscape: ChatGPT, FraudGPT, and WormGPT in Social Engineering Attacks." International Journal of Scientific Research in Computer Science, Engineering and Information Technology 9, no. 5 (Sep–Oct 2023): 188. ijsrseit.com.
9. Liu, Yihao, Jinhe Huang, Yanjie Li, Dong Wang, and Bin Xiao. "Generative AI Model Privacy: A Survey." Artificial Intelligence Review 58 (2025): 33. springer.com.
10. North, Douglass C. Institutions, Institutional Change and Economic Performance. 1990. cambridge.org.
11. Williamson, Oliver E. The Economic Institutions of Capitalism. 1987. jstor.org

Б. Хятад хэл дээр

1. 中华人民共和国.《个人信息保护法》. 2021年8月20日.
2. 中华人民共和国.《数据安全法》. 2021年8月20日.
3. 中华人民共和国.《网络安全法》. 2021年8月20日.
4. 国家互联网信息办公室等.《互联网信息服务算法推荐管理规定》. 2021年12月31日.
5. 国家互联网信息办公室等.《互联网信息服务深度合成管理规定》. 2022年11月25日.
6. 国家互联网信息办公室等.《生成式人工智能服务管理暂行办法》. 2023年7月10日.

Цахим эх сурвалж

1. “Motivation.” APA Dictionary of Psychology. American Psychological Association. Accessed October 29, 2025. <https://dictionary.apa.org/motivation>
2. China: Voice Biometric Collection Threatens Privacy 2017. Хүний эрхийн хяналт: <https://www.hrw.org>.
3. FraudGPT: The Villain Avatar of ChatGPT. 2023. <https://netenrich.com>.
4. Incident 200: Fraudsters Used AI to Mimic Voice of a UK-Based Firm’s CEO’s Boss. 2019. Хиймэл оюуны мэдээллийн систем: <https://incidentdatabase.ai>.
5. Internet Organised Crime Threat Assessment (IOCTA) 2024. Европын Холбооны Хууль Сахиулах Байгууллагуудын Хамтын Ажиллагааны Агентлаг: <https://www.europol.europa.eu>.
6. Schwab, Klaus. “The Fourth Industrial Revolution: What It Means and How to Respond.” World Economic Forum, 2016. Дэлхийн эдийн засгийн форум: <https://www.weforum.org>
7. Understanding Cybercrime-as-a-Service (CaaS) 2025. <https://register.bank>
8. Инфографик: Кибер аюулгүй байдлын тухай хуулийн танилцуулга, 2022. Монгол Улсын Их Хурал: <https://www.parliament.mn>.
9. 在沪全国政协委员吕红兵：加快制定有关生成式人工智能的行政法规， 2025. <https://www.icppcc.cn>.
10. 抖音、微信、Soul等都上线了这个功能：一键关闭算法推荐，将选择权交给用户. China Daily: <https://tech.chinadaily.com.cn>.

CRIME AND ARTIFICIAL INTELLIGENCE***Darkhanbold.O****Master of Law (LL.M.),
Lecturer, School of Law,
NUM****Ariunzaya.D****(Bachelor's student),
School of Law, NUM****Uuriintuya.M****(Bachelor's student),
School of Law, NUM***ABSTRACT:**

According to Europol's 2024 report, crimes committed through the use of Artificial Intelligence (AI) increased dramatically. Specifically, in 2023, 70% of all reported phishing and online fraud crimes were committed with the assistance of AI. Crimes based on deepfake technology increased 2.5 times across Europe. In 2021, Mongolia enacted a law on cybersecurity and established the Cybercrime Division under the General Police Department. Yet, there is a lack of legal regulation addressing the criminal use of AI, and the response measures against such crimes remain insufficient. This article examines the international approaches and actions that are being taken to prevent and detect the criminal use of AI.

KEYWORDS:

AI, risk assessment, crime cost, crime probability, cyber security

ЭМИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



П.Өлзийтогтох

*ДХИС-ийн Гэмт явдал судлалын докторант,
цагдаагийн дэд хурандаа*

ТОВЧЛОЛ:

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зөвшөөрөлгүй, хяналтгүйгээр эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, эм импортлох, хугацаа нь дууссан, бүртгэлгүй эмийг гар дээрээс худалдах, түгээх явдал хавтгайрснаас хуурамч эм хэрэглэсэн иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна. Сүүлийн жилүүдэд эм, эмнэлгийн хэрэгслээс гадна эмийн түүхий эд, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг иргэн, хуулийн этгээд ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр импортлох, худалдах болж, тэдгээрийн чанар хангалтгүй байгаа талаар мэдээлэл гарах болсон.

Ийнхүү өндөр ашиг орлого дагуулдаг энэ салбарт хуурамч болон зөвшөөрөлгүй эмийн үйлдвэрлэл, худалдаа, импорт, экспорт нэмэгдэж, Монгол Улсад гарал үүсэл нь тодорхойгүй, зөвшөөрөгдөөгүй, бүртгэлгүй, хуурамч, чанаргүй эмийн эргэлт олширсоор байна. Хуурамч эмийн эргэлт нь зөвхөн манай улсад биш дэлхийн олон улс гүрнүүдийн удирдлага төдийгүй эрүүл мэндийн байгууллага, эмч ажилтан, өвчтөн, эмчлүүлэгч бүрийн санаа бодлыг чилээсэн асуудал болсоор байна.

Иймд энэхүү илтгэлд эмийн хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг судалж, уг төрлийн гэмт хэргийн агуулга, эрх зүйн шинж чанар, нийгмийн хор аюулыг дэлгэрэнгүй шинжилж, хуулийн хийдэл, зохицуулалтын онцлог болон хэрэгжилтийн бодит байдлыг дахин дүн шинжилгээ хийж, холбогдох нэмэлт мэдээлэлд тулгуурлан судалгааг боловсронгуй болгон, цаашид эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГС:

Эмийн эргэлт, хууль бус, гэмт хэрэг.

I.ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуульд “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно”¹, “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг

¹ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг

сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”², Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “...Эмнэлгийн хэрэгсэл, эм, вакцин, био бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортод тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, биотехнологийн цогцолбор байгуулах замаар чанар, аюулгүй байдлыг хангана”³, “...Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах цогц бодлогын салшгүй хэсэг байна”⁴ гэж тус тус заасан.

Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд Монгол Улсад үйлдвэрлэх, импортлох-ханган нийлүүлэх, худалдах эм, эмийн үйлчлэгч бодис нь энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд бүртгэлтэй байна⁵, Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүсэлт, баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн уг бүтээгдэхүүнийг бүртгэнэ⁶. Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг тухай бүр /LicimedWeb/ бүртгэн, шинэчилнэ гэж заасан.

Нийгмийн эрүүл мэндийн салбарын үндсэн үүргүүдийн нэг бол хүн амыг чанартай, аюулгүй үр дүнтэй эмээр хангах асуудал байдаг. Харамсалтай нь үүний эсрэг талд стандартын бус, хуурамч эмийн эргэлт, хэрэглээ нь үргэлж сүүдэр мэт оршин тогтноод зогсохгүй эмийн зах зээлийн хууль ёсны эргэлтэд орсоор байна.⁷

Эмийн хууль бус эргэлт нь зөвхөн Монгол Улсад тулгараад байгаа асуудал биш бөгөөд хууль бусаар хар тамхи, мансууруулах бодис болон зэвсгийн худалдааны дараа ашиг орлогоороо Дэлхийд 3 дугаар байранд ордог хууль бус бизнес болох талаар судлаачид⁸ дурдсан.

Эмийн хууль бус эргэлтийг дэлхий нийтийн өмнө тулгарсан асуудал болохыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 1951 оны хуралдаанаар хэлэлцэн, тусгаар улс бүр өөр өөрийн нутаг дэвсгэртээ эмийн чанар, стандартад хяналт тавих шаардлагыг сайжруулах талаар чиглэл өгч байсан ч үр дүнд хүрэлгүй хэдийн хагас зуун жилийг туулжээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хийсэн судалгаагаар эмийн хууль бус эргэлтийн шалтгааныг:

- Эмийн хууль бус эргэлттэй тэмцэх хууль эрх зүйн орчин хангалтгүй;
- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрх зүйн актыг хэрэглэх чадвар хангалтгүй;
- Эмийн хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний байгууллагуудын хамтын ажиллагаа муу, эдийн засгийн эх үүсвэр бага, мэргэшсэн алба хаагчид байхгүй;
- Эмийн хууль бус эргэлтэд оногдуулж байгаа үндэсний эрх зүйн ял шийтгэлийн бодлого оновчтой бус;
- Эмийг хууль ёсоор үйлдвэрлэх, экспортлох, импортлох олон үе шаттай ажиллагааны зардал ихэссэн;
- Тусгаар улсуудын хил, гааль, шүүх гэх мэт байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байх;
- Эмийн хууль бус үйлдвэрлэлийн нөхцөл байдал, техник хэрэгсэл хэт сайжирсан явдал гэж үзсэн.

² МУҮХ-ийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

³ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-ын 3.4 дүгээр зүйлийн 1.12 дахь хэсэг

⁴ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2024)-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг

⁵ ЭЭХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг

⁶ ЭЭХТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг

⁷ Г.Мөнгөншагай, “Эмийн хууль бус эргэлт: тулгамдаж буй асуудал, урьдчилан сэргийлэх арга зам” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (Улаанбаатар: Гурванцагийн өнгө, хэвлэлийн компани, 2019) 9 дэх тал.

⁸ Б.Эрдэнэбат, “Эмийн хууль бус эргэлт: тулгамдаж буй асуудал, урьдчилан сэргийлэх арга зам” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (Улаанбаатар: Гурванцагийн өнгө, хэвлэлийн компани, 2019) 91 дэх тал

Уг судалгаа зөвлөмжийн дагуу тусгаар улс бүр эмийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар бодлого баримталж байна.⁹ Гэтэл сүүлийн жилүүдэд Монгол Улсад хууль бус эм, эмийн бүтээгдэхүүний эргэлт нэмэгдэж, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул учруулж байна.

Иймд Монгол Улсад эмийн зохистой хэрэглээ, чанар, аюулгүй байдалд анхаарах нь эрүүл мэндийн тогтолцооны чухал асуудал бөгөөд Монголын ард иргэдийн Үндсэн хуульд заасан дээрх эрх зөрчигдөж байна.

Энэхүү сэдвийн өмнө нь судлагдсан байдлыг авч үзвэл, Ц.Бадамцэцэгийн “Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал” (2013), А.Азжаргалын “Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээлүүд, Н.Нарангаравын “Хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн өнөөгийн байдал анхаарах асуудал” (2009), Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн, 30 (№4), 30 дугаарын өгүүлэл, Хууль зүйн ухааны магистр, цагдаагийн дэд хурандаа П.Өлзийтогтохын “Эмийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн түүхэн уламжлал” сэдэвт өгүүллийг “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүлийн 2025 оны №01 (41) дугаарт тус тус хэвлүүлсэн байна.

Монгол Улсад эмийн хууль бус эргэлтийн асуудлыг эрх зүйн үүднээс судалсан судалгаа харьцангуй цөөн байгааг дээрх бүтээлүүд харуулж байна. Эдгээр бүтээлд эмийн хууль бус эргэлтийн ойлголт, гэмт хэргийн ерөнхий шинж, эрүүгийн хариуцлагын асуудлыг тодорхой хэмжээнд авч үзсэн. Гэсэн хэдий ч эдгээр судалгаанууд нь тухайн үеийн хууль тогтоомжид тулгуурласан, зарим тохиолдолд зөвхөн онолын хүрээнд хязгаарлагдсан шинжтэй бөгөөд хууль тогтоомжийн шинэчлэл, гэмт хэргийн хэлбэрийн өөрчлөлт, практикт тулгамдаж буй хэрэгжилтийн асуудлыг иж бүрэн хамарч чадаагүй байна.

Түүнчлэн эмийн түүхий эд, био бэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний хууль бус импорт, худалдаа, тэдгээрт хамаарах эрх зүйн зохицуулалтын онцлог, хуулийн хийдэл, хэрэгжилтийн зөрчлийг тусгайлан судалсан судалгаа хомс байгаа нь анхаарал татаж байна. Иймд эмийн хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг гэмт хэргийн агуулга, нийгмийн хор аюул, хуулийн зохицуулалтын онцлог болон хэрэгжилтийн бодит байдалтай уялдуулан дахин судлах зайлшгүй шаардлага бий болсон.

II.ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсад эм болон эмийн хууль бус эргэлттэй тэмцэх асуудлыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна. Үүнд: Эрх зүйн баримт бичиг:

2.1.Хууль (цагаан толгойн үсгийн дарааллаар)

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр)
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2014 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр)
3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай (2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр)
4. Гаалийн тухай хууль (2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр)
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/ (2019 оны 06 дугаар сарын 06-ний өдөр)
6. Дархлаажуулалтын тухай (2000 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр)
7. Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ (2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр)
8. Зар сурталчилгааны тухай (2002 оны 05 дугаар сарын 30-ны өдөр)
9. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай (2004 оны 02 дугаар сарын 15-ны өдөр)

⁹ Мөн тэнд.

10. Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр)

11. Зөрчил шалган шийдвэрлэх тухай (2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр)

12. Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр)

13. Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр)

14. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2013 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр)

15. Хилийн тухай /Шинэчилсэн найруулга/ (2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр)

16. Хүнсний тухай хууль (2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр)

17. Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай (2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр)

18. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр)

19. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай (2011 оны 05 дугаар сарын 26-ны өдөр)

20. Монгол Улсын Үндсэн хууль (1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр)

21. Үндэсний аюулгүй байдлын тухай (2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр)

22. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай (2008 оны 05 дугаар сарын 22-ны өдөр)

23. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай (2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр)

24. Эрүүл мэндийн тухай хууль (2011 оны 05 дүгээр сарын 05-ний өдөр)

25. Эрүүл мэндийн даатгалын тухай (2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр)

26. Эрүүл ахуйн тухай (2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр)

27. Эрүүгийн хууль (2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр)

2.2. Уйх-ын тогтоол

1. “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

3. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого (2014 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 57 дугаар тогтоол)

4. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай (2001 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 81 дүгээр тогтоол)

2.3. Засгийн газрын тогтоол

1. Агентлаг байгуулах тухай-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоол)

2. Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай (Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт) (2019 оны 219 дүгээр тогтоол)

3. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт) (2003 оны 196 дугаар тогтоол)

4. Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам (2002 оны 219 дүгээр тогтоол)

5. Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай (2013 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 425 дугаар тогтоол)

6. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай (2011 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 73 дугаар тогтоол)

2.4. Сайдын тушаал

1. Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаал)
2. Бүртгэлийн болон GMP-ын шинжээч ажиллуулах журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 225 дугаар тушаал)
3. Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газрын ажиллах журам (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 284 дугаар тушаал)
4. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэн мэдээлэх, тандах журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаал)
5. Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дахь, Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 3 дахь жагсаалт шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/197 дугаар тушаал)
6. Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/184 дүгээр тушаал)
7. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал)
8. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/28 дугаар тушаал)
9. Монгол улсын үндэсний фармакопейд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/219 дугаар тушаал)
10. Өнчин эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 271 дүгээр тушаал)
11. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/30 дугаар тушаал)
12. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2017 оны А/301 дугаар тушаал)
13. Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/203 дугаар тушаал)
14. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн эрүүл мэндийн салбарт хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөө (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/289 дугаар тушаал)
15. Фармакопей боловсруулах, батлах, дугаар өгөх, фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 132 дугаар тушаал)
16. Хяналтын байцаагчийн эрх, албаны болон хувийн дугаар олгох тухай (Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/88 дугаар тушаал)
17. Хлорт фторт нүүрстөрөгч агуулсан ингаляци хэлбэрийн эмийн бүртгэлийг зогсоох тухай (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 217/259 дүгээр тушаал)
18. Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2015 оны 30 дугаар тушаал)
19. Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/144 дугаар тушаал)
20. Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам (Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/225/А/153/А/85 дугаар тушаалын хавсралт)
21. Цахимаар эмийн жор бичих, олгох заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/495 дугаар тушаал)

22. Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал)

23. Эмийн гаж нөлөөг мэдээллийг бүртгэх, мэдээлэх, үнэлэх тайлагнах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/67 дугаар тушаал)

24. Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 33 дугаар тушаал)

25. Эмийн жор цахимаар бичих, олгох түр заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/521 дугаар тушаал)

26. “Эмнэл зүйн туршилт явуулах, судалгаа, шинжилгээний зорилгоор хүний цус, цусан бүтээгдэхүүн, биологийн шингэн, эд, эрхтэн авах, хэрэглэх журам” (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/526 дугаар тушаал)

27. Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/190 дүгээр тушаал)

28. Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлын программыг нэвтрүүлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/19 дүгээр тушаал)

29. Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дүгээр тушаал)

30. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам батлах (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаал)

31. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам (ЭМС-ын 2017 оны А/493 дугаар тушаал)

32. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам (ЭМС-ын 2018 оны А/344 дүгээр тушаал)

33. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (ЭМС-ын 2018 оны А/345 дугаар тушаал)

34. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (ЭМС-ын 2021 оны А/464 дүгээр тушаал)

35. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дүгээр тушаал)

36. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам ЭМС-ын 2025 оны А/206 дугаар тушаал)

37. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаал)

38. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигт тавигдах шаардлага (Эрүүл мэндийн сайдын 2023 оны 100 дугаар тушаал)

39. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай (Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/363 дугаар тушаал)

40. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай (Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/50 дугаар тушаал)

41. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай (Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/97 дугаар тушаал)

42. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/46 дугаар тушаал)

2.5. Гаалийн ерөнхий газрын даргын тушаал

1. “Барааг хүлээн авахаас татгалзах горим хэрэгжүүлэх журам”-1, “Бараа устгах горим хэрэгжүүлэх журам”-2, “Улс хоорондын тээврийн үйлчилгээний барааг нэвтрүүлэх горим хэрэгжүүлэх журам (ГЕГ-ын даргын 2008 оны 680 дугаар тушаал)

2. Бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн тэмдэглэгээ хэрэглэх журам (ГЕГ-ын даргын 2008 оны 756 дугаар тушаал)

3. Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам» 1 дүгээр, «Барааг дотоодод дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам» 2 дугаар, «Барааг шилжүүлэн ачих гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам» 3 дугаар хавсралт (ГЕГ-ын даргын 2008 оны 679 дугаар тушаал)

4. Гаалийн хууль тогтоомж зөрчсөн болон зөрчихийг завдсан үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журам” 1 дүгээр, “Мэдээлэл бүртгэх маягт”-ын загвар 2 дугаар хавсралт/ (ГЕГ-ын даргын 2008 оны 618 дугаар тушаал)

5. Бараа, тээврийн хэрэгслийг саатуулах журам (ГЕГ-ын даргын 2008 оны 536 дугаар тушаал)

6. Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам (ГЕГ-ын даргын 2009 оны 362 дугаар тушаал)

7. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам (ГЕГ-ын даргын 2016 оны А/40 дугаар тушаал)

8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журам (ГЕГ-ын даргын 2016 оны А/81 дугаар тушаал)

9. Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам (ГЕГ-ын даргын 2016 оны А/41 дугаар тушаал)

10. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн Үндсэн маягт 1 дүгээр, Нэмэлт маягт 2 дугаар, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн хавсралт” 3 дугаар, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар” 4 дүгээр, “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар” 5 дугаар хавсралт/ (ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаал)

11. Барааны экспорт импортын статистикийн мэдээлэл» эмхтгэл, статистикийн мэдээлэл лавлагаагаар үйлчлэхэд авах төлбөрийн хэмжээ тогтоох журам (ГЕГ-ын даргын 2018 оны А/149 дугаар тушаал)

12. Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам, Зорчигчийн гаалийн мэдүүлгийн маягт (ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаал)

13. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам (ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаал)

14. Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам (ГЕГ-ын даргын 2022 оны А/25 дугаар тушаал)

15. Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур (ГЕГ-ын даргын 2022 оны А/338 дугаар тушаал)

16. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт (ГЕГ-ын даргын 2022 оны А/145 дугаар тушаал)

17. Бараанаас сорьц, дээж, загвар, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах (ГЕГ-ын даргын 2024 оны А/422 дугаар тушаал)

2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын тушаал

1. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын батламж олгох журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны А/168 дугаар тушаал)

2. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/236 дугаар тушаал)

3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, Биологийн идэвхт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар эрт сэрэмжлүүлэх түүнийг эргүүлэн татах журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/237 дугаар тушаал)

4. Эм, Биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/236 дугаар тушаал)

5. Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын бүртгэл олгох журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны А/249 дүгээр тушаал)

6. Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд тандалт, судалгаа хийх журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны А/32 дугаар тушаал)

2.7. Монгол улсын стандарт

1. Биобэлдмэлийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-2:2014

2. Уламжлалт эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-3:2015

3. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS/ISO 17025

4. Фармакопейн өгүүлэл боловсруулах арга зүй. MNS 5763:2015

5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага. MNS 5530:2014

6. Эмийн идэвхт бодис ба эмийн тогтвортой чанарын судалгаанд тавих ерөнхий шаардлага. MNS 6439:2014

7. Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-1:2014

8. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага. MNS 5260:2015

9. Эмийн анхдагч савлалтын материалд тавих ерөнхий шаардлага. MNS 6622-2016

10. Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт MNS 5376:2016

11. Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага. MNS 6621-2016

12. Эмнэлгийн цахилгаан тоног, төхөөрөмж, 2-25-р хэсэг: Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагаанд тавих шаардлага MNS/IEC 60601-2 25:2019

13. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмж. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжийн ээлжит болон засварын дараах туршилт MNS IEC 62353:2019 зэрэг болно.

III. ХУУЛИЙН ХИЙДЭЛ

НЭГДҮГЭЭРТ: Эмийн хууль бус эргэлттэй холбоотой хууль бус үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих, Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйл, Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах зүйл ангиар зөрчлийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж байна.

Нэрлэгдсэн халдлагын зүйлийг хуульд зааснаар тодорхойлвол:

- “эм” гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зориулалттай, хүний физиологийн үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдэл нь эм судлал, эмнэлзүйн туршилтаар нотлогдсон, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг, тодорхой хэлбэртэй бүтээгдэхүүнийг;¹⁰

- “уламжлалт эм” гэж уламжлалт анагаах ухааны эх сурвалжид үндэслэн байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн тодорхой тун, хэмжээ бүхий эмийг;¹¹

- “биобэлдмэл” гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зориулалтаар амьд бие, эд, эсээс үйлдвэрлэлийн болон биотехнологийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүн болон вакциныг;¹²

- “эмнэлгийн хэрэгсэл” гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, хянах, хүний бие махбодын үйл ажиллагааг дэмжих, орлох, нөхөн сэргээх, сэргээн засах, эмнэлгийн хэрэгслийг ариутгах, халдваргүйжүүлэх зорилгоор хэрэглэгдэх дараах

¹⁰ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг

¹¹ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дах хэсэг

¹² ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дах хэсэг

бүтээгдэхүүнийг:¹³

- “хуурамч эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэж гарал үүсэл, гадна байдал, найрлага, хэлбэр, шошго, цувралыг хууль бусаар дуурайлган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;¹⁴

- “эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэж хүний бие махбодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой хэлбэр, тунгаар хүнснээс гадна нэмэлтээр хэрэглэх байгалийн болон нийлэг гаралтай, тарилгаас бусад хэлбэрийн бүтээгдэхүүнийг¹⁵ ойлгоно гэжээ.

Монгол Улсад 2024 оны жилийн эцсийн байдлаар 6 уламжлалт эмийн үйлдвэр¹⁶ байгаа бөгөөд энэ нь нийт эмийн үйлдвэрийн 22 хувийг эзэлж байна.

Дотоодын 18 үйлдвэр 2024 онд үйл ажиллагаа явуулж нийт 122.1 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 121.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

2024 онд эмийн үйлдвэрүүд нийт 615 нэр төрлийн эм үйлдвэрлэснээс 265 нэрийн эм (43%), 46 нэрийн эмнэлгийн хэрэгсэл (7%), 24 нэр төрлийн Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн (4%), 251 нэрийн уламжлалт эм (41%), 29 нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис (5%) үйлдвэрлэсэн байна¹⁷. Монгол Улсаас 3 ханган нийлүүлэх байгууллага Бүгд Найрамдах Унгар улс болон Бүгд найрамдах Польш улс руу уламжлалт эмийг экспортолж байна гэсэн мэдээлэл байна.

Манай Улс уламжлалт аргаар бэлдсэн, хүний эрүүл мэндэд ач холбогдолтой, тодорхой төрлийн өвчнийг илааршуулахад чадалтай хэмээн мал, амьтны эсхүл ургамлын гаралтай “ТАН” гэх нэршилтэй уламжлалт эмийг амьдрал ахуйдаа хэрэглэж байна.

Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд 1.Хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.¹⁸

2.Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах, түгээх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр явуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Эрүүгийн хуульд зөвхөн Хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн үйлдлийг, Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах, түгээх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр явуулсан бол гэмт хэрэгт тооцохоор байна.

¹³ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дах хэсэг

¹⁴ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дах хэсэг

¹⁵ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх хэсэг

¹⁶ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын цахим хуудас <https://mmra.gov.mn>

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Эрүүгийн хууль (2015)-ийн Тусгай ангийн 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Тэгвэл Уламжлалт эмийг зөвшөөрөлгүй үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн үйлдлийг хуулиар зохицуулаагүй, Зөрчлийн тухай хуульд зөвхөн "...Эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортолх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, хүлээх үүрэг, хуулиар хориглосон зүйл, стандарт, тогтоосон журам, шинэ эм бүтээх, хэрэглээнд гаргахад тавих нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол",¹⁹ Эм, уламжлалт эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, хүлээх үүрэг, хуулиар хориглосон зүйл, стандарт, тогтоосон журмыг зөрчсөн бол" гэж заасан.


Уг хуулийн зохицуулалтаас үүдэн уламжлалт эмийг зөвшөөрөлгүй үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсний улмаас бусдад хор уршиг учирсан тохиолдолд ямар хуулиар хариуцлага хүлээх нь тодорхой бус байна.

Иймд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд уламжлалт анагаах ухааны эх сурвалжид үндэслэн байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн тодорхой тун, хэмжээ бүхий эмийг хэлнэ гэж тодорхойлогдсон бидний өвөг дээдсээс уламжлан амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн, хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй, эмийн адил үйлчилгээтэй Уламжлалт эм/эсхүл тан/ гэх нэршилтэй, шинжлэх ухааны хувьд эмчилгээний эсхүл аливаа өвчний эсрэг үйлчлэл нь батлагдаагүй уламжлалт эмийг хувиараа бэлтгэн хууль бусаар борлуулж буй үйлдлийг хуулиар зохицуулах шаардлага үүсч байна.

ХОЁРДУГААРТ: Судлаач миний бие фейсбүүк цахим орчинд худалдан борлуулж буй эм, тариа, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнээс хамгийн эрэлт хэрэгцээтэй, хэрэглэгч олонтой, ашигтай байгааг шалгуур үзүүлэлт болгон нийт 200 төрлийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг сонгон судалсан.

Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг сонгон авч үзвэл: Фейсбүүк сүлжээнд зарж, худалдаалан борлуулж буй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг нийт 105.754 гишүүнтэй "Витамин Д хэрэглэгчид" фейсбүүк групп, "Amerik Online Shop", "CF Mongolia", "Alimhan online shop", "fif to go Mongolia", "Уламжлалт эмчилгээ", "Турк тураах кофе", "Darkhan Ovaco Mongolia", "Gegee Amerik Vitamin" гэх нийт 9 фейсбүүк хуудсаар дамжуулан зарж буй 200 нэр төрлийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг сонгон судалгаанд ашигласан.

Дээрх 200 нэр төрлийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн Монгол Улсын эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх [LicemedWeb](http://druginfo.mohs.mn/default.aspx)²⁰-д албан ёсны бүртгэлтэй 20 буюу 10%, бүртгэлгүй 180 буюу 90% байна. (Зураг 3)




Зураг 3. Монгол Улсад бүртгэгдсэн эсэхийг графикаар харуулбал

¹⁹ Зөрчлийн тухай хуулийн (2017)-ийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

²⁰ Монгол Улсад эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн болон эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийн бүртгэл болон мэдээллийн нэгдсэн сан <http://druginfo.mohs.mn/default.aspx> LicemedWeb (Сүүлд үзсэн:2025.12.01)

Фейсбүүк сүлжээг ашиглан зарж буй Монгол Улсын эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх [LicimedWeb](#)-д бүртгэлгүй 180 эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улсаар нь авч үзвэл:

АНУ 100, Австрали 6, Берлин 1, БНСУ 38, БНХАУ 3, БНЭУ 1, ХБНГУ 9, Итали 1, Их британи 4, ОХУ 6, Турк 1, Франц 2, Япон 8 байна. Хамгийн их бүртгэлгүй биобэлдмэл АНУ-ын 100 бүтээгдэхүүн байна. (Зураг 4)



Зураг 4. Монгол Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, зарж буй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн, улс, эзлэх хувиар

Дээрх хувь хүний гар дээрээс эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн худалдсан тохиолдолд хуулийн ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэгт дараах бэрхшээл тулгарч байна. Үүнд:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэргийн 1 дэх хэсэгт халдлагын зүйлийг “...Хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэж тодорхойлсон бол 2 дах хэсэгт халдлагын зүйлд “...Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл эмнэлгийн хэрэгсэл” гэж тус тус тодорхойлсон.

Үүнээс 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮН-ийг 20.14 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт тодорхойлоогүй харин Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих:

11.Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу бүртгүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

Үүнээс эм, тариа, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хувь хүн зарж буй үйлдэл нь хоёулаа хууль зөрчсөн, хүний эрүүл мэндэд шууд нөлөө үзүүлж буй үйлдэл байхад Бүртгэлтэй болон бүртгэлгүй эм, тариа зарж байгаа үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй, бүртгэлтэй болон бүртгэлгүй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн зарж байгаа үйлдэл нь зөрчлийн шинжтэй буюу Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож, торгох шийтгэл оногдуулж байгаа шийтгэлийн ялгамжтай байдлыг харуулж байна.

Монгол Улсад эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хувь хүн гар дээрээс болон цахим орчинд зарж буй үйлдэлд Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэх оногдуулж байгаа нь шийтгэлийн төрөл сул, энэ төрлийн зөрчил тасрахгүй, улам ихсэх хандлагатай байгааг харуулж байна.

Иймд Монгол Улсад бүртгэлтэй болон бүртгэлгүй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн худалдсан үйлдлийг зохих зөвшөөрөл бүхий хангамжийн байгууллага худалддаг болгон

өөрчилж Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах гэмт хэрэгт гэмт хэргийн шинжээр хуульчилж өгөх шаардлагатай байна.

ГУРАВДУГААРТ: Мөн дээрх хуулийн хариуцлагаас гадна худалдаалан борлуулж буй бүртгэлгүй эм, тариан дотор ХЭРЭГЛЭХ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА ДУУССАН ЭМ, ТАРИА зарж буй этгээдэд хариуцлага хүлээлгэхэд дараах хуулийн давхцал үүсч байна. Үүнд: Ижил, төсөөтэй хариуцлага хүлээлгэх зүйл заалтыг хүснэгтээр харуулбал:

Зөрчлийн тухай хууль	Эрүүгийн хууль
6.6 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих	20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах
24.Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллага, хангамжийн байгууллага эм, эмийн үйлчлэгч бодис, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг бүртгэлгүй, эсхүл чанарын баталгаажилтгүй, ЭСХҮЛ ХЭРЭГЛЭХ ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА ДУУССАН эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнээр ҮЙЛЧИЛСЭН , эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтийн зохистой дадлын стандарт зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	1.Хүний эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, ХУГАЦАА ДУУССАН, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, ХУДАЛДСАН, ТҮГЭЭСЭН бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд “хангамжийн байгууллага” гэж тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн санг; ойлгоно гэж заасан.²¹

Гэтэл Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 24 дэх хэсэгт хангамжийн байгууллага хүчинтэй хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнээр үйлчилсэн бол,

Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хугацаа дууссан, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан, түгээсэн...” бол гэж ижил, төсөөтэй байдлаар хуульчилсан байна.

Тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан нь хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнээр үйлчилсэн,

Эсхүл 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тусгай зөвшөөрөлтэй хангамжийн байгууллага хугацаа дууссан, хуурамч эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн-экспортолсон, импортолсон-ханган нийлүүлсэн, худалдсан гэсэн ойлголт нэг үү эсвэл өөр ойлголт уу гэсэн ойлголт гарч ирж байна. Хэл зүйн болон, хууль зүйн талаас дээрх ойлголтуудыг авч үзвэл:

❖ Монгол хэлний товч тайлбар тольд тайлбарласан байдал:

Үйлчлэх, худалдсан гэх үгийн утгыг тайлбарлавал:

Үйлчлэх: 1.Ахас ихсийг хичээнгүйлэн сувилах, тэтгэх; зочдод үйлчлэх; эцэг эхдээ үйлчлэх; 2. Шударга зүтгэх; эх орондоо үнэнч шударга үйлчлэх²²

²¹ ЭЭХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь хэсэг

²² Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, (Улаанбаатар: Улсын хэвлэлийн эрхлэх хороо, 1966) 619 дэх тал

Худалдах: Үнэ авч арилжин өгөх; ангийн үс худалдах; худалдан авагч; худалдан авах /үнэ өгч арилжин авах морь мал, эд юм худалдан авах/²³ гэж тайлбарлажээ.

❖ Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичигт тайлбарласан байдал:

Худалдах авах: (bribery)-тухайн этгээдээр ямар нэгэн үйлдэл хийлгэсний төлөө түүнд ямар нэгэн эд хөрөнгийн ашиг хууль бусаар олгох буюу амлах. Хахууль өгөхөөс ялгагдах ялгаа нь Х.а үед хууль бус шан харамж авагч албан тушаалтанд хамрагддаггүй байдагт оршино.

Эрүүгийн хуульд Х.а нь: а/ гэмт хэрэг үйлдэхэд бусад этгээдийг хатгах нэг арга; б/ иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд саад хийх зэрэг гэмт хэрэг үйлдэх арган нэг болдог.²⁴

❖ Монгол хэлний тайлбар тольд тайлбарласан байдал:

Худалдах үйл: 1. Эд барааг үнэ авч арилжин өгөх: зарах худалдах хорш /ямар нэгэн зүйлсийг бусдад худалдан борлуулах/²⁵

Үйлчлэх үйл: 1. Ахас, ихэсийг хичээнгүйлэн сувилах, өргөж тэтгэх: өвчтөнд үйлчлэх /өвчтөнг асран тэтгэх/: 2. Үйлчилгээ үзүүлэх: эм үйлчлэх /өм нөлөөлөх/, өөртөө үйлчлэх дэлгүүр /бараан дотроо орж өөртөө хэрэгцээтэй зүйлээ сонгон авах дэлгүүр/: 3. Шударга зүтгэх: шинжлэх ухаанд үйлчлэх /шинжлэх ухаанд зүтгэх/, эзэндээ үйлчлэх /эзэндээ шударга зүтгэх/: 4. Эм тарианы үйлчлэлийн үр дүн мэдэгдэх.²⁶

Худалдах гэх үгийг худалдсан болгож өнгөрсөн цаг дээр тайлбарлав:

Өнгөрсөн цаг /*Paste tense*/: Өгүүлж буй үеэс өмнө болсон үйл хөдлөлийн цагийг хэлнэ. Жишээлбэл, Ах өчигдөр явжээ. /явлаа, явав, явсан/ гэхэд явах үйл хөдлөл өгүүлж буй үеэс өмнө болсныг зааж байна. Ийнхүү өнгөрсөн цагийг тодорхойгүй буюу энгийн өнгөрсөн цаг /*past simple tense*/ гэнэ. Үргэлжилж өнгөрсөн цаг /*past continuous tense*/ өгүүлж буй үеэс өмнө болсон нэг үйл хөдлөл нөгөө үйл хөдлөлтэй нэг цагт болж өнгөрснийг заана. Төгс өнгөрсөн цаг /*past perfect tense*/ өгүүлж буй үеэс өмнө болсон нэг үйл хөдлөл нь нөгөө нэг үйл хөдлөлөөс өмнө болсныг заана. Жишээлбэл, Батыг ирэхэд ах нь /аль хэдийн/ явчихсан байлаа гэх мэт.²⁷

Өнгөрсөн цагаар тодотгон холбох нөхцөл /*Perfective verbal noun*/: Монгол хэлэнд-сан⁴ нөхцлийг өнгөрсөн цагаар тодотгон холбох нөхцөл гэх ба тухайн үйл хөдлөл өгүүлж байгаа үеэс өмнө болсон харьцангуй өнгөрсөн цагийн утга илтгэж, үйл үгийг нэр үгтэй холбодгоороо онцлогтой. Жишээ нь: өссөн нутаг, явсан газар, үзсэн хүн гэх мэт. Харилцаагүй төгс бус өнгөрсөн цагийн утга илэрхийлдэг шинжээрээ -жээ², лаа⁴, -в нөхцлөөс ялгаатай.

“Худалдсан” гэх үг нь “худалдах” үйл үгийн өнгөрсөн цагийн хэлбэр юм. “Худалдсан” үгийн тайлбар:

Үгийн язгуур: худалдах (эд бараа, мал хөрөнгийг үнэ авч арилжин өгөх).

Хэлбэрзүй: “-сан/сэн” (тодотгон холбох нөхцөл, өнгөрсөн цагийг заах).

Утга: Өнгөрсөн цагт, аль хэдийн болсон арилжиж өгсөн, зарсан үйл явдлыг заана.

Жишээ: худалдсан бараа-аль хэдийн зарагдсан бараа. Шууд утгаараа→“зарагдсан, арилжсан” гэсэн өнгөрсөн цагийн үйл үг.

Хангамжийн байгууллага хугацаа дууссан эмээр үйлчлэх, хугацаа дууссан эм худалдсан гэсэн 2 ойлголтыг гаргаж ирвэл:

- “тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан хугацаа дууссан эмээр үйлчилсэн”
- “тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан хугацаа дууссан эм худалдсан”

²³ Я.Цэвэл, өмнөх ишлэл, 724 дэх тал

²⁴ С.Нарангэрэл, *Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2021) 515 дах тал

²⁵ А.Янжиндолгор, Н.Даш, *Монгол хэлний тайлбар толь*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, хэвлэлийн компани, 2018) 410 дах тал.

²⁶ А.Янжиндолгор, Н.Даш, өмнөх ишлэл, 637 дах тал.

²⁷ Ж.Бат-Ирээдүй, Г.Буянтогтох, Ц.Өнөрбаян, Б.Пүрэв-очир, А.Пүрэвжанцан, *Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг*, (Улаанбаатар: МУИС Пресс, хэвлэлийн компани, 2014) 175 дахь тал.

1. Субъектын хувьд адил

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, 4.1.25: “Хангамжийн байгууллага” гэж тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн санг ойлгоно.

Тэгэхээр “үйлчилсэн” ч бай, “худалдсан” ч бай үйлдэгч субъект нь адил: зөвшөөрөлтэй үйлдвэр, ханган нийлүүлэгч, эмийн сан.

2. Үйлдлийн агуулга нэг

Хугацаа дууссан эмээр үйлчлэх→тухайн эмийг эмчилгээний зорилгоор хэрэглэсэн.

Хугацаа дууссан эм худалдсан→тухайн эмийг борлуулсан.

Гэхдээ аль аль нь:

хэрэглээгчийн гарт хугацаа дууссан эм очиж байгаа үйлдэл.

эмийн чанар, аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн нэг л үйлдэл гэж дүгнэж байна.

Аль аль хуульд “үйлчилсэн” ба “худалдсан” гэж ялгасангүй, харин хугацаа дууссан эм хэрэглэсэн/зах зээлд гаргасан гэдэг адил үйлдэлд хариуцлага тооцохоор хуульчилсан.

Субъект→адил (зөвшөөрөлтэй үйлдвэр, ханган нийлүүлэгч, эмийн сан).

Үйлдэл→өөрөөр илэрхийлэгдсэн ч мөн чанартаа хугацаа дууссан эмийг хэрэглэгчийн гарт хүргэсэн нэг үйлдэл.

Хуулийн үр дагавар→адил (Зөрчлийн тухай хуульд торгууль, Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцох).

“Хугацаа дууссан эмээр үйлчилсэн” болон “хугацаа дууссан эм худалдсан” гэсэн хэллэг нь хууль зүйн хувьд хоёул ижил үйлдлийг илэрхийлж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тус тус хариуцлага тооцохоор заасан нь практикт уг асуудлыг хэрхэн шийдвэрлэхэд хүндрэл учирч, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагыг төөрөгдөлд оруулж байна.

IV. ДҮГНЭЛТ

Судалгааны ажилд үндэслэн дараах дүгнэлтийг дэвшүүллээ. Үүнд:

1. Монголчууд бид эртнээс уламжлалт аргаар бэлдсэн, хүний эрүүл мэндэд ач холбогдолтой, тодорхой төрлийн өвчнийг илааршуулахад чадалтай хэмээн мал, амьтны эсхүл ургамлын гаралтай “ТАН” гэх нэршилтэй уламжлалт эмийг амьдрал ахуйдаа хэрэглэсээр ирсэн.

Тэгвэл хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй, эмийн адил үйлчилгээтэй Уламжлалт эм/эсхүл тан/ гэх нэршилтэй, шинжлэх ухааны хувьд эмчилгээний эсхүл аливаа өвчний эсрэг үйлчлэл нь батлагдаагүй уламжлалт эмийг хувиараа бэлтгэн хууль бусаар борлуулж буй үйлдлийг хуулиар зохицуулах шаардлага үүсэж байна.

2. Судалгааны үр дүнгээс харахад “Фейсбүүк” сүлжээнд борлуулж буй эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний дийлэнх буюу 90% нь Монгол Улсад бүртгэлгүй, гаднын улс орнуудаас оруулж ирж борлуулж байна. Тухайлбал, АНУ-ын гаралтай бүтээгдэхүүнүүд хамгийн их буюу 100 нэр төрөл (55.5%)-ийг эзэлж байна. Энэ нь Монгол Улсад эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний импорт, хяналт, бүртгэлийн тогтолцоо сул, цахим орчинд хяналтгүй борлуулалт нэмэгдэж буйг харуулж байна.

Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хувь хүн гар дээрээс эсвэл цахим орчноор худалдах үйлдэл нь хүний эрүүл мэндэд бодит эрсдэл учруулж, эмийн зах зээлийн хууль ёсны эргэлтэд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч, одоогийн мөрдөж буй хуулиар ийм үйлдэлд зөвхөн Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулж буй нь шийтгэлийн бодлого сул, эрүүгийн хариуцлагын хүрээнд зохицуулагдаагүй байгааг харуулж байна. Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн нь эмтэй адил хүний бие махбодод шууд нөлөөлөх чанартай тул түүнийг хууль бус худалдах, түгээх үйлдлийг зөвхөн зөрчил гэж үзэх бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэл болгон Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд хамруулан тусгах нь хууль

хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэх бодит механизм болох юм.

3. Монгол Улсад одоо мөрдөгдөж буй хууль эрх зүйн зохицуулалт (Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль) нь бүртгэлгүй болон хугацаа дууссан эмийн худалдаа, үйлчилгээтэй холбоотой хариуцлагын заалтуудыг тусгасан боловч практикт хэрэгжүүлэхдээ давхардал, зөрчил үүсгэж байна.

“Тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан хугацаа дууссан эмээр үйлчилсэн” болон “тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан хугацаа дууссан эм худалдсан, түгээсэн” гэсэн ойлголтууд нь хууль зүйн хувьд нэг утгатай боловч хоёр өөр хуульд тус тус заасан нь цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын ажилд тодорхойгүй байдал үүсгэж байна.

V. САНАЛ

Судалгааны ажилд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд “эм”, “уламжлалт эм” гэсэн нэр томъёог тус тус өөр өөрөөр тайлбарласан. Тийм ч утгаараа 2 өөр төрөл зүйлүүд юм. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлд зөвхөн “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах” гэж халдлагын зүйлд “уламжлалт эм”-ийг тусгаагүй нь учир дутагдалтай тул одоогийн хүчинтөгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлд “Уламжлалт эм”-ийн тухай зохицуулалт тусгах;

2. Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн нь эмтэй адил хүний бие махбодод шууд нөлөөлөх чанартай тул түүнийг хууль бус худалдах, түгээх үйлдлийг зөвхөн зөрчил гэж үзэх бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэл болгон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйл “Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах”-ийн 2.Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл гэсний дараа “Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн” гэж нэмэлт оруулж “2.Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах, түгээх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр явуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тусгах;

3. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн давхардсан, төөрөгдүүлсэн заалтуудыг нэг мөр болгон тодорхой болгох. Цахим орчинд эмийн хууль бус худалдаа эрхэлсэн этгээдэд оногдуулах хариуцлагын хэмжээг нэмэгдүүлж, зөвхөн торгуулиар хязгаарлахгүйгээр үйл ажиллагааг нь таслан зогсоох, эрхийг нь хасах зэрэг бодитой арга хэмжээг тусгах.

4. Олон улсын хамтын ажиллагаа Хилийн чанадад үйлдвэрлэгдэж буй хуурамч эмийн хууль бус урсгалыг таслан зогсоохын тулд хил, гааль, цагдаа болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах. Бусад орны туршлагаас суралцаж, мэдээлэл солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Ингэснээр хууль бус эмийн наймааг бууруулах, цахим орчныг эрүүлжүүлэх, цаашлаад иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал алхам болох юм.

ЭХ СУРВАЛЖ**1. Монгол хэл дээрх эх сурвалж****А. Эрх зүйн эх сурвалж**

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он.
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он.
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, 2024 он.
5. Зөрчлийн тухай хууль, 2017 он.

Б. Ном, сурах бичиг

1. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 1966 он.
2. С.Нарангэрэл, Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он.
3. А.Янжиндолгор, Н.Даш, Монгол хэлний тайлбар толь, 2018 он.
4. Ж.Бат-Ирээдүй, Г.Буянтогтох, Ц.Өнөрбаян, Б.Пүрэв-очир, А.Пүрэвжанцан, Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг, 2014 он.

В.Эрдэм шинжилгээний бүтээл

1. Монгол Улс дахь эмийн хууль бус эргэлтийн шалтгаан нөхцөл. Эмийн хууль бус эргэлт, тулгамдаж буй асуудал, урьдчилан сэргийлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019 он.

Г.Цахим эх сурвалж

1. Монгол Улсад эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн болон эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийн бүртгэл болон мэдээллийн нэгдсэн сан [LicemedWeb http://druginfo.mohs.mn/default.aspx](http://druginfo.mohs.mn/default.aspx).
2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын цахим хуудас <https://mmra.gov.mn>.

LEGAL REGULATION FOR COMBATING THE ILLEGAL CIRCULATION OF MEDICINES

Ulziiotokh.P

Ph.D. Candidate, Criminology, UIA

Police Lieutenant Colonel

ABSTRACT:

Enterprises, organizations, and individuals have increasingly engaged in the unauthorized and uncontrolled production, trade, and import of medicines, as well as the sale and distribution of expired and unregistered drugs in informal markets. As a result, many citizens have suffered harm to their health and lives from consuming counterfeit medicines. In recent years, alongside medicines and medical devices, individuals and legal entities have begun importing and selling pharmaceutical raw materials, biopreparations, and health supplements without any official authorization, raising concerns about their poor quality.

As this sector yields high profits, the production, trade, import, and export of counterfeit and unauthorized medicines have increased, leading to the widespread circulation of drugs in Mongolia that are of unknown origin, unapproved, unregistered, counterfeit, and substandard. The issue of counterfeit medicines is not only a pressing concern for Mongolia but also a global problem that worries the leadership of many countries, health organizations, medical professionals, and patients alike.

Accordingly, this paper aims to examine the legal framework for combating the illegal circulation of medicines, to conduct a detailed analysis of the content of such crimes, their legal characteristics, and social harm, to reassess legal gaps, regulatory features, and the realities of implementation, and, based on relevant additional information, to refine the research and propose recommendations for improving the legal framework.

KEYWORDS:

Pharmaceutical circulation, Illegal, crime.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХАРИЛЦААНЫ ЁС ЗҮЙН ХҮРЭЭНД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
/ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖИШЭЭН ДЭЭР/**



Б.Баатарцогт
Хууль зүйн магистр

ТОВЧЛОЛ:

Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүйн тулгамдсан асуудлыг мэндлэх хүндлэх ёс, хувцаслалт, хүний эрхийн орчин үеийн шаардлагатай холбон үзнэ. Мэргэжил бүхэнд өөрийн ёс суртахууны шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал бий. Төрийн албаны ёс зүй нь ерөнхий суурь харин мэргэшлийн ёс зүй нь тусгайлсан шинжтэй ойлголт. Судлан буй цагдаагийн ёс зүйн асуудлыг мэргэшлийн ёс зүйд тулгуурлан тодорхойлох оролдлого хийлээ.

Цагдаагийн байгууллагын сургалтыг боловсронгуй болгох, шатлан дэвших тогтолцоог бий болгоход тус сэдэв ач холбогдолтой. Иргэдийн итгэл нь төрийн албан хаагчдын хувьд чухал үнэт зүйл. Ёс зүйгүй, хууль бус, хариуцлагагүй шийдвэр, үйлдэл нь олон нийтийн итгэлийг бууруулж, төрийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг.

Ёс зүй нь нийгмийн харилцаанд заавал мөрдөх зан байдлын журам бөгөөд хүн бүр гэр бүл, хамт олон, нийгэмд биеэ зөв авч явах өөрийгөө удирдан жолоодохын үндэс. Зөвхөн иргэдэд бус албан тушаалтан хэнд ч хамаарах нийтлэг шинжтэй, “бичигдээгүй” хууль мөн. Ёс зүйн шинжлэх ухаанд “мэргэжлийн ёс зүй” чухал байр суурь эзэлнэ. Мэргэжлийн ёс зүй нь мэргэжлийн хүмүүсийн ёс суртахууны өвөрмөц хууль (кодекс)-ийг өөртөө багтаадаг.

ТҮЛХҮҮР ҮГС:

Үнэт зүйл, зарчим, тангараг, зорилт, харилцааны соёл, ёс зүй, удирдлага

I. ОРШИЛ

1.1. Цагдаагийн мэргэшлийн ёс зүйн үндсэн асуудал.

А.Түүхэн тойм

Цагдаагийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн хуульчлан баталгаажуулж ирсэн түүхэн уламжлалыг авч үзвэл:

XX зууны эхэн үеийн Монгол Улсын цагдаагийн байгууллагын хууль, дүрэм (1916-1923 он)

1. Олноо өргөгдсөний 6 дугаар он. 1916 оны 12 дугаар сарын 30. Богд хааны зарлигаар “Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ тогтоохуй нь” 27 зүйл
2. Олноо өргөгдсөний 13 дугаар он. 1923 оны 5 дугаар сарын 13 буюу европын 6 дугаар сарын 26. Засгийн газраас “Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль” 9 бүлэг, 35 зүйл
3. Олноо өргөгдсөний 13 дугаар он. 1923 оны 5 дугаар сарын 13 буюу европын 6 дугаар сарын 26. “Засгийн газраас Цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ” 4 бүлэг, 42 зүйл

БНМАУ-ын цагдаагийн байгууллагын дүрмүүд (1926-1985 он)

1. 1926 оны 01 сарын 15. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс “БНМАУ-ын цагдан сэргийлэх газрын дүрэм, 9 бүлэг, 73 зүйлтэй
2. Цагдаа нарын дагаж явах дүрэм. 1928 онд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 61 дүгээр хурлын 1 дүгээр тогтоол. 20 зүйлтэй
3. 1928 оны 01 дүгээр сарын 06. Засгийн газрын тогтоол “Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрэм” 10 бүлэг, 56 зүйл
4. 1934 оны 02 дугаар сарын 02. Сайд нарын Зөвлөлийн тогтоол “БНМАУ-ын цагдан сэргийлэхийн тухай дүрэм” 7 бүлэг, 29 зүйлтэй
5. 1936 оны 06 дугаар сарын 13. Сайд нарын Зөвлөлийн 30 дугаар тогтоол “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа, Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм”. 7 бүлэг, 34 зүйл
6. 1942 оны 04 дүгээр сарын 02. Сайд нарын Зөвлөлөөс “Дотоод явдлын яамны харьяа Улсын Цагдан сэргийлэх газрын дүрэм” 3 бүлэг, 22 зүйлтэй
7. 1949 он БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчд, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаар “БНМАУ-ын цагдан сэргийлэх газрын дүрэм”. 4 бүлэг, 14 зүйл
8. 1955 оны 03 дугаар сарын 29. Сайд нарын Зөвлөлийн 129 дугаар тогтоол “БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм” 3 бүлэг, 22 зүйл
9. 1963 оны 10 дугаар сарын 25. Сайд нарын Зөвлөлийн 499 дүгээр тогтоол “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм” 4 бүлэг, 83 зүйл
10. 1985 оны 3 дугаар сарын 29-ний өдөр. Ардын их хурлын тэргүүлэгчдийн 96 дугаар зарлиг. БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай
11. 1985 оны 04 дүгээр сарын 26. Сайд нарын Зөвлөлийн 95 дугаар тогтоол. “БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”. 6 бүлэг, 32 зүйл.

Өнөөгийн цагдаагийн албаны тухай хууль, дүрэм хэм хэмжээ**(1990-2025 он)**

1. 1990 оны 10 дугаар сарын 05-нд Улсын Бага Хурлаас Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтны үүргээ биелүүлэх баталгааны тухай БНМАУ-ын хууль
2. 1993 оны 12 дугаар сарын 02. Улсын Их Хурлаас “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай” хууль. 8 бүлэг, 53 зүйлтэй
3. Монголын цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм. 67 зүйлтэй. Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
4. Цагдаагийн албан хаагчийн сахилгын дүрэм. 24 зүйлтэй. Засгийн газрын 1994 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
5. Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм. 41 зүйлтэй. Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
6. Цагдаагийн хүрээний дүрэм. 64 зүйлтэй. Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
7. Цагдаагийн туслах ажилтны дүрэм 14 зүйлтэй. Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт
8. Цагдаагийн цол олгох журам. 15 зүйлтэй. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 222 дугаар зарлигийн хавсралт
9. 2013 оны 07 дугаар сарын 05. Улсын Их Хурлаас “Цагдаагийн албаны тухай хууль” /Шинэчилсэн найруулга/
10. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хууль
11. Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр шинэчлэн батлагдан 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
12. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2017 оны 02 дүгээр сарын 09-ний өдрийн хууль
13. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм. ЦЕГ-ын даргын 2024 оны А/194 тушаалын нэгдүгээр хавсралт
14. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм. Мөн А/194 тушаалын хоёрдугаар хавсралт
15. Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм. 65 зүйл, 131 заалттай. ЦЕГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/196 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
16. Цагдаагийн хүрээний дүрэм. Мөн А/196 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Б. Цагдаагийн ажилтны ёс зүй:

Ёс зүйг ЮУ ЗӨВ бөгөөд БУРУУ вэ гэдгийг судалдаг ухаан хэмээн үздэг. Аристотель “Ёс зүй гэдэг бол хүнд юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг танин мэдэхэд тусалдаг шинжлэх ухаан” хэмээн тайлбарласан байдаг. Албан харилцааны ёс зүй Харилцаа гэж? ... Зорилго, нөхцөл байдлын талаар ижил төстэй ойлголттой болохын тулд хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн хооронд мэдээлэл солилцох харилцан бие биеэ ойлгох, нөлөөлөх үйл явцыг харилцаа гэнэ.¹

Аливаа улс үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдлыг “төр” хэмээх ойлголтоос ангид авч үзэх боломжгүй. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, хууль дээдлэх ёс, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, Монголын төрт ёс түүх, соёлын уламжлал, төрөө дээдлэх ард түмний итгэл нь төрийн албан хаагчийн

¹ Н.Цолмонтаа Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, а/741 Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтын гарын авлага (2019)

эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс гэж үзнэ.²

Төр ба иргэний харилцааны амин чухал асуудлын нэг нь төрийн үйлчилгээг эрхэлж буй төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, тэдний харилцааны ёс зүйн асуудал байдаг.

Өмнө дурдсанчлан төрийн албан хаагчийн ёс зүй нь цагдаагийн алба хаагчдын суурь ёс зүй бөгөөд Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.³ Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.⁴ ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх⁵ нь төрийн албан хаагчийн эрхэмлэвэл зохих ёс зүйн үндсэн зарчмууд мөн.

Ёс суртахууны харилцаанд андгай, тангараг өргөх нь үнэнч шударга, хэлсэндээ хүрэхийн гол шалгуур болж байдаг⁶. Цагдаагийн байгууллагын үнэт зүйл бол “Эх орон, ард түмэндээ өргөсөн тангараг бөгөөд Монгол Улсын иргэн цагдаагийн албанд орохдоо: «Монгол Улсын иргэн би цагдаагийн албанд ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, алба хаагчийн ёс зүй, сахилга, албаны нууцыг чанд сахин, чин шударгаар ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үл хайрлан зүтгэхээ батлан тангараглая. Би энэ тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ.» гэж тангараг өргөнө.⁷

Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын Үндсэн Хууль⁸⁻⁶, Төрийн албаны тухай хууль⁹⁻⁸, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль¹⁰⁻⁵, Цагдаагийн албаны тухай хууль¹¹⁻⁷, -д заасан зарчмаас гадна Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм¹²⁻⁵ зарчмыг баримтлах ёстой гэж заасан байдаг.

... Цагдаагийн алба хаагч, үүргээ гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.¹³

II. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Монгол Улсын төрийн байгууллагууд “төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн судалгаа”, “хэрэглэгчийн үнэлгээ”, “иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”, зэрэг нэрээр төрийн үйлчилгээний өнөөгийн байдлыг иргэд хэрхэн үнэлж байгааг судалж гүйцэтгэлээ сайжруулахад ашиглаж байна. Төрийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэлийг хянаж шинжлэх, үнэлэхэд “хэрэглэгчийн үнэлгээ”-г ашиглах шийдвэр 2006 онд гарсан байдаг. Тэр үеэс байгууллага болгон өөр, өөрийн арга зүйгээр судалгааг хийж ирсэн бөгөөд 2017 онд уг судалгааг Монгол улсын төрийн захиргааны байгууллагуудад, ялангуяа аймгийн хэмжээнд нэгдсэн арга зүйгээр хийх шийдвэр гарч хэрэгжүүлсэн.

Цагдаагийн байгууллага, алба хаагчид нь гомдол, мэдээллийг шийдвэрлэх явцад олон

² Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

³ Монгол улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

⁴ Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.

⁵ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1., 7.1.2.

⁶ Авлигатай тэмцэх газар. Төрийн албан хаагчийн ёс зүй гарын авлага (2019) 151 дахь тал.

⁷ Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйл

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

⁹ Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.

¹⁰ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.

¹¹ Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.

¹² Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм

¹³ Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.

удаа дуудаж чирэгдэл учруулдаг¹⁴, энэ байдал нь иргэн болон алба хаагчийн хоорондын харилцаанд бэрхшээл үүсгэхэд нөлөөлдөг бөгөөд “Цагдаа иргэдтэй соёлтой харилцах, харилцан хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах, иргэдтэй ярилцдаг байх”-ыг иргэд онцолж байна¹⁵.

Цагдаагийн байгууллагын албан хаагчид болон удирдах ажилтнуудын харилцааны соёл ямар түвшинд байгаа нь хэрэглэгчийн судалгаагаар 70 орчим хувь нь цагдаагийн үйлчилгээний сэтгэл ханамжийг “дунд” буюу түүнээс доош үнэлсэн байна. Түүнчлэн цагдаагийн албан хаагчдын харилцааны ёс зүйг 50 хувь нь “хангалтгүй” гэж үнэлсэн нь байнга шүүмжлэлд өртөж байгаа нэг шалтгаан болж байна. Энэхүү байдал нь цагдаагийн байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, иргэдийн хандлагад сөргөөр нөлөөлж, байгууллагын нэр хүндэд сөрөг үр дагавар учруулж байна.

Цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүйн талаар¹⁶

Сүүлийн 5 жилийн байдлаар иргэд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой 11384 өргөдөл, гомдол хүлээн авч, 12869 алба хаагчид холбогдуулан шалгаж, 97.1 хувь буюу 11384 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 67.7 хувь буюу 8720 алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй, 15.3 хувь буюу 1974 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, 309 алба хаагчийн холбогдох гомдлыг харьяаллын дагуу мөрдөн шалгах байгууллагад шилжүүлж, 89 алба хаагчийн үйлдэл нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр хааж, 158 бусад байдлаар шийдвэрлэсэн байна.¹⁷

Хүснэгт 3. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол, түүний шийдвэрлэлтийн талаар:

№	Он	Нийт өргөдөл, гомдол	Шийдвэрлэгдсэн	Алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй	Сахилгын шийтгэл оногдуулсан	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн
1.	2020	1713	1658	1027	572	42	17
2.	2021	1774	1710	1102	544	52	12
3.	2022	2938	2869	2247	417	80	39
4.	2023	3486	3451	3026	299	110	16
5.	2024.08	1473	1387	1318	142	25	5
Нийт		11384	11075	8720	1974	309	89

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судалж үзвэл дийлэнх хувь нь хэрэгт холбогдох этгээдээс хохирол төлбөр яаралтай гаргуулах, хэрэгт холбогдсон этгээдийг цагдан хорихгүй байна, шалгалтын ажиллагаа удаан байна, нэг талыг барьсан шийдвэр гаргаж байна, өөрт нь ашигтай шийдвэр гаргасангүй зэрэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар Цагдаагийн

¹⁴ Цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх үнэлгээний судалгаа. Максима судалгааны төвийн Максима судалгааны төв.УБ.,2013.

¹⁵ УБ хотын 9 дүүргийн цагдаагийн алба хаагчийн иргэдтэй харилцах харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох хоёр хувьсагчийн судалгааны тайлан. “Шударга монгол цагдаа” ТББ. УБ.,2015. 27 дугаар тал

¹⁶ “Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай өргөн мэдүүлсэн хуулийн төсөл”<https://lawforum.parliament.mn/project/744/>

¹⁷ Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын 2020, 2021, 2022, 2023, 2024 оны 08 дугаар сард гаргасан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, алба хаагчдын сахилга, ёс зүйн байдлын талаар” тайлан

байгууллага, мөрдөгчид олгогдоогүй шийдвэр гаргуулахаар ханддаг нь нэг талаас мөрдөн шалгах ажиллагааны явцад гарч буй шийдвэрүүд нь эрүүгийн хэрэг, зөрчлийн хохирогч, холбогдогч нарын аль нэг талын эрх ашиг заавал хөндөгдөж байдагтай холбоотой, нөгөө талаас иргэдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс, хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, хуулийн хүрээнд явагдаж буй ажиллагааг хий хардаж байдагтай холбоотой болох нь шалгагдсан алба хаагчдын 67.7 хувь нь буруутай болох нь тогтоогдоогүй байна.

Үүнээс үзвэл 2020-2024 онд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйтэй холбоотой ирсэн нийт өргөдөл, гомдлын 97.1 хувийг хуулийн хугацаанд багтааж шийдвэрлэсэн байна. Гэхдээ шийдвэрлүүлэхээр ирсэн өргөдөл, гомдлын 67.7 хувийг алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй гэж шийдвэрлэжээ. Цагдаагийн алба хаагчийн зөрчлийн тоо буураагүй. Цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувь нь цагдаагийн алба хаагч буруугүй гэсэн шийдвэр байгаа нь иргэд цагдаагийн байгууллага өөрийн ажилтнаа хамгаалж буй гэх хардалт үүсэх, цагдаагийн байгууллагад итгэх итгэл буурах эрсдэлтэй.

Мөн “Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоо, боловсронгуй болгох зарим асуудал” судалгаанд иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх илтгэл буурсан, хүний эрх чөлөөнд халдсан зөрчил өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн талаар дурдсан зэргийг онцолсон нь тус албаны үйл ажиллагаанд зөрчил, дутагдал байсаар байгааг илэрхийлнэ.¹⁸

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлд 4.4-д “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар /КГХТГ/ нь цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Энэ нь ЦЖСХ-д хамаарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хууль сахиулах гол нэгж⁴⁷ байна.

Цахим орчинд үйлдэгдсэн жендерт суурилсан хүчирхийлэл /гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг/-ийг гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг ихэвчлэн харьяа дүүргийн цагдаагийн хэлтэст хүлээн авч, хэрэг бүртгэл нээж, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг ба шаардлагатай тохиолдолд КГХТГ-аас цахим нотлох баримтыг бэхжүүлэх, техникийн туслалцаа авах, эсвэл прокурорын заавраар хэргийг тус газарт шилжүүлэх байдлаар уг гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг, хүчирхийлэлтэй тэмцэхэд тусгай мэдлэг, ур чадвартай мэргэшсэн хүний нөөц нэн чухал тул чадварлаг боловсон хүчнийг ажиллуулах боломжийг бүрдүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах, бодлого, аргачлалаар дэмжих, өнөөдрийн технологи, хэрэглээнд хариу үзүүлэхээс гадна ирээдүйд чиглэж ажиллах хэрэгцээтэйг тусгасан байна.

III. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛД:

Аливаа байгууллага өмнөө тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлэх нь олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд эдгээрийн нэг нь зөв менежмент, сайн удирдлага юм.

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны харилцааны соёл, мэргэжлийн ёс зүй нь өнөө үед хамгийн чухалд тавигдаж, энэ нь байгууллагын хөгжилд эерэг үр дүн авчрах гол үндсийн нэг болж байна.

Цагдаагийн байгууллага 2004-2025 онуудад удирдах ажилтны манлайлал, харилцааны соёл, ёс зүйг төлөвшүүлэх зорилтыг тогтмол дэвшүүлж байна.

¹⁸ Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал 2023 он /харьцуулсан судалгаа/ Хууль зүйн үндэсний хүрээлэн

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “төрийн үйлчилгээг хүртээмжтэй ил тод болгох, хүний эрхийг баталгаатай хангах, нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тус тус боловсронгуй болгоно.”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1-д “Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтална.”, 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэл хийх”-ээр¹⁹, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.14-д “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх...”, 4.2.3.11-д “Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.”, 4.2.3.8-д “Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад Төрийн албанд мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баримтлах, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна”, мөн хуулийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”, Цагдаагийн албаны тухай хуулийн 21.1.11-т “Хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох”, Дотоодын цэргийн тухай хуулийн 32.4 дэх хэсэгт “Дотоодын цэргийн алба хаагч энэ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техник хэрэглэх бэлтгэл, сургалтад заавал хамрагдсан байна” гэж цагдаагийн алба хаагчийг сургах эрх зүйн үндэслэлийг тус тус тогтоосон байна.

Төрийн албаны зөвлөлийн “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт батлах тухай” 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”-ыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн захиргааны албан тушаалд тогтоосон тусгай шаардлагыг хангасан байдлыг тодорхойлоход ашиглах нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасан байдаг.

IV. ДҮГНЭЛТ

Цагдаагийн албан хаагчийн харилцааны ёс зүйн зөрчил нь нэг талаас тухайн албан хаагчийн хариуцлагагүй үйлдэл, ёс суртахуун, ухамсар, соёл, мэргэжлийн ур чадварын түвшинтэй холбоотой байдаг хэдий ч нөгөө талаас, шууд удирдах ажилтны хяналт, удирдлага шаардлагатай үед хангалттай хэрэгждэггүй, мөн тэдний харилцааны соёл, бусдад нөлөөлөх чадвар, манлайлал сул байгаагаас үүдэлтэй гэж дүгнэхээс өөр аргагүй юм.

¹⁹ Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлал /2015 он/

Цагдаагийн байгууллагад манлайллыг төгөлдөржүүлэх нь харилцааны ёс зүйн хүрээнд тулгамдаж байгаа чухал асуудлын нэг мөн болох нь цагдаагийн байгууллагын жил бүрийн зорилтоос тодорхой харагдах бөгөөд хүний нөөцийн бодлого үйл ажиллагаанд төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцооны шинэчлэлийг хийхдээ төрийн албаны мэргэшүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай.

Байгууллага, хамт олныг удирдан чиглүүлэх ухаанд суралцаж, бусадтай харилцах эв дүй, албан харилцааны мөн чанар, нийгэм болоод албан хаагчдын хэрэгцээ шаардлагыг зохих хэмжээнд танин мэдэж чадаагүй удирдах албан тушаалтан бусдыг удирдан чиглүүлэх биш, харин ч хамтран зүтгэгчдийнхээ итгэл найдварыг алдаж, байгууллагын үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.

V. САНАЛ

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ (2015-2024), ажлын байрны тодорхойлолт, хүний нөөц, сургалттай холбоотой эрх зүйн актуудад судалгаа явуулах

Төрийн албаны тухай хуульд заасан богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтад хамруулах заалтыг цагдаагийн байгууллагын бүхий л албан тушаалын тодорхойлолтод тусгуулан, хэрэгжүүлэх.

Энэ сэдвээр сургалтын тусгайлсан хөтөлбөр боловсруулж, цагдаагийн цол олгох, албан тушаал дэвших шалгуурт тусгах нь цагдаагийн байгууллагын хөгжилд чухал ач холбогдолтой, амжилттай үр дүнд хүрэхэд туслах болно.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛАГААС УДИРДАХ АЖИЛТНЫ БОЛОН АЛБАН
ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙН МЭДЛЭГ, ХАРИЛЦАХ УР ЧАДВАР, ХАРИЛЦААНЫ
СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ 2004-2025 ОНД ДЭВШҮҮЛСЭН
ЗОРИЛТЫН СУДАЛГАА**

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТУУД:

Он	Дэвшүүлсэн зорилтын тоо	Удирдах ажилтны болон албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, харилцааны соёл, ёс зүйг төлөвшүүлэхтэй холбоотой дэвшүүлсэн зорилт
2004	4	-Удирдах ажилтны менежментийг сайжруулж, ажил хариуцах чадварыг дээшлүүлэх -Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг ахиулж, ёс зүйг төлөвшүүлэх.
2005	5	- Албан хаагчийн сургалтын чанарыг сайжруулан мэдлэг чадварыг дээшлүүлж, харилцааны соёл, ёс зүйг төлөвшүүлэхэд бүх шатны дарга нарын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх.
2006	5	-Бүх шатны даргалах бүрэлдэхүүний манлайллыг өндөржүүлж сургалтын чанар, алба хаагчдын мэдлэг, ур чадвар, хариуцлага, ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх
2007	3	-Сургалтын арга, хэлбэрийг боловсронгуй болгож, албан хаагчдын мэдлэг, чадавхыг сайжруулна.
2008	3	- Сургалтыг чанаржуулж, албан хаагчдын мэдлэг, ажлын хариуцлагыг дээшлүүлнэ.
2009	3	- Албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйд тавигдах шаардлагыг өндөржүүлж, харьцааны соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ.
2010	3	- Албаны сургалтыг чанаржуулж, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
2011	3	- Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэж, ажлын хариуцлага, харьцааны соёл, ёс зүйд тавигдаж буй шаардлагыг хангаж ажиллана.
2012	4	- Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшил, ур чадварын түвшин, ёс зүйд тавигдах шаардлага, хариуцлагыг өндөржүүлж, ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллана.
2013	3	-Удирдах бүрэлдэхүүний манлайлал, удирдлагын арга барил, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх.
2014	1	- Байгууллага, албан хаагчдын ажил үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд, иргэд, олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэж, ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх.
2015	4	-Удирдах ажилтны манлайлал, үүрэг, ажлын хариуцлагыг сайжруулж, алба хаагчидтай ажиллах арга барилыг шинэ шатанд гаргах.
2016	3	-Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах
2017	2	- Албаны сургалтыг бүсчилсэн хэлбэрт оруулж, чанар, үр дүнг сайжруулах.
2018	3	-Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод, шударга, шуурхай, хууль ажиллагааг хэрэгжүүлнэ.
2019	1	-Удирдлагын манлайлал, алба хаагчдын сахилга, хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ.
2020	2	- Удирдлагын манлайлал, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлнэ.

2021	2	- Удирдах ажилтны манлайлал, албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах.
2022	2	-Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зорилтууд дэвшүүлсэн.
2023	2	- Албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, менежментийн шинэлэг арга, хэлбэрийг нэвтрүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.
2024	3	-Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зорилтууд дэвшүүлсэн.
2025	7	-“Хамтдаа хөгжье” уриалгын хүрээнд арга барил, харилцаа, хандлага, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01 -ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫГ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛД АДИЛТГАН АВЧ ҮЗЭХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Төрийн тусгай албан тушаалын жагсаалт	Адилтгах төрийн захиргааны албан тушаалын ангилал
Цагдаагийн ерөнхий газрын дарга;	Тэргүүн түшмэл
Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын харьяа албадын дарга, газрын дарга; Дотоодын цэргийн штабын дарга;	Эрхэлсэн түшмэл
Цагдаагийн төв байгууллагын хэлтсийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжийн дарга болон тухайн нэгж, алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын газар, хэлтсийн дарга, Дотоодын цэргийн штабын орлогч, хэлтсийн дарга, Дотоодын цэргийн анги, тусгай салбарын захирагч; Цагдаагийн төв байгууллагын тасгийн дарга, Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгжийн тасаг, хэсгийн дарга, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дэд дарга, дотоодын цэргийн ангиудын орлогч;	Ахлах түшмэл
Цагдаагийн төв байгууллагын чиглэлийн ахлах байцаагч, чиглэлийн ахлах мэргэжилтэн, Дотоодын цэргийн штабын чиглэлийн ахлах, харьяа алба нэгж, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тасаг, хэсгийн дарга; Цагдаагийн төв байгууллагын ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн, тахлах нягтлан бодогч, Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, чиглэлийн ахлах байцаагч, чиглэлийн ахлах мөрдөгч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын тасаг, хэсгийн дарга, Дотоодын цэргийн штабын анги, тусгай салбарын чиглэлийн ахлах, ахлах, эрүүл мэндийн төвийн дарга, хэсгийн дарга, орон нутаг дахь тусгай салбарын захирагч; Цагдаагийн төв байгууллагын байцаагч, мэргэжилтэн, техникийн ажилтан, Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжийн ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, ахлах мөрдөгч, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын чиглэлийн ахлах мэргэжилтэн, чиглэлийн ахлах байцаагч, чиглэлийн ахлах мөрдөгч, Дотоодын цэргийн штабын ахлах офицер; Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжийн эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, мэргэжилтэн, байцаагч, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, ахлах мөрдөгч, Дотоодын цэргийн штабын офицер, анги, салбар, тусгай салбарын ахлах офицер; Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, байцаагч, мэргэжилтэн, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эргүүлийн офицер, инженер, сэтгэл зүйч, эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, нягтлан бодогч, зохицуулагч, Дотоодын цэргийн анги, тусгай салбар, орон нутаг дахь тусгай салбаруудын харуулын дарга, салааны захирагч, эмч, сэтгэл зүйч, нягтлан бодогч, эргүүл, шалгалтын офицер;	Дэс түшмэл
Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч бүрэлдэхүүн;	Туслах түшмэл

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол улсын үндсэн хууль, 1992 он.
2. Монгол улсын Төрийн албаны тухай хууль, 2017 он.
3. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он.
4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, 2023 он.
5. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, ЦЕГ-ын даргын тушаал. А/194, 2024 он.

Б. Ном, сурах бичиг

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он.
2. Авлигатай тэмцэх газар. Төрийн албан хаагчийн ёс зүй гарын авлага, 2019 он.
3. Н. Цолмонтаяа Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, а741 Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтын гарын авлага, 2019 он.
4. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа- 2015-2024.
5. Цагдаагийн байгууллагаас удирдах ажилтны болон албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, харилцах ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэхтэй холбоотой 2004-2025 онд дэвшүүлсэн зорилтын судалгаа.
6. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай”.
7. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 37/33 дугаар “мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай.
8. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, 2025 он.

**ISSUES ARISING WITHIN THE ETHICAL FRAMEWORK OF PUBLIC SERVANTS'
PROFESSIONAL RELATIONS
(USING THE POLICE ORGANIZATION AS AN EXAMPLE)**

Baatartsogt.B

Master of Law (LL.M.)

ABSTRACT:

The ethical issues of civil servant relations will be examined in relation to the modern needs of greetings, dress, and human rights. Every profession has its own ethical issues that need to be resolved. Civil service ethics is a general basis, while professional ethics is a specific concept. An attempt has been made to define the ethical issues of the police under study based on professional ethics.

This topic is important for improving police training and creating a system for promotion. Citizen trust is an important value for civil servants. Unethical, illegal, and irresponsible decisions and actions reduce public trust and negatively affect the reputation of the civil service.

Ethics are mandatory rules of conduct in social relations and the basis for everyone to conduct themselves correctly in their families, communities, and society. It is a general, “unwritten” law that applies not only to citizens but also to all officials. In the field of ethics, “professional ethics” occupies an important place. Professional ethics includes a unique code of conduct for professionals.

KEYWORDS:

Values, principles, oath, goals, communication culture, ethics, management

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ЭРСДЭЛД СУУРИЛСАН ДОТООД ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Л.Энхсайхан

*МУИС-ийн ХЗС-ийн магистрант,
УДШ-ийн дэргэдэх Шүүхийн академийн
Захиргааны эрх зүйн секторын судлаач*

ТОВЧЛОЛ:

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын хувьд үр ашиггүй, улсын төсөвт дарамт учруулж буй талаар Монгол Улсын Засгийн газраас гаргасан олон тоо баримтууд харуулдаг бөгөөд 2025 оны байдлаар Монгол Улсын төрийн өмчит 122 компанийн 41 нь буюу 3 компани тутмын 1 нь алдагдалтай ажиллаж байна гэх тоо, баримт бий. Гэтэл төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар нь төрөөс эдийн засгийг улс орны хөгжилд чиглүүлэх, үндэсний эдийн засгийг зохицуулж буй дэлхийн улсуудын түгээмэл нэг хэлбэр бөгөөд энэхүү алдаа, дутагдлыг зайлшгүй засан сайжруулах шаардлагатай юм.

Судлаачийн хувьд уг асуудлыг шийдвэрлэхэд төрийн өмчит компани болон төрийн өмчит үйлдвэрийн газрын засаглалын чухал нэгэн бүтэц болох дотоод хяналтын институтийг сайжруулах нь уг асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөөтэй гэж харж байна. Учир нь компани ч тэр, үйлдвэрийн газар ч тэр гадаад хүчин зүйлийн нөлөөнөөс гадна дотоод хүчин зүйл болох хяналтын институт нь маш сайн байх ёстой. Иймд хувь судлаачийн хувьд эрсдэлд суурилсан дотоод хяналтын институтийг сайжруулснаар төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үр ашиггүй байдлыг арилгана гэх таамаглалыг дэвшүүлж буй юм.

Энэ хүрээнд энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын эрсдэлд суурилсан дотоод хяналтын институтын онолын асуудал, практик хууль тогтоомж болон харьцуулсан судалгааг хийж хууль зүйн түвшинд санал, дүгнэлтийг гаргахыг зорьсон болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Төрийн өмчит компани, Төрийн өмчит үйлдвэрийн газар, Эрсдэлд суурилсан дотоод хяналт, Эрсдэлд суурилсан дотоод хяналтын систем, Эрсдэлд суурилсан дотоод хяналтын институт.

I. ОРШИЛ

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Тавдугаар зүйлийн 1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж тус тус зохицуулсан. Үүний дагуу Компанийн тухай хууль², Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль³, бусад журмаар төрөөс компани, хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулж буй юм.

Дээр дурдсан төрөөс эдийн засгийг зохицуулах чиг үүргийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын байдлаар Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 122 компани (цаашид “ТӨК” гэх), Төрийн өмчийн үйлдвэрийн газар (цаашид “ТӨҮГ” гэх) эрчим хүч, зам, тээвэр, уул уурхай, банк санхүүгийн зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулж байна.⁴ Гэтэл төрийн энэхүү зохицуулалтын алдаанаас шалтгаалан ихэнх ТӨК, ТӨҮГ олон жил алдагдалтай явж ирснийг судлаачид онцолдог бөгөөд энэ нь олон тоо баримтаас харагддаг. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улсын хөгжлийн бодлого, нийгмийн тогтвортой байдлыг хангах төрийн үндсэн хэрэгсэл юм. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд эдгээр байгууллагуудын үр ашиг буурч, төсөвт дарамт учруулах, авлига, ил тод бус удирдлага зэрэг институтын сул талууд илэрч байна. Энэ нь зөвхөн менежментийн бус, эрх зүйн орчны сул талтай шууд холбоотой. Тухайлбал 2025 оны 09 сарын байдлаар 122 ТӨК-ийн 41 ТӨК нь 150 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байгааг Засгийн газраас мэдээлсэн.⁵ Энэ нь Монгол Улсын төсөвт дарамт учруулж, эдийн засгийн хүндрэлийг үүсгэх бодит эрсдэлийг бий болгожээ.

Энэхүү асуудалтай холбоотойгоор 2025 онд Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх), Засгийн газраас олон тооны арга, хэмжээг авч хэрэгжүүлэх буюу хийхээр төлөвлөжээ. Тухайлбал Засгийн газар “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай”⁶ хуулийг УИХ-д өргөн барьсан. Түүнчлэн өмнөх жилүүдэд D.Parliament хуудсаар “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”⁷ хууль, “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай”⁸ хуулийн төсөлд олон нийтийн саналыг авч байна.

Судлаачийн хувьд ТӨК, ТӨҮГ-ын үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулахын тулд гаднаас буюу Засгийн газраас, төрийн захиргааны байгууллагын чиглүүлэх үйл ажиллагаанаас гадна, дотоод үйл ажиллагаа буюу хяналтын институтийг давхар сайжруулж “Эрсдэлд суурилсан дотоод хяналтын институт”-ийг эрх зүйн хувьд тодорхой болгох нь үр дүнд хүрнэ гэж таамаглаж буй юм. Тиймээс энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын институтын эрх зүйн байдал, сайжруулах боломжийг судлахыг зорьсон болно.

Сэдвийн өмнө нь судлагдсан байдлыг хувьд эрх зүйн мэдээллийн legaldata.mn цахим хуудас, хууль зүйн ном сурах бичгүүдийг шүүж үзэхэд ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналт,

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992) №01.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (2011) №42.

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл (1996) №11.

⁴ Б.Туул, Төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ирэх гурван жилийн зорилтыг хэлэлцжээ, цахим нийтлэл, <https://montsame.mn/mn/read/358796>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

⁵ А.Цэсүрэн “ЗГ: Төрийн өмчит компаниуд -150 тэрбумын алдагдалтай ажиллаж байна” цахим нийтлэл, <https://news.mn/r/2775151/>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

⁶ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл, 2025, <https://d.parliament.mn/tusul/d2de4e7c-1493-47a8-8dbc-d4d5d294ff31>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2021, <https://lawforum.parliament.mn/project/35/>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

⁸ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, 2022, <https://lawforum.parliament.mn/project/170/>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

эрсдэлд суурилсан засаглалыг зохицуулж буй эрх зүйн орчныг тусгайлан авч үзсэн хууль зүйн судалгаа харьцангуй цөөн байна. Одоогийн ихэнх хууль зүйн судалгаа нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн ерөнхий зохицуулалтыг үнэлэх түвшинд хязгаарлагдаж, эрсдэлд суурилсан дотоод хяналтын тодорхой механизм, хэрэгжилтийн үр нөлөөг хууль зүйн үүднээс системтэй шинжилсэн судалгаа байхгүй байгаа нь ажиглагдсан.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь ТӨК, ТӨҮГ-ын (1) Онолын судалгаа, (2) Практик судалгаа, (3) Харьцуулсан судалгаанаас бүрдэх бөгөөд түүнд үндэслэн дүгнэлт хийж, санал дэвшүүлэх болно.

II. ТӨК, ТӨҮГ-ЫН ОНОЛЫН АСУУДАЛ

Онолын судалгааны энэхүү хэсэг нь хоёр үндсэн агуулгатай. Нэгдүгээрт ТӨК, ТӨҮГ-ын эдийн засаг дахь үүрэг оролцооны талаар түүхчилсэн онолын үзэл баримтлалуудын талаар авч үзнэ. Хоёрдугаар эрсдэлд суурилсан дотоод хяналтын үндсэн ойлголт, бүтэц, агуулгыг дэлгэрэнгүй авч үзье.

Нэг. Онолын түүхэн асуудал

Дэлхийн 2 дугаар дайн төгссөний дараа дэлхийн эдийн засагт нэрт эрдэмтэн Жон Кейнс болон Фредрик Хайек нарын эдийн засгийн онолын зөрчилдөөн социалист улс орнуудаас бусад улс, орнуудын эдийн засгийн бүтцийг үндсэнд нь тодорхойлж байв.

Ж.Кейнсийн хувьд эдийн засгийн уналтын үед засгийн газраас идэвхтэй оролцохыг дэмжсэн. Төсвийн салбарын зарлага нь эрэлтийг өдөөж, эдийн засгийг хямралаас ажилгүйдлийг бууруулах замаар гаргаж чадна гэж тэр үзэж байв.⁹ Энэхүү хэтийн төлөв нь эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг хангах хэрэгсэл болгон ТӨК, ТӨҮГ-ыг байгуулж, өргөжүүлэхийг зөвтгөж байсан. Түүний онол нь биеллээ олж Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх), Их Британи зэрэг улсад ТӨК, ТӨҮГ-ын тоо 1970-аад он хүртэл өссөн байдаг. Гэтэл төрийн оролцоог хэт өндөр түвшинд байлгах нь эргээд эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж эхэлдэг нь харагдсан.¹⁰

Дээрх асуудлаас үүссэн эдийн засгийн зогсонги байдал, төрийн хэт оролцоог бууруулахаар Ф.Хайек “засгийн газрын хэт хяналт нь үр ашиггүй байдалд хүргэж, эргээд хувь хүний эрх чөлөөнд заналхийлж байна” гэх агуулга бүхий онолыг гаргасан. Тэрээр чөлөөт зах зээлийг нөөцийг хуваарилах хамгийн үр дүнтэй хэрэгсэл гэж үзсэн бөгөөд түүнийг санааг Их Британи улсын Ерөнхий сайд Маргарет Тетчер, АНУ-ын Ерөнхийлөгч Роналд Рейгэн нар XX дугаар зууны 80-аад онд идэвхтэй хэрэгжүүлсэн.¹¹ Жишээлбэл Их Британи улсад төмөр зам зэрэг олон салбарыг хувьчилсан бөгөөд 1990 онд Маргарет Тэтчерийг албан тушаалаасаа буух үед 600,000 ажилчинтай Их Британийн төрийн өмчит 40 гаруй аж ахуйн нэгж хувьчлагдсан байв.¹²

Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулсан энэхүү неолиберал бодлого нь мөн учир дутагдалтай байсан бөгөөд тухайн онолыг баримталсан ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсууд болон зүүн Европын улсуудад энэ нь тодорхой харагддаг. Монгол Улсын хувьд ч мөн адил ТӨК, ТӨҮГ-уудыг хувьчлахдаа дээрх неолиберал бодлогод үндэслэн алдаа дутагдал гаргасан нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн 1990-ээд оны туршлагаас харагддаг.

⁹ Sarwat Jahan, Ahmed Saber Mahmud, and Chris Papageorgiou. “What Is Keynesian Economics?” *Finance & Development* 51, no. 3 (September 2014). International Monetary Fund, <https://www.imf.org/external/pubs/ft/fandd/2014/09/basics.htm>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

¹⁰ Daniel Yergin. *Commanding Heights: The Battle of Ideas – Episode One (Official Video)*. YouTube video, 2002. <https://www.youtube.com/watch?v=gRTpoYpHfw&t=5s>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

¹¹ Мөн тэнд.

¹² Centre for Public Impact. “Privatising the UK’s Nationalised Industries in the 1980s.” *Public Impact Fundamentals*, April 11, 2016, <https://centreforpublicimpact.org/public-impact-fundamentals/privatising-the-uks-nationalised-industries-in-the-1980s/>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

Ерөнхийдөө дээрх онол, улс орнуудын практик зэргээс гарч ирсэн нэг дүгнэлт нь эдийн засаг дахь төрийн оролцоо нь байх ёстой зүйл байна. Үүний нэг хэлбэр нь ТӨК, ТӨҮГ байгуулж, түүний үйл ажиллагаагаар дамжуулан эдийн засгийн зохих түвшинд зохицуулна. Гагцхүү энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцэж байх тэр зохистой түвшинд байх ёстой юм.

Олон улс, оронд ТӨК, ТӨҮГ-ын үр ашиггүй байдалд нөлөөлсөн хүчин зүйл нь хүчтэй дотоод хяналт буюу аливаа эрсдэлийг тооцоолох чадваргүй байсантай холбоотой юм. Зохих түвшний эрсдэлд суурилсан хяналтгүйгээр ТӨК, ТӨҮГ-уудад авлига үүрлэх, буруу менежмент явуулах, санхүүгийн зөрчилд өртөмтгий болгох зэрэг эрсдэлтэй байдаг. Хамгийн ойрын жишээ бол манай хойд хөрш ОХУ-ын Амур мужид “Восточный” сансрын хөлгийн буудлыг барьж байсан тус улсын Дальспецстро гэх төрийн өмчит компанийн авлигын хэрэг юм. Тус хэргийн улмаас 126 сая долларын хохирол улсад учирсан гэж ОХУ-ын Ерөнхий прокурор мэдэгдсэн.¹³ Тус хэргийн үндсэн гол асуудал нь ТӨК, ТӨҮГ-т гадаад хяналтаас гадна хүчтэй дотоод хяналт тавих, ил тод байдал сул зэргээс шалтгаалсан гэж хувь судлаачийн хувьд дүгнэдэг.

Хоёр. Эрсдэлд суурилсан дотоод хяналтын бүтэц, агуулга

Эрсдэлд суурилсан дотоод хяналт (англ. risk-based internal control) гэдэг нь зорилгодоо хүрэхэд хамгийн их нөлөөлөх талбарт чиглэсэн бодлого, журам, хяналтын системээр дамжуулан байгууллагын эрсдэлийг удирдах стратегийн арга хэрэгсэл юм. Аливаа нэг эрсдэлд адил тэгш ханддаг уламжлалт дотоод хяналтын системээс ялгаатай нь эрсдэлд суурилсан дотоод хяналт нь эрсдэлийг магадлал болон болзошгүй нөлөөлөл дээр үндэслэн эрэмбэлдэг. Энэ нь байгууллагуудад нөөцийг илүү үр дүнтэй хуваарилж, асуудал үүссэний дараа хариу үйлдэл үзүүлэхээс илүү эрсдэл өндөртэй газруудад идэвхтэй хандах боломжийг олгодог байна. Бизнесийн байгууллагад учирч болох эрсдэлүүдийг олон улсад дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

1. Стратегийн эрсдэл (strategic risks)¹⁴. Эдгээр нь байгууллагын урт хугацааны зорилгодоо хүрэх чадварт нөлөөлдөг эрсдэлүүд юм. Үүнд улс төрийн чиглэлийн өөрчлөлт, эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой буруу шийдвэр гаргах, бодлогын алдаа зэрэг орно. Монгол Улсын хувьд стратегийн эрсдэлд уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудад онцгой нөлөөлдөг. Эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоо нь төрийн байгууллагуудад улс төрийн болон зах зээлийн тодорхойгүй байдлыг зохицуулахын зэрэгцээ стратегийн зорилтоо үндэсний зорилтуудтай уялдуулахад тусалдаг байна.
2. Үйл ажиллагааны эрсдэл (Operational risks)¹⁵. Эдгээр эрсдэл нь дотоод үйл явц, хүмүүс, системээс үүсдэг. Жишээ нь системийн доголдол, хүний алдаа, нийлүүлэлтийн сүлжээ тасалдах гэх мэт. Үйл ажиллагааны эрсдэл нь ихэвчлэн хоцрогдсон технологи, худалдан авалтын журам муу, боловсон хүчний бэлтгэл хангалтгүй зэргээс шалтгаалдаг. Эдгээр эрсдэлийг ангилж, хянаж чадвал компаниуд илүү үр ашигтай үйл явцыг хэрэгжүүлж, нийтийн нөөцийг хамгаалах боломжтой.
3. Санхүүгийн эрсдэл (Financial risks)¹⁶. Үүнд төсвийг төлөвлөх, мөнгөн гүйлгээ, гадаад валют, өрийн удирдлага, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлүүд

¹³ РИА Новости, Хищения на 7,5 миллиарда рублей найдены при строительстве “Восточного” статья, <https://ria.ru/20150727/1149435383.html?ysclid=makklhfuk557629166>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

¹⁴ Дам эшлэв: Жадамбаагийн Есүгэн, *Эрсдэлд суурилсан дотоод хяналтыг нэвтрүүлэх нь*, бакалаврын судалгааны ажил, Улаанбаатар.2022, Randle, T. (1999). Risk based Supervision.

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Мөн тэнд.

орно. Монгол Улсын хувьд эдийн засаг нь түүхий эдийн экспортод түшиглэдэг, дэлхийн зах зээлийн хэлбэлзлээс шалтгаалж санхүүгийн эрсдэлийг маш сайн анхаарах ёстой. Эрсдэлд суурилсан хяналт нь илүү сайн урьдчилан таамаглах, хөрөнгийн буруу зарцуулалтыг бууруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх боломжийг олгоно.

4. Хууль эрх зүйн эрсдэл (Legal Risks)¹⁷. Үүнд хууль тогтоомж, дүрэм журам, дотоод бодлогыг зөрчих эрсдэл хамаарна. Ийм эрсдэлийг сайтар ангилж, хянаж эрт илрүүлэх боломжийг олгох, хууль эрх зүй, ёс зүйн стандартыг бэхжүүлэхэд эрсдэлд суурилсан дотоод хяналт нь тусална.
5. Нэр хүндийн эрсдэл (Reputational Risks)¹⁸. Олон нийтийн сөрөг ойлголт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өртөх эсвэл оролцогч талуудын сэтгэл ханамжгүй байдлаас үүсдэг. Монгол Улсад ямар нэг нийгмийн сүлжээнд дуулиан шуугиан гарахад, ТӨК, ТӨҮГ-ын ил тод бус байдгаас төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд итгэх иргэдийн итгэл бага байна. Нэр хүндийн эрсдэлийг тодорхойлж, удирдах нь байгууллагууд олон нийтийн хүлээлтэд нийцүүлэн ажиллаж, хууль ёсны байдлаа хадгалахад тусална.

Судалгааны энэхүү хэсгийг дүгнэвэл төрийн эдийн засаг дахь оролцооны талаар онол, практикийн маргаан олон жил үргэлжилж ирсэн байдаг. Монгол Улсын хувьд Үндсэн хуульд заасан төр өөрийн эдийн засгийг зохицуулах чиг үүргийн хүрээнд ТӨК, ТӨҮГ-ыг байгуулан эдийн засгийг зохицуулж буй юм. Энэхүү ТӨК, ТӨҮГ-ын бүтээмж өндөр байх, ил тод байх, засаглалыг сайжруулахын тулд эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх нь онолын хувьд зөвтөгдөж байна.

III. ТӨК, ТӨҮГ-ЫН ПРАКТИК АСУУДАЛ

Дээр дурдсанчлан ТӨК, ТӨҮГ-ын бүтээмж өндөр байх, ил тод байх, засаглалыг сайжруулахын тулд эрсдэлд суурилсан дотоод хяналтын институтийн практикт хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг нь хамгийн чухал асуудал юм. Монгол Улсын хувьд Үндсэн хуульт, ардчилсан улсын хувьд аливаа асуудал эрх зүй буюу хууль, тогтоомжоор зохицуулагдсанаар биелэгдэх шинж чанартай байна. Иймд Монгол Улсын хууль, тогтоомжид эрсдэлд суурилсан дотоод хяналтын институтийг¹⁹ хэрхэн тусгасныг судалгааны энэ хэсэгт авч үзье.

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Хууль тогтоомжид (internal control) гэх онолын хувьд авч үзсэн ТӨК-ийн хувьд дотоод хяналт дотоод аудит, ТӨҮГ-ын хувьд дотоод хяналт гэх хүрээнд тусгасан. Үүнийг бүхэлд нь дотоод хяналт гэх ерөнхий үгээр авч үзсэн болно.

*Хүснэгт №1. Хууль тогтоомжид ТӨК, ТӨҮГ-ын
дотоод хяналтын институтийг тусгасан байдал*

№	Хууль тогтоомжийн нэр	Зохицуулалт	Эрсдэлд суурилсан дотоод хяналтын талаар туссан эсэх
1.	Компанийн тухай хууль	81 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо Хувьцаат компанийн аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна: 81.4.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих; 81.4.2.дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;	-Компанийн тухай хуулиар Төрийн өмчит компанийн эрх зүйн байдлын харилцааг зохицуулж байна. -Тус хуульд дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагад нийцэж буй эсэх мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих талаар тусгасан. -Харин дотоод хяналтын институт эрсдэлд суурилсан хяналт, үйл ажиллагаа явуулах талаар тусгаагүй юм.
2.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	21 дүгээр зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог 13.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ: 4/хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;	-Тус хуульд төрийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бөгөөд ТӨҮГ-ын эрх зүйн байдлыг тусгажээ. -Мөн хуулийн этгээд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг нийтэд мэдээлэх ёстой талаар хуульчилсан.
3.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 6.4.Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.	-Тус хуульд ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын институтийн журмыг Засгийн газарт олгосон. -Харин эрсдэлд суурилсан дотоод хяналтын талаар тусгаагүй байна.
4.	ААНБ-ын дотоод хяналт шалгалтын журам	Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг 3.7. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна: 3.7.9. байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;	-ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын эрх зүйн байдлыг тодорхойлж буй баримт бичиг нь энэхүү журам юм. -Тус журамд дотоод хяналтын институтийн нэгж, ажилтан эрсдэлийн талаарх мэдээллээр хангах ёстойг журамласан. Гэхдээ нарийвчлан тусгаагүй.

5.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	67 дугаар зүйл. Дотоодын хяналт шалгалт 1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.	-Тус хуулийн төсөлд ТӨҮГ-ын дотоодын хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан байх ёстой эсэх талаар тусгаагүй байна.
6.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл	40 дүгээр зүйл. Компанийн дотоод аудитын чиг үүрэг 40.1.2. компанийн үйл ажиллагааг компанийн хэтийн зорилго, бизнес төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 51 дүгээр зүйл. Санхүүгийн жил, санхүүгийн тайлан, бүртгэл 51.8. Энэ хуулийн 51.1-д заасан үйл ажиллагааны тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна: 51.8.2. бизнесийн стратегийн бодлого, зах зээлийн дүн шинжилгээ; 51.8.3. гадаад болон дотоод зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө; 51.8.4. ирээдүй хэтийн төлөвийг ойлгоход чухал ач холбогдолтой санхүүгийн бус эрсдэл, тодорхой бус хүчин зүйлсийн тайлбар;	-Төрийн өмчит компанийг хувийн эрх зүйн компаниас ялгаж, эрх зүйн байдлыг нь өөр хуулиар зохицуулах шаардлагатай гэх үндэслэл бүхий хуулийн төсөл юм. -Энэхүү хуулийн төсөлд эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний талаар зохицуулсан. -Харин дотоод хяналтын институт эрсдэлд хэрхэн үндэслэн шийдвэр гаргах эсэх талаар тусгаагүй байна.
7.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл	23 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл 23.1.3. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гадна хүний эрх, авлига, тэгш боломж, хөдөлмөр, мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалалт, өрсөлдөөн, байгаль орчин, татвар, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийн удирдлага болон хянан нийцүүлэлтийн нэгдсэн бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 38 дугаар зүйл. Компанийн дотоод аудитын чиг үүрэг 38.1.2. компанийн эрхэм зорилго, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, засаглалын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах замаар компанийг зорилтоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 47 дугаар зүйл. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан 47.3.3. гадаад болон дотоод зах зээлийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;	-Оршил хэсэгт дурдсанчлан Монгол Улсын Засгийн газраас ТӨК, ТӨҮГ-ын үр ашиг, ил тод байдлыг сайжруулахтай холбоотой олон тооны асуудлыг хөндөж буйн нэг нь тус хуулийн төслийг УИХ хэлэлцэж буй юм. -Тус хуулийн төслийг бүхэлд нь аваад үзвэл ТӨК-ийн засаглалыг эрсдэлийн удирдлагад үндэслэх ёстойг хуульчлахаар тусгаснаараа өмнөх хуулиудаас эрс ялгаатай байна. -Дотоод хяналтын институт буюу дотоод аудит нь эрсдэлийн удирдлагыг үнэлэх, эрсдэлийн шинжилгээ, төлөвлөгөө гаргах зэрэг үүрэгтэй байхаар тусгаснаараа давуу талтай байна.

Дээрх хууль тогтоомжийн үр дүнтэй байгаа эсэхийг тогтоохын эрсдэлд суурилсан дотоод хяналтын институтийн талаар хууль, тогтоомжийн заалт дутмаг байгаа гэх байдлаар тайлбарлах нь өрөөсгөл юм. Харин хууль, тогтоомж нь “Эрх зүй ба хөгжил” (англ. Law and Development)-ийн шинжлэх ухааны үүднээс Монгол Улсын хөгжилд ямар нөлөө үзүүлж буйг тогтоох ёстой юм. Эдгээрийг хууль тус бүрээр дүгнэлээ. Үүнд:

1. Компанийн тухай хууль- Энэхүү хуульд төрийн өмчит компаниудыг оролцуулан компаниудаас дотоод хяналтын хороо байгуулж, хяналтын механизмыг нэвтрүүлэх ёстойг заасан. Гэсэн хэдий ч эрсдэлийг хэрхэн үнэлэх, хянах, тайлагнах талаар тодорхой заагаагүй болно. Үүний улмаас ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналт нь урьдчилан сэргийлэхийн оронд журмын болон хариу үйлдэл үзүүлэх шинж чанартай хэвээр байгаа нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг удирдах үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль- Энэхүү хуульд төрийн болон орон нутгийн хөрөнгийн өмчлөл, менежмент, хамгаалалтыг зохицуулдаг боловч аж ахуйн нэгжийн түвшний дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын нарийвчилсан бүтцийг тусгаагүй болно. Ингэснээр ТӨК, ТӨҮГ-ын удирдлагын уялдаа холбоог сулруулж, үр ашиггүй байдал, шийдвэр гаргалтын тодорхой бус асуудал үүсэхэд хүргэх эрсдэлтэй байна.
3. Төрийн хяналт шалгалтын тухай хууль-Тухайн хуульд дотоод хяналтын журмыг Засгийн газар батлах ёстой гэсэн ерөнхий зарчмыг тусгасан боловч аливаа нэг эрсдэл, түүнийг хянах талаар тусгаагүй нь ТӨК, ТӨҮГ-ын хариуцлагын тогтолцоог бүдгэрүүлэх өндөр эрсдэлтэй байгаа юм.
4. ААНБ-ын дотоод хяналтын журам- Энэ журам нь төрийн өмчит компанийн дотоод хяналтын ерөнхий зарчмыг тодорхойлсон боловч эрсдэлийг илрүүлэх, эрэмбэлэх, бууруулах аргачлал дутмаг байдаг. Дотоод хяналтыг тасралтгүй хяналтын систем гэж үзэхгүй байгаа нь ТӨК, ТӨҮГ-т үр дүнгийн аливаа үзүүлэлт байхгүй зэрэгтэй шууд холбон үзэх боломжтой юм.
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл-Тухайн хуулийн төслүүдэд ТӨК-ийн дотоод хяналтын институтийн талаар тусгасан боловч өмнөх хуулиудтай адил тунхгийн шинжтэй, өмнөх хуулиудад байсантай агуулгын хувьд адил зохицуулалтууд болжээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сард УИХ-д өргөн барьсан “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай” хуулийн төсөл нь эрсдэлд суурилсан удирдлага, дотоод хяналтын системийг хуульчилж буйгаараа давуу талтай байна. Гэсэн хэдий боловч нэг дутагдалтай тал ажиглагдсан нь тодорхой эрсдэлийг, тухайлбал стратегийн, санхүүгийн зэргээр авч үзээгүй нь учир дутагдалтай юм. Онолын хэсэгт дурдсанчлан эрсдэлд суурилсан дотоод хяналтын институт, агуулгыг нарийвчлан авч үзэж, тухайн хуулийн төсөлд тусгах ёстой. Түүнчлэн эрсдэлд суурилсан хяналтын механизмыг дээр дурдсан хууль тогтоомжийн зохицуулалтад тусгасан шиг тунхгийн шинжтэй хуулийн зохицуулалт болохоос сэргийлж, зохих түвшинд хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг хангах ёстой.

Монгол Улсад ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын институтийг бүрдүүлэх эрх зүйн суурь орчин бүрэлдсэн боловч эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бодитойгоор хэрэгжүүлэхэд хангалтгүй хэвээр байна гэж хувь судлаачийн зүгээс дүгнэж байна. Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг хүчин төгөлдөр хууль тогтоомжууд нь дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар зарчмын шинжтэй зохицуулалт тусгасан боловч эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, түүнд үндэслэн хяналт хэрэгжүүлэх аргачлал, хариуцлагын механизм тодорхой бус хэвээр байна.

Харин сүүлийн жилүүдэд боловсруулагдаж буй ТӨК-ийн хуулийн төслүүдэд эрсдэлийн удирдлагыг засаглалын үндсэн элемент болгон тусгах оролдлого хийж буй нь эерэг боловч эдгээр нь хэрэгжилтийн баталгаагүй тохиолдолд өмнөх хууль тогтоомжийн адил тунхгийн шинжтэй үлдэх эрсдэлтэй юм. Иймд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг бодит үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг институтийн бүтэц, хариуцлага, тайлагналын тодорхой механизмтай уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай гэж хувь судлаачийн хувьд үзэж байна.

Судалгааны энэхүү хэсгийг нэгтгэн дүгнэвэл Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид эрсдэлд суурилсан дотоод хяналт, шалгалтын институтийн зохицуулалт байгаа боловч тунхгийн шинжтэй, практикт төдийлөн хэрэгжих боломжгүй, хуулиуд гэж дүгнэж болохоор байна. Харин Монгол Улсын Засгийн газраас “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай” хуулийн төсөлд олон давуу талтай зохицуулалт тусгагдсан байгаа боловч практикт, үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхгүй бол ямарваа нэг үр дүнгүй, өмнөх шиг тунхгийн шинжтэй болох эрсдэлтэй юм.

IV. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ

ТӨК, ТӨҮГ-г эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх асуудал нь зөвхөн хууль тогтоомжид заалт оруулахтай хязгаарлагдахгүй, харин тухайн улс орон уг тогтолцоог институтийн болон соёлын түвшинд хэрхэн ойлгож, хэрэгжүүлж буйтай шууд холбоотой байдаг. Энэ үүднээс харьцуулсан судалгааны хүрээнд ТӨК, ТӨҮГ-ын эрсдэлд суурилсан дотоод хяналтын эрх зүйн орчныг маш сайн бүрдүүлэн ажиллаж буй, Монгол Улстай адил ТӨК, ТӨҮГ-ыг зохих түвшинд дэмждэг, олон улсад жишиг болж буй, сайн туршлага бүхий Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Сингапур улсуудын хууль, түүний хэрэгжилтийн практикийг авч үзье.

Нэг. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх) социалист тогтолцоотой улс учраас эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байдаг. Тиймдээ ч дотоодын нийт бүтээгдэхүүний 25-30 хувийг төрийн өмчит хуулийн этгээд бүрдүүлдэг гэх судалгаа бий.²⁰ Төрийн томоохон хөрөнгийг удирддаг. БНХАУ-ын эдийн засгийн тогтолцоонд ТӨК, ТӨҮГ-ууд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд тэдгээр нь эрчим хүч, харилцаа холбоо, дэд бүтэц, уул уурхай зэрэг стратегийн салбаруудыг голлон хариуцдаг байна. Ийм нөхцөлд ТӨК, ТӨҮГ-ын эрсдэлийг зөвхөн зах зээлийн механизмаар зохицуулах боломжгүй гэж үзэж, төрөөс хууль эрх зүйн түвшинд эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон хуульчилсан нь БНХАУ-ын онцлог юм.

БНХАУ-ын Засгийн газар эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог хууль эрх зүйн орчиндоо шууд суулгаж өгснөөрөө тун давуу талтай байна. Дараах хуулиудад ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтыг хуульчилжээ. Үүнд:

4.1.1. БНХАУ-ын төрийн өмчит үйлдвэрийн газрын тухай хууль (2008)²¹

17 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хууль, хууль, дүрмийг сахин биелүүлж, аж ахуйн удирдлагыг бэхжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, ардын засгийн газар, тэдгээрийн холбогдох хэлтэс, байгууллагаас хууль ёсоор хэрэгжүүлж буй удирдлага, хяналтыг хүлээн зөвшөөрч, олон нийтийн хяналтыг хүлээн зөвшөөрч, нийгмийн үүрэг хариуцлага хүлээн, хувь нэмэр оруулагчийн өмнө хариуцлага хүлээх ёстой. Төрийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж

²⁰ Лутсүхийн Энхсайхан, *Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох шаардлагыг арилжааны эрх зүйн хүрээнд дүгнэх нь*” эрдэм шинжилгээний өгүүлэл, 9 дэх тал, <https://legalddata.mn/buteel/pdf?id=2057>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²¹ Law on the State-Owned Assets of Enterprises (2008), article 17, 21, <https://www.lawinfochina.com/Display.aspx?lib=law&C-gid=109891>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

нь хуулийн этгээдийн засаглалын бүтэц, дотоод хяналтын удирдлага, эрсдэлийн хяналтын тогтолцоог хуульд заасан журмын дагуу бүрдүүлж, сайжруулна.

21 дүгээр зүйл. Төрийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийнхээ хөрөнгийн өгөөж, томоохон шийдвэр гаргахад оролцох, менежер сонгох, бусад хувь нэмэр оруулагчийн эрхийг хуулиар эдэлнэ. Хөрөнгө оруулалт хийж буй аж ахуйн нэгжийн хувьд төрийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хууль тогтоомж, захиргааны журмын дагуу хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хөрөнгө оруулалт хийж буй аж ахуйн нэгжийнхээ дүрмийг боловсруулах, боловсруулахад оролцох, тодорхой эрх, үүрэг хариуцлагатай, үр дүнтэй хяналт, тэнцвэртэй аж ахуйн нэгжийн дотоод хяналт, эрсдэлийн хяналтын тогтолцоог бий болгох замаар хамгаална.

4.1.2. БНХАУ-ын компанийн тухай хууль (2023)²²

177 дугаар зүйл. Төсвийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хуульд заасан журмын дагуу дотоод хяналт, удирдлага, эрсдэлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэн сайжруулж, дотоод нийцлийн удирдлагыг бэхжүүлнэ.

Үүнээс үзвэл БНХАУ-д ТӨК, ТӨҮГ-ын засаглалыг сайжруулах зорилгоор 2 чухал хуулийг баталсан байна. Тус хуулиудад эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоо, менежментийн шинэчлэл зэрэг чухал өөрчлөлтүүдийг оруулжээ. Энэхүү хууль тогтоомжийг биелүүлж, эрсдэлийн удирдлагад үндэслэсэн дотоод хяналтыг бий болгох талаар ТӨК, ТӨҮГ-ууд маш их хэмжээний хүчин чармайлт гаргадаг бөгөөд үүнийг төрийн бодлогын хүрээнд үүрэг болгодог байна. Тухайлбал 2024 онд China Mobile компани “Эрсдэлд суурилсан дотоод хяналтын системийг хэрэгжүүлэх тал дээр томоохон ахиц дэвшил гаргасан. Тус компани 2024 оны жилийн тайлангийн дагуу компанийн Аудитын хороо 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хугацаанд Группийн эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үр нөлөөнд иж бүрэн үнэлгээ хийсэн байна. Энэхүү үнэлгээ нь санхүү, үйл ажиллагаа, нийцлийн хяналт зэрэг бүх чухал талыг хамарсан.”²³ гэж тайландаа дурджээ. Түүнчлэн PetroChina зэрэг төрийн өмчийн компаниуд тайландаа²⁴ эрсдэлд суурилсан дотоод хяналтын талаар тун чухалд тооцож тусгасан байдаг.

Хоёр. Сингапур Улс

Сингапурын төрийн өмчит аж ахуйн нэгж (англ. state-owned enterprises) хандах ханд засгийн газрын компаниуд (government-linked companies (GLCs)) гэгддэг бөгөөд компанийн хүчирхэг засаглал, эрсдэлийн менежментийг эрхэмлэдэг гэдгээрээ алдартай байдаг. Тус улсын хувьд ТӨК-ийг “төрийн захиргааны нэгж” бус, зах зээлийн өндөр сахилга баттай, олон улсын стандартад нийцсэн арилжааны компани хэлбэрээр удирддаг байна. Энэ үзэл баримтлал нь дотоод хяналтыг компанийн засаглалын төвд байрлуулах үндэс суурь болох суурь шалтгаан болсон гэж хэлж болно.

Тухайн тогтолцооны зарчмыг 1967 оны Компанийн тухай хууль, 2018 оны Компанийн засаглалын кодекс гэх хоёр гол баримт бичгээр тогтоосон байна. Үүнд:

4.2.1. Сингапур улсын компанийн тухай хууль (1967)²⁵

199 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл ба хяналтын систем

(1) Компани бүр компанийн гүйлгээ, санхүүгийн байдлыг хангалттай тайлбарлаж, үнэн зөв, шударга санхүүгийн тайлан, түүнд хавсаргах шаардлагатай аливаа баримт бичгийг тухай бүр гаргах боломжтой нягтлан бодох бүртгэл болон бусад бүртгэл хөтлөх

²² Company Law of the People's Republic of China (2023), article 177, <https://www.lawinfochina.com/Display.aspx?lib=law&C-gid=109891>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²³ China Mobile company, *Corporate Governance Report 2024*, <https://www.chinamobiletd.com/en/esg/cg.php>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²⁴ PetroChina Company Limited, (2023) annual report, <https://www.petrochina.com.cn/ptr/rdxx/202404/82094bcd-144f40068ae45d46d48b643b/files/f9a9a2c3b2cb4029b33399ea3c699fa6.pdf>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²⁵ Singapore Attorney-General's Chambers, *Companies Act 1967*, Singapore Statutes Online, article 199, <https://sso.agc.gov.sg/act/coa1967>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

ёстой бөгөөд тэдгээр бүртгэлийг хялбар, хяналт тавих боломжтой байхаар хийх, хөтлөх ёстой.

4.2.2. Сингапур улсын компанийн засаглалын кодекс (2018)²⁶

9 дүгээр зүйл. Эрсдэлийн удирдлага ба дотоод хяналт

Зарчим: Удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлагыг хариуцах бөгөөд Удирдлага нь компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын тулд эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын найдвартай тогтолцоог хангах үүрэгтэй.

9.1. Удирдах зөвлөл нь стратегийн зорилгодоо хүрэх, үнэ цэнийг бий болгоход компанийн хүлээхэд бэлэн байгаа томоохон эрсдэлийн шинж чанар, цар хүрээг тодорхойлно. Удирдах зөвлөл нь шаардлагатай бол үүнийг тусгайлан шийдвэрлэхийн тулд Удирдах зөвлөлийн Эрсдэлийн хороог (англ. Board Risk Committee) байгуулна.

9.2. Удирдах зөвлөл дараах зүйлсийг шаардаж, компанийн жилийн тайланд тусгана.

Гүйцэтгэх захирал ба Санхүү хариуцсан захирал нь санхүүгийн бүртгэлийг зохих ёсоор хөтөлж, санхүүгийн тайлан нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн талаар үнэн зөв, шударгаар харуулна;

Гүйцэтгэх захирал болон бусад нол удирдлагын ажилтнууд, компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны хүрэлцээ, үр дүнтэй байдлын талаар хариуцлага хүлээнэ.

Сингапур улсын хувьд хуулийн дээрх зохицуулалтыг практикт маш сайн хэрэгжүүлдэг бөгөөд ТӨК, ТӨҮГ-ууд нь эрсдэлд суурилсан дотоод хяналтыг явуулдаг байна. Жишээ татвал Temasek Holdings (Private) Limited гэх хөрөнгө оруулалтын компанийг Сингапур улс Сангийн ямаараа дамжуулан Засгийн газар 100 хувь эзэмшдэг. Тус компани 2024 оны байдлаар 389 тэрбум америк долларын үнэлгээтэй хөрөнгө оруулалтын багцыг удирдаж буй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын компани юм.²⁷ Тус компанид аудитын хороо нь “дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн тайлан гаргах, аудит хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл явцыг хянан шалгах замаар Удирдах зөвлөлд хяналт тавих үүрэг хариуцлагыг нь дэмжих” ерөнхий чиг үүрэгтэй байдаг. Мөн түүнчлэн Эрсдэл ба тогтвортой байдлын хороо гэх тун сонирхолтой бүтэц байх бөгөөд энэ нь зөвхөн уламжлалт санхүүгийн эрсдэлийг хянаад зогсохгүй, санхүүгийн бус төвөгтэй эрсдэлүүдийг үнэлдэг байна. Үүнд уур амьсгалтай холбоотой эрсдэл, кибер аюул, геополитикийн тогтворгүй байдал, нэр хүндийн нөлөөлөл зэрэг орно.²⁸ Сингапур улсад энэ мэтчилэн хүчтэй засаглал, дотоод хяналтын дагуу ТӨК, ТӨҮГ-ыг төрөөс удирддаг байна.

Сингапур улсын хувьд эрсдэлд суурилсан дотоод хяналтын эрх зүйн болон институтын тогтолцоо нь хууль тогтоомжийн хатуу шаардлага болон хэрэгжиж буй байдлаар тодорхойлогддог. Тус улсын компанийн тухай хуульд санхүүгийн бүртгэл, дотоод хяналтыг үнэн зөв хөтлөхийг үүрэг болгосон бол Компанийн засаглалын дүрэмд эрсдэлийн удирдлага болон дотоод аудитын чиг үүргийн талаар нарийвчлан тусгажээ.

Судалгааны энэ хэсгийг дүгнэвэл ТӨК, ТӨҮГ-ын эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог маш сайн хэрэгжүүлж буй Азийн өндөр хөгжилтэй хоёр улсыг сонгон авч, судаллаа. Эдгээр улсуудад нийтлэг ажиглагдсан зүйл нь хуулийн зохицуулалтад дотоод хяналтын тогтолцоог эрсдэлд үндэслэсэн байх талаар зохицуулалтыг маш сайн тусгаснаас гадна практикт энэ нь бодит үйл хэрэг болон хэрэгждэг байна. Монгол Улсад ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохдоо эдгээр улсуудын

²⁶ Monetary Authority of Singapore, *Code of Corporate Governance 1967*, article 9, <https://www.mas.gov.sg/-/media/mas/regulations-and-financial-stability/regulatory-and-supervisory-framework/corporate-governance-of-listed-companies/code-of-corporate-governance-6-aug-2018.pdf>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²⁷ Temasek. “Portfolio Performance.” *Temasek Holding*, <https://www.temasek.com.sg/en/our-financials/portfolio-performance>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

²⁸ Temasek. “Corporate Governance.” *Temasek Holdings*, <https://www.temasek.com.sg/en/about-us/corporate-governance#rc>. (Сүүлд үзсэн. 2025.10.18).

туршлагыг харгалзан үзвэл эрсдэлд суурилсан дотоод хяналтын систем нь бодит үр дүн авчрах механизм болох ёстой юм.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж хуульчилсан. Үүний дагуу төрөөс эдийн засгийг зохицуулах нэг хэлбэр нь ТӨК, ТӨҮГ-аар дамжуулан улс орны эдийн засгийг зохицуулж буй билээ. Гэсэн хэдийн боловч сүүлийн жилүүдэд ТӨК, ТӨҮГ-уудын үр ашиггүй байдал гаарч, үүнийг засах зарим шинэчлэл хийх ёстой гэж УИХ, Засгийн газрын түвшинд яригдаж байна. Судлаачийн хувьд энэхүү шинэчлэлийг хийхдээ ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын институтийг эрсдэлд суурилсан дотоод хяналтын системийг нэвтрүүлэх шаардлагатай гэх таамаглалыг дэвшүүлэн онолын, практик, харьцуулсан судалгааг хийлээ.

Онолын хувьд улс, орны эдийн засаг дахь төрийн оролцооны маргаан бүхий онол нь ТӨК, ТӨҮГ-ийг ямар түвшинд байх ёстой талаар зохих түвшний хариултыг өгсөн. Монгол Улсын хувьд эдийн засаг дахь төрийн оролцооны хүрээнд ТӨК, ТӨҮГ-ыг удирдах төрөөс удирдах боловч энэ нь эдийн засгийн үр ашигтай, ил тод байх ёстой гэдэг нь харагдсан. Үүнийг хийж, хэрэгжүүлэхийн тулд ТӨК, ТӨҮГ-ыг эрсдэлд суурилсан дотоод хяналтын институттэй байх нь давуу талтай гэдэг нь онолын хувьд нотлогдож буй юм.

Практик судалгааны хүрээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтыг зохицуулсан хууль тогтоомжийг судлахад эрсдэлд суурилсан дотоод хяналтын талаар тунхгийн шинжтэй, практикт хэрэгжих боломжгүй зохицуулалтаас бүрдэж байгаа нь ажиглагдсан. Харин “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай” хуулийн төсөлд зохих түвшний эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар хуульчилсан нь сайшаалтай байна.

Харьцуулсан судалгааны үр дүнгээс үзвэл БНХАУ, Сингапур зэрэг улсууд ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтыг эрсдэлд суурилсан байдлаар хууль, институтийн түвшинд нарийвчлан зохицуулж, практикт бодитой хэрэгжүүлж чадсанаар төрийн өмчит байгууллагуудын үр ашиг, ил тод байдал, хариуцлагыг мэдэгдэхүйц сайжруулж чаджээ. Эдгээр улсын туршлагаас харахад эрсдэлд суурилсан дотоод хяналт нь тунхгийн шинжтэй зохицуулалт бус, байгууллагын өдөр тутмын удирдлага, стратегийн шийдвэр гаргалтад нөлөөлөх бодит механизм байх ёстойг харуулж байна.

Эцэст нь дүгнэхэд, эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бодитойгоор нэвтрүүлж, институтийн түвшинд төлөвшүүлж чадвал Монгол Улсад ТӨК, ТӨҮГ-ын үр ашиг, засаглалын чанар, олон нийтийн итгэлцлийг нэмэгдүүлэх бодит боломж бүрдэх бөгөөд энэ нь улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм. Эдгээрт үндэслэн хувь судлаачийн зүгээс ТӨК, ТӨҮГ-ын дотоод хяналтын механизмыг сайжруулах дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрх зүйн зохицуулалтын шинэчлэл-ТӨК, ТӨҮГ-ын эрсдэлд суурилсан дотоод хяналтын эрх зүйн зохицуулалтыг ерөнхий, тунхгийн шинжтэй байхаас зайлсхийж, бодит хэрэгжилтийг хангахуйц процессын шинжтэй, нарийвчилсан зохицуулалтаар хуульчлах;
2. Хэрэгжих нөхцөлийг тодорхой байлгах- ТӨК, ТӨҮГ-ын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх аргачлал, хяналтын давтамж, тайлагнал болон ил тод байдлын механизмыг хуульд тодорхой тусгаж, хяналтын үр дүнг хариуцлагын тогтолцоотой уялдуулах;
3. Институтийн бүтэц, хараат бус байдлын баталгаа-ТӨК, ТӨҮГ бүрд дотоод дотоод хяналтын бие даасан нэгж, эрсдэлийн хороо зэрэг бүтэц байгуулж, тэдгээрийг институтийн түвшинд байр суурь, хариуцлагыг нь тодорхой болгон, хамгаалах шаардлагатай юм.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996 он.
3. Компанийн тухай хууль, 2011 он.
4. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл, 2025 он.
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2021 он.
6. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, 2022 он.

Б. Эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэл

1. Лутсүхийн Энхсайхан, Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох шаардлагыг арилжааны эрх зүйн хүрээнд дүгнэх нь, эрдэм шинжилгээний өгүүлэл. 2023 он.
2. Жадамбаагийн Есүгэн, Эрсдэлд суурилсан дотоод хяналтыг нэвтрүүлэх нь, бакалаврын судалгааны ажил, 2022 он.
3. Б.Туул, Төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ирэх гурван жилийн зорилтыг хэлэлцжээ, цахим нийтлэл.
4. А.Цээсүрэн ЗГ: Төрийн өмчит компаниуд -150 тэрбумын алдагдалтай ажиллаж байна, цахим нийтлэл.

Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээрх эх сурвалж

1. Companies Act of Singapore, 1967.
2. Singapore Code of Corporate Governance, 1967.
3. Law on the State-Owned Assets of Enterprises, 2008.
4. Company Law of the People's Republic of China, 2023.
5. Randle, T. (1999). Risk based Supervision.
6. Sarwat Jahan, Ahmed Saber Mahmud, and Chris Papageorgiou. "What Is Keynesian Economics? Finance & Development 51, no. 3 (September 2014). International Monetary Fund.
7. Daniel Yergin. Commanding Heights: The Battle of Ideas – Episode One (Official Video). "Privatising the UK's nationalised industries in the 1980s" article.
8. China Mobile company, Corporate Governance Report 2024.
9. PetroChina Company Limited, (2023) annual report.
10. Centre for Public Impact. "Privatising the UK's Nationalised Industries in the 1980s." Public Impact Fundamentals, April 11, 2016.

Б. Орос хэл дээрх эх сурвалж

1. РИА Новости, Хищения на 7,5 миллиарда рублей найдены при строительстве "Восточного" статья.

Цахим эх сурвалж:

1. Монцаме агентлагийн цахим хуудас- <https://montsame.mn/mn/>.
2. News.mn мэдээллийн цахим хуудас- <https://news.mn/>.
3. Эрх зүйн судалгааны бүтээлийн цахим хуудас- <https://legaldata.mn/>.
4. D.Parliament цахим хуудас- <https://d.parliament.mn/>.

5. УИХ-ын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн цахим хуудас- <https://lawforum.parliament.mn/>.
6. АНУ-ын эдийн засагч, түүхч Даниель Ергиний Юүтүб хуудас- <https://www.youtube.com/@DanielYerginihs>.
7. Law of China цахим хуудас- <https://www.lawinfochina.com/index.aspx>.
8. Олон Улсын Валютын Сангийн цахим хуудас- <https://www.imf.org/en/Home>.
9. Хятад Улсын China Mobile компанийн цахим хуудас- <https://www.chinamobileltd.com/en/global/home.php>.
10. Хятад Улсын PetroChina компанийн цахим хуудас- <https://www.petrochina.com.cn/ptr/index.shtml>.
11. Сингапур Улсын Temasek Holdings компанийн цахим хуудас-<https://www.temasek.com.sg/en/index>.
12. Сингапур Улсын төв банкны цахим хуудас- <https://www.mas.gov.sg/>.
13. Singapore Statutes Online цахим хуудас- <https://sso.agc.gov.sg/>.
14. Centre for Public Impact цахим хуудас- <https://centreforpublicimpact.org/>.

LEGAL REGULATION AND REQUIREMENTS FOR THE IMPLEMENTATION OF RISK-BASED INTERNAL CONTROL SYSTEMS IN STATE-OWNED COMPANIES AND STATE-OWNED ENTERPRISES

Enkhsaikhan.L

Master's student, School of Law, NUM

Researcher, Administrative Law sector,

Judicial Academy under the Supreme Court of Mongolia

ABSTRACT:

The government has released many figures showing that state-owned companies and state-owned enterprises operating in Mongolia are inefficient and burdensome to the state budget. For example, 41 of Mongolia's 122 state-owned companies, or 1 in 3 companies, are operating at a loss. However, state-owned companies and state-owned enterprises are a common form of government directing the economy towards the development of the country and regulating the national economy, and these mistakes and shortcomings need to be corrected.


As a researcher, I believe that improving the internal control institution, which is an important structure of the governance of state-owned companies and state-owned enterprises, is an important factor in solving this problem. Because companies and enterprises must have very good internal control institutions in addition to the influence of external factors. Therefore, it is hypothesized that implementing a risk-based internal control system will eliminate this situation and eliminate the inefficiency of state-owned companies and state-owned enterprises.

In this context, this research paper aims to conduct a theoretical, practical, and comparative study of the risk-based internal control institution of state-owned companies and state-owned enterprises and to draw conclusions at the legal level.

KEYWORDS:

State-owned companies, State-owned enterprises, Risk-based internal control, Risk-based internal control institute.

МОНГОЛ УЛСАД ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА ДУУСГАВАР БОЛСНЫ ДАРААХ ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ПРАКТИКТ ТУЛГАМДСАН АСУУДАЛ



Б.Бадамханд

Идэр их сургуулийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Гэр бүл нь нийгмийн анхдагч нэгж бөгөөд хүний ёс суртахуун, хүмүүжил, зан төлөв төлөвших орчин болдог. Гэвч нийгмийн хөгжлийн дагавартайгаар гэр бүл салалт өсөх хандлагатай байгаа нь хүүхдийн эрх, сэтгэл зүй, хүмүүжилд ноцтой нөлөө үзүүлж байна. Монгол Улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-д нэгдэн орсноор хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын үүрэг хүлээсэн. Үүнтэй уялдан Монгол улсын Үндсэн хууль (1992), Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Гэр бүлийн тухай хууль (2022) зэрэг дотоодын хууль тогтоомжид хүүхдийн эрхийн баталгааг нарийвчлан тусгаж өгчээ. Гэвч эрх зүйн зохицуулалт хангалттай байлаа ч, хэрэгжилтийн түвшинд зарим сул тал илэрч, хүүхдийн тэтгэмж, асрамж, хүмүүжилтэй холбоотой маргаан олонтоо гарсаар байна. Иймд энэхүү судалгааны зорилго нь гэр бүл салалтын үед хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, түүний хэрэгжилт, тулгамдсан асуудлыг судалж, сайжруулах боломжийг тодорхойлох явдал юм. Судалгааны зорилго гэр бүл салалтын үед хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүүхдийн тэтгэлэг болон асрамжийн тогтолцоог сайжруулах боломжийг тодорхойлоход оршино.

ТҮЛХҮҮР ҮГС:

Гэр бүлийн харилцаа, хүүхдийн эрх, тэтгэмж, нийгэм, шүүхийн шийдвэр, амьжиргааны түвшин.

I. ОРШИЛ

Гэр бүлийн харилцаа дуусгавар болох гэдэг нь хуулиар баталгаажсан гэрлэлтийн харилцааг шүүхийн шийдвэрээр цуцлах ажиллагааг хэлдэг бөгөөд энэхүү процесс нь зөвхөн хоёр насанд хүрэгчдийн харилцаа төдийгүй хүүхдийн эрх, ашиг сонирхолд шууд нөлөөлдөг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 16-22 дугаар зүйлд гэрлэлт цуцлах журмыг зохицуулсан бөгөөд шүүх нь гэрлэлт цуцлахдаа “хүүхдийн эрх, ашиг сонирхлыг

нэн тэргүүнд харгалзан үзнэ” гэж заасан байдаг¹. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг аливаа шийдвэр гаргахдаа нэн тэргүүнд харгалзан үзэх” зарчмыг хуульчилсан нь хүүхдийн эрхийг дээдлэхийн үндсэн зарчмыг илэрхийлдэг². Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь гурван үндсэн чиглэлтэй байна. Үүнд:

1. Хүүхдийн амьдрах, хөгжих эрхийг баталгаажуулах;
2. Хүүхдийн асрамж, хүмүүжил, боловсролд анхаарах;
3. Хүүхдийн санал бодлыг сонсох, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах эрхийг хангуулах³ зэрэг болно.

Гэрлэлт цуцлуулахаар шүүхэд хандахаас өмнөх хугацааны тэтгэлгийг нөхөн гаргуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар Гэр бүлийн тухай хуульд зохицуулалт байхгүй нь хүүхдийн амьдралын чанарыг дордуулж, эрхийг нь зөрчих нэг нөхцөл болсон мөн гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс гарсан хүүхдийн эрх шүүхийн шат дараалалтай удаан үйл ажиллагаанаас мөн хүүхдийн эцэг эхийн эрх зүйн мэдлэг бага байгаагаас хамааран шүүхийн шийдвэр гаргахаас өмнөх тэтгэлгийг нөхөн авах боломжгүй байгаа нь хүүхдийн эрх зөрчигдөж байгаагийн нэг хэлбэр мөн.

II. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА ДУУСГАВАР БОЛСНЫ ДАРААХ ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоо дараах хуулиудад тулгуурладаг. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 он);
- Гэр бүлийн тухай хууль (2022 онд шинэчлэгдсэн);
- Хүүхдийн эрхийн тухай хууль (2016 он);
- Хүүхэд хамгааллын тухай хууль (2016 он).

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-д “эх, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан бол Гэр бүлийн тухай хуульд гэр бүл салалтын үед хүүхдийн асрамж, хүмүүжил, тэтгэлэг, эцэг эхийн үүргийг тодорхой тусгаж өгчээ. Гэр бүлийн тухай хуулийн 28.1-д “эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй”, 28.5-д “эцэг эхийн аль нэг нь энэ үүргээ биелүүлээгүй бол шүүх хүүхдийн тэтгэмж тогтооно” гэж заасан нь тэжээн тэтгэх үүргийн эрх зүйн үндэс болдог.

Шүүхийн практикт хүүхдийн тэтгэмжийн хэмжээ тухайн бүс нутгийн амьжиргааны түвшний доод хэмжээгээр нас харгалзан бүтэн болон хагасаар байхаар тогтоох тохиолдолд түгээмэл байдаг. Гэвч энэ нь хүүхдийн амьдралын бодит өртөг, амьжиргааны түвшинтэй уялдахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын сул талд тооцогдож байна. Ийнхүү хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн хөлс, нөхөн олговрын хэмжээг тогтоох, төрөөс иргэдэд эд, мөнгөний туслалцаа үзүүлэхэд хүн амын амьжиргааны доод түвшнийг жишиг болон зохих хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасныг удирдлага болгожээ. Тухайн хүүхэд амьдралын чанарын ямар түвшинд амьдарч байсныг үл харгалзан хүүхдийн тэтгэлгийг түүний амьдарч байгаа бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний хэмжээгээр жишиг болгон тогтоосон нь хүүхдийн амьдралын чанарын түвшнийг дордуулах нөхцөл болсон. Зүй нь хүүхдийн амьдралын чанар өмнөхөөсөө дордох биш, харин наанадаж өмнөхөөсөө дордохгүй байх нөхцлийг хуульчлан баталгаажуулж өгвөл шударга ёсонд нийцнэ.

¹ Монгол Улсын гэр бүлийн тухай хууль, 2022

² Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016

³ Ж.Эрдэнэбат, Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, У6, 2020

⁴ Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай хууль, 1998

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-д “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчиж байна гэж үзэж байна. Үүний зэрэгцээ хуулийн заалт нь НҮБ -ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1-д “...хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг анхаарал хандуулна.”, 6 дугаар зүйлийн 2-т “...Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасныг зөрчиж байж болзошгүй гэж зарим судлаач үздэг⁵.

III. ХҮҮХДИЙН ТЭТГЭМЖ БА ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заажээ. Хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоох бөгөөд хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр:

1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар;
2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшнээр тус тус тогтоожээ.

Харин зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй этгээдээс тэтгэлэг гаргуулах тохиолдолд хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй. Хүүхдийн тэтгэлгийг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд зарцуулах ба тэтгэлгийг тухайн хүүхдийн өөрийнх нь хэрэгцээнд зарцуулаагүй болох нь тогтоогдвол тэтгэлэг төлөгч /эцэг, эх/ тэтгэлгийг зориулалтын дагуу зарцуулагдахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Мөн тэтгэлэг төлөгч нь шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлөх үүрэгтэй бөгөөд алдангийн нийт хэмжээ нь төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байхаар хуульд заасан.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр болон эд хөрөнгөөр олгож болох бөгөөд сар, улирал, хагас жил, жилээр, эсхүл нэг удаа бөөнд нь олгож болно.

Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болдог. Харин шүүхийн шийдвэрээр суутгах, эсхүл тэжээн тэтгэх гэрээний дагуу төлөх хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрсэн буюу шүүхээр өөр тэтгүүлэгчид тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн бол тэтгэлэг төлөгч тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Хүүхдийн тэжээн тэтгэх үүрэг нь зөвхөн эдийн засгийн тусламж бус, сэтгэл зүйн болон хүмүүжлийн үүрэгтэйгээр илэрхийлэгддэг. Гэр бүлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “эцэг, эх хүүхдийн хүмүүжил, боловсролд тэгш оролцох үүрэгтэй” гэж заасан нь зөвхөн мөнгөөр бус, хүмүүжлийн оролцоогоор ч тэжээн тэтгэх үүргийг хүлээлгэж буйг

⁵ UNICEF, 1989; Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт №06, 2010

харуулна⁶. Гэвч практикт зарим эцэг эх тэтгэлгээ тогтмол төлдөггүй, шүүхийн шийдвэр биелдэггүй, эсвэл орлогоо нуух, хөдөлмөрийн гэрээгүй ажиллах зэргээр хүүхдийн эрхийг хохироодог тохиолдол цөөнгүй⁷ байдаг тухай судлаач нар дурдсан байдаг.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд зааснаар, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд төрийн байгууллага, асран хамгаалагч нийгмийн ажилтан шүүх, прокурорын байгууллага хамтран ажиллах ёстой ч, бодит амьдрал дээр байгууллагын уялдаа сул байгаагаас хүүхдийн эрх хангалттай хамгаалагдахгүй байна. Хүүхдийн тэтгэлгийн тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтоон хуульчилсан нь эцэг эх хүүхдээ тэжээн тэтгэхэд санхүүгийн хувьд адил тэнцүү үүрэг хүлээх нөхцөлийг хаасан, тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс зайлсхийхэд ашигтай байдал бий болгосон эрх зүйн орчин болж хувирчээ. Хуульд хүүхдийн тэтгэлгийг тогтоохдоо нас харгалзсан нь үндэслэл муутайн дээр уг заалт нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хууль зүйн орчин болж чадсангүй. Түүнчлэн, энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг ...нас...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”. гэж заасантай зөрчилдсөн гэж үзэж байна⁸.

IV. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Үндэсний статистикийн хорооноос гаргасан насанд хүрээгүй хүмүүст олгосон тэтгэлгийн төлбөр барагдуулалтын байдлыг доорх хүснэгт /Хүснэгт 1/-ээс харна уу.

ТЭТГЭЛЭГ ОЛГОСОН БАЙДАЛ (2022-2024 оны байдлаар)

Төлөлтийн байдал	Хэмжээ (тоон үзүүлэлтээр)
Гүйцэтгэвэл зохих	47,789.3
Гүйцэтгэсэн	20,078.7
Дуусгавар болгосон	4,593.4
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	14,884.1

2022 он

Төлөлтийн байдал	Хэмжээ (тоон үзүүлэлтээр)
Гүйцэтгэвэл зохих	53,568.8
Гүйцэтгэсэн	22,675
Дуусгавар болгосон	4,975.5
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	17,251.2

2023 он

Төлөлтийн байдал	Хэмжээ (тоон үзүүлэлтээр)
Гүйцэтгэвэл зохих	48,596.2
Гүйцэтгэсэн	18,308.9
Дуусгавар болгосон	13,863.7
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	3,904.1

2024 он

Хүснэгт №1, 2, 3⁹

Дээрх үзүүлэлтээс харахад гүйцэтгэвэл зохих дүн болон бодит гүйцэтгэлийн зөрүү нь хуулийн хэрэгжилт сул байгааг шууд харуулж байна.

Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд дараах нийтлэг хүндрэлүүд илэрч байна. Үүнд:

⁶ Гэр бүлийн тухай хууль, 2022

⁷ Ж.Эрдэнэбат, Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, УБ, 2020

⁸ Монгол Улсын Үндсэн хууль, 1992

⁹ Үндэсний статистикийн хороо, www.nso.mn

1. Хүүхдийн дуу хоолойг хангалттай тусгахгүй байх;
2. Тэтгэлгийн хэмжээг нэг хэвийн тогтоодог, амьдралын өртөгтэй уялдуулахгүй байх;
3. Тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага сул оногдуулах;
4. Хүүхдийн сэтгэл зүйн байдалд төрийн дэмжлэг хомс байх;
5. Асрамжийн маргааны шийдвэрлэлт хэт удаахрах. Эдгээр хүчин зүйлээс шалтгаалан хүүхдийн эрх зөрчигдөх, ялангуяа амьжиргааны түвшин доогуур, хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхийн хүүхдүүд илүү эрсдэлд орж байна.

Судлаач Ж.Эрдэнэбатын тэмдэглэснээр хүүхдийн тэтгэлгийг тогтоохдоо хүүхдийн насны ангиллыг урьтал болгох нь хүний эрхийн түгээмэл зарчимд нийцэхгүй байна. Тиймээс Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 40.1-д “заасан насны зааг”-ийг халж, хүүхдийн бодит хэрэгцээ болон эцэг эхийн санхүүгийн чадамжид суурилсан “холимог аргачлал”-ыг нэвтрүүлэх нь хүүхдийн эрхийг практикт хамгаалах гол гарц мөн гэжээ.

Санал

1. Хүүхдийн тэтгэмжийн хэмжээг өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;
2. Шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих тусгай нэгж байгуулах;
3. Хүүхдийн санал бодлыг сонсох ажиллагааг шүүхийн практикт тууштай хэрэгжүүлэх;
4. Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний тогтолцоо (салалтын дараах зөвлөгөө, сэтгэл засал) бий болгох;
5. Тэжээн тэтгэх үүргээс зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах хууль зүйн механизм бүрдүүлэх зэрэг болно.

V. ДҮГНЭЛТ

Гэр бүл салалтын үед хүүхдийн эрхийг хамгаалах асуудал нь нийгмийн тулгамдсан сэдэв байсаар байна. Хууль зүйн зохицуулалт оршин байгаа ч, хэрэгжилтийн түвшинд хангалтгүй, ялангуяа хүүхдийн тэжээн тэтгэх үүргийн хэрэгжилт, сэтгэл зүйн хамгаалалт хангалтгүй байна.

Хүүхдийн эрхийг дээдлэх зарчим нь хууль зүйн төдийгүй ёс зүйн асуудал юм. Тиймээс хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомж, шүүхийн практикийг уялдуулан боловсронгуй болгох нь нэн чухал билээ. Ингэснээр Монгол Улс хүүхдийн эрхийг бодитоор хамгаалж, гэр бүл салалтын сөрөг үр дагаврыг бууруулах бодит алхам хийх боломж бүрдэнэ.

Засгийн газраас тогтоосон амьжиргааны доод түвшин нь Монгол Улсын иргэний хэвийн амьжиргааг тодорхойлсон үзүүлэлт биш юм. Гэрлэлт цуцлуулсан эцэг, эхээс сард нэг удаа хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан тогтоосныг зөвтгөх боломжгүй. Учир нь гэрлэлт цуцлахаас өмнө тухайн хүүхэд амьдралын чанарыг ямар түвшинд амьдарч байсныг харгалзан үзэхгүйгээр болон 11 нас хүрээгүй тул “хагас хүн” гэж тооцон түүнд өөрийнх нь эцэг, эхээс олгох тэтгэлгийг хүн амын амьжиргааны доод түвшний 50 хувиар тогтоосон нь шударга бус, хуулийн албадлагаар насаар ялгаварласан, амьдралын чанарыг нь дордуулсан явдал болсон. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнд онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай. Гэр бүл салалтын үед хүүхдийн эрхийг хамгаалах хууль зүйн зохицуулалт байгаа боловч хэрэгжилтийн түвшинд хангалтгүй байна. Хүүхдийн тэтгэлгийг амьжиргааны доод түвшнээр хязгаарлан тогтоож байгаа нь хүүхдийн амьдралын чанарыг дордуулж, шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Цаашид хүүхдийн эрхийг дээдлэх зарчмыг хууль тогтоомж, шүүхийн практикт бодитоор хэрэгжүүлж, төрийн бодлогыг боловсронгуй болгох нь гэр бүл салалтын сөрөг үр дагаврыг бууруулах үндсэн алхам болох юм.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын үндсэн хууль, 1992 он.
2. Монгол Улсын иргэний хууль, 2002 он.
3. Монгол Улсын гэр бүлийн тухай хууль, 2020 он.
4. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он.

Б. Ном, сурах бичиг

1. Х.Чимэд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2018 он.
2. Б.Чимэд, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, 1992 он.
3. “Хуулийн тэтгэлгийн тухай” хуулийн төсөл, ХЗДХЯ, 2022 он.
4. Үндсэн хуулийн тайлбар, 2018 он.
5. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт №06, 2010 он.
6. Ж.Эрдэнэбат, Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, 2020 он.

Цахим эх сурвалж

1. www.shuukh.mn
2. www.legalinfo.mn
3. www.csc.gov.mn
4. www.conscourt.gov.mn
5. www.nso.mn

PROTECTING CHILDREN'S RIGHTS AFTER FAMILY RELATIONSHIP TERMINATION: LEGAL AND PRACTICAL CHALLENGES IN MONGOLIA

Badamkhand.B

Master's student,

School of Law, Ider University

ABSTRACT:

The family constitutes the fundamental unit of society and provides the primary environment in which moral values, personal development, and social behavior are formed. However, ongoing social transformation has led to a rising rate of divorce, which has significant consequences for children's rights, psychological well-being, and upbringing. Mongolia has assumed international obligations to protect children's rights through its accession to the United Nations Convention on the Rights of the Child. In accordance with these commitments, domestic legislation - including the Constitution of Mongolia (1992), the Law on the Rights of the Child (2016), and the Law on the Family (2022) establishes comprehensive legal guarantees for the protection of children's rights.

Despite the existence of a relatively well-developed legal framework, shortcomings remain in its practical implementation. In particular, disputes concerning child support, custody, and upbringing continue to arise frequently in judicial and administrative practice. Against this background, this study examines the current legal regulation of children's rights protection in the context of divorce in Mongolia, evaluates its implementation in practice, and identifies key challenges. The study further aims to propose avenues for improving the effectiveness of the child support and custody system in order to better safeguard children's rights and living standards following the termination of family relations.

KEYWORDS:

Family relations, children's rights, child benefits, court decisions, society, living standards

КЛАСС АКШИОН БОЛОН ХАМТЫН МАРГААНЫ ШҮҮХИЙН ЗАРДЛЫН ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН САНХҮҮЖИЛТ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: АНУ, АВСТРАЛИ, ИТАЛИ, ФРАНЦ)



З.Буяндаваа

*Өмгөөллийн Голомт Консалтинг ХХН-ийн партнер,
гүйцэтгэх захирал, өмгөөлөгч*

ТОВЧЛОЛ:

Засгийн газар, корпорацууд болон бусад этгээдийн хууль зөрчсөн үйлдлийн улмаас олон тооны иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг шүүхийн журмаар гаргуулах механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг иргэдэд олгох зорилгоор класс акционы механизмыг бий болгосон. Гэвч уг механизмыг хэрэгжүүлдэг улс орнуудад шүүхийн процессын ажиллагаанд маргалдагч талуудын тэгш бус байдлыг шийдвэрлэхэд үр дүнтэй санхүүжилтийн тогтолцоог бий болгох асуудал чухлаар хөндөгдөж байна. Иймд энэхүү өгүүлэлд класс акционы шүүхийн зардлын гуравдагч этгээдийн санхүүжилтийг хэрхэн зохицуулж байгаа талаарх АНУ, Австрали, Итали, Франц улсын туршлагыг харьцуулан авч үзлээ. Энэхүү харьцуулсан судалгаа нь Монгол улсад класс акцион болон нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн нэхэмжлэх эрхийг өргөжүүлэх чиглэлд бодлого, эрх зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгоход онол, практикийн чухал ач холбогдолтой хэмээн итгэж байна. Агуулгын төөрөгдлөөс зайлсхийхийн тулд нийтийн болон иргэнлэг эрх зүйн бүлийн улс орнуудын энэ талаарх туршлагыг ялган зааглахыг эрмэлзэв.

ТҮЛХҮҮР ҮГС:

Класс акцион, шүүхийн зардал, гуравдагч этгээдийн санхүүжилт

I. ОРШИЛ

Класс акцион¹ нь зөвхөн ижил ашиг сонирхолтой олон тооны нэхэмжлэгчийн нэг эсхүл хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг шийдвэрлэх тухай асуудал огт биш. Энэ нь шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх,² хууль дээдлэх зарчмыг хангах,³ нэхэмжлэгч болон хариуцагч хоорондын маргаанд нөөцийн буюу хүчний тэгш

¹ Класс акцион гэж ижил төсөөтэй ашиг сонирхол бүхий бүлэг этгээдтйн зүгээс нэг буюу хэд хэдэн хариуцагчийг эсрэг шүүхийн маргаан үүсгэх ажиллагааг хэлнэ.

² Edward Elgar, “Encyclopedia of Law and Economics”, *Procedural Law and Economics* vol 8 (2012), 34.

³ Bernard Murphy and Camille Cameron, “Access to Justice and the Evolution of Class Action Litigation in Australia”, *Melbourne University Law Review*, Vol 30 (2006), 402.

бус байдлыг тэнцвэржүүлэх,⁴ хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг үр дүнтэй таслан зогсоох, хуулийн хэрэгжилтийг бодитоор хангах зэрэг олон талын ач холбогдолтой. Уг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь хууль, эрх зүйн зохицуулалт, практикийн тодорхой бус байдлыг арилгах, хэрэглэгчийн эрх зэрэг эрх зүйн олон салбарт шүүхийн жишиг, прецедент тогтоох, хуулийг дагаж мөрдөх журмыг хялбар тодорхой болгох, хожим үүссэн эрх зүйн маргааныг зардал багатайгаар шийдвэрлэх, эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүхийн процедурын шударга ёсны баталгааг хангахад дэмжлэг үзүүлдэг.⁵

Улс орнууд класс акционыг хүлээн зөвшөөрөх эсэх, ямар хэмжээнд хүлээн зөвшөөрөх, шударга төлөөллийн зарчмыг хэрхэн хангах, шүүхийн хяналтыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх, зохион байгуулалтын стратеги болон санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудал чухлаар тавигддаг.

Эрх зүйн уламжлал, эрх зүйн тогтолцоо, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос хамааран класс акционыг хүлээн зөвшөөрөх улс орнуудын эрх зүйн хандлага харилцан адилгүй. АНУ, Канад, Австрали зэрэг нийтлэг эрх зүйн улс орнууд класс акционыг харилцан адилгүй түвшинд хүлээн зөвшөөрсөн бол иргэнлэг эрх зүйн бүлийн орнуудад маргааны талуудын бие даасан байдал, заавал төлөөллийн зарчмаас үүдэн хуульд заасан зарим төрлийн маргаанд ихэвчлэн хамтын нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрдөг. Гэвч уг механизмыг хэрэгжүүлдэг улс орнуудад маргалдагч талуудын шүүхийн процессын ажиллагааны тэгш бус байдлыг шийдвэрлэхэд үр дүнтэй санхүүжилтийг бий болгох асуудал чухлаар хөндөгдөж байна.

Харин Монгол улсын хувьд класс акцион, нийтийн ашиг сонирхлыг шүүхийн журмаар нэхэмжлэх эрхийн хүрээнд зарим судалгаа хийгдсэн⁶ боловч шүүхийн зардал, тэр дундаа гуравдагч этгээдийн санхүүжилтийн талаарх судалгаа хараахан байхгүй. Харин нийтийн ашиг сонирхлыг иргэний болон захиргааны хэргийн шүүхэд төлөөлөх хамгаалах процедурын шударга ёсыг хангах, маргалдагч талуудын нөөцийн тэгш бус байдлыг үр дүнтэй шийдвэрлэх хүрээнд хариуцагч өөрийн гэм буруугүй болохоо нотлох үүргийг хуулиар оногдуулах, шүүхийн тэмдэгтийн хураамж болон шүүхийн зардлын асуудлыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэх асуудал хөндөгдсөөр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)-ний дөрөвт, “нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, хэд хэдэн оролцогч хамтран нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх”-ээр тусгасан боловч энэ талаарх судалгаа, үр дүнтэй өргөн хүрээний хэлэлцүүлэг хомс байна. Гуравдагч этгээдийн санхүүжилт нь класс акцион, нийтийн ашиг сонирхлын маргааны шүүхийн зардлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарын нэг байж болох тул энэ талаарх зарим улс орнуудын эрх зүйн болон практикийн асуудлыг харьцуулан судлав.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Нийтлэг эрх зүйн бүлийн улс орнуудын туршлага:

Дээр дурдсанчлан класс акционыг хүлээн зөвшөөрөх нийтлэг эрх зүйн бүлийн улс орнуудын хүрээ, түвшин харилцан адилгүй.

⁴ Ben Chen and Michael Legg, “An Economic Perspective on Cost in Australian Class Action”, *Melbourne University Law Review*, Vol 45(3) (2022), 952.

⁵ Ibid.

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх”, УБ, 2013, С.Сүхчулуун, Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахтай холбоотой хууль хэрэглээний практик ба Улсын Дээд Шүүхийн Тайлбар, Нээлттэй Нийгэм Форум, Бодлогын Асуудал, №45, https://forum.mn/uploads/users/3092/files/OSF_Bodlogiin%20asuudal_45.pdf (сүүлд үзсэн 2025.10.01); Ө.Эрдэнэ-Очир: “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”, 2023 (сүүлд үзсэн 2025.10.01) <https://legaldatal.mn/b/2390>.

АНУ-ын эрх зүйн зохицуулалт, туршлага: Класс акционы opt-in/opt-out⁷ хэлбэрийг аль алиныг харьцангуй өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн төдийгүй энэ төрлийн маргааны шүүхийн зардлын санхүүжилтэд хуулийн фирмүүд болон хөрөнгө оруулагч зэрэг гуравдагч этгээдийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалт, туршлагаар бусад улс орнуудаас ихээхэн ялгардаг.

Класс акционы нэхэмжлэгчид нь хариуцагчийн эсрэг өдүүлсэн зарга маргаантай холбогдох шүүхийн зардлыг хариуцах, хэрэв шүүхийн маргаанд ялагдсан тохиолдолд маргалдагч нөгөө талд учирсан зардал, хохирол, шүүхийн зардлыг нөхөн төлөх үүрэгтэй байдаг. Иймд шүүхийн зардлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх баталгааг хангах асуудал тулгардаг. Уг асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх боломжит хувилбарын нэг нь гуравдагч этгээдийн санхүүжилт юм.

АНУ-д класс акционы шүүхийн зардлыг гуравдагч этгээдийн санхүүжилтээр шийдвэрлэхийг хүлээн зөвшөөрсөн үндсэн хоёр хувилбар байдаг.⁸ Эхнийх нь гэм хорын нөхөн төлбөр гэх зэрэг харьцангуй бага үнийн дүнтэй хэргийг санхүүжүүлдэг зээлийн хувилбар /litigation lending market/ бөгөөд энэ төрлийн шүүхийн зарга маргаанд санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэх үндсэн шалгуур нь зарга маргаанд ялах өндөр боломжтой байх явдал юм.⁹ Шүүхийн зардлыг санхүүжүүлэгч гуравдагч этгээд нь нэхэмжлэгч шүүхийн маргаанд ялсан тохиолдолд олгосон санхүүжилтийг урамшуулалт хүүтэйгээр эргүүлэн авах, харин ялагдсан тохиолдолд эргэн төлөхгүй байх үндсэн нөхцөлтэйгөөр тухайн маргаанд ажиллаж байгаа хуульч, эсхүл хуулийн фирмээр дамжуулахгүйгээр нэхэмжлэгч талд олгодог.¹⁰ Санхүүжүүлэгч нь хуульч болон хуулийн фирмтэй ямар нэгэн бизнесийн харилцаатай байх шаардлагагүй бөгөөд олон тооны нэхэмжлэгчид хуваарилахад жижиг үнийн дүнтэй боловч нийлбэр дүнгээр томоохон арилжааны маргаантай адилтган үздэг.

Харин шүүхийн маргааны хөрөнгө оруулалт /litigation investment/ хэмээн нэрлэдэг хоёрдох хувилбарыг шүүхийн маргаанд ялах өндөр магадлалтай маш өндөр үнийн дүнтэй маргааны шүүхийн зардлыг санхүүжүүлэхэд хэрэглэдэг бөгөөд хөрөнгийн зах зээлийн үндсэн зарчимд үндэслэдэг.¹¹ Санхүүжүүлэгч нь банк, даатгалын компаниуд, эрсдэлээс хамгаалах сангууд гэх мэт институциональ хөрөнгө оруулагчид бөгөөд хөрөнгө оруулалтыг эрсдэлийг багасгаж, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд санхүүжүүлэгчдийн хөрөнгө оруулалтыг шүүхийн санхүүжилтийн мэргэшсэн фирмүүд удирддаг.¹² Хэдийгээр санхүүжилт олгох зохион байгуулалтын систем нь өөр мэт боловч санхүүжилтийн үндсэн загвар нь эхний хувилбарын нэгэн адил зээлийн хэлбэрт үндэслэх бөгөөд зарга маргаанд ялагдсан тохиолдолд зээлийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэгч тал аливаа хэлбэрээр буцаан шаардах эрхгүй.

Шүүхийн зардлын гуравдагч этгээдийн санхүүжилтийн бие даасан хувилбар хэмээн нийтлэг хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч нэхэмжлэгчийн хуулийн фирм, эсхүл хөрөнгө оруулалтын журмаар бусад хуулийн фирмүүдээс олгох хувийн санхүүжилт шүүхийн зардлын санхүүжилтийн механизмд чухал байр суурь эзэлдэг.¹³ Тус улсад үйлчилдэг класс акционы дэглэмийн дагуу шүүхээс хуулийн фирмүүдийг класс акционы зөвлөл /class council/ томилдог бөгөөд тэдгээр нь шүүхийн маргаантай холбоотой баримт бичгийг боловсруулахын өмнө хөрөнгө оруулалтын асуудлыг урьдчилан шийдвэрлэсэн байх шаардлагатай. Хэрэв шүүхээс нэхэмжлэлийг ханган шийдвэрлэсэн тохиолдолд өмгөөллийн

⁷ З.Буяндаваа, “Класс акционы эрх зүйн онол, практикийн зарим асуудал”, Legaldata, 2024, <https://legalddata.mn/b/2358> (сүүлд үзсэн 2024.09.23).

⁸ Deborah R. Hensler, “Third-Party Financing of Class Action Litigation in the United States: Will the Sky Fall?”, *DePaul Law Review*, Vol. 63:499 (2014), 501.

⁹ Ibid.

¹⁰ Ibid.

¹¹ Ibid.

¹² Ibid, 502-503.

¹³ Binyamin Applebaum, “Putting Money on Lawsuits, Investors Share in the Payouts”, *N.Y. TIMES*, Nov. 15, 2010.

үйлчилгээний төлбөрийг ихэнх тохиолдолд нөхөн төлбөрийн хэмжээтэй пропорциональ хувь хэмжээгээр тооцох, хэрэв амжилтгүй бол зардлыг нөхөн олгохгүй байхаар тогтоодог.¹⁴ Иймд хуулийн фирмүүд алдагдал хүлээх өндөр эрсдэлтэй класс акшионд хөрөнгө оруулалт хийхээс татгалзаж, санхүүжилт олгосон тохиолдолд ихэвчлэн тухайн маргаанд нэхэмжлэгчийг төлөөлөн оролцдог.

Гэхдээ шүүхийн зардлын гуравдагч этгээдийн санхүүжилтийг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөх нь өргөн хүрээний дараах маргаан, шүүмжлэлийг дагуулдаг.

Эрх зүйн үндэслэл муутай класс акшионы маргаан ихсэж, шүүхийн ачааллыг нэмэгдүүлнэ хэмээн үзэх нь бий. Гэвч энэ таамаглалыг нотолсон судалгаа хомс бөгөөд 2007 онд Иргэний шударга ёсны RAND институтээс тус улсын шүүхээр шийдвэрлэсэн даатгалын компаниудын эсрэг класс акшионы маргаанд хийсэн судалгаагаар энэ төрлийн маргааны ердөө 14 хувьд нь маргаан үүсгэж, 12 хувьд нь хохирлын төлбөрийг ханган шийдвэрлэж, 37 хувийг хариуцагчийн талд шийдвэрлэж, 20 хувийг эвлэрэн хэлэлцэх журмаар, 27 хувийг нэхэмжлэгчид нэхэмжлэлээсээ сайн дураараа татгалзаж хэрэгсэхгүй болгосон болохыг дурджээ.¹⁵ Бодлого боловсруулагчид, шүүхийн институцийн аль аль нь энэ төрлийн санхүүжилт нь эрх зүйн тогтолцоонд нөлөөлөх эерэг, эсхүл сөрөг үр дагаврыг өргөн хүрээнд дүгнэхгүй байгаа нь, тухайлбал зөвхөн нэгэнт үүссэн маргааны санхүүжилтийн асуудалд илүү анхаарч маргаан үүсэхээс өмнөх үр дагаврын асуудалд анхаарахгүй байгаа нь уг санхүүжилтийн загварыг өргөн хүрээнд дүгнэх боломжийг сулруулж¹⁶ байгааг зарим судалгаанд онцолсон.

Хэдийгээр гуравдагч этгээдийн санхүүжилт нь шүүхийн ачааллыг нэмэгдүүлдэг гэх таамаглалыг үр дүнтэй нотлоогүй боловч энэ төрлийн санхүүжилтийн хэмжээ улам бүр хурдацтай тэлж байгаа нь шударга ёсны тогтолцоог санхүүгийн хөрөнгө оруулагчдын өрсөлдөөний талбар болгоно¹⁷ гэх шүүмжлэлд хүргэдэг. Санхүүжилт олгох эсэх асуудлыг шийдвэрлэхийн тулд зарга маргаанд ялах боломжийг урьдчилан үнэлж, улмаар маргааныг арилжаалах, хөрөнгө оруулалт болгон хувиргаж байгаа нь шүүхийн гүйцэтгэх үүрэг, хуульчдын ёс зүйн хариуцлагыг сулруулах эрсдэлтэй¹⁸ хэмээн үздэг. 2017-2023 оны хооронд класс акшионы шүүхийн зардлыг хариуцах гуравдагч этгээдийн санхүүжилтийн хөрөнгө оруулалт ойролцоогоор 2 дахин нэмэгдсэн бөгөөд энэ салбарын хөрөнгө оруулалт дэлхийн хэмжээнд 15 тэрбум доллар, АНУ-д 3 тэр бум долларт хүрсэн, цаашлаад 2030 он гэхэд энэ хэмжээ 25-30 тэрбум долларт хүрнэ¹⁹ хэмээн тооцоолжээ.

Энэ салбарын хөрөнгө оруулалтын ил тод байдал хангагдаагүй бөгөөд гадаад улсын хөрөнгө оруулалт, ялангуяа зарим улсын үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалт энэ салбарт нэмэгдэж байгаа нь АНУ-ын үндэсний аюулгүй байдалд аюул учруулах эрсдэлтэй хэмээн үзэх хандлага ажиглагдаж байна. Улс орнууд эдийн засгийн хориг арга хэмжээний эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор энэ төрлийн хөрөнгө оруулалтыг ашигладаг²⁰ гэх таамаглал ч бий. 2024 оны 3 дугаар сарын Bloomberg хуулийн нийтлэлд Владимир Путинтэй холбоотой хоригт хамрагдсан Оросын тэрбумтнуудын байгуулсан хөрөнгө оруулалтын фирмүүд олон улсын хориг арга хэмжээнээс зайлсхийхийн тулд АНУ, Их Британид зарга үүсгэх ажиллагааг санхүүжүүлсэн²¹ талаар дурджээ.

¹⁴ Theodore Eisenberg & Geoffrey P. Miller, “Attorney Fees and Expenses in Class Action Settlements: 1993–2008”, *Cornell Law Review*, Vol 6 (2010). 248-250.

¹⁵ Nicholas M. Pace, Stephen J. Carroll, Ingo Vogelsang & Laura Zakaras, “Insurance Class Actions in the United States” (RAND Corporation, 2007).

¹⁶ Sunel Bedi, William C. Marra, “The Shadows of Litigation Finance”, *Vanderbilt Law Review*, Volume 74(3) (2021), 568.

¹⁷ Mark Behrens, “Third-party litigation funding: A call for disclosure and other reforms to address the stealthy financial product that is transforming the civil justice system”, *Cornell Journal of Law and Public Policy*, Vol 34:1 (2025), 4.

¹⁸ Sunel Bedi, William C. Marra, “The Shadows of Litigation Finance”, *Vanderbilt Law Review*, Volume 74(3) (2021), 555-556.

¹⁹ Ibid, 3.

²⁰ <https://www.uschamber.com/lawsuits/setting-the-record-straight-on-third-party-litigation-funding>

²¹ <https://news.bloomberglaw.com/litigation-finance/putins-billionaires-sidestep-sanctions-by-financing-lawsuits>

Класс акционы нэхэмжлэгчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч болон санхүүжүүлэгч байгууллагуудын олон талт ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх нь өргөн хүрээний эрх зүйн асуудлыг бий болгодог. Нэхэмжлэгчдийн идэвхгүй оролцоо нь тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид маргааны стратеги, процессыг удирдах өргөн боломжийг бүрдүүлдэг нь зарим талаар тэд нэхэмжлэгчдийн ашиг сонирхлыг боломжит дээд түвшинд хамгаалахгүйгээр, зарга маргааныг хурдан хугацаанд, зардал багатайгаар шийдвэрлэхийн тулд хариуцагчтай тохиролцох тохиолдол гардаг.²² Харин гуравдагч этгээдийн санхүүжилт, түүний зарга маргааныг шийдвэрлэхэд оролцох хөндлөнгийн оролцоо нь боломжит нөөцийг дээд хэмжээнд ашиглах замаар зарга маргааны үр дүнг дээд түвшинд нэмэгдүүлэхэд нөлөөлдөг.

Гэвч эсрэгээрээ нэхэмжлэгчдийг төлөөлж байгаа хуулийн фирм болон санхүүжүүлэгч гуравдагч этгээдийн хооронд байгуулсан тохиролцоог нэхэмжлэгчид мэдэхгүй байх, эсхүл уг гэрээний нөхцөл, тохиролцоо, үр дагавар нь нэхэмжлэгчдийн ашиг сонирхолтой зөрчилдөх тохиолдол гарч болно. Энэ нь хуулийн фирм, өмгөөлөгчид үйлчлүүлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хараат бусаар, бүрэн тууштай хамгаалах хуульчийн ёс зүйн үүргийг сулруулж, хэт их ашиг олох хөрөнгө оруулагчдын бизнесийн ашиг сонирхлыг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнээс дээгүүр тавихад хүргэдэг гэсэн шүүмжлэл хүчтэй байдаг. Хэдийгээр энэ салбарт хөрөнгө оруулагчид нь өөрсдийгөө маргааны процесст хөндлөнгөөс оролцдоггүй идэвхгүй оролцогч хэмээн нэрлэх нь нийтлэг хэдий ч нэхэмжлэгчдийн төлөөлөгч хуулийн фирмүүд хөрөнгө оруулалтын баталгаатай хүртэх үр өгөөжийн хувь хэмжээг өсгөхийн тулд үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх стратегийн сонгох явдал гардаг.²³

Иймээс уг асуудлыг шийдвэрлэхийн тулд Холбооны иргэний процессын дүрмийн 23(e)3-т “класс акционы зөвшөөрөл авахыг хүссэн талууд төлбөр тооцооны саналтай холбогдуулан хийсэн аливаа гэрээг тодорхойлсон мэдэгдлийг гаргахдаа өмгөөлөгч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг санхүүжүүлэгч гуравдагч этгээдийн хооронд байгуулсан гэрээг шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй. Улмаар шүүхээс маргалдагч талуудын тохиролцоо, эвлэрлийг баталгаажуулах эсэхийг шийдвэрлэхдээ тухайн тохиролцоо нь нэхэмжлэгчдийн ашиг сонирхлыг зөрчсөн эсэхийг хянах боломжтой болно. Нэхэмжлэгчдийн хувьд нэхэмжлэгчдийн төлөөлөгч өмгөөллийн фирм, санхүүжүүлэгч гуравдагч этгээдийн урамшууллын хувийг тодорхой мэдэж, ойлгосноор тухайн класс акционд нэгдэхгүй байх шийдвэр гаргах боломж бүрдэнэ. Түүнчлэн дээрх дүрмийн 23(g)(1)(A)(iv)-д заасны дагуу шүүгч класс акционы зөвлөлийг томилохдоо “класс акционы зөвлөлийн нөөц бололцоог” анхааралтай авч үзэхийн зэрэгцээ дүрмийн 23(g)(1)(B)-д заасны дагуу нэхэмжлэгчдийн ашиг сонирхлыг шударгаар, зохих ёсоор төлөөлөх өмгөөлөгчийн чадвартай холбоотой бусад асуудлыг авч үзнэ.”²⁴

Австрали улсын эрх зүйн зохицуулалт, туршлага:

Тус улсад гуравдагч этгээдийн хөрөнгө оруулалт нь класс акционы шүүхийн зардлын санхүүжилтийн гол эх сурвалж бөгөөд 2018 оны байдлаар тус улсад 25 орчим шүүхийн маргааныг санхүүжүүлэгч идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 оны байдлаар энэ тоо 33 болж нэмэгджээ.²⁵

Энэ төрлийн харилцааг Австралийн Холбооны Шүүхийн тухай хуулиар (Federal Court of Australia Act 1976)-иар зохицуулдаг бөгөөд класс акционы маргаан үүсгэхийн тулд хамгийн багадаа 7 буюу түүнээс дээш нэхэмжлэгч хамтран нэхэмжлэл гаргах шаардлагатай. Хэдийгээр тус улсад класс акционы opt-out загварыг хүлээн зөвшөөрсөн хэмээн үздэг хэдий

²² Deborah R. Hensler, “Third-Party Financing of Class Action Litigation in the United States: Will the Sky Fall?”, *DePaul Law Review*, Vol. 63:499 (2014).

²³ Mark Behrens, “Third-party litigation funding: A call for disclosure and other reforms to address the stealthy financial product that is transforming the civil justice system”, *Cornell Journal of Law and Public Policy*, Vol 34 (2025):1-7.

²⁴ https://www.law.cornell.edu/rules/frcp/rule_23

²⁵ Ibid, 1.

ч бодит байдалд opt-in хувилбар үйлчилдэг.²⁶ Иймд хөрөнгө оруулагчид класс акционы маргааны нэхэмжлэгч бүртэй хөрөнгө оруулалтын гэрээг тусгайлан байгуулдаг шинжээрээ АНУ-ын санхүүжилтийн хөрөнгө оруулалтын гэрээний загвараас ялгаатай. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын гэрээг хүлээн зөвшөөрч байгуулсан класс акционы нэхэмжлэгчдийн зардлыг хөрөнгө оруулагч хариуцна.

Түүхэн уламжлалын хувьд тус улсын холбооны болон муж улсуудад шүүхийн хамгаалалтыг арилжааны талбар болгохоос сэргийлэх, шүүхийн тогтолцоог урвуулан ашиглах замаар зүй бусаар ашиг олох зорилгоор шүүхийн маргааныг санхүүжүүлэх явдлаас хамгаалахын тулд гуравдагч этгээдийн санхүүжилтийг хууль бус үйлдэл, гэмт хэрэг хэмээн үздэг байв.²⁷ Гэвч шүүхийн зардлын тогтолцоонд нэхэмжлэгчдийн санхүүжилтийн дутмаг байдлыг шийдвэрлэх зорилгоор 2000 оноос эхлэн гуравдагч этгээдийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрөх болсон.²⁸

Уг санхүүжилтийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөхөд тус улсын шүүхээс 2006 онд Campbells Cash and Carry Pty Limited v Fostif Pty Ltd маргааныг шийдвэрлэсэн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэсэн. Шүүхийн шийдвэрт "... гуравдагч этгээдийн санхүүжилтийг хууль бусаар урвуулан ашиглах аливаа хандлагыг хуулиар хянах боломжтой тул шударга ёсонд хүрэх боломжийг олгодог санхүүжилтийн зохицуулалтыг нааштайгаар харж байна»²⁹ гэжээ.

Гэхдээ гуравдагч этгээдийн санхүүжилт нь зүй бус, хэт ашиг олох зорилготой маргааныг нэмэгдүүлэх эрсдэл тийм өндөр биш боловч урьдчилан сэргийлэх, шүүхийн хяналтыг сайжруулах, хуульчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн тус улсын Бүтээмжийн хороо (Productivity Commission) дүгнэжээ.³⁰ Австралийн эрх зүйн шинэтгэлийн хорооны хийсэн судалгаагаар гуравдагч этгээдийн санхүүжилт авсан класс акционы нэхэмжлэгчдийн дундаж өгөөж 51 хувь, харин санхүүжилтгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж өгөөж нь 85 хувь байсан нь энэ төрлийн санхүүжилтэд цаашид анхаарах шаардлагатай хэмээн зөвлөсөн.³¹

Бизнесийн буюу санхүүгийн хөрөнгө оруулагчид өөрсдийн бизнесийн загварт нийцүүлэн класс акционы журмыг батлах, өөрчлөхөд үзүүлэх лоббины нөлөөлөл нь шүүхийн чиг үүрэг болон нэхэмжлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилттой зөрчилдсөөр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд тус улсын засгийн газар шүүхийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг харгалзан энэ талаарх зохицуулалтын журмыг чангатгаж байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд шүүхийн хяналт тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Эхэн үед гуравдагч этгээдийн санхүүжилтийн гэрээг шүүхээс гадуур хувийн эрх зүйн хүрээнд байгуулсан гэрээ хэмээн үзэж шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх боломж ихээхэн хязгаарлагдмал байсныг хожим өөрчилж Австралийн Холбооны шүүхийн 2010 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн "Санхүүжилтийн нөхцөл ба зардлын баталгааны тухай баримт"-аар нэхэмжлэгчийн төлөөлөгчид шүүхийн зардлыг урьдчилан төлөх, эсхүл уг зардлыг хариуцах гуравдагч этгээдийн хувь нэмрийн талаарх хэлцлийг шүүхэд гаргаж өгөхөөр, хэрэв уг хэлцэлд нэхэмжлэгчийн стратеги тактиктэй холбоотой мэдээлэл байгаа тохиолдолд уг мэдээллийн нууцлалыг хангахаар заасан.³²

²⁶ Samuel Issacharoff, "Class Action Conflicts", *University of California Davis Law Review*, 30(3) (1997) 805.

²⁷ Michael Legg, "The rise and regulation of litigation funding in Australian Class Action", *UNSWLRS* 8 (2022), 6

²⁸ Ibid.

²⁹ Campbells Cash and Carry Pty Ltd v Fostif Pty Ltd (2006) 229 CLR 386, [65] citing Fostif Pty Ltd v Campbells Cash & Carry Pty Ltd (2005) 63 NSWLR 203, 227 [105].

³⁰ Michael Legg, "The rise and regulation of litigation funding in Australian Class Action", *UNSWLRS* 8 (2022), 8.

³¹ Australian Law Reform Commission, "Integrity, Fairness and Efficiency – An Inquiry into Class Action Proceedings and Third-Party Litigation Funding", [2018] ALRC 134.

³² Federal Court of Australia, Class Actions Practice Note CM 17, cl 3.6.

Бусад улсын нэгэн адил класс акционы нэхэмжлэлийг шүүхээс хангаагүй тохиолдолд санхүүжүүлэгчид нь зардлыг нэхэмжлэгч, эсхүл тэдний төлөөлөгчөөс буцаан шаардах эрхгүй. Харин нэхэмжлэлийг ханган шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгө оруулагч шүүхийн зардал болон урамшууллыг авах үндсэн хоёр хувилбар байдаг. Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтын хариу төлбөрийг “санхүүжилтийн тэгшитгэх дүрэм” (Funding equalisation orders)-ээр шийдвэрлэж болно. Ингэхдээ санхүүжилтийн гэрээ хийгээгүй класс акционы нэхэмжлэгчдийн нөхөн төлбөрийг шүүхийн зардлыг санхүүжүүлсэн бүлгийн гишүүдийн санхүүжүүлэгчид төлөхөөр тохиролцсон дүнгээр бууруулж, дараа нь энэ дүнг бүлгийн бүх гишүүдэд дахин хуваарилдаг.³³ Санхүүжилтийн тэгшитгэх энэхүү дүрэм нь класс акционы бүлгийн гишүүдийн тэгш байдлыг хангах, санхүүжүүлэгчтэй гэрээ байгуулаагүй бусад бүлгийн гишүүд ийнхүү гэрээ байгуулсан нэхэмжлэгчдийн бүлгийн зардлаар хохирлын төлбөр авах шударга бус байдлыг шийдвэрлэх зорилготой. Гэхдээ энэ нь санхүүжүүлэгчдийн буцаан авах урамшууллын хэмжээг ямар нэгэн байдлаар нэмэгдүүлэхгүй бөгөөд санхүүжүүлэгч нь санхүүжилтийн гэрээнд тулгуурлан санхүүжилт авсан бүлгийн гишүүдэд дахин хуваарилсан үнийн дүнгийн тохиролцсон хувь хэмжээг авах замаар хөрөнгө оруулалтын төлбөрийг эргүүлэн авна.

Санхүүжилтийн төлбөрийг авах өөр нэг хувилбар нь нийтлэг сан (common fund) юм. Энэ нь шүүхийн шийдвэрээр тогтоосон орлого, төлбөрөөс бүх бүлгийн гишүүд, түүний дотор шүүхийн санхүүжилтийн гэрээ байгуулаагүй хүмүүс санхүүжүүлэгч этгээдэд буцаан төлөх төлбөрт хувь нэмрээ оруулдаг. Санхүүжилтийн тэгшитгэх дүрэм болон нийтлэг санхүүжилтийн дүрмийн ялгааг харьцуулан харуулбал:³⁴

Таамаглал	
(а) Нэг нэхэмжлэгч нь гуравдагч этгээдийн санхүүжилтийг авсан, нөгөөх нь санхүүжилт аваагүй нэхэмжлэгчид нэмэгдэх боломжтой нээлттэй класс акционы бий болсон хэмээн төсөөлье.	
(б) 200,000 долларын төлбөрийг нэхэмжлэгчид олгохоор шүүхийн шийдвэр гарсан тооцъё.	
(в) Санхүүжүүлэгч нь санхүүжилтийн гэрээ байгуулсан нэхэмжлэгчийн шүүхийн шийдвэрээр олгох төлбөрийн 20 хувиар санхүүжилтийн төлбөрийн буцан авахаар тохиролцсон.	
Тайлбар: Австрали улсад класс акцион өрнүүлэхэд хамгийн багадаа долоон гишүүн байхыг шаарддаг боловч тайлбарыг энгийн, ойлгомжтой дүрслэхийн тулд зөвхөн хоёр нэхэмжлэгчтэй байхаар жишээ авлаа. Гуравдагч этгээдийн санхүүжилт авсан, аваагүй нэхэмжлэгчийн үр өгөөж болон гуравдагч этгээдийн авах санхүүжилтийг харьцуулан харуулав.	
Санхүүжилтийн тэгшитгэх дүрэм (Funding Equalization Order)	
Нэхэмжлэгч А (санхүүжилт авсан) Хохирлын нөхөн төлбөрт шүүхээс болгохоор шийдвэрлэсэн хэмжээ: \$100,000 \$20,000 санхүүжүүлэгчийн өгөөж А-д үлдэх хэмжээ \$80,000	Нэхэмжлэгч В Хохирлын нөхөн төлбөрт шүүхээс болгохоор шийдвэрлэсэн хэмжээ: \$100,000 В-ийн нийт үр өгөөж: \$100,000
Тэнцвэржүүлэлт	
А-гаас гаргасан \$20,000-ийг мөн В-ээс хасах бөгөөд хасагдсан нийт хувь хэмжээг нийт нэхэмжлэгч нарт тэнцүү байхаар хуваарилж, үлдэгдлийг буцаан хуваарилна.	
\$80,000+\$10,000А-гаас гаргасан төлбөр=\$90,000	\$80,000+\$10,000В-гаас гаргасан төлбөр=\$90,000
Санхүүжүүлэгчийн комиссын бусад боломжит зардал ³⁵ \$10,000-ийн 20 хувь буюу \$2,000 \$88,000	\$90,000

³³ Dorajay Pty Ltd v Aristocrat Leisure Ltd [2009] FCA 19, [14]; P Dawson Nominees Pty Ltd v Brookfield Multiplex Ltd (No 4) [2010] FCA 1029, [26]–[28];

³⁴ Vicki Waye and Michael Duffy, “The Fate of Class Action Common Fund Orders: The Policy, Procedural and Constitutional Issue of a Legislative Revival”, *University of Queensland Law Journal*, Vol 40(2) (2021), 222-223.

³⁵ Санхүүжилтийн гэрээ нь санхүүжүүлэгч этгээд санхүүжилт аваагүй гишүүдийн нөхөн төлбөрөөс (класс акционы бүх нэхэмжлэгчдийн) дахин хуваарилсан дүнгээс нэмэлт шимтгэл авах боломжийг олгож болно.

Нийт үр өгөөж Нэхэмжлэгч А \$88,000 Санхүүжүүлэгч \$22,000	Нэхэмжлэгч В \$90,000
Нийтлэг санхүүжилтийн дүрэм (Common Fund Order)	
Нэхэмжлэгч А (санхүүжилт авсан) Хохирлын нөхөн төлбөрт шүүхээс болгохоор шийдвэрлэсэн хэмжээ: \$100,000 \$20,000 санхүүжүүлэгчийн өгөөж А-д үлдэх хэмжээ \$80,000	Нэхэмжлэгч В (санхүүжилт авсан) Хохирлын нөхөн төлбөрт шүүхээс болгохоор шийдвэрлэсэн хэмжээ: \$100,000 \$20,000 санхүүжүүлэгчийн өгөөж В-д үлдэх хэмжээ \$80,000
Нийт үр өгөөж Нэхэмжлэгч А \$80,000 Санхүүжүүлэгч \$40,000	Нэхэмжлэгч В \$80,000

Иргэнлэг бүлийн эрх зүйн зарим улс орны туршлага:

Нийтлэг эрх зүйн бүлийн улс орнуудтай харьцуулахад иргэнлэг эрх зүйн бүлийн улс орнууд класс акционы хүрээ, нэхэмжлэл гаргах этгээдийн хүрээг нэлээд хязгаарлагдмал байдлаар тодорхойлдог. Иймд уг асуудлыг онол, үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн шинэчлэлийн хүрээнд авч үзэж байгаа иргэнлэг эрх зүй бүлд хамаарах европын зарим улс орнуудын зохицуулалт, туршлагыг авч үзье.

Европын бүс нутагт хэрэглэгчийн эрх, байгаль орчин, мэдээллийн хамгаалалт, санхүүгийн үйлчилгээ зэрэг олон салбарт шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх, хил дамнасан маргааныг шийдвэрлэх, Европын Холбооны хууль тогтоомж, бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх чиглэлд сүүлийн жилүүдэд онцгой анхаарал хандуулж байна. Үүний үр дүнд Европын Холбоо Хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхлыг хамгаалах төлөөллийн үйл ажиллагааны тухай 2020/1828 удирдамжийг нэвтрүүлж, 2009/22/ЕС удирдамжийг хүчингүй болгосон.³⁶

Дээрх удирдамж нь гишүүн улс орнуудын хамтын нэхэмжлэл гаргах талаарх үндэсний эрх зүйн зохицуулалтыг орлохгүй, харин тэдгээрийн зохицуулалтыг уялдуулах, нэмэлтээр дэмжих зорилготой. Ингэхдээ нэг талаас шударга ёсны хүртээмжийг тэнцвэржүүлэх, нөгөө талаас хууль бусаар зарга мэдүүлэхээс урьдчилан сэргийлэх процессын баталгааг хангах гэсэн үндсэн хоёр асуудалд онцгойлон анхаарч хамтын нэхэмжлэл гаргах төлөөллийн эрхийг “мэргэшсэн байгууллага” (qualified entity)³⁷-д олгохыг дэмждэг. Удирдамж зааснаар “төлөөлөх арга хэмжээ” гэж хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэгч байх шаардлага хангасан этгээдээс хэрэглэгчийн нэрийн өмнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гомдол барагдуулах арга хэмжээ авах үйлдлийг хэлнэ.

Мэргэшсэн байгууллага нь дараах шаардлагыг хангасан байхаар удирдамжид тодорхойлсон.³⁸

- Гишүүн улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан байх, нэхэмжлэл гаргахаас өмнө хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр 12 сарын хугацаанд олон нийтийн бодит үйл ажиллагааг явуулсан байх;
- Ашгийн бус зорилготой байх, үйл ажиллагааны зорилго нь Европын холбооны хууль тогтоомжид заасан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолтой байх;

³⁶ Directive (EU) 2020/1828 of the European Parliament and of the Council of 25 November 2020 on representative actions for the protection of the collective interests of consumers and repealing Directive 2009/22/EC (Text with EEA relevance), https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2020.409.01.0001.01.ENG (access 11.11.2025).

³⁷ “Мэргэшсэн байгууллага” гэж гишүүн улсаас энэхүү удирдамжийн дагуу төлөөлөх үйл ажиллагаа явуулах эрх бүхий гэж тодорхойлсон хэрэглэгчдийн эрх ашгийг төлөөлдөг аливаа байгууллага, төрийн байгууллагыг хэлэхээр удирдамжид тодорхойлсон.

³⁸ Directive (EU) 2020/1828 of the European Parliament and of the Council of 25 November 2020 on representative actions for the protection of the collective interests of consumers and repealing Directive 2009/22/EC.

- Төлбөрийн чадваргүй гэж зарлагдаагүй, эсхүл төлбөрийн чадваргүйд тооцох маргааны оролцогч болоогүй байх;
- Хараат бус байх, хэрэглэгчээс бусад аливаа этгээд (тухайлбал, худалдаа эрхлэгч, маргааны шүүхийн зардлыг санхүүжүүлэгч гуравдагч этгээд гэх мэт)-ийн нөлөөнд автаагүй, аливаа зүй бус нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам тогтоосон байх;
- Дээрх шалгууруудын хангасан болохыг нотолж санхүүжилтийн эх үүсвэр, зохион байгуулалт, удирдлага, гишүүнчлэлийн бүтэц, дүрмийн зорилго, үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийтэд нээлттэй байршуулсан байх;

Хэдийгээр дээрх удирдамж нь хэрэглэгчийн эрхийн асуудлыг голлон анхаардаг хэдий ч гишүүн улс орнууд, бизнес эрхлэгчдэд эдгээр журмыг хэрэглэх боломж нь чөлөөтэй. Тухайлбал, Герман, Нидерланд, Польш зэрэг улсад хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийн төлөө хамтын нэхэмжлэл гаргах боломжтой бол Бельги улс 2018 онд хамтын нэхэмжлэл гаргах үндэсний хуулийн хамрах хүрээг өргөжүүлж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хамтын маргаан өдүүлэх боломжийг олгосон. Түүнчлэн Франц улсад дээрх удирдамжийг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан хуулийн төсөлд хамгийн багадаа таван хувийн хуулийн этгээдийг төлөөлөн үйл ажиллагаа явуулдаг холбоод энэ төрлийн нэхэмжлэлийг гаргаж болохоор тусгасан.³⁹

ЕХ-ны бусад санаачилгууд нь шүүхийн зардлыг хариуцах гуравдагч этгээдийн санхүүжилтийн механизмд ихээхэн нөлөөлдөг. Тухайлбал, 2022 оны есдүгээр сард Европын парламентаас ЕХ дахь гуравдагч санхүүжүүлэгчдийн зохицуулалтыг сайжруулах тогтоолыг баталсан.⁴⁰ Энэхүү тогтоол нь класс акцион буюу хамтын нэхэмжлэлд гуравдагч этгээдийн санхүүжилтэд чиглэсэн дараах суурь стандартыг тогтоож, Шүүхийн маргааны хариуцлагатай хувийн санхүүжилтийн тогтоолын (Resolution on responsible private funding of litigation)-гөслийг хавсаргасан.⁴¹

- санхүүжүүлэгчид зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих хяналтын байгууллагыг бий болгох;
- шүүхийн зардлыг санхүүжүүлэгч болон санхүүжилт авсан талууд хамтран хариуцах;
- санхүүжилтийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байхыг санхүүжүүлэгчдээс шаардах;
- санхүүжүүлэгчид нь санхүүжилт авч байгаа талын эрх, ашиг сонирхлыг ямагт хүндэтгэх фидуцийн үүрэг хүлээх;
- санхүүжилтийн гэрээ байгаа эсэхийг холбогдох шүүх, захиргааны байгууллагад мэдээлэхийг санхүүжүүлэгчид үүрэг болгох;
- онцгой нөхцөл байдал байхгүй бол санхүүжүүлэгчдийн эзлэх хувийг нөхөн олговрын 40 хувьд хүртэл хязгаарлах.

ЕХ-ны гишүүн улс орнууд 2022 оны 12 дугаар сарын 25-ны дотор уг удирдамжийг дотоодын хуульдаа хэрэгжүүлж, 2023 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх заалтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Грек, Нидерланд, Итали, Литва, Унгар, Словени зэрэг улсууд 2023 оны 6 дугаар сарын эцэс гэхэд үндэсний хэмжээнд энэ талаарх арга хэмжээг хэрэгжүүлсэн.⁴²

ЕХ-ны гишүүн улсын төлөөлөл болгон Итали улсын туршлагыг товч авч үзье. Итали улс хэрэглэгчдийг эрхийг хамгаалах хамтын нэхэмжлэл гаргах асуудлыг холбогдох

³⁹ A&O Shearman, "Class actions in the European Union", <https://www.lexology.com/library/detail.aspx?g=097dd0b4-28f2-4c2f-9a55-0ce3e58183f4#&:text=While%20the%20focus%20of%20the.and%20medium%20enterprises%20in%202018.>

⁴⁰ European Parliament resolution of 13 September 2022 with recommendations to the Commission on Responsible private funding of litigation (2020/2130(INL)), https://www.europarl.europa.eu/doceo/document/TA-9-2022-0308_EN.html

⁴¹ Ibid.

⁴² A&O Shearman, "Class actions in the European Union".

хуулиар хязгаарласаар ирсэн уламжлалтай.⁴³ 2019 онд Хэрэглэгчийн тухай хуулиас тусад нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар олон нийтэд бүртгэлтэй байгууллага, холбоодод ижил төстэй бүлгүүдийн эрхийг хамгаалах зорилгоор хамтын нэхэмжлэлийг төлөөлөх гаргах боломжийг олгосон.

“Хамтын нэхэмжлэл буюу класс акционы шинэчлэл» хэмээн нэрлэгдэх энэхүү арга хэмжээ нь хэрэглэгчийн эрхийн хүрээнд хамтын нэхэмжлэл гаргах боломжийг өргөтгөсөн боловч энэ төрлийн харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм журам, нэхэмжлэгчийн гаргасан өндөр зардал, хуулийн фирмүүд бүлгийн нэхэмжлэлийг хүлээн авах урамшуулал хангалтгүй зэрэг нь энэхүү тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлж байна. Уг шинэтгэлийн цар хүрээ нь бараа бүтээгдэхүүний доголдол, шударга бус гэрээний нөхцөл, хувийн мэдээллийг зөрчих, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудал, эмийн үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ гэх зэрэг өргөн хүрээг хамрах боломжтой.

Хамтын маргааны гуравдагч этгээдийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал тус улсад өргөн хүрээний хэлэлцүүлгийн сэдэв болж байна. Шүүхийн маргааныг шийдвэрлэхэд маш их хугацаа зарцуулдаг, шүүхийн практик савлагаа ихтэй, өөрчлөгддөг зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй болгодог тул олон улсын томоохон хөрөнгө оруулагчид энэ зах зээлд шүүхийн зардалд хөрөнгө оруулалт хийхээс болгоомжилсон хэвээр байна.⁴⁴ Гэхдээ энэ салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна. Тус улсын эдийн засагт жижиг, дунд үйлдвэрлэлд илүүтэй суурилдаг тул эдгээр салбарт түшиглэсэн хил дамнасан эрх зүйн маргаанд шүүхийн зардлын хөрөнгө оруулалт илүүтэй чиглэдэг.⁴⁵

Америкийн тогтолцоотой харьцуулахад шүүхийн зардлын санхүүжилтийн гэрээг зээлийн эсхүл хөрөнгө оруулалтын, эсхүл даатгалын гэрээ хэмээн үздэггүй бөгөөд atypical contract буюу гэрээний төрлийг тогтоох боломжгүй гэрээнд хамруулдаг. Аль ч гэрээний төрлөөр тайлбарласан эсэхээс үл хамааран уг гэрээний дагуу шүүхийн зарга маргаанд ялагдсан хөрөнгө оруулалтыг хүлээн авсан тал хөрөнгө оруулагч талд зардлыг буцаан төлөх үүрэг хүлээхгүй.

Тус улсын холбогдох хууль тогтоомжид санхүүжилтийг хүлээн авагч болон санхүүжүүлэгч талууд шүүхийн зардлын санхүүжилтийн гэрээ байгаа эсэх, эсвэл санхүүжүүлэгчийн хувийн мэдээллийг задруулах үүргийг хуульчлаагүй хэвээр байна. Иймд шүүхийн зардлын гуравдагч этгээдийн санхүүжилтийн гэрээ байгаа эсэхийг ил болгох эсэх нь маргалдагч талуудын хувьд стратегийн сонголт байж болно. Энэ нь гуравдагч этгээдийн санхүүжилтийн гэрээнд холбогдох талуудын эрх ашгийг тэнцлийг хангахад шүүхийн үүрэг оролцоог тодорхойгүй байдалд хүргэдэг.

Франц улс. Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний арбитрын хурдацтай хөгжлийн нөлөөгөөр тус улсад шүүхийн санхүүжилтийн портфолио санхүүжилт (portfolio funding), хамтарсан санхүүжилт (co-funding), хамгаалалтын санхүүжилт (defence funding) зэрэг олон хувилбар хөгжсөн. Парисын хуульчдын зөвлөл олон улсын арбитрын хүрээнд гуравдагч этгээдийн шүүхийн санхүүжилтийг ашиглах нь нэхэмжлэгч болон хуульчдын, ялангуяа олон улсын арбитрын эрх ашигт бүрэн дүүрэн нийцнэ хэмээн мэдэгдсэн.⁴⁶

Шүүхийн маргааны зардлын гуравдагч этгээдийн санхүүжилтийн зохицуулалт нь энэ төрлийн харилцааны оролцогчдын өөрийн зохицуулалт болон төрийн зохицуулалтаас бүрдэнэ. Төрийн зохицуулалтыг бий болгоход Европын Холбоо Хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхлыг хамгаалах төлөөллийн үйл ажиллагааны тухай 2020/1828 удирдамж ихээхэн нөлөөлсөн.

⁴³ Herbert Smith Freehills Kramer, “Class Actions radar: Italy” (2024) <https://www.hsfkramer.com/insights/reports/class-actions-radar-scanning-global-trends-and-risks/italy>

⁴⁴ Giacomo Lorenzo, “Litigation Funding Overview – Italy: Review of the third-party legal funding market in Italy”, <https://www.deminor.com/en/litigation-funding/global-landscape/italy/>

⁴⁵ Ibid.

⁴⁶ Olivia de Tatoul, “Litigation Funding Overview – France: Review of the third-party legal funding market in France” <https://www.deminor.com/en/litigation-funding/global-landscape/france/> (access 30 Sep 2025)

Итали улсын нэгэн адил Франц улсад гуравдагч этгээдийн шүүхийн зардлыг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой харилцааг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулаагүй хэдий ч гэрээний эрх чөлөөний зарчим, гэрээний нөхцөл, талуудын хүсэл зоригийг харгалзан гэрээний төрлийг шүүхээс тодорхойлох боломжтой.

Түүнчлэн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалт, ёс зүйн хэм хэмжээ, тухайлбал 1971 оны хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалт, мэргэжлийн үйл ажиллагааны нууцлалыг хадгалах, хараат бус байх, гэнэтийн төлбөр авахыг хориглох зэрэг зохицуулалт нь санхүүжилтийн гэрээнд зарим талаар нөлөөлдөг. Тухайлбал, хараат бус байх үүрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх аливаа стратегийн шийдвэр, тэр дундаа маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэх талаарх зөвлөгөө өгөхөд хамаарна. Энэ үүргийн дагуу хуульч, өмгөөлөгчид шүүхийн зардлыг санхүүжүүлэгчээс бус харин үйлчлүүлэгчээс заавар авах ёстой. Үүнийг Францын хуульчдын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрийн тогтоолоор мөн баталгаажуулсан.⁴⁷ Иймд өмгөөлөгч нь үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдийн санхүүжүүлэгчид нэгэн зэрэг зөвлөгөө өгөх боломжгүй бөгөөд үйлчлүүлэгчийн эзгүйд санхүүжүүлэгчтэй уулзахаас татгалзахаар зохицуулсан.

Хамтын шүүхийн маргаанд нэхэмжлэгчид өмгөөлөгч буюу хуулийн фирмийг сонгох эрхтэй хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульч, өмгөөлөгч, хуулийн фирмийг солих тохиолдолд санхүүгийн баталгаатай үр шимийг хүртэхийн тулд хөрөнгө оруулсан санхүүжүүлэгч гуравдагч этгээдтэй зөвшилцож, тохиролцсон байх шаардлагатай. Гэхдээ эцсийн сонголт хийх эрхийг нэхэмжлэгч хэрэгжүүлнэ.

Санхүүжүүлэгч нь хэрэг хянан шийдвэрлэж ажиллагаа, өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн хоорондын харилцаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй хэдий ч гэрээнд тухайлан заасан тохиолдолд шүүх хуралдаанд хөндлөнгийн журмаар байлцаж болно. Нээлттэй шүүх хуралдаанд энэ нь тийм ч ач холбогдолтой тохиролцоо биш хэдий ч харин арбитрын хуралдаанд энэ нь чухал ач холбогдолтой. Гэвч санхүүжүүлэгч тал арбитрын хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд хөндлөнгийн ажиглагчаар оролцох нь түгээмэл бус бөгөөд арбитрын бүхий л ажиллагааны нууцыг хадгалахын тулд нэхэмжлэгч болон хариуцагч талууд энэ талаар тохиролцсон байх шаардлагатай.

Түүнчлэн маргалдагч талуудын тохиролцоо, тохиролцооны үнийн дүнгийн босго гэх мэт санхүүжилтийн гэрээний зорилго, үр ашигтай холбоотой асуудал, тухайлбал, хариуцагчийн санал болгосон үр ашиг багатай зөвшилцлийн саналыг хэрхэх талаарх асуудалд хөрөнгө оруулагч талын оролцоог үгүйсгэх боломжгүй бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэх талаарх харилцааг хөрөнгө оруулалтын гэрээнд тодорхой тусгадаг.

Шүүхийн санхүүжилтийн гэрээг цуцалж болох нөхцөлийн талаар талууд чөлөөтэй тохиролцох бөгөөд ихэвчлэн эдгээр нөхцөлийг урьдчилан тодорхойлсон жагсаалтыг гэрээнд тусгадаг. Эдгээр жагсаалтад ихэвчлэн нэхэмжлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэгсэхгүй болгох, урьд өмнө мэдэгдээгүй баримт, нөхцөл байдал бий болсон, нотлох баримт алдагдсан эсвэл өмнө нь ил болоогүй нотлох баримтууд илэрсэн, шийдвэр гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн үйл явдлууд (жишээ нь, төлбөрийн чадваргүй болох, дампуурах) зэрэг нөхцөлийг тусгадаг.

Ийм нөхцөлд санхүүжүүлэгч нь гэрээг дуусгавар болох хүртэл олгосон санхүүжилтээ алдаж болзошгүй бөгөөд гэрээг цуцалснаас үүсэх зардлыг ихэвчлэн хариуцна. Санхүүжилтийг хүлээн авагч тал шүүхийн санхүүжилтийн гэрээг зөрчсөн нь гэрээний зөрчлийн хэр хэмжээнээс хамааран урьдчилан мэдэгдэх журмаар эсвэл мэдэгдэхгүйгээр дуусгавар болгох бөгөөд санхүүжүүлэгчид гарсан зардал, хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.⁴⁸

⁴⁷ Ibid.

⁴⁸ Olivia de Tatoul, Litigation Funding Overview – France: Review of the third-party legal funding market in France. <https://www.deminor.com/en/litigation-funding/global-landscape/france/>

III. ДҮГНЭЛТ

Класс акцион болон хамтын нэхэмжлэл гаргах үйл ажиллагаанд шүүхийн буюу шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх, нэхэмжлэгч болон хариуцагчдын харилцааны тэгш бус байдлыг бууруулахын тулд шүүхийн зардлын санхүүжилтийн олон хувилбарыг бий болгох асуудлыг улс орнууд чухлаар хэлэлцэж байна. Зарга маргаанд ялагдсан тал нь шүүхийн зардал болон маргалдагч нөгөө талд учирсан хохирлыг барагдуулах процессын үйл ажиллагааны нэгэнт тогтсон дэглэм, шүүхийн зардлыг урьдчилан төлөх, эсхүл төлөх баталгааг хангах шаардлага нь ихэвчлэн нэхэмжлэгч талд шударга ёсыг шаардах, учирсан хохирлыг арилгуулах, эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсооход бэрхшээл учруулдаг нь шүүхийн зардлыг хариуцах гуравдагч этгээдийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрөх үндэслэл болж байна.

Гэвч ийнхүү гуравдагч этгээдийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрсөн нь шүүхийн үйл ажиллагааг бизнесийн буюу ашиг олох зорилгоор ашиглах, санхүүжүүлэгч болон санхүүжүүлэлтийг хүлээн авагч талын хоорондын харилцаанд хуульч, өмгөөлөгч, хуулийн фирмийн мэргэжлийн үйл ажиллагааны үйл ажиллагааны ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудал чухлаар хөндөгдөж байна. Уг асуудлыг шийдвэрлэх үндсэн үр дүнтэй арга нь санхүүжүүлэгчид болон санхүүжилтийн гэрээний ил тод байдлыг хангаж, санхүүжилтийн гэрээнд шүүхийн хөндлөнгийн хяналтыг бий болгох явдал. Нийтлэг болон иргэнлэг эрх зүйн бүлийн улс орнуудын энэ төрлийн харилцааны шүүхийн хяналтын хүрээ, хяналтын арга, хэлбэрийн зохицуулалт харилцан адилгүй хэдий ч шүүхийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалтын хандлага нийтлэг ижил болж байна.

Монгол Улсын хувьд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар класс акцион буюу хамтын нэхэмжлэл гаргах талаарх харилцааг тухайлан зохицуулаагүй, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд зарим хязгаарлагдмал хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч эдгээр маргаанд шүүхийн зардлын асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга, боломжийн талаар зохицуулалтгүй хэвээр байна. Иймд Монгол улсад нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, хэд хэдэн оролцогч хамтран нэхэмжлэл гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн маргааны гуравдагч этгээдийн санхүүжилтийн тогтолцоог бий болгох боломжийн талаар хэлэлцэх шаардлагатай.

ЭХ СУРВАЛЖ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он.
2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027).

Б.Эрдэм шинжилгээний бүтээл

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх”, УБ, 2013 он.
2. С.Сүхчулуун, “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахтай холбоотой хууль хэрэглээний практик ба Улсын Дээд Шүүхийн Тайлбар”, Нээлттэй Нийгэм Форум, Бодлогын Асуудал, №45, 2024 он.
3. Ө.Эрдэнэ-Очир: “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”, Legaldata.mn, 2023.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Directive (EU) 2020/1828 of the European Parliament and of the Council of 25 November 2020 on representative actions for the protection of the collective interests of consumers and repealing Directive 2009/22/EC
2. European Parliament resolution of 13 September 2022 with recommendations to the Commission on Responsible private funding of litigation (2020/2130(INL))
3. Australian Law Reform Commission, “Integrity, Fairness and Efficiency – An Inquiry into Class Action Proceedings and Third-Party Litigation Funding”, [2018] ALRC 134
4. Dorajay Pty Ltd v Aristocrat Leisure Ltd - [2009] FCA 19
5. Campbells Cash and Carry Pty Ltd v Fostif Pty Ltd (2006) 229 CLR 386, [65] citing Fostif Pty Ltd v Campbells Cash & Carry Pty Ltd (2005) 63 NSWLR 203, 227 [105].

Б. Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Bernard Murphy and Camille Cameron, “Access to Justice and the Evolution of Class Action Litigation in Australia”, Melbourne University Law Review, Vol 30, 2006.
2. Ben Chen and Michael Legg, “An Economic Perspective on cost in Australian Class Action”, Melbourne University Law Review, Vol 45(3), 2022.
3. Binyamin Applebaum, “Putting Money on Lawsuits, Investors Share in the Payouts”, N.Y. TIMES, Nov. 15, 2010.
4. Deborah R. Hensler, “Third-Party Financing of Class Action Litigation in the United States: Will the Sky Fall?”, DePaul Law Review, Vol. 63, 2014.
5. Edward Elgar, “Encyclopedia of Law and Economics”, Procedural Law and Economics, vol 8, 2012.
6. Giacomo Lorenzo, “Litigation Funding Overview – Italy: Review of the third-party legal funding market in Italy”, 2025.
7. Herbert Smith Freehills Kramer, “Class Actions radar: Italy”, 2024.
8. Mark Behrens, “Third-party litigation funding: A call for disclosure and other reforms to address the stealthy financial product that is transforming the civil justice system”, Cornell Journal of Law and Public Policy, Vol 34:1, 2025)

9. Michael Legg, “The rise and regulation of litigation funding in Australian Class Action”, UNSWLRS 8, 2022.
10. Nicholas M. Pace, Stephen J. Carroll, Ingo Vogelsang & Laura Zakaras, “Insurance Class Actions in the United States”, RAND Corporation, 2007.
11. Olivia de Tatoul, “Litigation Funding Overview – France: Review of the third-party legal funding market in France” Samuel Issacharoff, “Class Action Conflicts”, University of California Davis Law Review, 30(3), 1997.
12. Theodore Eisenberg & Geoffrey P. Miller, “Attorney Fees and Expenses in Class Action Settlements: 1993–2008”, Cornell Law Review, Vol 6, 2010.
13. Brookfield Multiplex Ltd (No 4) [2010] FCA 1029, [26]–[28];
14. Vicki Wayne and Michael Duffy, “The Fate of Class Action Common Fund Orders: The Policy, Procedural and Constitutional Issue of a Legislative Revival”, University of Queensland Law Journal, Vol 40(2), 2021.
15. Suneal Bedi, William C. Marra, “The Shadows of Litigation Finance”, Vanderbilt Law Review, Volume 74(3) (2021)

3. Цахим эх сурвалж

1. <https://www.uschamber.com/lawsuits/setting-the-record-straight-on-third-party-litigation-funding>
2. <https://news.bloomberglaw.com/litigation-finance/putins-billionaires-sidestep-sanctions-by-financing-lawsuits>

**THIRD-PARTY FUNDING OF LITIGATION COSTS IN CLASS ACTIONS AND
COLLECTIVE DISPUTES
(A COMPARATIVE STUDY OF THE UNITED STATES, AUSTRALIA, ITALY, AND
FRANCE)**

Buyandavaa.Z

*Founding Partner and Director of
Golomt Legal Consulting LLP*

ABSTRACT:

Class actions have emerged as an important procedural mechanism for enabling individuals to seek redress for widespread rights violations and to obtain judicial compensation for harm caused by unlawful conduct by governments, corporations, and other actors. Despite their growing significance, jurisdictions that permit class actions continue to face structural challenges arising from disparities in financial and institutional resources between the parties to litigation. These challenges have underscored the critical role of effective litigation financing mechanisms in ensuring meaningful access to justice. Against this background, this article undertakes a comparative analysis of the regulatory approaches to third-party funding of litigation costs in class actions in the United States, Australia, Italy, and France. The study seeks to contribute both theoretical insight and practical guidance for the further development of policy and legal frameworks aimed at expanding access to class actions and public interest representative litigation in Mongolia. To avoid conceptual ambiguity, particular attention is paid to distinguishing the approaches adopted within common law and civil law legal traditions.

KEYWORDS:

Class actions; litigation costs; third-party funding

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ



Б.Намуун-Эрдэнэ
МУИС-ийн ХЗС-ийн магистрант

Товчлол:

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг оновчтой тодорхойлох нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ хэргийн бодит байдлыг үнэн зөвөөр тогтоож, ялын бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолохоор шинэчлэн зохицуулсан. Уг өөрчлөлттэй холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааг тоолох журамд эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зарчим үйлчлэх эсэх талаар үзэл баримтлалын болон хууль хэрэглээний зарим зөрүүтэй ойлголт бий болоход хүрсэн. Энэхүү бэсрэг өгүүллийн зорилго нь уг асуудлыг тухайлан тодруулан шинээр авч үзэж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалыг гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалттай тоймлон харьцуулж, өөрийн хийсэн судалгаанд тулгуурлан үндэслэл бүхий зарим санал, дүгнэлтийг дэвшүүлэхэд чиглэгдсэн болно. Түүнчлэн өөрийн магистрын судалгааны ажлын үр дүн, эх сурвалжид тулгуурлан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг зарим гадаад орнуудын эрүүгийн эрх зүйтэй харьцуулж нийтлэг чиг хандлагыг тодорхойлох, 2015 оны Эрүүгийн хууль, 2020 оны 01 дүгээр сарын 10-нд Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлт, ҮХЦ-ийн дүгнэлт, УДШ-ийн тогтоол зэрэг анхаарал татсан асуудалд судалгаагаа чиглүүлж, тулгамдсан асуудлыг тодорхойлоход энэхүү өгүүллийн зорилгыг чиглүүлсэн болно.

Түлхүүр үгс:

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, Эрүүгийн хууль, Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх, Хөөн хэлэлцэх хугацааг тоолох нөхцөл журам, Материаллаг эрх зүйн хэм хэмжээ, Процессын эрх зүйн хэм хэмжээ

I. ОРШИЛ

Хөөн хэлэлцэх хугацааны тухай анхны төсөөлөл Ромын эрх зүйд анхлан үүссэн бөгөөд өнөө үед зөвхөн хувийн эрх зүй төдийгүй нийтийн эрх зүйн салбарт ч чухал ач холбогдол бүхий судлагдахуун болсон билээ. Тодруулбал, Ромын эрх зүйн гол эх сурвалж болох “Арван хоёр хүснэгтийн хууль”-ийн “Өмчлөх ба эзэмших эрхийн тухай” VI хүснэгтийн

долдугаар зүйлд “Хөдлөх эд хөрөнгийн хувьд нэг жилийн [Эзэмшил]-ээр, харин үл хөдлөх хөрөнгө болон барилга байгууламжийн хувьд хоёр жилийн [Эзэмшил]-ээр хөөн хэлэлцэх эрх (Usucapio) дуусна.”¹ Гэж заасан нь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын эхлэл болсон гэж үздэг. Улмаар энэхүү ойлголт нь дэлхийн олон улсын, тэр дундаа эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах орнуудын хууль тогтоомжид зонхилон тусгагдаж, улам боловсронгуй болсоор иржээ.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн эрдэмтэн, судлаачид гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын онол, практикийн асуудлыг өөрсдийн бүтээлүүдэд тусган, судалсаар ирсэн. Тухайлбал, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, академич С.Нарангэрэлийн “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” ерөнхий анги (1999), хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” (1973), “Эрүүгийн хариуцлага: уламжлал, шинэчлэлийн асуудал” хууль зүйн докторын зэрэг горилж бичсэн бүтээл (1992), хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцангийн “Гэмт хэргийн олонлог” (1990), “Монгол Улсын эрүүгийн эрх зүй (альбом-схем)” (1991), доктор, профессор Д.Баярсайханы “Харьцуулсан эрүүгийн эрх зүй” (2011), Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган нарын “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал” (2004), Г.Гантөмөр, О.Амарсайхан нарын “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа” (2004), Х.Сэлэнгэ “Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол практикийн асуудал” (2022), Г.Гантөмөр “Үндэсний эрүүгийн эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн асуудал” (2024) зэрэг бүтээлүүд гарсан бөгөөд тэдгээрт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны үндсэн асуудлыг зохих хэмжээнд хөндөж бичсэн байдаг. Түүнчлэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 онд гаргасан “Судалгааны тайлангийн эмхэтгэл XX боть (Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгаа)”-д гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг харьцуулсан судлалын болон, норматив судалгааны хүрээнд нэлээд дэлгэрэнгүй гаргасан байдаг. Харин 2020 оны 01 сарын 10-нд орсон нэмэлт өөрчлөлт болон ҮХЦ-ийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 12 дүгнэлт, Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 11 тогтоол зэрэг өнөөгийн анхаарал татсан асуудлыг харьцуулж судлан дүн шинжилгээ хийсэн бүрэн хэмжээний бүтээл хараахан гараагүй байна.

Хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн үеэс хойш тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэм хэмжээг харгалзан гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах, эрүүгийн хариуцлагыг хөөн хүлээлгэж болох үйлдсэн гэмт хэргийн ангиллаар нь ялгамжтай тогтоосон хугацааг хэлнэ.² Эрүүгийн хуулиар тогтоосон энэ хугацаа өнгөрсний дараа /хуулиар тухайлан хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж зааснаас бусад төрлийн гэмт хэрэгт/ гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэл оногдуулах боломжгүй болдог.

Хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачид гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, академич С.Нарангэрэл: “Эрүүгийн эрх зүйн институтын нэг, хэрэв шүүн таслах ажиллагаанаас зайлсхийгээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацаа.”³, доктор, профессор С.Жанцан: “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах, эрүүгийн хариуцлагыг хөөн хүлээлгэж болох үйлдсэн гэмт хэргийн ангиллаар ялгамжтай тогтоосон хугацаа.”⁴, доктор, профессор Д.Баярсайхан: “...нийтлэг утгаараа тухайн хэрэг үйлдэгдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа энэхүү хэрэг илэрч, мөрдөж шалгах буюу хянан шийдвэрлэх үед эрүүгийн хариуцлага ба ялыг шууд оногдуулах боломжгүй байдал бий болсныг ойлгоно.

¹ The Twelve Tables, <https://archive.org/stream/thetwelvetables14783gut/14783.txt>

² Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, 2013, 212 дахь тал.

³ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монголын эрх зүйн эх толь бичиг*, (Улаанбаатар: Адмон, 2015), 516 дахь тал.

⁴ Суурийн Жанцан, *Гэмт хэргийн олонлог*, (Улаанбаатар, 1990).

Өөрөөр хэлбэл эрүүгийн хариуцлагад татах үндэслэлийг үгүйсгэж буй цаг хугацааны хүчин зүйлээр нөхцөлдсөн бодит шаардлагыг илэрхийлнэ.”⁵ гэж тодорхойлсон байдаг. Мөн доктор, профессор Г.Совд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй (хөөн хэлэлцэх) хугацааг хуульчилсан явдал бол гэмт хэрэг үйлдсэнээс хойш уг этгээдийг илрүүлж, эрүүгийн хариуцлагад таталгүй урт хугацаа өнгөрсний дараа хуульд заасан болзол бүрдсэн нөхцөлд хэрэг хуучирсан буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх нь хууль ёсны үндэслэл юм. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш илрэхгүй хуульд заасан хугацаа өнгөрч гэмт хэрэг хуучирсан тохиолдолд эрүүгийн хариуцлагад татаж болдоггүйн шалтгаан гэвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ямар ч зорилгогүй болсон байдаг.”⁶, доктор Гантөмөр “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хугацаа нь зөвхөн материаллаг эрүүгийн эрх зүй төдийгүй, эрүүгийн процесст хамааралтай судлагдахуун”⁷ гэжээ.

Гадаадын эрдэмтдээс харьцуулсан эрүүгийн эрх зүй судлаач В.Н.Додонов “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа материаллаг эрүүгийн эрх зүйд илүү хамааралтай бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг тодорхойлох шалгуур төдийгүй гэмт хэргийн институцийн судлагдахуунд зайлшгүй хамаарагдах ойлголт”⁸ гэж тэмдэглэсэн байдаг.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг зарим эрдэмтэд, тухайлбал, А.М.Иванов, А.Г.Корчагин, А.В.Наумов, J.C. Smith, G.Dix зэрэг судлаачдын үзэж байгаагаар Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх онолын үзэл баримтлалыг хэд хэдэн чиг хандлагаар авч үздэг байна. Үүнд:

1. Шалгуур үндэслэл талаас нь:

- Зөвхөн ялын санкцийн хэмжээ шалгуураар;
- Гэмт хэргийн үр дагавар, ангиллын зарчмаар;

2. Эрүүгийн хариуцлагын үр дагавар, үр нөлөөний шалгуураар:

- Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцож болохгүй нөхцөлүүд;
- Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцож болох нөхцөлүүд;

3. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг процессын шалгуураар:

- Гэмт хэрэг гарсан өдрөөс шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тооцох
- Гэмт хэрэг гарсан өдрөөс гэмт хэргийг илрэх хүртэл буюу эрүүгийн хэрэг үүсгэх хүртэл тооцох г.м

Дээр дурдсан үзэл хандлагууд нь эрдэмтэн, судлаачдын хувьд бүрэн нэгдмэл чиг хандлагатай болж чадаагүй бөгөөд орчин үед уг асуудлыг материаллаг эрүүгийн эрх зүй болон эрүүгийн процессын алинд хамааруулах талаар эрдэмтэд нэгдмэл бус байр суурьтай байдаг боловч эх газрын тогтолцооны орнуудын ихэнх судлаачид түүнийг материаллаг эрүүгийн эрх зүйд хамааруулж үзэх нь түгээмэл байна.⁹ Түүнчлэн эрүүгийн эрх зүйн онолын хувьд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны Позитив онолоор (В.Н.Додонов): “Эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчмын үүднээс хэдийгээр гэмт хэрэг үйлдсэнээс хойш тодорхой хугацаанд үйлдсэн хэргийнхээ нийгмийн хор аюулыг ухамсарлаж ойлгосон, засарч хүмүүжсэн гэж үзвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой” гэж тайлбарладаг. Тэгвэл Негатив онолоор (И.А.Малиновский) тайлбарлахдаа: “Хуулийн байгууллагууд хэргийг түргэн шуурхай илрүүлэх үүргээ биелүүлээгүйгээс ял завшуулж, Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг зөрчихөд хүргэнэ. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинжээ алдаж, улмаар төрийн зүгээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрхээ

⁵ Должингийн Баярсайхан, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй*, (Улаанбаатар: Адмон, 2011), 181 дэх тал.

⁶ Галдангийн Совд, *Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар*, (Улаанбаатар: Бест колор, 2002).

⁷ Галбатын Гантөмөр, *Үндэсний эрүүгийн эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн асуудал*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2024), 276 дахь тал.

⁸ Додонов В.Н. Сравнительное уголовное право. Учебник. изд. Юрлитинформ.М. 2009. –176-180, 392 с.

⁹ Хилгендорф Эрик, Дашзэвэгийн Чанцалдулам, *Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Удиртгал*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015).

алдах, эрүүгийн процессын хувьд хэргийг илрүүлэхэд бэрхшээлтэй байдал үүсэх зэрэг сөрөг нөхцөл байдал бий болж хэргийн ул мөр арилах, нотлох баримт устаж үгүй болох нөхцөлийг бүрдүүлдэг.

Өөрөөр хэлбэл хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хугацааны хязгаар (хөөн хэлэлцэх хугацаа) тогтоох нь цаг хугацааны явцад хэргийн үйл баримт бүдгэрч, нотлох баримтын чадамж сулрах, ялын зорилго биелэхгүй болох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжрах, улмаар эрүү шүүлт болон ялаас гадуурх төрийн дарамт үүсэх эрсдэл нэмэгдэх зэрэг хэд хэдэн бодит шаардлагад үндэслэдэг байна.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

Эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлалаас үзэхэд, 1926 оноос хойш батлагдан гарсан Монгол улсын бие даасан төрөлжсөн Эрүүгийн хуулиудад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалт тухай бүр тусгагдан, цаг үеийн шаардлага болон эрх зүйн хөгжлийн түвшинд нийцүүлэн боловсронгуй болж хөгжсөөр иржээ. Тухайлбал, 1926, 1929 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичигт “Ялыг үл хэлэлцэх”, 1934 оны Шүүх цаазын бичигт “Шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаан”, 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд “Хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаан” хэмээн тус тус хуульчилсан байдаг.¹⁰ Харин 1961 оны Эрүүгийн хуульд “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн нэр томъёог анхлан тусгасан ба тус улсын хууль тогтоомжид уг хугацааг “эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа” болон “шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацаа” гэж ялган тодорхойлж хуульчилсан. ОХУ болон Пост-Коммунист улсуудын эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааг “Эрүүгийн хариуцлагад татах хугацаа” гэсэн агуулгаар тодорхойлж ирсэн бөгөөд хууль зүйн үр дагавар нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх байв.¹¹

1961 оны Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйл¹² болон 1986 оны Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд¹³ эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг зарчмын хувьд ижил агуулгаар хуульчилсан байдаг. Харин 1986 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацаанд дараах өөрчлөлтүүдийг оруулжээ. Тухайлбал, таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэнээс хойш найман жил өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагад татах боломжгүй гэж заасан зохицуулалтыг “Таван жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл түүнээс хүнд ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш арван жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татахгүй” гэж; “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй” гэсэн заалтыг арван таван жил болгон өөрчлөн тусгасан байна.¹⁴

2002 оны Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацааг тухайн гэмт хэргийн ангиллаас /хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд/ хамааруулан тоолохоор хуульчилсан нь өмнө мөрдөгдөж байсан эрүүгийн хуулиудаас шинэлэг зохицуулалт болсон төдийгүй гэмт хэргийн ангиллыг хуульд илүү оновчтой байдлаар тодорхойлсон байна. Мөн хүн төрөлхтний аюулгүй байдал болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байх зохицуулалтыг

¹⁰ Очирбатын Батсүх, *Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2021), 267 дахь тал.

¹¹ Баяраагийн Батаа, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны онолын үндэслэл”, *legaldata.mn*, 2022, 5 дахь тал, (Сүүлд үзсэн: 2025.12.15)

¹² Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн, *Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2011), 430 дахь тал.

¹³ Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн, *Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2011), 527 дахь тал.

¹⁴ Эрүүгийн хууль (1986)-ийн 44 дүгээр зүйл.

тусгасан нь онцлох өөрчлөлт болсон юм. Харин 2002 оны Эрүүгийн хуулийг өмнөх социалист тогтолцооны үеийн Эрүүгийн хуулиудтай харьцуулахад, хөнгөн гэмт хэрэг буюу хорих ял оногдуулахгүй гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг богиносгосон хэдий ч, уг хугацааны дээд хязгаарыг илт нэмэгдүүлсэн, түүнчлэн хөөн хэлэлцэх хугацааны дотор хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах тухай зохицуулалтыг “гэмт хэрэг санаатай үйлдвэл” гэж өөрчилсөн нь ялын бодлогын хувьд харьцангуй чангатгасан буюу гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзэж болох үндэслэл бий.

	1986 оны Эрүүгийн хууль /44 дүгээр зүйл/	2002 оны Эрүүгийн хууль /72 дугаар зүйл/
Хөөн хэлэлцэх хугацаа тоолох	Оногдуулж буй ялын хэмжээтэй уялдуулан тоолохоор зохицуулсан.	Гэмт хэргийн ангиллаас хамааруулан тоолохоор зохицуулсан.
Хөөн хэлэлцэх хугацаа	2 жилээс 15 жил	Зургаан сараас 25 жил
Хөөн хэлэлцэх хугацаа тасрах	Энэ хуулийн 44.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад энэ хуульд зааснаар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шинээр тоолно. ¹⁵	Энэ хуулийн 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно. ¹⁶

2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөөн хэлэлцэх хугацааг ялын төрөл, түүнд оногдуулах ялын хэмжээнээс хамааруулан тогтоосон ба гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолохоор хуульчилсан нь өмнөх Эрүүгийн хуулиудаас ялгаатай онцлог зохицуулалт болсон буюу уг хуулиар хөөн хэлэлцэх хугацаа “тасрах” ойлголт хүчингүй болжээ. Мөн хуульд “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.”¹⁷, “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.”¹⁸ гэж тус тус нэмж хуульчилсан нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолох эрх зүйн үндсийг шинээр бий болгосон төдийгүй, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр хураах боломжийг бүрдүүлсэн зэрэг нь шинэлэг зохицуулалт юм.

	2002 оны Эрүүгийн хууль /72 дугаар зүйл/	2015 оны Эрүүгийн хууль /1.10 дугаар зүйл/
Хөөн хэлэлцэх хугацаа тоолох	Гэмт хэргийн ангиллаас хамааруулан тоолохоор зохицуулсан.	Ялын төрөл, түүнд оногдуулах ялын хэмжээнээс хамааруулан тогтоосон.
Хөөн хэлэлцэх хугацаа	Зургаас сараас 25 жил	1 жилээс 20 жил

¹⁵ ЭХ (1986)-ийн 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

¹⁶ ЭХ (2002)-ийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэг.

¹⁷ ЭХ (2015)-ийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

¹⁸ ЭХ (2015)-ийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг.

Хөөн хэлэлцэх хугацаа тасрах	Энэ хуулийн 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно. ¹⁹	Энэ хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно. ²⁰
Хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	Бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолохоор хуульчилсан байдаг. Уг зохицуулалт нь эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор гэмт хэргийн хөөн хэлэлцэх дуусгахын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зориуд саатуулах, хэргийг буцаах, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэргээр шүүх ажиллагааг удаашруулах нөхцөл байдлыг бий болгосон. Иймд практикт үүсээд буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох” гэснийг “яллагдагчаар татах” болгож өөрчлөлт оруулсан бөгөөд уг өөрчлөлттэй холбогдуулан хууль тогтоогчоос “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийг батлан гаргасан байна.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш шүүхийн практикт хийсэн хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд зарим шүүх хянан хэлэлцэгдэж байгаа хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны дотор ял сонсгож, яллагдагчаар татсан бол уг хугацааг цаашид тоолохгүй, зогсонд тооцно гэж үзсэн бол хэд хэдэн шүүх тухайн өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж дүгнэн уг заалтын өмнөх агуулгыг буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолж хэргийг шийдвэрлэжээ. Энэхүү хууль хэрэглээний зөрүү шүүхийн практикт үүссэнтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол болон Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол тус тус батлагдан гарчээ.

2.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт болон Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолын гол агуулга.

Улсын Их хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, мөн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй гэсэн агуулга оруулсан. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж Цэцийн дунд болон их суудлын хуралдаанаар шийдвэр гаргаж дээрх агуулга бүхий заалтыг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн.

¹⁹ ЭХ (2002)-ийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэг.

²⁰ ЭХ (2015)-ийн 1.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

- *Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 12 дүгнэлтийн агуулгыг тоймлон авч үзвэл:*

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу эрх бүхий этгээд болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээн шалгах аргаар тогтоосон, түүнчлэн зөвхөн тодорхой төрлийн гэмт хэргийг буюу Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгах аргаар тусгасан нь иргэдийн эрх зүйн байдлыг дордуулах нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй Үндсэн хуулиар тунхагласан шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг зөрчсөн байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах агуулгатай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахгүйгээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай дээрх хуулиар тогтоосон нь хууль дээдлэх зарчмыг зөрчсөний зэрэгцээ, эрх зүйн суурь онолд нийцээгүй болно гэх дүгнэлтүүдийг тус тус гаргажээ.²¹

Харин Үндсэн Хуулийн Цэцээс хүчингүй болгосон хуулийг Улсын Дээд Шүүх тайлбараараа дахин хүчинтэй байдлаар хэрэглэх ёстой мэт зөрүүтэй байдлаар тайлбарласан байна.

- *Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 11 тогтоолын агуулгыг тоймлон авч үзвэл:*

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйл нь тодорхой төрлийн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй шинжээрээ материаллаг эрх зүйн, уг хугацааг тоолж буй шинжээрээ процессын эрх зүйн хэм хэмжээний шинж чанарыг агуулсан байна. Эрүүгийн хуульд тусгагдсан материаллаг хэм хэмжээ нь *lex severior poenali*²² үед буцаж үйлчлэх байдлаар өнгөрсөн ба эдүгээ цагт зэрэг хүчин төгөлдөр байж чадах бол процессын хэм хэмжээний хувьд бүх тохиолдолд *lex retro non agit* зарчмын нөлөөллөөр зөвхөн одоо үйлчилж буй хэм хэмжээ нь мөрдөгдөж өмнөх зохицуулалт халагддаг. Хэрэв процессын хэм хэмжээг хэрэг маргаанд материаллаг хэм хэмжээний адил зарчмаар хэрэглэвэл хууль урьдчилан тодорхой байх, тогтвортой бөгөөд бүгдэд тэгш үйлчлэх зарчмууд зөрчигдөж тухайн процессын хэм хэмжээгээр зорьсон үр дүн бий болохгүй. Иймд хууль тогтоогч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг өөрчилснөөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор тухайн этгээдийг яллагдагчаар татсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсох ба энэхүү процессын хэм хэмжээний мөн чанарыг агуулсан зохицуулалт нь хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээсээ хойш үйлчлэх бөгөөд уг заалт өөрчлөгдөхөөс өмнө мөрдөж байсан зохицуулалтыг буцааж хэрэглэхгүй гэж дүгнэсэн.²³

Дээрх 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар үзэл баримтлалын хувьд эрүүгийн эрх зүйн уламжлалт ойлголтыг тодорхой бус зөрчилтэй болгож, хууль хэрэглээний оновчтой бус байдалд хүргэх, материаллаг эрх зүйг үгүйсгэх зэрэг эрх зүйн зөрчилдөөн бүхий нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэх үндэслэлтэй.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж

²¹ Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 12 дүгнэлт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123489870951>

²² Илүү хүнд ял тусгасан лат.

²³ Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 11 тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468236563861>

байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.”²⁴ гэж заасан байдаг. Гэтэл Дээд шүүхийн хөөн хэлэлцэх хугацаа нь процессын эрх зүйн журамласан заалт учраас өмнөх хуулийн заалтыг хэрэглэхгүй гэх агуулга бүхий тогтоол нь эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх хууль ёсны зарчмын гол агуулгатай зөрчилдөж байна гэж үзэж болно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль гэдэг нь үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлын хувьд эерэг үр дагавар бий болгож буй хэм хэмжээ юм. Үүнд а) өмнөх хуулиар оногдуулж байсан ялыг шинэ хуулиар ялын тогтолцооноос хассан, хүчингүйд тооцсон; б) тодорхой төрлийн ял оногдуулах, эдлүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, нөхцөлийг шинэ хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ашигтай байдлаар хуульчилсан; в) эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг оногдуулах, хэрэглэх үндэслэл журмыг хөнгөрүүлсэн, эсхүл түүний зарчим нөхцөлийг хүчингүй болгосон; г) гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн бусад тохиолдлууд хамаардаг.²⁵

Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны ойлголт нь эрүүгийн эрх зүйн хуулийн хариуцлагаас чөлөөлөх институтын нэг хэсэг²⁶ бөгөөд өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа тоолж, тухайн хугацаа өнгөрсний дараа эрүүгийн хариуцлагад татан, ял шийтгэл оногдуулахгүй байхын хууль зүйн үр дагавар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ба энэ нь ял шийтгэлд шууд нөлөөдөг тул материаллаг эрх зүйн хэм хэмжээд илүү хамааралтай гэж үзэж болно. Иймд Дээд шүүхийн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхийн шатанд хянагдаж буй хэрэгт «гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолох» зохицуулалтыг хэрэглэнэ гэх тайлбар нь эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй гэх зарчимд нийцэхгүй төдийгүй Үндсэн хуулийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”²⁷ гэх заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2.3. Гадаадын зарим орнуудын Эрүүгийн хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа.

Өөрөөр эрх зүйн бүлийн төлөөлөл болгосон 30 гаруй орноос ихэнх орнууд /Азербайжан, Армен, Украин, Беларусь, Гүрж, Молдов, Казакстан, Кыргызстан, Узбекистан, Тажикстан, Туркменистан, ОХУ, БНХАУ, Монгол, Тайланд, Австри, Болгар, Польш, ХБНГУ, Голланд, Швед, Швейцар, Турк, Аргентин/ хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульдаа зааж өгсөн байна. Эдгээрээс ОХУ болон ТТУХН-ын гишүүн дийлэнх улсууд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн “Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх”, Аргентин улс “Эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэж болохгүй байдал”, Болгар, Голланд, Дани, Турк улсууд “Гэмт хэргийн үр дагавар арилах” гэсэн бүлэгт хуульчилсан бол Австри, Герман, Польш, Швейцар, Тайланд улс “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн бие даасан бүлэгт шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны хамт хуульчилсны зэрэгцээ, хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байх хэргүүд, түүнийг тоолох журмыг нарийвчлан зааж өгчээ. Тухайлбал:

²⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: <https://legalinfo.mn/mn/detail?law-id=1257>

²⁵ Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, 2013, 57-58 дахь тал.

²⁶ Хаянхярваагийн Сэлэнгэ, “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практик, эрх зүйн хийдэл”, *legaldada.mn*, 2022, 3 дахь тал, (Сүүлд үзсэн: 2025.12.15)

²⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг.

- *Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн тухайд*.²⁸

ОХУ-ын Эрүүгийн хуулийн IV хэсэг, 11 дүгээр бүлэг, 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний улмаас эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хуульчилсан байдаг. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулан (хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц ноцтой) тоолохоор хуульчилсан нь Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуультай харьцангуй ижил төсөөтэй байдаг.

Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолно. Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсхийсэн, эсхүл энэ хуулийн 76.2-т зааснаар шүүхээс тогтоосон торгууль төлөхөөс зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоохоор хуульчилсан.

- *Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хуулийн тухайд*.²⁹

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий дүрэм, дөрөвдүгээр бүлэг, наймдугаар хэсэгт хүчин бүхий хугацааг (5-20 жил) хуульчилсан байдаг. Шүүн таслах ажиллагаанаас зайлсан байвал нэхэмжлэн заалдах хугацаанд хязгаарлагдахгүй бөгөөд мөн ялт ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт ажиллагааны дууссан өдрөөс эхэлж бодно. Нэхэмжлэн заалдах хугацааны дотор дахиж ял хийсэн байвал өмнөх ялыг нэхэмжлэн заалдах хугацааг хойнох ялыг хийсэн өдрөөс эхэлж тооцохоор зохицуулсан байдаг.

Хорлогдогчоос нэхэмжлэн заалдах хугацааны дотор заалдлага гаргасан ба ардын шүүх хороо, ардын байцаах хороо, дотоодыг хамгаалах байгуулга түүнийг хэрэг болгон данслах ёстой байтал хэрэг болгон данслаагүй байвал нэхэмжлэн заалдах хугацаанд хязгаарлагдахгүй. Энэхүү заалт нь хөөн хэлэлцэх хугацааны ерөнхий нөхцөлийг процессын тодорхой журмаар хуульчилснаараа ялгаатай зохицуулалт болж өгчээ.

БНХАУ-ын Эрүүгийн хуулиар цаазаар авах болон бүх насаар хорих ялыг өргөн хэрэглэдэг хэдий ч, эдгээр хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 20 жилээр тогтоосон нь нэлээд өвөрмөц хэм хэмжээ болж хуульчлагдсан байна.

- *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн тухайд*.³⁰

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн тавдугаар бүлэг, нэгдүгээр хэсэг, 78 дугаар зүйлд мөрдөн байцаах хөөн хэлэлцэх хугацааг (3-30 жил) хуульчилсан байдаг ба хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар гэмт хэрэгт ял оногдуулахгүй бөгөөд арга хэмжээ авахгүй.

Гэмт хэрэг төгссөн үеэс хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор заасан боловч, хэрэв гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон бол тэр үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан нь Монгол Улсын хуулиас ялгаатай зохицуулалт юм. Мөн хөөн хэлэлцэх хугацаа тасрах болон зогсох нөхцөл, журмыг илүү нарийвчлан хуульчилснаараа онцлогтой. Герман улсын эрүүгийн эрх зүйн дээрх зохицуулалтын онцлогийг судлан дүгнэхэд хөөн хэлэлцэх хугацааны үргэлжлэх хугацааг харьцангуй уртасган тогтоосон, материаллаг эрх зүйн зарчим, шалгуурыг зонхилон хуульчилж тусгасан, энэ хугацааны тасрах, зогсох болон үргэлжлэн тооцогдох хугацааны шалгуурыг материаллаг эрүүгийн хуульд илүү тодруулж хуульчилсан зэрэг нь анхаарал татсан дэвшилттэй хандлага гэж үзэж байна.

Харин Франц, Бельги, Израйл, Япон, Солонгос зэрэг орнууд хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн журмаар мөрдөн шалгах /мөшгөх/ хугацаа хэмээн тодорхойлж, түүнийг процессын агуулгаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгасан байна. Тухайлбал:

- *Япон улсын тухайд*.³¹

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2 дугаар хэсгийн “Прокурор яллах” гэсэн 2 дугаар бүлгийн 250 дугаар зүйлд Цаазаар авах ялтай хүн амины хэргээс бусад хэрэг үйлдсэнээс хойш хуульд заасан хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй гэж заасан бөгөөд

²⁸ Уголовный кодекс Российской Федерации. <https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/17946>

²⁹ 中华人民共和国刑法 (1997). <http://www.npc.gov.cn/>

³⁰ German Criminal Code. https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p0807

³¹ Japan Code of Criminal Procedure. https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2056/en#je_pt2ch2at4

хөөн хэлэлцэх хугацааг 1-30 жилийн хугацаатайгаар тогтоосон. Япон улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд орсон 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр 2 дугаар бүлгийн 250 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсэг буюу Хүчиндэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр уртасгасан байдаг. Ингэхдээ шилжилтийн үеийн зохицуулалт буюу дагалдах заалтын 5 дугаар зүйлд “Шинэ хуулиар хөөн хэлэлцэх хугацааг сунгасан боловч, уг хууль хэрэгжиж эхлэхээс өмнө аль хэдийн хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан хэргийг буцааж сэргээхгүй байхаар тусгажээ.”³²

Мөн Европын Холбооны Хүний Эрхийн Шүүхийн тайлбараар “хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хүчин төгөлдөр болсон даруй үйлчилж эхэлснээр Европын Хүний Эрхийн Конвенцын 7 дугаар зүйлийг зөрчихгүй ч, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээхгүй болсон гэмт хэрэгтэнд ял оногдуулах боломжийг сэргээсэн заалт нь уг 7 дугаар зүйлийг зөрчинө” гэж хөөн хэлэлцэх хугацааны өөрчлөлт болон эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчмын уялдаа холбоог дүгнэсэн байдаг.³³

Гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг судалсан байдлаас үзэхэд Англи-Америкийн системийн орнуудад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг бичмэл эрүүгийн хууль тогтоомжид хуульчлаагүй буюу энэ талаар институцийн түвшинд бүрэн зохицуулагүй байдал харагдаж байна. Харин Эх газрын эрүүгийн эрх зүйн системд тухайн асуудал бүрэн буюу хэсэгчилэн зохицуулагдсан ба дийлэнх орнуудын хувьд материаллаг эрүүгийн хуульд зонхилон тусгасан байна.

“...Улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хоёр хэлбэрээр, өөрөөр хэлбэл эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон оногдуулж болох ялын дээд хэмжээтэй нь харьцуулан, харин таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан ялын төрөл, хэмжээтэй нь харьцуулан тогтоосон байх ба хугацааг тоолох нөхцөл, журам нь ерөнхийдөө нийтлэг боловч хугацааны хязгаар нь харилцан адилгүй байна.”³⁴ Түүнчлэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн онцлог, төрлөөс хамаарахгүйгээр гэмт хэргийн ангилал болон ялын үр дагавар, хэмжээгээр тодорхойлогдох явдал харьцангуй нийтлэг байна. Үүний хамт хэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хэмжээг тогтоохдоо хүнд ноцтой гэмт хэрэгт тухайн хугацааг нь уртасгах буюу, уг хугацааг тооцохгүй байх, ялын төрөл, нөхцөлтэй уялдуулж хөөн хэлэлцэх хугацааг нарийвчлан тодорхойлох хандлага түгээмэл байгаа нь судалгаанаас харагдлаа. Ялангуяа ХБНГУ, Франц, Сингапур, Швед зэрэг орнуудад авилгын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгасан нөхцөлөөр нарийвчлан зохицуулах хандлага зохилох чиглэлтэйгээр хуульд нь тусгагдаж иржээ.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тухай ойлголт нь өнөөгийн эрүүгийн эрх зүйд гүнзгийрүүлэн судлах зайлшгүй шаардлагатай нэн чухал судлагдахуун болсон бөгөөд хууль хэрэглээний хувьд өмгөөлөгчид, хуульчид, мөрдөгч, прокурор, шүүгчдийн хувьд нэгэн мөр ойлголт болж бүрэн төлөвшөөгүй байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг зөвхөн материаллаг эрүүгийн эрх зүйн талаас гол шалгуурыг нь авч үзэх зохистой бөгөөд эрүүгийн процессын аспектаар тодорхойлж зохицуулах нь хууль хэрэглээний хувьд ойлгоход төвөгтэй, хүндрэлтэй

³² 刑法及び刑事訴訟法の一部を改正する法律（令和五年法律第六十六号） https://www.shugiin.go.jp/internet/itdb_housei.nsf/html/housei/21120230623066.htm

³³ Дам зилэв: Батжаргалын Ариунзаяа, “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим хөөн хэлэлцэх хугацаа тоолох журамд үйлчлэх эсэх, түүний учир холбогдол”, *legaldata.mn*, 2022, 5 дахь тал. (Сүүлд үзсэн: 2025.12.15)

³⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Судалгааны тайлангийн эмхэтгэл ХХ боть (Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгаа)”, 2025, 50 дахь тал.

байдлыг бий болгоход хүргэж байна.

Гадаадын зарим орны Эрүүгийн хуулийн зохицуулалтад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцох үндэслэлийг эхлэх, дуусах нөхцөлийг хатуу заахгүйгээр эрүүгийн эрх зүйн үр дагавар талаас нь илүү хуульчилсан байдлыг анхаарч үзэх нь зүйтэй юм.

Харин өнөөгийн Монгол Улсын эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн орчин тогтвортой биш, анхан шатны шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн баталгаа зарим талаар хангалтгүй, авлигын болон зарим хүнд гэмт хэргийг илрүүлж, хянан шийдвэрлэх процесс удаашралтай байдаг зэрэг бодит бэрхшээлээс хамаарч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг гарсан өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл тоолох зохицуулалт нь манай нөхцөлд зөв зүйтэй хандлага гэж үзэж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар хорих, зорчих эрхийг хязгаарлах зэрэг ялын зарим төрөлд нийцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тооцохоор хуульчилсан боловч энэхүү зохицуулалтын тодорхой нөхцөлийг торгох ялын тухайд тухайлан оновчтой хуульчлахгүй орхигдуулсан нь зарим гэмт хэргийн хувьд ял завших, болон эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд хийдэл зөрчилдөөн үүсгэх үр дагаврыг бий болгож байгаад анхаарч холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь зүйтэй юм.

ЭХ СУРВАЛЖ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966/1976 он.
3. Эрүүгийн хууль, 2002 он.
4. Эрүүгийн хууль, 2015 он.
5. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020 он.
6. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2020 он. (Хүчингүй болсон)
7. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 12 дүгнэлт.
8. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 11 тогтоол.

Б. Ном, сурах бичиг

1. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, 2015 он.
2. С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019 он.
3. Г.Совд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, 2002 он.
4. С.Жанцан, Гэмт хэргийн олонлог, 1990 он.
5. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2011 он.
6. Б.Баярсайхан нар, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 2011 он.
7. Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013 он.
8. Э.Хилгендорф, Д.Чанцалдулам, Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Удиртгал, 2015 он.
9. О.Батсүх, Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги, 2021 он.
10. Г.Гантөмөр, Үндэсний эрүүгийн эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн асуудал, 2024 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Х.Сэлэнгэ, “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаа: Онол, практик, эрх зүйн хийдэл”, legaldata.mn, 2022 он.
2. Х.Сэлэнгэ, “Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Онол практикийн асуудал”, legaldata.mn, 2024 он.
3. Б.Батаа, “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны онолын үндэслэл”, legaldata.mn, 2022 он.
4. Б.Ариунзаяа, “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим хөөн хэлэлцэх хугацаа тоолох журамд үйлчлэх эсэх, түүний учир холбогдол”, legaldata.mn, 2022 он.

Г. Бусад

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл XX боть (Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгаа), 2025 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээр

1. German Criminal Code. https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p0807

2. The Twelve Tables. <https://archive.org/stream/thetwelvetables14783gut/14783.txt>
3. Japan Code of Criminal Procedure https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2056/en#je_pt2ch2at4

Б. Орос хэл дээр

1. В.Н.Додонов, Сравнительное уголовное право. Учебник. изд. Юрлитинформ.М.2009 г.
2. Уголовный кодекс Российской Федерации. <https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/17946>

В. Хятад хэл дээр

1. 中华人民共和国刑法 <http://www.npc.gov.cn/>

Г. Япон хэл дээр

1. 刑法及び刑事訴訟法の一部を改正する法律（令和五年法律第六十六号）
https://www.shugiin.go.jp/internet/itdb_housei.nsf/html/housei/21120230623066.htm

3. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>
2. Хууль зүйн судалгаа бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn/>

ISSUES OF THE CRIMINAL CODE REGARDING THE STATUTE OF LIMITATIONS FOR CRIMINAL OFFENSE

Namuun-Erdene.B

Master's student,

School of Law, NUM

ABSTRACT:

Optimal determination of the statute of limitations for a criminal offense is essential for preventing the risk of misapplication of the Criminal Code, as well as for accurately establishing the facts of the case and ensuring effective the achievement of the objectives of criminal liability.

By the Law on Amendments to the Criminal Code dated January 10, 2020, paragraph 2 of Article 1.10 of the Criminal Code was revised to stipulate that the statute of limitations for a criminal offense shall be calculated from the date the offense was committed until the date the person is charged as an accused. Following this amendment, both theoretical and practical inconsistencies have arisen regarding whether the principle of retroactive application of the Criminal Code applies to the calculation of the statute of limitations.

The purpose of this article is to specifically address this issue, to review the historical development of the legal regulation of the statute of limitations for criminal offenses in comparison with the legal frameworks of certain foreign countries, and to propose several well-founded options and conclusions.

KEYWORDS:

Statute of limitations for criminal offenses; Criminal Code; Grounds for imposing criminal liability; Legal consequences under Criminal Code; Procedure for calculating limitation periods; Substantive legal norms; Procedural legal norms.

НОТОЛ, НОТОЛЖ ЧАДАХГҮЙ БОЛ ЦАГААТГАХ ЗАРЧИМ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ



Э.Энхзул

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

ТОВЧЛОЛ:

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн процессын хуульд хэргийг прокурорт буцаах тухай зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр талуудаас хүсэлт гарсан тохиолдолд хэргийг прокурорт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах зохицуулалт бий. Гэтэл гэм буруугийн шатнаас хэргийг прокурорт буцаадаг шүүхийн практик халагдахгүй оршсоор байх бөгөөд энэ нь ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн улсад тохиромжгүй юм. Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах улсуудын тухайд хэргийн бодит байдлыг тогтоох болон нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчим зэрэг эрүүгийн процессын хуулиудад нь агуулагдах бөгөөд хэрхэн уялдаа холбоотойгоор тус зарчмыг хэрэгжүүлэх нь чухал асуудал болжээ. Хэргийн бодит байдлыг тогтоох зарчим эрүүгийн процесс ажиллагааны бүхий л үе шатанд хэрэглэгдэхээр яллах чиг үүрэгтэй шүүхийн үүргийг гүйцэтгэж, эрх мэдлийн тэнцвэргүй байдал үүссэнээрээ хүний эрхийг зөрчих, хатуу харгис хуультай болоод цаашлаад хэлмэгдүүлэлт, эрүү шүүлтийг бий болгох эрсдэлтэй юм. Судлаачийн зүгээс энэхүү судалгааны бүтээлийн үр дүнд хуульд агуулагдаж буй тус хоёр зарчмыг хэрхэн тэнцвэртэй ашиглах тухайд холимог тогтолцоотой орны хувьд шүүхийн өмнөх шатанд хэргийн бодит байдлыг тогтоох зарчим үйлчилж, шүүхийн шатанд хэлбэр төдий бус мэтгэлцэх зарчим үйлчилж эргэлзээ бүхий нөхцөл тогтоогдвол шүүгдэгчид ашигтай байдлаар шийдвэрлэж, цагаатгах зарчмын хэрэгжилтийн хангах тухайд санал дэвшүүлсэн болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, Хэргийг прокурорт буцаах, Прокурорт даалгах, Хуулийн үзэл баримтлал, Хэргийг нэмэлт ажиллагаанд буцаах,

I. ОРШИЛ

Эрүүгийн процесс нь тодорхой үе шаттайгаар хэлбэршүүлсэн журмын дагуу хэрэгжих зүй тогтолтойг Ромын эрх зүйгээс уламжлан авсан билээ¹. Хууль зүйн шинжлэх ухаан түүний дотроос шүүхийн процесст бодит байдлыг зөв танин мэдэх нь шударга ёсыг тогтоохын үндэс юм. Аль ч нийгмийн төрт ёсны шударга байдлын шалгуур нь хэрэг маргааныг хянан

¹ М.Гантулга, Эрүүгийн процессын тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, (УБ, 2018), 6-7 дахь тал.

шийдвэрлэх тогтолцооны шударга байдлаар илэрхийлэгддэг². Тогтолцоо нь тус бүртээ сул хийгээд давуу талтай хэдий ч аль ч тогтолцооны хувьд үнэнийг эрэлхийлэх, олж тогтоох зорилго агуулагдаж байдаг³. Гагцхүү өөрийн улсын онцлогт нийцсэн оновчтой сонголтыг хийх нь зүйтэй юм. Гэм буруутай нь шударга шүүхийн процедураар тогтоогдсон бол тохирсон ял шийтгэлийг оноох нь гарцаагүй зүйл болно. Шүүхийн процесс тодорхойгүй эргэлзээ төрүүлэхүйц байх нь үнэнийг эрэлхийлэх, олж тогтоох чадваргүйн зэрэгцээ шүүхэд итгэх итгэлийг хөсөрдүүлэх юм.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд /2017/ эрүүгийн процесс ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчилж өгсөн бөгөөд тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг шийдвэрлэхэд удирдлага болгох ерөнхий зохицуулалт болно. Аливаа хэргийн бодит байдлыг тогтоох чиг үүрэг нь мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч прокурорт хадгалагдах бөгөөд тухайн хэргийг шүүхийн шатанд нотолж чадахгүйд хүрвэл прокурор хариуцлага хүлээж, шүүх цагаатгадаг байх систем нь хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн тогтолцоотой оронд хамгийн сайн зүйл нь болно.

Монгол улсад үе үеийн мөрдөгдөж буй эрүүгийн процессын хуульд хэргийг прокурорт буцаах /мөрдөн байцаалтад буцаах/ зохицуулалт хэрэгжсээр шүүхийн практик үүсгэсэн. 2017 оноос эхлэн мөн хуульд өөрчлөлтүүд орж, шүүхээс хэргийг прокурорт, мөрдөн байцаалтад буцаадаг явдлыг халж, шүүх хэргээ өөрт үлдээж, прокурорт тодорхой ажил хийлгүүлэхийг үүрэг болгох чиглэлээр даалгах зохицуулалт мөн оролцогчийг эрхийг ноцтой зөрчсөн асуудлаар зайлшгүй прокурорт буцаах бол Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас л зөвхөн прокурорт буцааж болохоор зохицуулсан боловч гэм буруугийн шатнаас прокурорт буцаадаг хууч хамаарал шүүхийн практикт нэгэнтээ тогтжээ. Тус хууч хамаарал нь хүний эрхийг дээдэлсэн ардчилсан улсад мөрдөгч, прокурор ажилдаа хуумгай хандах, шүүхийн тогтолцоог босооруулах, дахин нотлоод ир гэх хэргийг сунжруулах, эргэлзээ үүсвэл шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх, нотолж чадахгүй бол цагаатгах зэрэг зарчмыг хэрэгжихгүйд хүргэж, яллах чиг үүргийг шүүх хэрэгжүүлдэг сөрөг үр дагаврыг бий болгосон юм.

Франц улсын эрдэмтэн Ш.Монтескье /1689-1755/ нь эрх мэдлийн хувиарлалтын онолыг гаргаж ирсэн бөгөөд түүнтэй нэгэн адил хэргийг шийдвэрлэх хүртэл процесст шүүгч, прокурор, мөрдөгч тус бүр өөр өөрийн чиг үүргийг гүйцэтгэвээс хэргийг бодитой шийдвэрлэх шударга тогтолцоо бүрдэх юм. Манай жишгээр шүүх хэргийг прокурорт, мөрдөн байцаалтад буцаах нь прокурорын яллах чиг үүргийг хэрэгжүүлсэн «Яллагч шүүх» болж хувирах тул шүүхийн шатанд «нотол, нотолж чадахгүй бол цагаатга» зарчмын хэрэгжилтийг хангах нь зүйтэй. Гэтэл манай улсад шүүхээс прокурорт хэргийг буцааж шийдвэрлэж буй нь тус зарчмын хэрэгжилтэд нөлөөлж байна.

II. ШҮҮХЭЭС ПРОКУРОРТ ХЭРГИЙГ БУЦААХ ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Аль ч нийгмийн үед шүүхийн хэлэлцүүлгийн гэм буруугийн шатанд хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар прокурорт буцаадаг зохицуулалт Монгол улсад үйлчилж байсан байна. Тодруулбал 1935 онд таслан шийтгэх хурал товлон зарлахаас өмнө хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах ,1949-1994 оны хооронд хэргийг буруу тусгаарласан, хуулийг ноцтой зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан тохиолдолд шүүхээс прокурорт хэрхэн, яаж яллах талаар чиглэл өгч, захиран тушаах хурлаар хэргийг хяналтын шатны шүүхээс бусад үе шатанд прокурорт буцаадаг байв. 1994

² Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, *Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал*, (УБ, 2018), 222 дахь тал.

³ Дам эшлэв: Thomas. Wegn Law and Truth; Panel III; Truth the jury, and the adversarial system; Is the Criminal process about truth?; A German Perspective (Harvard Journal of Law & Public Policy, Winter, 2003)

онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтээр шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хангалттай нотлох боломжгүй нөхцөлд шүүх хуралдааныг 30 хүртэлх хоногийн хугацаагаар хойшлуулж, нэмэлт мөрдөн байцаалт хийлгүүлдэг байжээ. 2002 оны хуулиар давах болон хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах гэсэн өмнө нь байгаагүй зохицуулалтыг нэмсэн байна⁴.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хүрээнд хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буюу прокурорт буцаах зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг судлан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатыг бий болгож, хуучин хуулийн зохицуулалтыг сайжруулах ажил хийгдсэн байна.

ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт⁵ шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр тухайн асуудлыг гэм буруугийн шатанд хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, гэм буруугийн хэлэлцүүлэгт шилжүүлэн хэлэлцэж, нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаах эрх хэмжээ 2017 онд нээлттэй байсан. Үүний дараагаар 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр⁶ ҮХЦ-ийн шийдвэрийг иш үндэс болгон давах болон хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг хязгаарласан өөрчлөлт орсон. Тодруулбал анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох хэрэгсэхгүй болгох зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр шийдвэрлэх эрх хэмжээтэйгээр хуульчлагджээ.

2022 оны нэмэлт өөрчлөлтөөр, ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь⁷ хэсэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр тухайн асуудлыг гэм буруугийн шатанд хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, гэм буруугийн хэлэлцүүлэгт шилжүүлж, прокурорт буцаах эрх хэмжээг халсан байна. 1994 онд хэрэглэгдэж байсан гэм буруутай эсэхийг хангалттай нотлох боломжгүй нөхцөлд шүүх хуралдааныг 30 хүртэл хугацаагаар хойшлуулж, хойшлуулах хугацаанд нэмэлт мөрдөн байцаалт хийлгүүлэх боломжтой зохицуулалт үйлчилж байжээ. Харин 2022 онд 60 хоногт прокурорт даалгаж⁸, шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалтыг хуульчилсан. Прокурорт буцаах болон даалгах зохицуулалт нь зарчмын хувьд ялгаатай. Тодруулбал прокурорт хэргийг буцаахад хавтаст хэргийг хүлээлгэн өгч тодорхой нэмэлт ажиллагаа хийлгэх боломжтой байдаг бол прокурорт даалгах ойлголтын тухайд хавтаст хэргийг өгөхгүйгээр тодорхой хуульд заасан үндэслэлийн дагуу шүүх хуралдааныг хойшлуулж, прокурорт үүрэг даалгавар өгөхөд оршино.

А. Бүх шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг халах шинэ үзэл, хандлага

А1. Шинэчлэх үндэслэл шаардлага:

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын⁹ 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” гэж,

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын фактын¹⁰ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй...” гэж,

⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, 2012, 34-75 дахь тал.

⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12694>

⁶ Мөн тэнд,

⁷ Мөн тэнд,

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017, 5-34.16 [/https://legalinfo.mn/mn/detail/12694](https://legalinfo.mn/mn/detail/12694)

⁹ Монгол Улсын Олон Улсын гэрээ, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948, <https://legalinfo.mn/mn/detail/1271>

¹⁰ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, <https://legalinfo.mn/mn/detail/1257>

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид¹¹ Монгол Улс 2005 онд нэгдэж орсон бөгөөд тус конвенцын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэл дэх түүний шийдвэрлэх үүргийг санан, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.» гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт¹² “...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэх гэм буруугийн зарчмыг хуульчилсан. Шүүхийн шийдвэр эцэслэж гарах хүртэл хэн ч хэнийг ч гэмт хэрэгтнээр “зарлахгүй” гэх энэхүү зарчим нь гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, мөрдөн шалгах, гэм буруугийн асуудлыг шүүхээр хэлэлцэх бүхий л процесст эхнээс нь дуустал үйлчлэх учиртай. Тэр ч утгаараа Эрүүгийн процессын үндсэн “оролцогч”-ид болох мөрдөгч, прокурор, шүүгч нарт яллах ба цагаатгах нотлох баримтыг бүгдийг тэгш цуглуулах, үнэлэх аль нэг талыг хэт баримталж давуу байдлыг олгох буюу гаргахгүйгээр шүүх хуралдаанд талууд мэтгэлцэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчим болгож хуульчилсан. Тодруулбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлд зааснаар гэм буруугүйд тооцох зарчим мөн эргэлзээ үүсвэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх / in dubio pro reo /¹³ зарчмыг хуульчилсан.

Нотлох баримт гэдгийг мөн хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлохдоо¹⁴: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.”, мөн зүйлийн 9 дэх хэсэгт: “Хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.” гэжээ. Өөрөөр хэлбэл, шүүх нь хавтаст хэрэгт хуулийн дагуу цугларсан нотлох баримтын хэмжээнд үндэслэж хэрэг маргааныг шийдвэрлэхийг нэн тодорхой хэлж өгсөн бөгөөд сураг ажигар, олон нийтийн сэтгэл зүйгээр эсхүл танил тал, аливаа албан тушаалтан, хувь хүний нөлөөллөөр шүүхэд ирээгүй баримт мэдээлэл, сэжиг таамаг, сэтгэл хөдлөлд үндэслэж шийдвэрээ хэрхэвч гаргаж болохгүйг хэлж өгсөн байна. Үүнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цааш дэлгэрүүлэн, дахин нэн тодорхой байдлаар хуульчилсан асуудал нь шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах хэмжээ хязгаарыг заасан 34.14 дүгээр зүйл, мөн шүүхийн шийдвэр чухамхүү ямар хэлбэр, бүтэцтэй байхыг илтгэсэн 36.2 дугаар зүйлээр илэрнэ./ шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна/ Тодруулбал уг хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана” гэж зохицуулсан

Дээр дурдсан Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд үндэслэн гарсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчмуудыг бүхэлд нь дүгнэвэл “Нотол, нотолж чадахгүй бол цагаатга” гэх зарчмыг манай улс үндэсний хууль тогтоомждоо нутагшуулсаар ирсэн байна. Үүнийг нөгөө талаар “Нэг гэмгүй хүнийг хилсээр ялласан дорвол зуун гэмт хэрэгтэнг сулла” гэдэг хэлц үгээр ч илэрхийлсэн нь байдаг. Товчдоо гэмт хэрэгтэнг олж илрүүлэх, гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, түүнд ял шийтгэл ногдуулах нь төрийн үндсэн чиг үүрэг бөгөөд хэрэгтнээр өөрөөр нь хэргийг нь нотлуулах, тулгах буюу хилс ял шийтгэхээс төр үргэлж зайлсхийж, хуулиас гадуур ажиллаж хэн нэгнийг хэлмэгдүүлэхийг

¹¹ Авлигалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16760279163531&showtype=1>

¹² Монгол Улсын Үндсэн хууль, 1992, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=367>

¹³ Улсын Дээд шүүхийн 2023оны 05 дугаар сарын 08-ны өдрийн, дугаар 24 тогтоол, <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=32&active=1&page=1&sort=title&page=1>

¹⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

Эрүүгийн процесс өндөр хөгжсөн барууны орнууд болон Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой улсад гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч голлох субъект нь мөрдөгч, прокуророос гадна өмгөөлөгч, хувийн мөрдөгч, агентууд, түүнчлэн шүүх, шүүхийн төлөөлөгч нар байдаг. Монгол улсад өмгөөлөгчийн статусыг өргөжүүлэхэд чиглэгдсэн өөрчлөлтүүдийг бий болгохыг зорьж буй ч өмгөөлөгчийн оролцоо өргөдөл, гомдол, хүсэлтээр хязгаарлагдаж, идэвх сул тул

¹⁸ Дам эшлэв: Гученко К.Ф Филипинов Б.А Уголовный процесс зарубежных государств I..2004

бусад барууны орнууд шиг өмгөөлөгчийн идэвхтэй оролцоог бий болгож чаддаггүй. Энэ утгаараа шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгчийн оролцоог зохицуулснаар өмгөөлөгчийн эрх тэгш байдлыг харгалзсан, хавтаст хэрэг дагадаг шийдвэр гаргахдаа процесст “төв рүү тэмүүлэх хүч” буюу албан тушаалтан эрх мэдлийнхээ хүрээнд хэргийн хувь заяаг шийддэг энэхүү тогтолцоог аажмаар халах нь зүйтэй. “Цаашид мэтгэлцэх зарчим руу шилжих, оролцогчдын тэгш боломжийг хангасан шүүхийн урьдчилсан шатны хэлэлцүүлгийн төрлийг нэмэх, зөвшөөрлийн системийг уян хатан болгох чиглэл рүү хөгжих нь зүйтэй” гэж судлаачид дүгнэсэн байна¹⁹.

A2. Шүүхээс хэргийг буцаах эерэг үндэслэлүүд:

Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны алдааг илрүүлж засуулах арга хэмжээ авснаар шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэлтэй гарах нөхцөлийг хангаж, алдаатай шүүхийн шийдвэр гарахгүй байх баталгаа болно. Хэргийг бүх талаас нь бүрэн шалгах нөхцөлийг хангаж, ингэснээр хэргийн бодит байдлыг тогтооход чанарын ахиц дэвшлийг бий болгоно. Хийсэн хэрэгтээ тохирсон ял, хариуцлага хүлээх шударга ёсны зарчим хангагдах, ял завшуулахгүй байх баталгааг бүрдүүлнэ. Түүнчлэн зөрчигдсөн эрх ашиг сонирхлыг сэргээх боломж, нөхцөлийг илүү нэмэгдүүлнэ. Тодруулбал анхан шатны алдаа гаргасан шийдвэрийг дээд шатны шүүхээс засаж залруулах боломжтой бөгөөд практикт шүүгчид иргэн хэнийг ч болов гэмт хэрэгт хэлмэгдүүлж, бас ял завшуулж болохгүй учраас хэргийн талаар нотолбол зохих байдлуудыг бүрэн тогтоогоогүй байх нь хэргийг дахин шалгуулах үндэслэл болдог түүнээс “таамаглал”-аар шийдвэрлэх ёсгүй. Энэ бол хууль ёсны зарчмын үндсэн гол шаардлага²⁰. гэж дүгнэдэг

A3. Сөрөг дүгнэлтүүд:

Монгол улс Ардчилсан улсын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн чиг үүргийг харилцан хяналт, тэнцвэр бүхий талуудад хариуцуулах, хооронд нь санал бодлоо уралдуулан мэтгэлцүүлэх, хөндлөнгийн байлгах явдлыг гол үндэс болгохыг зорьж байгаа болно. Гэвч прокурорт шүүхийн санаачилгаар хэргийг буцаах болон дээд шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах нь дээрх чиг үүргийн тэнцвэртэй хуваарилалтыг зөрчдөг. Тодруулбал шүүх хөндлөнгийн шинжтэй байж, нотол, нотолж чадахгүй бол цагаатга буюу нотлогдоогүй бол гэм буруугүйн зарчим эсхүл яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим хэрэгжихгүйд хүрч, яллах шүүхийн шинжийг харуулж байна²¹. Нөгөө талаар мөрдөгч, прокурор нь хаашдаа шүүхээс буцаадаг заалт байгаа юм чинь гэдгээр дутуу шалгасан, хэргийн бодит байдал бүх талын нотлох баримтаар нотлогдож чадаагүй, “дутуу боосон” хэргийг шүүхээс чиглэл авчихъя гэдэг байдлаар шүүхэд шилжүүлж, улмаар тодорхой чиглэл авч буцаалган тэр чиглэлийнхээ хүрээнд дахин ажиллагаа хийдэг хариуцлагагүй байдал үүснэ. Нүдээ боосон охин тэнгэрээс нүдний шилтэй Зевс бурхан²² буюу шүүх гэм бурууг хэлэлцэхдээ прокуророос боож ирүүлсэн хэргийн хүрээнд бус түүнээс давж харч дахин нотлоод ир гээд прокурорт буцааж буй нь шүүхийн тогтолцоог гүнзгийрүүлж, хуульд тусгалаа олсон зарчим хэрэгжихгүйд хүрч байна.

III. ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ, ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ПРАКТИК, АНХААРАХ АСУУДАЛ

Дэлхийн Эрүүгийн загвар хууль /2008/-д Монгол улс нэгдэж ороогүй ч гэсэн нийтлэг жишиг түгээмэл хандлагыг баримталбал зохих түл судалгаа шинжилгээний үндсэн дээр бусад ардчилсан хөгжил дэвшилттэй гэж тооцогддог улс орнуудын сайн жишгийг

¹⁹ Хууль зүйн Үндэсний Хүрээлэн, “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь” 2017.

²⁰ Г.Ганбаатар, Хуулийн засаглал шударга ёсны эрэлд, 2016, 142 дахь тал

²¹ Ж.Эрхсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу”, 2020, УБ хот, эрх зүй сэтгүүл цуврал 51, №3, 357-358 дахь тал.

²² Мөн тэнд, 368 дахь тал.

харгалзаж, шүүхээс прокурорт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаадаг зохицуулалтыг халж, ШУХ-ийн зохицуулалтыг оруулж ирсэн явдал нь хэргийн бодит байдал буюу нотолбол зохих байдлын бүрдлийг хангах, шударгаар шүүлгэх эрхийг хангасан давуу талтай болно. Энэ 2017 оны ЭХХШТХ-ийн өөрчлөлтөөрөө Монгол улс бол шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах /инквизици- Investigation process/, шүүхийн шатанд мэтгэлцэх /аккусаци- Accusatory process/ буюу холимог буюу хосолсон /Equivocacy and mixed process/ хагас нээлттэй зарчмыг тунхагласан эрх зүйн орчин бүрдсэн байна²³.

ЭХХШТХ-ийн 33.1 дүгээр зүйлийн 6.15 дугаар зүйлд зааснаар²⁴ прокурорт нэмж, нэмэлт ажиллагаа хийлгэх эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шийдвэрлэх болсон нь гэм буруугийн хэлэлцүүлэгт прокурорт буцаах үр дагавраас сэргийлэх зорилготой болно. Тодруулбал ЭХХШТХ-н 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй.” гэж заасан. Хэргийг буруу тусгаарласан, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн ба шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-г ноцтой зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн алдаа гарсан тохиолдолд ЭХХШТХ-н 33.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мөн хуулийн 33.3 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд нэг удаа шүүгч хэргийг прокурорт буцаах боломжтой болсон. Шинэчилсэн хуулийн чухамхүү нэг гол үзэл баримтлал нь шүүхийн хэлэлцүүлгийн үе шатыг хоёр хувааж шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, гэм буруугийн шүүх хуралдаан гэж зааглаж салгасан. Заагласны мөн чанар, зорилго, агуулга нь Эрүүгийн процессын үндсэн «оролцогчид» болох мөрдөгч, прокурор, шүүгч нарт яллах ба цагаатгах нотлох баримтыг бүгдийг тэгш цуглуулах, үнэлэх, аль нэг талыг хэт баримталж, давуу байдлыг олгохгүйгээр шүүх хуралдаанд талууд мэтгэлцэхийг ЭХХША-ны суурь зарчим болгож хуульчилсан. Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд үндэслэсэн ЭХХШТХ-н зарчмуудыг бүхэлд нь дүгнэвэл “Нотол. Нотолж чадахгүй бол цагаатга” гэх зарчмыг манай улс үндэсний хууль тогтоомждоо нутагшуулсаар ирсэн байна.

Хэргийн бодит байдлыг тогтоох болон нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчим нь хоорондоо харшилдах зарчим мөн боловч Монгол улс нь эрүүгийн процессын холимог зарчмыг тунхагласан бөгөөд шүүхийн өмнөх шатанд хэргийн бодит байдлыг тогтоох чиг үүрэг мөрдөгч, прокурорт хадгалагддаг бол шүүхийн шатанд тухайн мөрдөгч, прокурорыни боосон хавтаст хэргийн хүрээнд хэргийг шийдвэрлэдэг байх нь нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчмын хэрэгжилтийг хангах нэг хэлбэр болно. Гэвч мөрдөгч, прокурорын хариуцлагагүй байдал, шүүхийн хэвтээ бус босоо тогтолцоонд ял завшуулахгүй байх үүднээс дахин ажлаа хийгээд ир гэх прокурорт мөн мөрдөн байцаалтад буцаадаг үр дагавар харагдаж байна.

Эрүүгийн процессын хуульд прокурорт буцаах, мөрдөн байцаалтад буцаах, прокурорт даалгах гэх нэршлүүд хэрэглэгдэж байсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд прокурорт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах гэх нэр томъёо шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хэрэглэгдэх бол прокурорт даалгах гэх нэр томъёо нь шүүхийн шатанд нэг удаа 60 хүртэлх хоногийн хугацаагаар шүүх хуралдааныг хойшлуулах боломжийг олгосон юм. Тухайн хэрэгт оролцогчийн эрхийг хязгаарласан, мөрдөн шалгах ажиллагааны журам зөрчиж нотлох баримт цуглуулсан зэрэг нөхцөлд тодорхой хугацаанд хойшлуулах эрх шүүгчид бий боловч тухайн хэрэгт дээр дурдсан алдаа гарсан бол нотлох баримтад үл тооцож, нотлох үүргийг хариуцлагагүй хийсэн албан тушаалтанд хариуцлага тооцож шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэдэг байх нь эрүүгийн процессын хуульд байх шударга ёсны илрэл. Хэдийгээр прокурорт даалгах зохицуулалт нь хэрэг шүүхэд үлдэж, тодорхой ажиллагаа хийсэн материалыг мөрдөгч, прокурор авчрах боловч, энэхүү зохицуулалтыг

²³ Монголын Хуульчдын Холбоо, Д.Баярсайхан «Эрүүгийн процессын эрх зүйн зарим тулгамдсан асуудал» хэлэлцүүлэг 2017.12.08, <https://www.youtube.com/watch?v=WUyGi8ISV9o&t=1966s>

²⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

цаана ч яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зохицуулалт хэрэгжихэд бэрхшээлтэй тулгарч байна.

А. Статистик судалгааны үр дүн

Баянзүрх дүүргийн прокурорын газраас, шүүхээс прокурорт хэргийг буцаасан шалтгаан нөхцөлийг 2022 оны 4 дүгээр улирлын судалгаа хийгдсэн байна. /2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд/²⁵ Судалгаа хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Үүнд:

Дээрх хугацаанд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн хэргээс анхан шатны шүүхээр 894 хэрэг, давж заалдах шатны шүүхээр 94 хэрэг, хяналтын шатны шүүхээр 5 хэрэг, нийт 993 хэрэг шүүхээр хянан хэлэлцэгдсэн ба судалгаанд хамрагдах хугацаанд нийт 33 хэрэг буюу 4 хувь нь прокурорт буцаж шийдвэрлэгдсэн байна. ЭХХШтХ-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаас хэргийг шууд прокурорт буцаасан тохиолдол байхгүй. Бөгөөд хүчингүй болгож шийдвэрлэсэн хэргүүд байна. Нийт шүүхээс буцсан 33 хэргийн урьдчилсан хэлэлцүүлгээс прокурорт буцсан 27 хэрэг, шүүх хуралдаанаас 6 хэргийг прокурорт буцааж буюу даалгаж, шийдвэрлэсэн байна. Шүүхээс хэргийг прокурорт буцаасан үндэслэлээр нь авч үзвэл, өмнөх шүүгчийн захирамжид заасан ажиллагаануудыг бүрэн биелүүлээгүй үндэслэлээр 5, хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх үндэслэлээр 13, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрсөн үндэслэлээр 9, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг зөрчсөн үндэслэлээр 6 хэргийг буцаасан байна. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгдэх болсон үндэслэлээр авч үзвэл, шүүхийн санаачилгаар 9, яллагдагч болон яллагдагчийн өмгөөлөгчийн хүсэлтээр 17, хохирогчийн төлөөлөгчийн гаргасан хүсэлтээр 1 хэрэг байна.

Анхан шатны шүүх нь прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан нотлох баримтууд нь хэргийн үйл баримтыг хөдөлбөргүй тогтооход хүрэлцэхүйц байх шаардлагыг хангасан эсэх, мөрдөн шалгах ажиллагааны шатанд нотолбол зохих байдлыг бүрэн шалгаж тогтоосон эсэх, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаанд хуульд заасан журмыг зөрчсөн эсэх, оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг үндэслэлгүйгээр хасаж, хязгаарласан эсэхийг шалгаж дүгнэхээс гадна яллах болон өмгөөлөх талын хүсэлтээр шинжлэн судлагдсан, хэрэгт хамааралтай нотлох баримт бүрийг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэт, бодит байдлаар шинжлэн судалж, харьцуулан үнэлэх замаар гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, шүүгдэгчийг яллах, эсхүл цагаатгах үндэслэл, хэргийн зүйлчлэл болон эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөл байдлын талаар үндэслэл бүхий хууль зүйн дүгнэлт хийх үүрэгтэй болно.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хувьд гомдол, эсэргүүцлийн дагуу доод шатны шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянаж, хууль буруу хэрэглэсэн, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн алдааг илрүүлсэн бол түүнийг зөвтгөн шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах, эсхүл тухайн шийдвэрийг хүчингүй болгох эрх хэмжээг хуулиар олгосон. Тухайлбал, анхан шатны шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн алдаа нь тухайн шийдвэрийг хүчингүйд тооцох, эсхүл өөрчлөх үндэслэлд хамаарах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлд хуульчлан заасан б.айна

²⁵ Баянзүрх дүүргийн прокурорын газарт, улирал бүр тогтмол судалгаа шинжилгээ хийгдэж, үр дүнд үндэслэн мэргэжлийн арга зүйн зөвлөгөөг хүргэдэг байна.

2023 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацааны прокурорт буцааж шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн шийдвэрүүдээс нэгдсэн дүгнэлтэд хүрвэл, Үүнд: Анхан шатны шүүхийн шийдвэрийн ЭХХШТХ-ийн 39.5 дугаар зүйлд заасны дагуу бүхэлд нь хянах эрх нь давж заалдах шатны шүүхэд олгогдсон. Анхан шатны шүүхийн шийдвэрээр цагаатгасан хэрэгт давж заалдах шатны шүүхээс хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхгүй, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй гэдэг үндэслэлээр хянан шийдвэрлэхгүй орхих нь ял завших үр дагаварт хүргэх тул зайлшгүй хүчингүй болгох шаардлагатай. Мөн Улсын Дээд шүүхээс “Цаашид хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шалтгаан, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний дүгнэлтийн агуулгыг сайтар судалж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эсхүл гэм буруугийн шүүх хуралдааны аль үе шатнаас хэлэлцэхийг нягталж байвал зохино” гэж тогтоолдоо дурдсан. Давж заалдах шатны шүүхээс хэргийг прокурорт шууд буцаах бол хууль хэрэглээний ноцтой зөрчил болно. Зүйлчлэлийг хүндрүүлэх хийгээд, нотолбол зохих байдал бүрэн хангагдаагүй байдалтай холбоотойгоор шийдвэр гаргах тохиолдолд хүчингүй болгох эрхтэй байна. Хүчингүй болгох эрх хэмжээг ашиглах шаардлагатай. Анхан шатны шүүхээс давж заалдах шатны шүүхэд хэргийг бүрэн хянуулах эрх хэмжээг, шийдвэртээ тусгаж, заавал хянуулахаар үүрэгдүүлсэн захирамжийг дэмжиж, зөвшөөрсөн. Иймд хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг хэлбэрийн хувьд халж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг оруулж ирсэн боловч, бодитой хэрэгжих боломжгүй байснаар, “Double, Jeopardy” зарчмын хэрэгжилт болоод өмнө дурдсан шүүхийн хөндлөнгийн хараат бус байдал, урьдчилсан хэлэлцүүлгээр цугларсан нотлох баримтын хүрээнд л гэм бурууг эцэслэн шийдвэрлэх “Нотол. Нотолж чадахгүй бол цагаатгах” зарчим хэрэгжих боломжгүй болсон байна.

Б. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

2023 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаан.д Хяналтын шатны шүүхийн прокурорт буцааж шийдвэрлэсэн 10 шийдвэр байна²⁶

Тус шийдвэрүүдэд анхан шатны шүүхийн шийдвэрийн ЭХХШТХ-ийн 39.5 дугаар зүйлд заасны дагуу бүхэлд нь хянах эрх нь давж заалдах шатны шүүхэд олгогдсон. Анхан шатны шүүхийн шийдвэрээр цагаатгасан хэрэгт давж заалдах шатны шүүхээс хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхгүй, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй гэдэг үндэслэлээр хянан шийдвэрлэхгүй орхих нь ял завших үр дагаварт хүргэх тул зайлшгүй хүчингүй болгох шаардлагатай. Мөн Улсын Дээд шүүхээс “Цаашид хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шалтгаан, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний дүгнэлтийн агуулгыг сайтар судалж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эсхүл гэм буруугийн шүүх хуралдааны аль үе шатнаас хэлэлцэхийг нягталж байвал зохино” гэж тогтоолдоо дурдсан. Давж заалдах шатны шүүхээс хэргийг прокурорт шууд буцаах бол хууль хэрэглээний ноцтой зөрчил болно. Зүйлчлэлийг хүндрүүлэх хийгээд, нотолбол зохих байдал бүрэн хангагдаагүй байдалтай холбоотойгоор шийдвэр гаргах тохиолдолд хүчингүй болгох эрхтэй байна. Хүчингүй болгох эрх хэмжээг ашиглах шаардлагатай. Анхан шатны шүүхээс давж заалдах шатны шүүхэд хэргийг бүрэн хянуулах эрх хэмжээг, шийдвэртээ тусгаж, заавал хянуулахаар үүрэгдүүлсэн захирамжийг дэмжиж, зөвшөөрсөн. Хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг хэлбэрийн хувьд халж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг оруулж ирсэн боловч, бодитой хэрэгжих боломжгүй байснаар, “Double, Jeopardy” зарчмын хэрэгжилт болоод өмнө дурдсан шүүхийн хөндлөнгийн хараат бус байдал, урьдчилсан хэлэлцүүлгээр цугларсан нотлох баримтын хүрээнд л гэм бурууг

эцэслэн шийдвэрлэх “Нотол. Нотолж чадахгүй бол цагаатгах” зарчим хэрэгжих боломжгүй болж хууль зөрчсөн шүүхийн шийдвэрүүд гарах болсон нь анхаарах асуудал мөн

Үүнийг тодруулахын зэрэгцээ дараах Улсын Дээд шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийе.

“Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”²⁷

Танилцуулах хэсэг:

(1) Шүүхийн шийдвэрийн нэр: “Б.У-т холбогдох эрүүгийн хэргийн тухай”,

(2) Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн огноо: Улсын Дээд шүүхийн тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр /дугаар 82/, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр /дугаар 164/,

(3) Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан²⁸,

Үйл явдлын агуулга:

(4) Гол үйл баримт: Б.У нь 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 18-19 цагийн үед Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны 8 дугаар гудамжинд байрлах “Улсын их дэлгүүр”-ийн гэх нийтийн байрны 00 тоотод бусадтай архиан согтуурсан байх үедээ Р.М-тэй харилцан маргалдаж, улмаар тус нийтийн байрны гадна дагуулан гарч түүнийг 3 удаа баруун зүүн мөрөөрөө ээлжлэн үүрч газарт шидэж унагахдаа гэдэс, хэвлий тус газарт нь өөрийн жингээр мөр, тохой хэсгээрээ 3 удаа дарж унан эрүүл мэндэд нь хэвлийн хөндийн битүү гэмтэл буюу дэлүүний задрал, элэгний эдийн язрал, урагдал, хэвлийн хөндийн цус хуралдалт, нойр булчирхайн няцрал гэмтэл учруулж, хүнийг санаатай алсан гэмт хэрэгт холбогджээ.

Шийдвэрлэсэн байдал:

(5) Процессын түүх: Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 1172 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.У-ыг хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 9 жилийн хорих ялаар шийтгэж, уг ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Шүүгдэгч болон түүний өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг үндэслэн хэргийг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хянан хэлэлцэж 297 дугаар магадлалаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Б.У, түүний өмгөөлөгч Ж.Гантулга, Г.Энхболд нарын гаргасан давж заалдах гомдлуудыг хэрэгсэхгүй болгожээ. Хяналтын шатны шүүхээс /нотолбол зохих байдал бүрэн хангагдаагүй/, Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 1172 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 297 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн

Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Б.У-т холбогдох эрүүгийн 2209000000343 дугаартай хэргийг Сүхбаатар дүүргийн прокурорын газарт буцааж, урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, яллагдагч Б.У-т урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлэхээр шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс, Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 1703 дугаар захирамжийг хэвээр үлдээсүгэй. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 952 дугаар магадлалыг хүчингүй болгосон.

(6) Одоогийн шийдвэрийн шийдэл ба үндэслэл:

²⁷ Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, УБ, 2015.

²⁸

Монгол Улсын Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүх нь шүүхийн дээд байгууллагын хувьд хэрэг хянан шийдвэрлэх дээд хяналтыг хэрэгжүүлдэг онцгой бүрэн эрхтэй болно. Улснд ээд шүүх нь хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэр, үйл ажиллагааг хянаж хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх жишгийг тогтоох, шаардлагатай тохиолдолд шүүхийн хэрэглэх хуулийг албан ёсоор тайлбарлаж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Иймээс анхан болон давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил, хууль хэрэглээг гаргасан шийдвэрт нь тулгуурлан өөрчлөх, хүчингүй болгох бүрэн эрх хуулиар олгогдсон бөгөөд энэхүү заавал биелэгдэх императив шинжтэй шийдвэрийг бүх шатны шүүх хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх үүргийг холбогдох хуулиар хүлээлгэсэн болно.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар Б.У-т холбогдох хэргийг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хянан хэлэлцээд “... мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэт биш хийсэн бөгөөд үүнийг шүүхийн шатанд нөхөн гүйцэтгэх боломжгүй” үндэслэлээр 2 шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгожээ. Энэхүү шийдвэрийн дагуу анхан шатны шүүх Б.У-т холбогдох хэргийг урьдчилсан шүүх хуралдаанаар хэлэлцэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1.2-т заасан дагуу хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй болно.

Мөрдөн шалгах ажиллагаагаар хэргийн талаар нотолбол зохих байдал буюу Б.У-ын гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг эргэлзээгүй нотлох шаардлагатай гэсэн үндэслэлээр хэргийг прокурорт буцаасан шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгыг хангаж чадаагүйгээс гадна хэргийн бодит байдал тогтоогдохгүй байж болзошгүй нөхцөл байдалд хүргэхээр байна. Иймд магадлалыг хүчингүй болгож, хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх тухай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Цаашид хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шалтгаан, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний дүгнэлтийн агуулгыг сайтар судалж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эсхүл гэм буруугийн шүүх хуралдааны аль үе шатнаас хэлэлцэхийг нягталж байвал зохино.

Дүн шинжилгээ:

(7) Формал шаардлага: УДШ-ын 2006 оны 4 сарын 25-ны “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмжид заасны дагуу формал шаардлага хангагдсан байна.

(8) Асуудал:

2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал нь хүний язгуур эрхийг хангахад чиглэсэн Үндсэн хууль болон бусад хууль дахь суурь зохицуулалтыг хэрэгжүүлэхийг зорьсон. Тодруулбал, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан шинэлэг зохицуулалтын нэг болох анхан шатны шатны журмаар хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хоёр хувааж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, үндсэн шүүх хуралдаан гэж заагласантай холбоотойгоор мөрдөн байцаалтын шатанд нотолбол зохих буюу нотлох баримтын хүрэлцээ, хангалттай байдалтай холбоотой асуудлыг үндсэн шүүх хуралдаанаар хэлэлцэх бус шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас цаг алдалгүй прокурорт буцаах замаар хэлэлцэх тусгайлсан үе шатыг бий болгосон нь энэхүү өөрчлөлтийн гол үзэл баримтлал юм. Энэ агуулгаараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах” тухай заалтыг хүчингүй болгосон.

Үүнээс үзэхэд хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг зөвхөн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд зөвшөөрсөн заалтыг хэвээр үлдээж, харин бусад шатны шүүх хуралдаанаас “хэргийг прокурорт буцаах” заалтыг хориглохын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт “шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй” гэж хоёрдмол салаа утгагүй, тодорхой илэрхийлж, хатуу хуульчилж өгсөн байхад анхан шатны шүүхээс Б.У-т холбогдох хэргийг урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдаанаар хэлэлцэж, Улсын дээд шүүхийн тогтоолд заасан ажиллагааг хийлгэх шаардлагатай гэж үзэн, хууль зөрчиж хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болжээ²⁹.

Харин үндсэн шүүх хуралдааны явцад шүүгдэгчид сонгосон ялыг хүндрүүлэх шаардлагатай гэж үзвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг хойшлуулж, прокурорт даалган гүйцэтгүүлэх журмыг хуульчилсан. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүх Улсын дээд шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаартай тогтоолыг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5-д “... эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна” гэсний дагуу шүүх хуралдааныг хойшлуулж болох байсан ч энэ зохицуулалтаар нэмэлт ажиллагаа хийлгэх бололцоогүй болно.

(9) Өмнө нь гарч байсан шүүхийн шийдвэр³⁰:

2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй” Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн.

Давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр үлдээсэн, ингэхдээ “анхан шатны шүүхийн шийдвэр хэргийн бодит байдалтай нийцээгүй, прокурорын яллах дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримтуудад дүгнэлт хийхгүй орхигдуулсан” гэж үзсэн хэдий ч “Монгол Улсын Их хурлаас 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах, зүйлчлэлийг хүндрүүлэх хууль зүйн боломжгүй болсон” тул гэж дүгнэн анхан шатны шүүхээс цагаатгасан хэргийг хэвээр үлдээсэн байна.

(10) Эрх зүйн онол, үзэл баримтлал:

2017 оны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго бол гэм буруугийн шүүх хуралдаанаас хэргийг буцаадаг байдлыг халж, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой зохицуулалт болно. Үүнээс зарчмын хувьд МУ холимог тогтолцооны хэрээр мөрдөн шалгах зарчим болон мэтгэлцэх зарчмыг хооронд нь уялдаа холбоотойгоор зохист түвшинд хэрэглэх нь зүйтэй. Зөвхөн мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийн үүднээс авч үзвэл ял завших үр дагаварт хүргэж, мөрдөн шалгах зарчмын үүднээс авч үзвэл дахиад нотлоод ир гэж хэргийг прокурорт буцаах нь “double jeopardy” зарчмын хэрэгжилт хангагдахгүй, зарчим хоорондоо зөрчилдсөн үр дагаврыг үүсгэж байна.

Улсын дээд шүүх нь хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэр, үйл ажиллагааг хянаж хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх жишгийг тогтоох эрх хэмжээтэй бөгөөд, тус эрх хэмжээний хүрээнд “Цаашид хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шалтгаан, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний дүгнэлтийн агуулгыг сайтар судалж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эсхүл гэм буруугийн шүүх хуралдааны аль үе шатнаас хэлэлцэхийг нягталж байвал зохино” гэж тогтоолдоо тусгажээ.

²⁹ УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн хяналтын прокурор А.Золзаяа,

³⁰ Б.Батцэрэн, Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй, <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/174>, 2023, (Сүүлд үзсэн: 2024.12.25)

IV. ГАДААД ОРНЫ САЙН ТУРШЛАГА, ИЖИЛ БОЛОН ЯЛГААТАЙ ТАЛ

Монгол улсын хувьд Ром Германы эрх зүйн бүлд хамаарч, эрүүгийн процессын холимог системтэй буюу шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагааний үр дүнд хэргийн бодит байдлыг тогтоох, шүүхийн шатанд мэтгэлцэх буюу нотол, нотолж чадахгүй бол цагаатгах зарчим үйлчилдэг байх онцлогтой улс юм. Иймд гадны орны сайн туршилгыг өөрийн улсын онцлогт тааруулах үүднээс манай улстай төстэй байж болох нэг эрх зүйн бүлд хамаарах улсыг сонгосон болно.

А. Оросын Холбооны улс³¹

ОХУ-н Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 237 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөөр мөрдөн шалгах ажиллагааны дутууг нөхөж, гүйцээлгэх зорилгоор буцааж байсныг бүрмөсөн болиулж, шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж буй нөхцөл байдлыг арилгуулах зорилгоор хэргийг прокурорт буцаах боломжийг хуульчилсан байна. Ингэхдээ 2 тохиолдлыг хуульчилсан байна. Үүнд:

- Хэргийг шүүхэд шилжүүлсний дараа яллагдагчид аюултай шинэ үр дагавар үүсэж, түүнд нь илүү хүнд ял сонсгох шаардлагатай болсон.
- Эрүүгийн хэргийн талаар өмнө гаргасан шүүхийн тогтоол, магадлал, захирамжийг дээд шатны шүүхээр хүчингүй болгосон бөгөөд хүчингүй болгох шийдвэрийн үндэс болсон шинэ болон дахин үүссэн нөхцөл байдал нь яллагдагчид илүү хүнд ял сонсгох болсон³².

Шүүх бүрэлдэхүүн ял оноох бүрэн үндэслэлтэй гэж үзвэл шүүхийн яллан шийтгэх тогтоол гарна. Хэрэв үндэслэлгүй буюу нотлогдоогүй гэж үзвэл шүүхийн цагаатгах буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол гаргана. Харин анхан шатны шүүх хуралдаанаар бүрэн хэлэлцсэний дараа прокурор эсхүл мөрдөн байцаалт руу буцаах шийдвэр гаргахгүй³³. Давж заалдах болон хяналтын шатны шүүх эрүүгийн хэргийг прокурор болон доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээ эдэлдэг. Монгол Улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүхэн уламжлал нь ОХУ-ын нөлөөгөөр хөгжиж ирсэн бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зарим зохицуулалтын хувьд ойролцоо, ижил төстэй зүйл, хэсгийг харьцуулан судлах, манай улсын хууль тогтоомжид байхгүй дэвшилтэт шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлэх боломжтой болно.

Статья 237. Шүүхээс хэргийг прокурорт буцаах нөхцөлүүдийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- Хууль зөрчсөн шийтгэлийн акт;
- Яллагдагч өмгөөлөх авах хүсэлттэй боловч өмгөөлөгч аваагүй,
- Эмчилгээ шаардлагатай;
- Хэд хэдэн хэрэг нэгтгэх шаардлага гарсан,
- Яллагдагчид, түүний эрхийг тайлбарлаагүй;
- Шинээр илэрсэн нөхцөл байдлаас илүү хүнд ял шийтгэлийг шаардсан гэх мэт. Хэрэв прокурорт хэрэг буцсан тохиолдолд яллагдагчид шүүхээс таслан сэргийлэх арга хэмжээ авч шийдвэрлэдэг байна.

Статья 238–239.2 Бусад холбогдох зүйлийг үүнд зохицуулсан ба хэрэг түр зогсоох, яллагдагч ор сураггүй болсон, хүнд өвчин туссан, Үндсэн хуулийн шүүхэд хандсан, яллагдагч шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон зэрэг тохиолдолд прокурорт даалгавар өгч даалгаж шийдвэрлэдэг байна. УПК РФ-д шүүхийн урьдчилсан шат буюу урьдчилсан хэлэлцүүлгээс эсвэл үндсэн шүүх хуралдаанаас прокурорт хэрэг даалгах заалт бий. УПК РФ-ийн 34-р бүлэг (Ст.234–237)-д зааснаар: Урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр

³¹ Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлэг” 2024.03.01, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf

³² “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (сүүлд үзсэн огноо:2024.03.01)

³³ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн процесс, УБ, 2015, 115 дахь тал.

шүүх хэрэгт нотлох баримт дутагдалтай, эрх зөрчигдсөн эсвэл хууль зөрчсөн тохиолдолд хэргийг прокурорт буцааж болно. Үндсэн буюу гэм бурууг хэлэлцэх үед (Ст.237, 307–308) Хэрвээ шинээр илэрсэн нотолгоо, хууль зөрчсөн үйлдэл, эсвэл яллагдагчийн эрх ноцтой зөрчигдсөн бол шүүх хэргийг прокурорт буцаах эрхтэй. Энэ нь хэрэг урьдчилсан шатнаас дамжин үндсэн хэлэлцүүлэгт орсны дараа дахин буцаагдаж болно гэсэн үг.

Дээрхээс үзэхэд прокурорт буцаах зохицуулалт энэ улсад үйлчилдэг бөгөөд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон зарим тохиолдолд шүүхийн гэм буруугийн хэлэлцүүлгээс ч прокурорт хэрэг буцах мөн даалгах зохицуулалт байдаг байна. Тэгвэл тухайн улсад мэтгэлцэх зарчмын тухайд Ст. 15, 16 “хэргийн бүх оролцогчдын эрх тэгш, шүүхийн өмнө мэтгэлцэх эрхийг хангана” мөн Ст. 237–238 “Хэрэг буцаах, прокурорт даалгах үед талуудын санал, мэтгэлцэх эрхийг хадгална” Ст. 241–247, 307-308 мэтгэлцэх зарчмын тухай уялдах хуулийн зохицуулалтыг Эрүүгийн процессын хуульдаа тусгасан байна.

Тус улсад “нотол, нотолж чадахгүй бол цагаатгах” зарчмын хувьд хуулийн Статъя 49, “Яллагдагчийн эрх зөрчигдсөн, нотолгоо хангалтгүй бол шүүх цагаатгах шийдвэр гаргана” гэж зохицуулсан мөн энэ талаад тухайн улсын эрдэмтэн судлаачид бүтээлээ туурвисаар байгаа боловч практикт Монгол улсын нэгэн адил бэрхшээлийг туулж явна. Тодруулбал:

Алексей Алексеевич Суханов: Оросын эрүүгийн процессын эрх зүйн салбарт нэр хүндтэй эрдэмтэн. Түүний “Уголовно-процессуальное право России” ном нь Оросын эрүүгийн процессын эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд шүүхийн шийдвэр гаргах эрх зүйн үндэслэл, нотолгооны үүрэг, цагаатгах зарчим зэрэг асуудлыг гүнзгий судалсан.

Владимир Владимирович Лазарев: Оросын эрүүгийн процессын эрх зүйн салбарт судалгаа хийдэг эрдэмтэн. Түүний “Уголовный процесс: теория и практика” бүтээл нь шүүхийн практик дахь асуудлуудыг судалсан бөгөөд нотолгоо хангалтгүй бол прокурорт буцаахгүйгээр цагаатгах асуудлыг хөндсөн.

Николай Николаевич Поляков: Оросын эрүүгийн процессын эрх зүйн салбарт судалгаа хийдэг эрдэмтэн. Түүний “Процессуальные гарантии прав обвиняемого в уголовном процессе” бүтээл нь яллагдагчийн эрхийг хамгаалах асуудлыг судалсан бөгөөд нотолгоо хангалтгүй бол цагаатгах зарчмыг онцолсон.

Б. Холбооны Бүгд Найрамдах Герман улс³⁴

Холбооны Бүгд Найрамдах Герман /цаашид ХБНГУ/ улсын эрүүгийн процесс шүүн таслах ажиллагаа нь мөрдөн шалгах зарчмын үндсэн дээр 3 үе шаттайгаар явагддаг.

- Нэгдүгээр үе шатанд: Прокурор мөрдөн шалгах ажиллагааг явуулж, яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулдаг байна.
- Хоёрдугаар үе шатанд: Шүүх хуралдааныг явуулах эсэхийг шийдвэрлэх шат. Сэжигтэн, яллагдагчийг шүүхээр хянан хэлэлцэхэд хангалттай эсэхийг хянасны үндсэн дээр шүүх хуралдаан явуулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ үед яллагдагчийг дуудан ирүүлж, хэрэгт авагдаагүй нэмэлт нотлох баримт цуглуулах боломжийг олгож, өмгөөлөгчтэй уулзаж, хүсэлтийг сонсох, цагаатгах нотлох баримт бүрдүүлэх, гэрчүүдийн мэдүүлгийг шалгах зэрэг ажиллагаануудыг хийдэг байна. Хуулийн 202 дугаар зүйлд “... хэргийн бодит байдлыг сайтар судалж тогтоох зорилгоор шүүх нэмэлт нотлох баримт цуглуулахаар тогтоож болох ба түүнд хэн ч гомдол гаргах эрхгүй” гэж зохицуулж, үүний дараагаар шүүх гэм буруугийн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлаа шийдвэрлэдэг байна. Гэм буруугийн шүүх хуралдаанд прокурор зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол хуралдааныг завсарлаж, тэр дор нь шийдвэрлэхээр зохицуулсан байна. Гэвч шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх эсэхийг шалгаж үзсэн шүүгч тухайн хэрэгт шүүгчээр оролцохыг хориглосон байдаг. /23.3 дугаар зүйл/

³⁴ Хууль Зүйн Үндэсний хүрээлэн, “ЭБШ хууль дахь, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах талаарх судалгааны ажлын тайлан”, УБ, 2012 он,

- Гуравдугаар үе шат: Шүүн таслах үе шат юм. Гэм буруугийн талаар хэлэлцэж, дахин хэргийг прокурорт буцаах зохицуулалт байхгүй ба хэргийг шийдвэрлэхэд эргэлзээ гарвал, хангалттай нотлогдохгүй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэдэг байна.

ХБНГУ-д давж заалдах ажиллагаа нь доод шатны шүүхийн алдааг засах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой. Эрүүгийн процесст давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үйл баримтын эсрэг “Berufung”, хууль хэрэглээний эсрэг “Revision”, шүүхийн бусад шийдвэрийн эсрэг “Beschwerde” гомдол гаргах ажиллагаа гэж гурван төрөлд хуваадаг³⁵. Шүүх гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, тогтоогдсон хэргийн үйл баримтад тулгуурлан шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл, “Berufung” зарчмаар давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүх шүүгдэгчийн гэм буруу болсон хэргийн үйл баримтын талаар өөрийн дүгнэлтийг өгөх эрхтэй. Оногдуулсан ял шийтгэлийн эсэргүүцэж, гомдол гаргасан бол ялыг өөрчлөх эрхтэй ч “reformation in reus” буюу өмнөх шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлж оногдуулахгүй байх зарчмыг баримтална. Давж заалдах шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрийг ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуулийн 352 дугаар зүйлд зааснаар зөвхөн гомдолд дурдагдсан асуудал болсон үйл баримтын хүрээнд хянан хэлэлцэнэ. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүйн судлаач Майкл Бонлайндерын тайлбарлаж буйгаар гомдол гаргагчаас дэвшүүлсэн үйл баримт нь гомдолд тусгагдсан тухайн нэг процессын зөрчилтэй хамааралгүй бөгөөд гомдолд дурдахааргүй бусад зөрчлийг илэрхийлж байвал шүүхээс сүүлд илэрсэн зөрчлийн хүрээнд шийдвэр гаргаж болно³⁶.

Хэргийг прокурорт буцаах тухай зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн “Revision” төрлөөр давж заалдах ажиллагаа явуулах үед тухайн хэрэг үйл баримтын болон хууль хэрэглээний алдаа аль аль нь илэрсэн тохиолдолд хэргийг доод шатны шүүх рүү буцааж болно.

ХБНГУ-д шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зохицуулалт Япон, Хятад хоёртой харьцуулахад илүү нарийн, хуульчлагдсан байдаг. Эрүүгийн процессын хууль (Strafprozessordnung, StPO)-д шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг Vorverfahren буюу шүүхийн урьдчилсан шат гэж тодорхойлсон. Үүнд прокурор, шүүх, сэжигтэн болон өмгөөлөгч оролцдог. Энэхүү шатанд хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгах, сэжигтэнд ял тулгах эсэхийг урьдчилан шийдвэрлэх, хэргийн ач холбогдлыг тодорхойлох зорилготой.

Урьдчилсан шатанд (Pre-trial / Vorverfahren) прокурор хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгадаг. Хэрвээ нотолгоо дутуу байвал нэмэлт нотолгоо цуглуулах эсвэл хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэрийг прокурор гаргана. Шүүхийн шатанд (Trial stage) шүүх нотолгоо хангалтгүй гэж үзвэл цагаатгах эсвэл хэргийг прокурорт буцаах (remand to prosecutor) боломжтой. Прокурор энэ үед нэмэлт нотолгоо цуглуулж, дахин яллах эсэхийг шийддэг. Энэ нь АНУ-ын системтэй илүү төстэй, харин Орос шиг шүүх нөхцөл байдлаар буцааж шийддэг механизм байдаггүй.

Цагаатгах зарчмын тухайд ХБНГУ-ын эрүүгийн процессын хуулийн §154 StPO (Germany) “Хэрэв нотолгоо хангалтгүй, хэрэгтээ хэрэг үүсгэх боломжгүй гэж үзвэл прокурор хэрэг үүсгэхээс татгалзаж болно”. Мөн §170 StPO “Прокурор хэрэгт нотолгоо хангалтгүй бол шүүхэд шилжүүлэхгүйгээр хэрэгт цагаатгах шийдвэр гаргах эрхтэй. Хэрэв шүүх нотолгоо хангалтгүй гэж үзвэл хэрэг прокурорт буцаагдана” гэж зохицуулсан байна. Германд adversarial elements илүү хөгжсөн (§136, §160–162 StPO) өмгөөлөгч болон прокурор шүүхэд нотолгоо, тайлбар тавих эрхтэй. Шүүх зөвхөн дүн шинжилгээ хийхгүй, мөн талуудын мэтгэлцээн дээр үндэслэн шийдвэр гаргана гэж зохицуулснаар мэтгэлцэх зарчим агуулагдсан байна. Эдгээр мэдээллээс үзэхэд тус улсад шүүхийн урьдчилсан

³⁵ Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, p.251 (Сүүлд үзсэн: 2023.03.09), <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>.

³⁶ Micheal Bohnlander, 2012, p.251

хэлэлцүүлэг болоод гэм буруугийн шатанд прокурорт хэргийг буцааж шийдвэрлэдэг. Тухайн шийдвэр тус улсад үйлчилдэг цагаатгах болон мэтгэлцэх зарчимтай мөн Монгол улс шиг харшилдаг гэх үр дүн харагдаж байна.

Энэ тухайд ХБНГУ-ын эрдэмтэд болох Prof. Dr. Klaus Tiedemann: Германы эрүүгийн эрх зүйн салбарт нэр хүндтэй эрдэмтэн, шүүмжлэлтэй ханддаг. Мөн Prof. Dr. Hans-Jürgen Pabst: Германы Үндсэн хуулийн шүүхийн дарга асан, эрх зүйн үндсэн зарчмуудыг хамгаалаг,

Prof. Dr. Michael Kubiciel: Эрүүгийн эрх зүйн профессор, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон прокурорт буцаах асуудлаар судалгаа хийдэг шүүмжлэлттэй ханддаг бөгөөд тус хуулийн § 170 StPO зүйлд заасан прокурорт буцаах зохицуулалтад шүүмжлэлтэй ханддаг байна. Ингэхдээ шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг зайлшгүй хийх нэг үе шат болгох талаар хуульчлаагүй байна.

В. Япон улс³⁷

Япон улс нь 1946 онд шинэ Үндсэн хуулиа баталсны дараа Эрүүгийн процессын хууль тогтоомжоо түүнд нийцүүлж гаргах замаар гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тогтолцоог өөрчлөн шинэчлэх болсон билээ. 1948 онд Японы Эрүүгийн процессын хууль шинээр батлагдан гарчээ. Энэ хууль нь Японы Үндсэн хуулийн суурь зарчмуудыг тусгаж, нотлох ажиллагааны шалгуурыг шинэчлэн шүүхийн мэтгэлцүүлэн хэлэлцэх журмыг тогтоосноос гадна процессын оролцогчдын эрхийг зааглан хуульчилж өгснөөрөө түүхэн ач холбогдолтой.

Япон улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт “Прокурор нь улсын дээд шүүхээс тогтоосон журмыг баримтална” гэж зохицуулсан³⁸. Мөн хуулийн 40-р зүйлд “Баривчлагдаж, цагдан хоригдсон хүн, хэрэв тодорхой хугацааны дараа шүүхийн тогтоолоор хэрэг нь хэрэгсэхгүй болж, гэм буруугүй нь тогтоогдвол төрөөс хохирлоо барагдуулахаар нөхөн төлбөр гаргуулж болно” гэсэн байна.

Японы Эрүүгийн шүүхийн шүүх хуралдаан нь Америкийн шүүхийн чөлөөт мэтгэлцээний зарчмыг ихэнх агуулгаар тусгаж, шүүн таслах ажиллагааны бүхий л явцад уг зарчим сонгодог утгаар хэрэгждэг гэж үзэж болно. Онц ноцтой зарим эрүүгийн хэргийг шүүхээр хэлэлцэхэд тангарагтны төлөөлөгч гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоотой. Эрүүгийн процессын хуулийн 41-р зүйлд: “... Өмгөөлөгч нь хуулийн тусгайлан олгогдсон эрхийн дагуу бие даан өмгөөллийн үйл ажиллагаа явуулна”. гэж заажээ. Өмгөөлөгчид хуулиар олгогдсон эрхэд нотлох баримтыг цуглуулах, өөрийн биеэр хэргийн газрын үзлэгт оролцох, үзлэгийг газар дээрээс нь зураг авах, яллагдагчийг байцаахад зарим үед байлцах, гэрч нараас асуулт асуух, шинжээчтэй уулзаж ярилцах зэрэг эрхээр хангагдсан байдаг. Эрүүгийн процессын хуулийн 298.1-р зүйлд: “Прокурор, шүүгдэгч, өмгөөлөгч нь нотлох баримтыг шүүхээр шинжлэн судлуулахаар хүсэлт гаргах эрхтэй” гэж заасан бол мөн хуулийн 312.1-р зүйлд: “Шүүх нь прокурор яллах дүгнэлт үйлдэж, хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай актад заасан шүүхэд шилжүүлэх үндэслэл, шалтгаан, яллах дүгнэлтийн агуулга болон нэмэлт хийх, өөрчлөх, татгалзах, талаар шүүхээр хэлэлцүүлэх эсэх талаар шийдвэр гаргана” гэж дурджээ³⁹. Мөн хуулийн 298.2-р зүйлд: “Шүүгч нь хэрэгтэй, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн санаачлагчаар нотлох баримтыг шалгах, шинжлэн судлах эрхтэй” гэж заасан. Энэхүү зохицуулалт нь мэтгэлцэгч талуудын аль нэг нь тэгш бус байр суурьтай байгаа тохиолдолд оролцогчдын эрх, үүргийг хамгаалахын тулд шүүгч өөрийн санаачлагчаар

³⁷ 1948 оны 131 дүгээр Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 昭和二十三年法律第三百一十一号刑事訴訟法, https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000131_20240215_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITCyXYbcRffOXE2yC8cpITGdIj6dijWSdUTpLsz_0EkGGY, (Сүүлд үзсэн: 2024.04.25),

³⁸ Япон улсын Үндсэн хууль, 昭和二十一年憲法日本国憲法, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321CONSTITUTION>, (Сүүлд үзсэн: 2024.05.01),

³⁹ Япон улсын 2015 оны Эрүүгийн Процессын хуулийн 312 дугаар зүйл, Д.Баярсайхан,

нотлох баримтыг дахин шалгах, шинжлэн судлах, баримт сэлтүүдийн нотлох чадварыг эргэн хянаж эргэлзээгүй байдал хангагдсан эсэхийг эцэслэн тогтооход чиглэгдэнэ. Зарим судлаачид энэ зохицуулалтыг мөрдөн шүүх тогтолцооны хэв шинж тусгагдсан гэж үзэх нь бий⁴⁰.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хууль зөрчсөн, зүй бус арга хэрэгслээс урьдчилан сэргийлэхийн тулд Японд байцаалт явагдсаныг ил тод болгох зорилгоор дүрс бичлэгийн бүх үйл явцыг хамруулан бэхжүүлэн авч, байх журмыг хэрэгжүүлдэг байна. Байцаалт бүрэн гүйцэд бус, зөвхөн нэг хэсэг нь буюу зарим нь бичигдсэн бол мэдүүлэг гаргах ажиллагааг үнэлэхэд эрсдэлтэй гэж үздэг ажээ⁴¹. Японы Эрүүгийн процессын 312-р зүйлд⁴² “Ялын үндэслэлийг өөрчлөх” тухай зохицуулалтаар шүүх нь прокурорын хүсэлтээр яллах дүгнэлт болон хэргийн бодит байдал нэгдмэл байх зарчмыг хөндөхгүй хүрээнд ялын тогтоолд дурдагдсан яллах үндэслэлийг нэмэх, хүчингүй болгох, өөрчлөхийг зөвшөөрдөг бөгөөд энэ нөхцөл нь шүүх хуралдааны явцад зүйлчлэлийг өөрчлөх, хүндрүүлэх, хөнгөрүүлэх эрхийг прокурорт өгсөн бөгөөд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх үүднээс шүүх ялын хэмжээнд өөрчлөлт орсон нь шүүгдэгчийн хууль ёсны эрх ашгийг зөрчих аюул бий болсон гэж үзсэн тохиолдолд шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн хүсэлтээр шүүгдэгчид өөрөө өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэх хугацаа олгож хуралдааныг түр завсарлуулдаг байна⁴³. Мөн 402-р зүйлд “Ашиггүй байдлаар өөрчлөхийг хориглох” заалтын хүрээнд шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн давж заалдсан хэргийн тухайд анхан шатны шүүхээр оноосон ялаас хүнд ял оноохыг хориглох. Жишээ нь шүүгдэгч ял хүндэдсэн гэх гомдол гаргасан тохиолдолд дээд шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах явцдаа гомдлын үндэслэлийн хүрээнд шийдвэр гаргах учиртай. Гомдол үндэслэлтэй бол ялыг багасгах, үндэслэлгүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгох, шийдвэрт хүрнэ.

Япон улсад прокурорт даалгаж шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалт байхгүй. Учир нь шүүгч болон прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр өөр үүрэгтэй, бие даан ажилладаг гэдгээрээ онцлог. Шүүхийн үндсэн үүрэг бол шүүх хуралдааныг шударгаар явуулах явдал юм. Шүүх нотлох баримтыг хянаж үзээд хуулийн дагуу шийдвэр гаргадаг. Шүүхийн төвийг сахих, шударга байдлыг хангах үүднээс прокурор болон бусад талуудаас хараат бус байр суурьтай байдаг бол прокурорууд эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, яллах ажиллагааг хариуцаж, шүүхэд нотлох баримт гаргаж, шүүх хуралд оролцоно. Шүүгч шүүх хуралдаанд прокуророос гаргасан нотлох баримт, нотлох баримтыг судалж, өөрийн дүгнэлтийг гаргадаг.

Мэтгэлцэх зарчмын (Adversarial vs Inquisitorial) тухайд Япон улс нь инквизицион систем (inquisitorial system)-ийг баримталдаг бөгөөд прокурор болон мөрдөн байцаагч гол үүрэгтэй, шүүхийн үүрэг нь нотолгоо хянах, маргааныг шийдэхэд хязгаарлагдмал. Яллагдагчийн өмгөөлөгчийн мөн манай улс шиг хязгаарлагдмал эрхтэйгээр оролцдог.

Япон Улсад presumption of innocence буюу цагаатгах зарчим Үндсэн хууль (Article 31) болон Эрүүгийн процессын хуульд тусгалаа олсон. Хэрэв нотолгоо хангалтгүй бол шүүх цагаатгах шийдвэр гаргана. Прокурор нотлох баримтыг хангалтгүй гэж үзвэл хэрэгсэхгүй болгож эсвэл шүүх рүү шилжүүлэхээс өмнө дахин мөрдөн байцаалт хийх боломжтой. Тодруулбал Япон улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 337 дугаар зүйлд зааснаар, хэрэв прокурорын нотлох баримт хангалтгүй гэж шүүх үзвэл, шүүх нь яллагдагчийг цагаатгах шийдвэр гаргах эрхтэй. Хэргийн нотлох баримт хангалтгүй, эсвэл хууль зөрчигдсөн тохиолдолд прокурорын хүсэлтээр шүүх хэрэгсэхгүй болгох эсвэл яллагдагчийг

⁴⁰ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн процесс, УБ, 2015, 147 дахь тал.

⁴¹ Д.Баярсайхан, Гадаадын Эрүүгийн процесс номноос дам эшлэв/ Кага Жожи. Япон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, сорилт, Ази номхон далайн орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага 2001 он, УБ, 72 дахь тал.

⁴² Ж.Эрхэсхулан, “Япон улсын 2019 оны Эрүүгийн Процессын хуулийн 312 дугаар зүйл”.

⁴³ Эрх зүй сэтгүүл, Ж.Эрхэсхулан, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хэрэглээний зарим асуудал”, 2019, №2, Цуврал 46, 208 дахь тал.

цагаатгах шийдвэр гаргах боломжтой. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг бүх хэрэгт бус зөвхөн тодорхой төрлийн гэмт хэрэг эсхүл ноцтой хүнд гэмт хэргүүдэд хийгддэг байна.

Г. Бүгд Найрамдах Хятад Ард улс⁴⁴

Хятад нь социалист дэглэмтэй ардчилсан бус орон боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд инквизицийн мөрдөн шалгах уламжлалыг аккусацийн мэтгэлцүүлэн шүүх зарчимтай маш өвөрмөц аргаар хослуулж, эрүүгийн хэргийн нотлох ажиллагааны хаалттай нөхцлийг улс, орны онцлогт нийцсэн байдлаар зохицуулж иржээ.

БНХАУ-ын Үндсэн хууль⁴⁵, Ардын шүүх байгуулах хуулийн 12 дугаар зүйлд зааснаар улсын шүүх тогтолцоо нь Ардын дээд шүүх, Газрын шат шатны ардын шүүх, Цэргийн шүүх зэрэг тусгай шүүхээс бүрдэх бөгөөд Ардын дээд шүүх нь газар бүрийн шат шатны ардын шүүх, тусгай ардын шүүхийн шүүн таслах ажлыг хянана. Өөрөө хэлбэл дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн шүүн таслах ажлыг хянах буюу газрын шат шатны ардын шүүх нь дээд шатны шүүх, дунд шатны шүүх, үндсэн шатны шүүхэд тус тус хуваагдана. Харин Тусгай ардын шүүхийн бүтцэд цэргийн, далайн, санхүү, оюуны өмчийн шүүхүүд багтана гэж хуульчилжээ⁴⁶.

Эрүүгийн процессын хуулийн 150 дугаар зүйлд зааснаар “...Шүүх нь прокурорын зөвшөөрч шилжүүлсэн яллах нэхэмжлэл бүхий эрүүгийн хэргийг хянаж, шалгасны дараа зайлшгүй шүүхээр ял оногдуулах бодит шаардлага нь хангагдсан бол гэрч болон гэрчлэх баримтын жагсаалт, гол гэрч, гэрчлэх мэдүүлсэн баримтын гэрэл зураг дагалдуулсан материал зэрэг үндсэн нотолгооны баримтууд бүрэн цугларсан нөхцөлд шүүх хуралдаанаар хэлэлцэх ажиллагааг эхлүүлнэ. Мөн хуулийн 158 дугаар зүйлд зааснаар шүүх танхимд эрүүгийн хэргийг шүүн хэлэлцэх явцад нотлох баримтад эргэлзээ төрвөл шүүх хурлыг завсарлаж, нотлох баримтыг шалган үнэн зөв байдлыг дахин нягталж болно.

Анхан шатны ардын шүүх прокуророос шилжүүлсэн эрүүгийн хэргийг хянаж тус шүүхийн харьяалалд хамаарахгүй, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх шаардлагатай зэрэг тохиолдолд буцаах эрхийг Ардын дээд шүүхийн тайлбараар нарийвчлан зохицуулсан байна. Тодруулбал шүүхээс бие даан хэргийг прокурорт буцаах эрхгүй боловч, прокурорын саналыг шүүх хүлээн авч, шүүх хуралдааныг 1 сар хүртэлх хугацаагаар хойшлуулах эрхтэй байна⁴⁷. Харин давж заалдах шатны шүүх буюу хоёрдугаар шатны шүүхийн эрх хэмжээг гомдол, эсэргүүцлийн хүрээнд хязгаарлагдахгүй анхан шатны шийдвэрээр тогтоосон бодит байдал, хуулийн хэрэглээг бүхэлд нь хянах. Мөн бүлэглэж гүйцэтгэсэн гэмт хэргийг зөвхөн хэсэг шүүгдэгч давж заалдсан бол хэргийг бүхэлд нь хянаж нэгтгэж шийдвэрлэнэ.⁴⁸

Анхан шатны ардын шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан процессыг зөрчсөн дараах нөхцөл байдлын аль нэгийг давж заалдах шатны ардын шүүх илрүүлсэн бол шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр тухайн шатны ардын шүүхэд буцаана⁴⁹. Давж заалдах шатны ардын шүүхэд шүүгдэгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, ойр дотнын хүнээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ шүүгдэгчийн ялыг хүндрүүлэхгүй. Давж заалдах шатны ардын шүүх тухайн шатны ардын шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэгт ардын прокурорын газраас нэмж шинэ гэмт хэрэг үйлдсэн бодит байдлыг заалдсанаас бусад тохиолдолд тухайн шатны ардын шүүх шүүгдэгчийн

⁴⁴ Д.Баярсайхан, Гадаад орнуудын Эрүүгийн процесс, УБ, 2015, 117 дахь тал.

⁴⁵ БНХАУ-ын Үндсэн хуулийн 129 дүгээр зүйл/ 中华人民共和国宪法/ (Сүүлд үзсэн: 2023.03.22), <https://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>.

⁴⁶ БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль, /中华人民共和国人民法院组织法/ (Сүүлд үзсэн: 2023.03.22)8 https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm.

⁴⁷ Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар, 最高人民法院关于适用《中华人民共和国刑事诉讼法》的解释 (Сүүлд үзсэн: 2023.03.22)8 http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml

⁴⁸ БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 233 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ (Сүүлд үзсэн: 2023.03.22); <http://www.npc.gov.cn/npc/index.html>.

⁴⁹ БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 238 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ (Сүүлд үзсэн: 2023.03.22), <http://www.npc.gov.cn/npc/index.html>.

ялыг хүндрүүлэхгүй байхаар хуульчилсан байна⁵⁰.

Criminal Procedure Law, Article 12 “No one shall be found guilty without sufficient evidence.”

Прокурор нотолгоо хангалтгүй гэж үзвэл хэрэгт цагаатгах шийдвэр гаргах тухай дурдсан боловч цагаатгах зарчим албан ёсоор тусгагдаагүй, гэхдээ нотолгоо хангалтгүй бол прокурор хэрэг үүсгэхээс татгалзаж, практик байдлаар сэжигтнийг буруутай гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, цагаатгах нь прокурорын шийдвэртэй шууд холбоотой, шүүх шууд буцааж нэмэлт нотолгоо цуглуулах эрх хязгаарлагдмал. Хятад улсад Японы болон барууны “шүүхэд мэтгэлцэх (adversarial) зарчим” шууд хэрэгждэггүй, харин микс буюу хос (inquisitorial + adversarial) систем нь голчлон хэрэгждэг. Эрүүгийн процессын хуульд Япон шиг “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг (pre-trial hearing)” гэсэн тусгай шат заагдаагүй. Харин хуулиар тодорхой зааснаар шүүх хяналтын болон урьдчилсан шатны хяналт /审查程序 (review procedure) нь хэрэгт нотолгоо хангалттай эсэхийг шалгах зарчмаар зохицуулагддаг. 审查起诉 (Shěrchá qǐsù) – прокурорын хэрэг шалгах / урьдчилсан хяналт прокурор нотолгоо хангалтгүй бол хэрэг үүсгэхээс татгалзаж болно (Criminal Procedure Law, Article 169).

Шүүх прокурорын шийдвэрийг хянах эрхтэй, гэхдээ Японы “pre-trial hearing”-ийн шиг бие даасан шүүхийн хэлэлцүүлэг хязгаарлагдмал. 审判前程序 (Pre-trial procedure) шүүх хэргийн материалыг шалгаж, нотолгоо хангалттай эсэхийг нягтлах. Шүүх хуралдаан мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд шүүхээс нотлогдохгүй бол цагаатгах эрхтэй ч прокурорт хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаадаг. Гэхдээ нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах зохицуулалт байхгүй боловч, шүүхийн практикаар ийнхүү буцааж шийдвэрлэдэг байна.

Дээрх улсуудаас Оросын Холбооны улс болон Бүгд Найрамдах Хятад ард улсад хэргийг прокурорт нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаадаг байна. Ингэхдээ Оросын Холбооны улсад цагаатгах зарчмын тухай хуульд агуулагдсан боловч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болоод гэм буруугийн шатанд прокурорт буцааж шийдвэрлэж болохоор заажээ. Бүгд Найрамдах Хятад ард улсын тухайд цагаатгах зарчмыг хуульчлаагүй бөгөөд эргэлзээ гарвал мадаггүй тогтоож хэрэг хийсэн нь үнэн бол шийтгэж, хийгээгүй нь үнэн бол хэргийг хэрэгсэхгүй болгодог зохицуулалттай байна. Япон улсын тухайд шүүх, прокурор, мөрдөгч нар тус тусын чиг үүргийг ялгаа заагтайгаар гүйцэтгэх ба шүүхийн шатанд эргэлзээ бүхий нөхцөл илэрвэл прокурорын зүгээс тус хэргийг хэрэгсэхгүй болгох буюу цагаатгах санал гаргаж хэргийг шийдвэрлэдэг байна. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хувьд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шаттай бөгөөд тухайн шатанд л хэргийн дутуу дулимаг зүйлийг хэлэлцэж, прокурорт буцаах эрх хэмжээ эдэлдэг байна. Харин гэм буруугийн хэлэлцүүлэгт тухайн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон шүүгч хэргийг бус өөр шүүгч хэргийг шийдвэрлэж, нотлох баримт хангалтгүй бол цагаатгах шийдвэр гаргадаг байна. Тус улсын хуульд ийнхүү заасан боловч шүүхийн практикт гэм буруугийн хэлэлцүүлгээс прокурорт буцаах цөөн тохиолдол гардаг байна.

V. ДҮГНЭЛТ

Хүний эрхийг дээдэлсэн ардчилсан улсын нэг шалгуур нь гэм бурууг эцэслэн тогтоохдоо шударга шүүхийн процедураар тогтоодог байх явдал юм. Хүн, хүн байхын хувьд тодорхой эрх эдэлж, мөн үүрэг хүлээх нь нийгэмтэй салшгүй холбоотой зүйл юм. Энэ утгаараа хүний эрхийг хангахын тулд баримталбал зохих зарчим, журам, хуулиудыг ОУ-д тунхагласан бөгөөд түүнийг дагаж мөрдөх нь зохилтой. Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалд гэм буруугийд тооцох зарчим мөн эргэлзээ үүсвэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх / in dubio pro reo / зарчмыг хуульчилсан бөгөөд нотол,

⁵⁰ БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 236 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ (Сүүлд үзсэн: 2023.03.22), <http://www.npc.gov.cn/npc/index.html> ,

нотолж чадахгүй бол цагаатгах зарчмыг эрүүгийн процессын хуульд тусгалаа олсноор яллагдагчийг хүн болохын хувьд хэргээ түргэн шуурхай шийдвэрлүүлэх, эрүүдэн шүүлтээс урьдчилсан сэргийлэх зорилготой болохыг тэмдэглэсэн.

Тодруулбал Бүгд Найрамдах Хятад ард улсад цагаатгах зарчмын тухай хууль тогтоомждоо тусгаагүй бөгөөд тус зарчим нь тухайн оронд хэрэгждэггүй. Зөвхөн үнэхээр гэмт хэрэг үйлдээгүй бол тус хэргийг хэрэгсэхгүй болгодог. Харин эргэлзээ бүхий нөхцөл тогтоогдвол түүнийг маргалдаж шийдвэр гаргадаг социалист орон юм. Манай улсын шүүхийн практик тухайн улсын шүүхтэй их төстэй байдлаар шийдвэр гаргаж байна. Бидний үлгэр дуурайлал авдаг Оросын Холбооны улсын тухайд мөн л хэргийг аль ч шатнаас прокурорт буцааж шийдвэр гаргадаг байна. Харин Холбооны Бүгд Найрамдах Герман улсын тухайд манай улстай ижил зохицуулалттай боловч прокурорт буцаах эрх хэмжээг аажмаар халж байгаа бөгөөд практикт машцоон тохиолдолд хэргийг прокурорт буцааж шийдвэрлэж байна. Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах улсын тухайд ихэвчлэн холимог системтэй байх бөгөөд хэргийн бодит байдлыг тогтоох болон мэтгэлцэх болоод цагаатгах зарчмын тухайд харшилсан байр суурьтай байна. Дээрх хоёр зарчим нь эрүүгийн процесс ажиллагаанд нэгэн зэрэг хэрэгжих боломжтой эсэх тухайд нэгэнтээ процесс ажиллагааг шүүхийн өмнөх болоод шүүхийн шат гэж ангилбал тухайн шүүхийн өмнөх шатанд мөрдөгч, прокурор мөрдөн шалгах буюу хэргийн бодит байдлыг тогтоох зарчим үйлчилж, шүүхийн шатанд мэтгэлцэх буюу эргэлзээ гарвал яллагдагч шүүгдэгчид ашигтай байдлаар хэргийг шийдвэрлэх нь зохимжтой байна. Эс бөгөөс мөрдөн шалгах зарчим нь эрүүгийн процессын бүхий л үе шатанд үйлчлэхээр бол эргээд социалист, дарангуйлсан, хүний эрхийг боосон хэв маягт шилжих эрсдэлийг болгож байна.

Монгол улсын хувьд шүүх бүхнээс эрх мэдэлтэй тул прокурорыг удирдаж, тодорхой үүрэг даалгавар, ажиллагааг заавал хийх шийдвэр гаргах нь яллах шүүхийн хэв шинжийг бий болгож, дахин нотлоод ир гэж прокурорт хэргийг гэм бурууг хэлэлцсэний дараа буцаадаг шүүхийн шатанд мэтгэлцэх болоод цагаатгах зарчмын хэрэгжилт хангагдах боломжгүй практик бий болсон юм. Тодруулбал 2017 оны Эрүүгийн процессын хуулийн өөрчлөлтөөр нотолбол зохих байдал шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд бүрэн хангагдахаар хууль тогтоогч хуульчилсан боловч, нотолбол зохих байдал бүрэн хангагдахгүй дутуу орж ирсэн нь гэм буруугийн хэлэлцүүлэгт дээд шатны шүүхээс “прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шийдвэрийг хэвээр батлах үндэслэл болохгүй” гэж үзэн прокурорт гэм бурууг хэлэлцсэний дараа буцааж шийдвэрлэсэн тохиолдлууд их гарах болсон. Эцсийн дүндээ прокурорт хэргийг буцаадаг байдал нь сөрөг үр дагавартай бөгөөд, эрүүгийн процессын цаашдын хөгжлийн чиг хандлага, өөрийн улсын өвөрмөц онцлогт тохирсон ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн улсад тохирох, дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд: Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг чадавхжуулж, шүүхийн гэм буруугийн шатанд хэргийг прокурорт буцаахгүй бөгөөд тус хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотолбол зохих байдал нотлогдоогүй, оролцогчийн эрхийг зөрчсөн, нотлох баримтын шаардлага хангаагүй, эргэлзээтэй бүхийн нөхцөл байдал гэм буруу хэлэлцэгдэхгүй яллагдагчийг шүүхэд шилжүүлэх бэлтгэл хангах ажиллагаа буюу ШУХ-ийн шатанд тогтоогдвол хэргийг тус шатнаас прокурорт буцааж, харин гэм бурууг хэлэлцэх шатанд нотлогдохгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгадаг байх нь зүйтэй. Үр дүнд прокурор, мөрдөгч нар ажлаа хариуцлагатай гүйцэтгэх ба эргээд дахин алдаа гаргах эрсдэлийг бууруулж хариуцлага тооцдог байх нь тохиромжтой байна.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх эх сурвалж:****А. Эрх зүйн эх сурвалж**

1. Монгол Улсын Олон Улсын гэрээ, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, <https://legalinfo.mn/mn/detail/1271>
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, <https://legalinfo.mn/mn/detail/1257>
3. Авлигалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16760279163531&showtype=1>
4. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэлэх тухай хууль, 2017 он.

Б. Ном, сурах бичиг

1. М.Гантулга, Эрүүгийн процессын тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь, 2018 он.
2. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, 2018 он.
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009, 2012 он.
4. Д.Баярсайхан, Гадаадын орнуудын эрүүгийн процесс, 2015 он.
5. Г.Ганбаатар, Хуулийн засаглал шударга ёсны эрэлд, 2016 он.
6. Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн Урьдчилсан хэлэлцүүлэг” 2024.03.01, https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/ErkhZuinemkhetgel.pdf
7. Кага Жожи. Япон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага, сорилт, Ази номхон далайн орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага 2001 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Хууль зүйн Үндэсний Хүрээлэн, “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх нь” 2017 он,
2. Эрх зүй сэтгүүл, Ж.Эрхэсхулан, “Шүүхээс хэргийг буцаах нь зайлшгүй асуудал уу”, цуврал 51, №3, 2020 он.
3. Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, 2015 он.
4. Б.Батцэрэн, Хэргийг прокурорт буцаах эрх хэмжээг хуулиар хязгаарласан нь хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх үндэслэл болохгүй, <https://legaldata.mn/shiidver/huraangui/view/174>, 2023 он,
5. Хууль Зүйн Үндэсний хүрээлэн, “ЭБШ хууль дахь, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах талаарх судалгааны ажлын тайлан”, 2012 он.
6. Эрх зүй сэтгүүл, Ж.Эрхэсхулан, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хэрэглээний зарим асуудал”, №2, Цуврал 46, 2019 он.

Г. Бусад

1. ЭХХШтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, <https://www.google.com/search?q=%D0%AD%D0%A5%D0%A5%D0>,
2. Монголын Хуульчдын Холбоо, Д.Баярсайхан «Эрүүгийн процессын эрх зүйн зарим тулгамдсан асуудал» хэлэлцүүлэг 2017.12.08, <https://www.youtube.com/watch?v=WUyGi8ISV9o&t=1966s>
3. Улсын Дээд шүүхийн 2023оны 05 дугаар сарын 08-ны өдрийн, дугаар 24 тогтоол, <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=32&active=1&page=1&sort=title&page=1>

4. Улсын Дээд шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3444?daterange=2023/01/01%20-%202023/05/15%20&id=3&court_cat=2&bb=
5. УДШ-ийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 164 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3521?start_date=&end_date=&id=3&court_cat=2&bb=1
6. УДШ-ийн 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 135 дугаар тогтоол https://shuukh.mn/single_case/3485?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1,
7. УДШ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 117 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3477?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1,
8. УДШ-ийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3444?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1,
9. УДШ-ийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 21 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/3281?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1,
10. УДШ-ийн 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/3274?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1
11. УДШ-ийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/3292?daterange=2022-12-01%20-%202024-04-01&id=3&court_cat=2&bb=1
12. УДШ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 45 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/3571?daterange=2024/01/01%20-%202024/05/10%20&id=3&court_cat=2&bb=
13. УДШ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 51 дугаартай тогтоол, https://shuukh.mn/single_case/3579?daterange=2024/01/01%20-%202024/05/10%20&id=3&court_cat=2&bb=
14. УДШ-ийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 82 дугаар тогтоол: https://shuukh.mn/single_case/3444?daterange=2023/01/01%20-%202023/05/15%20&id=3&court_cat=2&bb=1
15. УДШ-ийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 164 дүгээр тогтоол https://shuukh.mn/single_case/3521?start_date=&end_date=&id=3&court_cat=2&bb=1.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж

А. Англи хэл дээр

1. Дам эшлэв: Thomas. Wegn Law and Truth; Panel III; Truth thejury, and theadversarial system; Is the Criminal process about truth?; A German Perspective (Harvard Journal of Law& Public Policy, Winter, 2003)
2. Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, p.251 (Сүүлд үзсэн: 2023.03.09), <https://b-ok.asia/book/3656000/4e3da3> ,

Б. Орос хэл дээр

1. Дам эшлэв: Головка Л.В Реформа уголовного процесса во Франции.Государство и право 2001 №8
2. Дам эшлэв: Гученко К.Ф Филипинов Б.А Уголовный процесс зарубежных государств I.,2004
3. “Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ф3 https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/ , (сүүлд үзсэн огноо:2024.03.01)

В. Япон хэл дээр

1. 1948 оны 131 дүгээр Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 昭和二十三年法律第三百一十一号刑事訴訟法 https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000131_20240215_505AC0000000066&fbclid=IwAR3SZ5MVzBooAITCyXYbcRffOXE2yC8cpITGdlj6dijWSdUTpLsz_0EkGGY (Сүүлд үзсэн: 2024.04.25),
2. Япон улсын Үндсэн хууль, 昭和二十一年憲法日本国憲法, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321CONSTITUTION>, (Сүүлд үзсэн: 2024.05.01),

Г. Хятад хэл дээр

1. БНХАУ-ын Үндсэн хуулийн 129 дүгээр зүйл/ 中华人民共和国宪法/ (Сүүлд үзсэн: 2023.03.22), <https://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116> ,
2. БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль, /中华人民共和国人民法院组织法/ (Сүүлд үзсэн: 2023.03.22)8 https://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm ,
3. Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар, 最高人民法院关于适用《中华人民共和国刑事诉讼法》的解释 (Сүүлд үзсэн: 2023.03.22)8 http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml
4. БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 233 дугаар зүйл /习近平会见美国工商界和战略学术界代表/ (Сүүлд үзсэн: 2023.03.22), <http://www.npc.gov.cn/npc/index.html> ,

THE PRINCIPLE OF PROOF AND EXONERATION IN CASES OF INSUFFICIENT EVIDENCE: CHALLENGES AND ISSUES

Enkhzul.E

Master's student, School of Law, NUM

ABSTRACT:

In the criminal procedure law currently in force in Mongolia, there is no general provision allowing a case to be returned to the prosecutor. The law only permits the return of a case to the prosecutor for supplementary investigation when, during the preliminary hearing, a party files a motion to that effect. Nevertheless, in judicial practice, the return of cases to the prosecutor even at the stage of determining guilt has persisted, which is incompatible with the principles of a democratic state that upholds human rights.

In countries belonging to the Romano-Germanic legal family, criminal procedure laws encompass such principles as establishing the facts of the case and the rule that, if the facts cannot be proven, the accused must be acquitted. How these principles are applied in a coherent and complementary manner has become an important issue.

The principle of establishing the facts of the case applies at all stages of criminal proceedings; however, when the court assumes the function of accusation, this creates an imbalance of powers that risks infringing upon human rights, giving rise to excessively harsh legislation, and ultimately fostering wrongful convictions and even torture. From the perspective of this research, it is proposed that in a mixed legal system such as that of Mongolia, the principle of establishing the facts of the case should operate during the pre-trial phase, while at the trial stage the principle of adversarial proceedings should be applied in substance rather than formality. In circumstances of doubt, the resolution should be made in favor of the defendant, thereby ensuring the effective implementation of the presumption of innocence.

KEYWORDS:

Pretrial Hearing, Returning the Case to the Prosecutor, Assigning the Case to the Prosecutor for 60 Days, Concept of Law, Returning the Case for Additional Investigation,

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
2025 ОНЫ IV УЛИРЛЫН
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ
(МЭДЭЭ)**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН ШИНЭ БАЙРНЫ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шинэ байрны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 101 жилийн ойн өдөр болж өнгөрлөө.

Хууль зүйн салбарын судалгаа, сургалтын гол төв болсон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шинэ байр нь Сүхбаатар дүүрэг 11 хороо, 7 дугаар хороолол /14182/, Алтайн гудамж 841 гэсэн дугаартай албан ёсны хаягт байрлаж байна.

Нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Төрийн дээд шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор, Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, академич С.Нарангэрэл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, Бригадын генерал Ж.Бямбасүрэн, Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн захирагч, хурандаа Э.Болдбаатар болон хууль зүйн салбарын хүндэт зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцлоо.



/Зүүн гар талаас ХЗҮХ-ийн захирал Н.Жамъянхүү, “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, академич С.Нарангэрэл, ХЗДХ-ийн сайд Б.Энхбаяр, ХХЕГ-ын дарга, Бригадын генерал Ж.Бямбасүрэн, Хилийн цэргийн 0119 дүгээр ангийн захирагч, хурандаа Э.Болдбаатар нар тууз хайчлах ёслолын үйл ажиллагааны үеэр/

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хууль зүйн мэдээллийн төв, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Прокурорын давтан сургалтын төв, Цагдаагийн академийн дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэн болон Хуульчдыг давтан сургах төвийг тус тус нэгтгэн “Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв” буюу “Хууль зүйн үндэсний төв»-ийг байгуулснаар Монгол улсын эрх зүйн салбарт анх удаа үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага байгуулагдсан түүхтэй.

Хүрээлэнгийн анхны барилга Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл”-ийн хүрээнд 2004 онд Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд Засгийн газрын ордны баруун талд баригдсан бөгөөд тус таван давхар байранд хүрээлэн 2004-2023 он хүртэл үйл ажиллагаа явуулжээ. 2023 оны 7 дугаар сарын 7-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор УИХ-ын 77 дугаар тогтоол гарч, Засгийн газрын 2024 оны 1 дүгээр тогтоолоор барилгыг УИХ-ын Тамгын газарт шилжүүлсэн билээ.

Улмаар Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд 2000 м² газарт шинэ барилгыг Хилийн цэргийн 0119 дүгээр анги барьж 2025 оны 10 дугаар сарын 03-нд хүлээн авснаар өдгөө үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.



/Сүхбаатар дүүрэг 11 хороо, 7 хороолол, Алтайн гудамж 841-д байрлах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шинэ барилга/

Шинэ барилга нь цутгамал төмөр бетон карказан, гадна хана шилэн хийцтэй, 5 давхар, газар доор нэг давхартай байгууламж юм. 20 машины ил зогсоол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат болон хоёр машины зогсоол, ногоон байгууламжтай уг байр нь орчин үеийн шаардлагад бүрэн нийцсэн байна.

Түүнчлэн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр нь шинэ суурьшлын бүсэд хамаарах бөгөөд “Улаанбаатар трам” төслийн хүрээнд хэрэгжүүлэх хөнгөн галт тэрэгний системийн I шугамын чиглэлд багтсан газар юм.

Барилгын нээлтийн үйл ажиллагаанд олон олон эрдэмтэн, докторууд хүрэлцэн ирсэн бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Төрийн дээд шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор, Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, академич С.Нарангэрэл нар үг хэллээ.



/УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нээлтийн үеэр/



/“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, Төрийн дээд шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор, Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, академич С.Нарангэрэл нээлтийн үеэр/

Хууль зүйн үндэсний хүрээлэн ийнхүү шинэ барилгатай болоход өөрсдийн хүч хөдөлмөрөөр, үнэлж баршгүй хувь нэмрээ оруулж ажилласан өмнөх удирдлагууд хүрэлцэн ирж нээлтийн үйл ажиллагаанд оролцсон билээ.

Энэхүү барилгыг санаанаасаа ажил хэрэг бөгөөд зураг төсөл, зураг төслөөс ийнхүү нүдний өмнө сүндэрлэх барилга болтол хичээн зүтгэсэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал асан, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, мөн барилгын ажлыг саадгүй үргэлжлүүлж, хүлээн авч, нүүлгэлтийн нөр их ажлыг хоёргүй сэтгэлээр удирдан зохион байгуулсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал асан, Хууль зүйн ухааны доктор Б.Өлзийсайхан нартаа халуун сэтгэлийн угаас онцгойлон талархал илэрхийлэе.



/Зүүн гар талаас ХЗҮХ-ийн Захирал асан Б.Өлзийсайхан (Ph.D.), ХЗҮХ-ийн Захирал Н.Жамъянхүү, ХЗҮХ-ийн Захирал асан Х.Эрдэм-Ундрах (Dr.jur.) нар нээлтийн үеэр/

АКАДЕМИЧ СОДОВСҮРЭНГИЙН НАРАНГЭРЭЛ “ЧИНГИС ХААН” ТЭРГҮҮН ЗЭРГИЙН ОДОН ХҮРТЛЭЭ

Академич Содовсүрэнгийн Нарангэрэлд төрийн дээд шагнал, “Чингис хаан” тэргүүн зэргийн одонг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх зарлиг гарган, Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 863 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гардууллаа.

“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, академич С.Нарангэрэл нь Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн дарга бөгөөд “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хуульч, өмгөөлөгч, хууль тогтоогч, төр, нийгмийн зүтгэлтэн билээ. Тэр бээр МУИС-ийн Хууль зүйн сургуульд 50 гаруй жил багшлахдаа хууль зүйн салбарын дотоод, гадаадын 30 гаруй эрдэмтэн, олон мянган хуульч бэлтгэжээ.

Танд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт хамт олны өмнөөс баяр хүргэж, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!



/“Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, академич С.Нарангэрэл шагнал гардаж авах ёслолын үйл ажиллагааны үеэр/

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ УРАЛДААНЫ ГИШҮҮДИЙГ ШАЛГАРУУЛЖ, ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 104 жилийн ой, “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийн өдрийг тохиолдуулан эрдэм шинжилгээний “Шилдэг бүтээл”, “Шилдэг илтгэл”, “Грант олгох төсөл” шалгаруулах V уралдааны шилдэг оролцогчдод шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд боллоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын эрдэм шинжилгээ, инновацыг хөгжүүлэх, онол, практикт тулгамдсан асуудлыг судалгаанд үндэслэн шийдвэрлэх, эрдэмтэн, судлаачдын оюуны бүтээлийг үнэлж, урамшуулах зорилгоор эрдэм шинжилгээний “Шилдэг бүтээл”, “Шилдэг илтгэл”, “Грант олгох төсөл” шалгаруулах уралдааныг ХЗДХЯ, Дотоод хэргийн их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран тав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



/Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааны ёслолын нээлтийн үеэр/

Шилдэг төслийн уралдаан нь хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын эрдэм шинжилгээ, сургалт, инновац, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, шинэ эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зорилготойгоор зохион байгуулдаг. Уралдааныг хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачид болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл оролцож, шүүгчээр ажиллалаа. Энэ жилийн шилдэг төслийн грантын уралдаанд 40 орчим бүтээл ирснээс 27 төсөл шалгарч II шатанд хэлэлцүүлээ.



/Шагнал гардан авсан оролцогчид/

“Оюутны шилдэг илтгэл”-ийн уралдаанд шалгарсан:

I байрт МУИС-ийн ХЗС-ийн V түвшний оюутан Б.Жамбалдоржийн “Хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэх бүрэлдэхүүн ба En banc зарчим”;

II байрт ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн 3221 дүгээр дамжааны сонсогч Б.Даваажавын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хоригдлын үсийг хусах практик ба хүний эрхийн асуудал”;

III байрт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Т.Анужин, Э.Жавзмаа нарын “Цахилгаан хөдөлгүүрт хэрэгсэл /цахилгаан дугуй, скуүтер, мопед/-ийн эрх зүйн орчин, хяналт, зохицуулалтыг сайжруулах нь /Өргөн барьсан төслийн шүүмж/”;

Тусгай байрт:

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Б.Болор, СЭЗИС-ийн II түвшний оюутан Б.Индра нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дахь гэрчийн эрх зүйн байдалд тулгамдсан асуудал”;

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Б.Оюунтунгалагийн “Нийтийн өмчийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуульт ёсны үүднээс авч үзэх нь”;

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан С.Гантуяагийн “Анагаахын эрүүгийн эрх зүй ба түүний үндэсний эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь” сэдэвт илтгэл тус тус шалгарлаа.



/Зүүн гар талаас ДХИС-ийн дэд профессор, доктор, цагдаагийн хошууч Н.Сайнбаяр, ДХИС-ийн багш, судлаач В.Номинчулуун, ХЗҮХ-ийн захирал Н.Жамъянхүү, Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар нар шагнал гардуулах үйл ажиллагааны үеэр/

“Грант олгох шилдэг төсөл”-ийн уралдаанд шалгарсан:

Суурь судалгааны төсөл I байрт Шүүх шинжилгээний ерөнхий газрын судлаачдын багийн гишүүд Д.Долгормаа, Б.Наранбямба, Э.Халиун, Э.Төрболд, Э.Энхдөлгөөн, Б.Урнаа, У.Сувд-Эрдэнэ нарын хамтарсан “Гистохимийн будгаар нас баралтын зарим шалтгааныг нарийвчлан тогтоох нь” сэдэвт суурь судалгааны төсөл;

Хавсарга судалгааны төсөл I байрт Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын баг Д.Дашзэвэг, З.Сүлд нарын “Амьтны биед хэмжилт хийх криминалистикийн арга зүй сургалтын төлөвлөгөө” сэдэвт хавсарга судалгааны төсөл;

Инновацын төсөл I байрт Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын баг Н.Сайнбаяр В.Номинчулуун С.Солонго, Б.Даваапүрэв нар “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих “Hotspot application development” сэдэвт төсөл тус тус шалгарлаа.



“Шилдэг бүтээл”-ийн уралдаанд шалгарсан:

I байрт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, дэд профессор Г.Давааням “Компанийн эрх зүйн онол, практик”;

II байрт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Б.Оюунжаргал, багш Б.Баялагмаа нарын “Биткойн, Ботокс, Үнэт зүйл: Инфлүенсэрийн хууль бус зар сурталчилгаанаас хэрэглэгчийг хамгаалах нь”;

III байрт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Э.Байгалын “Олон улсын хувийн эрх зүй”;

Тусгай байрт:

МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч С.Жавхлан “Арбитрын эрх зүйн орчин үеийн чиг хандлага”;

ДХИС-ийн профессор Ц.Азбаяр, П.Очбадрах, В.Амарсанаа, Л.Бат-Очир, В.Номинчулуун нарын “Хууль сахиулагчийн хууль ёсны үйл ажиллагааны онолын үндэс”;

ДХИС-ийн Шинжлэн магадлахуйн профессорын судалгааны багийн тэргүүлэх профессор, доктор, профессор Т.Очирбат, Шинжлэн магадлах ухааны сургуулийн Криминалистикийн тэнхимийн эрхлэгч, доктор, цагдаагийн дэд хурандаа З.Сүлд нарын “Криминалистик” бүтээл тус тус шалгарлаа.

АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ (ALIN)-НИЙ 21 ДЭХ ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN) олон улсын байгууллагын гишүүн орнуудын 21 дэх ээлжит чуулга уулзалт болон олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI) болон Лаос Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль хамтран 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Вьентьян хотноо амжилттай зохион байгууллаа.

Чуулга уулзалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнг төлөөлж тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал саналын эрхтэй оролцлоо. Энэхүү чуулга уулзалтад Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN)-ний гишүүн байгууллагууд болох нийт 18 хууль зүйн сургууль болон хууль зүйн судалгааны хүрээлэнгээс 30 гаруй эрдэмтэн багш, судлаач, мэргэжилтнүүд оролцсон. Тус уулзалтын үеэр Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль “ALIN”-ы шинэ гишүүн болж олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүллээ.

21 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурал “Хууль тогтоомжийн сайн туршлага: Ази тив дэх хууль тогтоомжийн чанарыг сайжруулах стратеги” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсаас “Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ: Бодлогын зарим асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцсон. Тус илтгэлийг ХЗҮХ-ийн Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын эрхлэгч Б.Энх-Амгалан хамтран бэлтгэж, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Д.Дэмидханд хэлэлцүүлээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд нийт 14 улсын төлөөлөл биечлэн болон цахимаар оролцож илтгэл тавьсан ба Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн бодлогын болон практик арга хэмжээг бусад улсын туршлагаас суралцсанаараа ач холбогдолтой болж өндөрлөлөө.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ХАННС-ЗАЙДЕЛИЙН САНТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү, Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал нар Германы Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Феликс Гленк, төслийн зохицуулагч С.Мөнхжаргал нартай уулзаж, хоёр байгууллагын өнгөрсөн хугацааны хамтын ажиллагаа болон цаашдын хамтран ажиллах чиглэлүүдийн талаар санал солилцлоо.

Хоёр байгууллага өнгөрсөн 20 гаруй жилийн хамтын ажиллагааны үр дүнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, хууль зүйн салбарт одоо тулгамдаж байгаа сорилтууд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн оруулж буй хувь нэмэр, түүнчлэн сангийн зүгээс ямар чиглэлээр дэмжлэг үзүүлэх талаар ярилцлаа.

Уулзалтын үеэр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү Хууль тогтоомжийн тухай хуульд сүүлийн үед орсон нэмэлт, өөрчлөлтөөр Хүрээлэнгийн чиг үүрэг өргөжсөн, залуу судлаачдаар эгнээгээ тэлж байгаа энэ үед тэднийг мэргэшүүлэх, чадавхжуулах асуудал тулгамдаж байгааг онцоллоо.

Мөн хуулиар хүлээсэн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд ижил төстэй Герман улсын туршлагыг олон талт хэлбэрээр судлах нь чухал. Ирэх онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд хууль зүйн салбарын бусад байгууллага, судалгааны хүрээлэн, Олон улсын байгууллагуудтай уялдаа холбоогоо улам бэхжүүлэн, хамтран ажиллах боломжтой талаар санал солилцлоо.



/Зүүн гар талаас ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал, ХЗҮХ-ийн захирал Н.Жамъянхүү, нар Германы Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Феликс Гленк, төслийн зохицуулагч С.Мөнхжаргал нар уулзалтын үеэр/

ДОКТОРАНТЫН ЦУВРАЛ СЕМИНАРЫН АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Докторантын цуврал семинарыг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороонд байрлах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд амжилттай зохион байгууллаа.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлаа өргөжүүлэх хүрээнд 2017 оноос эхлэн “Докторантын цуврал семинар”-ыг зохион байгуулж ирсэн билээ.

Энэ удаагийн цуврал семинарт МУИС-ийн ХЗС-ийн докторант Р.Онончимэг “Эрх зүйн хийдэл ба түүнийг туулах арга зам”, Дотоод хэргийн их сургуулийн докторант Э.Уянга “Хууль зүйн боловсролын тогтолцоо” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж, хууль зүй, эдийн засаг, боловсролын салбарын тэргүүлэх эрдэмтэн, судлаачдыг урьж оролцуулан, онолын хэлэлцүүлэг өрнүүллээ.

Докторант Р.Онончимэг “Эрх зүйн хийдэл ба түүнийг туулах арга зам” сэдэвт илтгэлээрээ манай улсын эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудлыг даван туулах арга замыг эрэлхийлж буй талаараа онолын түвшинд судалснаа танилцуулан семинарт хэлэлцүүллээ.



/Зүүн гар талаас МУИС-ийн ХЗС-ийн докторант Р.Онончимэг, ШЕЗ-ийн гишүүн, Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн ухааны доктор Д.Зүмбэрэлхам, МУИС-ийн ХЗС-ийн зөвлөх профессор, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Х.Сэлэнгэ нар хэлэлцүүлгийн үеэр/

Дотоод хэргийн их сургуулийн докторант Э.Уянга “Хууль зүйн боловсролын тогтолцоо”-нд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, эрх зүй, хууль зүйн боловсролын

зааг, ялгааг тодорхойлох, хуульч бэлтгэх тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлэх боломж, гарцын талаар танилцуулснаар салбарын эрдэмтэн, судлаачид санал, зөвлөмж өгч семинарын ач холбогдол, үр нөлөөг бататгасан сайхан ажил болж өнгөрлөө. Цаашид тус хүрээлэнгээс “Докторантын цуврал семинар”-т 2017 оноос хойш оролцсон оролцогчдын бүтээлийн танилцуулга, мэдээллийг боловсруулан хүргэж, тухайн семинарыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, үр дүн ач холбогдлыг нь өргөжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



/Дотоод хэргийн их сургуулийн докторант Э.Уянга хэлэлцүүлгийн үеэр/

Мөн тус семинарт МУИС, ДХИС, ИЗИС, Шихихутуг, УБЭИС зэрэг их сургуулийн докторантууд, Хууль зүй, боловсролын салбарын эрдэмтэн, судлаачид оролцож хүрээлэнгийн шинэ байрны заал танхимын зохион байгуулалт, үйл ажиллагаа, номын сан, номын худалдаа үйлчилгээтэй танилцлаа.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХАМТ ОЛОН МОД ТАРИЛАА

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамт олон 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдөр шинэ байрныхаа хашаанд мод тариалаа.

Уг арга хэмжээнд тус хүрээлэнгийн Ахмадын зөвлөлийн гишүүд оролцон мод тарьж, арчлан ургуулах заавар, зөвлөгөө өглөө.

Хууль зүйн үндэсний хүрээлэн байрлаж буй Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр нь шинэ суурьшлын бүсэд хамаарах бөгөөд 24 мега төслийн нэг “Улаанбаатар трам” төслийн хүрээнд хэрэгжүүлэх хөнгөн галт тэрэгний систем нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу I шугамын чиглэлд багтсан билээ.

Мод тарьснаар тухайн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төдийгүй байгалиа нөхөн сэргээх, хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, агаарын бохирдлыг бууруулахаар хэрэгжүүлж байгаа олон талт ажилд хувь нэмрээ оруулах юм. Бүх нийтээр мод тарих үйлсийг дэмжин дэлгэрүүлэхийг манай хамт олон уриаллаа.



/Зүүн гар талаас Ахмадын зөвлөлийн гишүүн Д.Батсүх, Д.Баатарнүрэв, ХЗҮХ-ийн Хүний эрх Олон улсын секторын эрхлэгч Б.Энх-Амгалан, ХЗҮХ-ийн албан хаагч Д.Оюунсайхан, В.Мөнхгэрэл, С.Эрдэнэнүрэв нарын хамт мод тарих үеэр/